Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, БАТЛАН ХАМГААЛАХ СУДЛАЛ

№30 (40) 2021

Улаанбаатар
2021

Institute for Defense Studies

JOURNAL
of
SECURITY AND DEFENSE STUDIES

№30 (40) 2020

EDITORIAL BOARD:

Editor in Chief: B.Bayarmagnai (M.A.)

Editor: B.Munkhsaikhan (Ph.D, Professor)

Deputy Editor-in-Chief: T.Soronzonbold (Ph.D, Professor)

Editorial Panel:

J.Mendee (Sc.D)

O.Urjin (Sc.D, Professor)

Sh.Palamdorj (Sc.D, Professor)

Techinical Editor: B.Bayarmagnai

ISSN 2220-9115

The authors will bear the responsibility for facts, information and views expressed in the article.

Address:
Postal box-184, Branch 22, Mongolpost,
Ulaanbaatar city, 13320
Phone: 976-453942
www.mids.gov.mn



Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ:

Ерөнхий эрхлэгч: Б.Баярмагнай (М.А.)

Эрхлэгч: Б.Мөнхсайхан (Ph.D, профессор)

Хариуцлагатай нарийн бичгийн дарга:
Т.Соронзонболд (Ph.D, профессор)

Гишүүд:
Ж.Мэндээ (Ph.D)
О.Үржин (Sc.D, профессор)
Ш.Паламдорж (Sc.D, профессор)

Техник редактор: Б.Баярмагнай

ISSN 2220-9115

Өгүүлэлд нийтлэгдсэн тоо, баримт, мэдээлэл, дүгнэлтийн үнэн зөвийг зохиогч өөрөө хариуцна.

Хаяг:
Ш/х-184 Монгол шуудан. 22 дугаар салбар,
Улаанбаатар хот, 13320
Утас: 976-453942
www.mids.gov.mn

АГУУЛГА

Аюулгүй байдал

О.Үржин
Х.Батбилэг — Үндсэний аюулгүй байдлыг хангахад тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам 6

Б.Өлзийхуяг — Оршин тогтнохуйн аюулгүй байдал ба эх оронч үзэл 9

Д.Уламбаяр — Дэлхийн социалист систем дэх хүйтэн дайн: Зөвлөлт, Хятад, Монголын гурвалжин 26

Р.Нямдаваа — Цөмийн зэвсэг хориглох гэрээ ба түүний хамрах хүрээ, хүчин төгөлдөр болсон үйл явц 42

П.Цэдэв, С.Бямбасүрэн ухааны нэг — Уламжлалт ба уламжлалт бус аюул нь аюулгүй байдлын судлагдахуун болох нь 54

Батлан хамгаалах бодлого

Д.Баасандамба — Цэргийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийг боловсронгуй болгох зарим асуудал 66

Х.Орхончимэг — Батлан хамгаалах боловсролын сургалтын арга зүй, түүний мөн чанарын асуудалд 75

Б.Баатарсүрэн — АНУ ба Монгол Улсын цэргийн хамтын ажиллагаа, хэтийн төлөв 83

Б.Очирсүрэн, Э.Батгэрэл — Дэд бүтцийн талаарх ойлголт ба батлан хамгаалах дэд бүтцийн тухайд 90

Цэргийн урлаг судлал

Ц.Гандорж — Энхийг дэмжих ажиллагаанд Европийн холбооны оролцооны цаашдын хандлага 97

Т.Мөнх-Оргил — НҮБ-ийн энхийг дэмжих ажиллагаа, тулгамдаж байгаа асуудал.. 103

С.Пүрэвдорж — Террорист хүний сэтгэл зүйн зарим асуудалд 117

Д.Болод — Их сургуулийн сургалтын шинэчлэл ба судалгаа хөгжүүлэлтийн асуудалд 131

Цэргийн түүх, уламжлал

Т.Сүхбаатар — Ардын цэргийн даргын сургуулийн анхны захирал Павел Михайлович Толпыгин (1881-1937) 139

Ж.Базарсүрэн — Эрт, дундад үеийн Монголчуудын төмөрлөг боловсруулжасан арга технологийн тухайд 144

Т.Эрдэнэхишиг — Ма И-ийн отолт 153

С.Ганболд, Ц.Бямба-Эрдэнэ — Жанчхүүгийн дабаанд болсон байлдаан 158

Н.Наранхүү — Түүх бичлэгт БНМАУ-ын ЦЯЯ-ны Сайд бөгөөд бүх цэргийн жанжин, улсын маршал Г.Дэмидийн талаар судалсан нь 166

CONTENTS

Security

O.Urjin
Kh.Batbileg — Emerging issues to National security and ways to solve them 6
B.Ulziikhuyag — Security of Existence and patriotism 9
D.Ulambayar — Cold War in the World Socialist System: Triangle of Soviet, China and Mongolia 26
R.Nyamdavaa — Nuclear Weapon ban treaty, its scope and progress to enter into force 42
П.Цэдэв, С.Бямбасүрэн — Traditional and non-traditional threats as a subject of security studies 54

Defense Policy

D.Baasandamba — Some issues to promote organizational structure of military organizations 66
Kh.Orkhonchimeg — Training methodology of Defense education and some issues of it's intension 75
B.Baatarsuren — Military cooperation between the USA and Mongolia and it's prospect 83
B.Ochirsuren, E.Batgerel — Concept of infrastructure and defense infrastructure 90

Military art studies

Ts.Gandorj — Tendency of the EU's participation in peace support operations 97
T.Munkh-Orgil — UN peacekeeping operations and some emerging issues 103
S.Purevdorj — Some issues on psychology of a terrorist individual 117
D.Bolod — Some issues on training reform and research development of the University 131

Military History and Tradition

T.Sukhbaatar — Pavel Mikhailovich Tolpygin, the first director of People's Military Commander's School (1881-1937) 139
J.Bazarsuren — On methods and technologies of ancient and medieval Mongolians to develop metallurgy 144
T.Erdenekhishig — Ambush in Ma Yi 153
S.Ganbold, Ts.Byamba-Erdene — The battle of Janchkhuu 158
N.Narankhuu — Historical documents about Marshal G.Demid, Minister of Military Affairs and commander-in-chief of Armed Forces of People's Republic of Mongolia 166

РЕДАКЦИЙН ЗУРВАС

Хүндэт уншигчид аа, эрдэмтэн, судлаачид аа,

Та бүхэнд “Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал” сэтгүүлийн №30(40) дугаар хүрэх өдрийн мэндийг сэтгүүлийн редакцийн зөвлөлийн нэрийн өмнөөс хүргэе.

БХЭШХ-ээс хагас жил тутам эрхлэн гаргадаг “Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал” сэтгүүлийн энэ удаагийн дугаарыг ивээн тэтгэн бидний ажилд дэмжлэг үзүүлж буй Батлан хамгаалах яаманд талархал илэрхийлж байна.

“Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал” сэтгүүлийн энэ удаагийн дугаарт уламжлал ёсоор Аюулгүй байдал, Батлан хамгаалах бодлого, Цэргийн урлаг судлал, Зэвсэглэл, техник технологи, инноваци, Цэргийн түүх, уламжлал гэсэн булангуудад энэ чиглэлийн эрдэмтэн, судлаачдын туурвисан тулгамдаж буй асуудлууд, хөгжлийн чиг хандлагын талаарх өгүүллүүдийг багтаасан.

Цар тахлын энэ үед гэрээсээ ажиллах, судалгаа шинжилгээний ажлыг цахим орчинд үр дүнтэй явуулах зэрэг олон зүйлийг өдөр тутамдаа хэвшүүлэх шаардлагатай болгож байна. Манай эрдэмтэн, судлаачид энэ нөхцөл байдалд зохицон ажиллаж, үр бүтээлтэй байдалд анхаарч байгаа нь сайшаалтай байна.

Аюулгүй байдал, цэргийн ухааны чиглэлээр судалгаа хийж, бүтээл туурвидаг эрхэм судлаач, мэргэжилтэн та бүхэн сэтгүүлийн дараагийн дугаарт эрдэм шинжилгээний өгүүллийн нийтлэг шаардлагад нийцсэн бүтээлээ хэвлүүлэхээр редакцид илгээх боломжтойг энэ завшааныг тохиолдуулан мэдэгдье.

Номын цагаан буян дэлгэрэх болтугай.

Таныг хүндэтгэсэн,

Сэтгүүлийн эрхлэгч, БХЭШХ-ийн захирал, доктор (Ph.D),
профессор, хурандаа Б.Мөнхсайхан

Үндсэний аюулгүй байдлыг хангахад тулгамдаж Буй асуудал, шийдвэрлэх арга зам

О.Үржин
БХЭШХ-ийн Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалын
төвийн ЭША доктор(Sc.D), профессор
Х.Батбилэг
Докторант, бригадын генерал

Key words: development, dependence of development and security, sustainable development, education of sustainable development, risk, criteria of education

Abstract: This article discusses the challenges and solutions to ensure national security based on fundamental changes of Post-Cold War era security as well as in context of interdependence of development and security and the key concepts of sustainable development and sustainable development education which is main the way of its solutions.

Оршил. Өгүүлэлд хөгжил ба аюулгүй байдлын харилцан хамаарлыг нөхцөлдүүлж байгаа эрсдэлийг таван хэмжээсээр ойлгон үнэлж, түүнийг бууруулах менежментийг тогтвортой хөгжлийн стратегийн төлөвлөлтийн үндэс болгох, стратегийн төлөвлөлтөд явцын байнгын хяналт сайжруулалт болон субъектив хүчин зүйлсийн сөрөг нөлөөг бууруулах хэрэгцээ шаардлага үргэлж шаардагдах бөгөөд үндэсний аюулгүй байдлын болон түүнийг хангах системийн мөн чанарыг ойлгохгүй байх нь улс орныг сүйрэлд хүргэх аюул дагуулдгийг харуулсан. Мөн тогтвортой хөгжлийн боловсролын түвшнөөс үүдсэн, ялангуяа улс орны эрх баригчдын алдаа улс орны үндэсний аюулгүй байдалд тулгамдсан олон асуудлыг үүсгэдэг болохыг үзүүлсэн.

Энэ үндсэн дээр үндэсний аюулгүй байдлыг хангахад тулгамдсан асуудал, түүний гол шалтгаан, шалтгааныг бий болгоход нөлөөлсөн хүчин зүйлийг тогтвортой хөгжлийн боловсролын өнцгөөс тайлбарлаж, түүнийг арилгах арга замыг боловсролын шалгуур үзүүлэлттэй холбон шийдвэрлэхийг санал болгосон.

Үндсэн хэсэг.

Орчин үеийн олон улсын болон Монгол Улсын аюулгүй байдлын орчны өөрчлөлтийн эхлэлийг хүйтэн дайны төгсгөлтэй зайлшгүй холбон авч үзэж байж шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлэлт дүгнэлт хийх боломжтой юм.

Хүйтэн дайн төгссөнөөр аюулгүй байдал ба хөгжлийн үзэл баримтлалын хувьд дараах өөрчлөлтүүд гарсан. Үүнд: *нэгд*, зөвхөн уламжлалт цэрэг дайны аюулд төвлөрч байсан аюулгүй байдлын ойлголт уламжлалт бус аюулын ойлголт руу хандаж, улсын аюулгүй байдлаас хүний аюулгүй байдалд илүү анхаарал тавих болсон; *хоёрт*, уламжлалт бус аюулаас хамгаалах болон хүний аюулгүй байдлыг хангах үүднээс НҮБ-аас "эрсдэл дунд амьдарч сурах" уриалгыг дэвшүүлсэн; *гуравт*, НҮБ-аас "эрсдэл дунд амьдарч сурах" гол арга замыг улс орны тогтвортой хөгжлийг хангах, харин түүнийг хэрэгжүүлэх чухал арга механизм нь тогтвортой хөгжлийн боловсрол олгох явдал болохыг тодорхойлсон.

Аливаа асуудлыг шийдвэрлэхэд юуны өмнө тухайн асуудлын талаарх шинжлэх ухааны үндэслэлтэй ойлголтын суурь бааз харилцан ойлголцол, нэгдсэн бодлого, үйл ажиллагааг бий болгодгийг үндэслэн хөгжил ба аюулгүй байдлын хамаарлын дараах суурь ойлголтууд үндэсний аюулгүй байдлыг хангахад тулгамдаж буй асуудлын шалтгаан, шийдвэрлэх арга замыг зөв зааж өгөх болно. Үүнд:

Хөгжил ба аюулгүй байдлын хамаарал. Хөгжил болон аюулгүй байдал хоёр хоорондоо нягт холбоотой, салангид хэрэгжиж чадахгүй эздрээтэй диалектик шинжтэй, өөрийн мөн чанар агуулгаар үргэлж сөргөлдөх хандлагатай байх бөгөөд тэр хандлага нь эрсдэлээр дамжин илэрч байдаг.

ХӨГЖИЛ:	**АЮУЛГҮЙ БАЙДАЛ:**
Нийгмийн үйл ажиллагааны бүхий л хүрээнд байнгын өргөжилт, шинэчлэл, инновацийг шаардана.	Байгаа тогтвортой байдлыг хадгалж, аливаа төрлийн ялангуяа эрсдэлтэй шинэ санааныудыг хязгаарлахыг шаардана.
Тогтвортой хөгжил дэх хөгжил, аюулгүй байдал хоёрын хоорондын харилцан холбооны эздрээтэй диалектик шинжийг илэрхийлж буй ухагдахуун бол "эрсдэл"[1] юм. Эрсдэл нь мөн үндэсний аюулгүй байдлыг хангахад тулгамдаж буй асуудлын шалтгаан, шийдвэрлэх арга замыг тогтооход туслана.	

Иймд үндэсний аюулгүй байдлын хангахад тулгамдаж байгаа асуудлыг тодорхойлж, хөгжлийн төлөвлөлтөд тооцоход хамгийн эхлээд "эрсдэлийг ойлгох" шаардлагатайг эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх СЕНДАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ баримт бичигт улс орнууд орон нутгийн, үндэсний, бүс нутгийн болон салбар хоорондын үйл ажиллагааг *дөрвөн тэргүүлэх чиглэлд* хандуулах зайлшгүй нөхцлийн

[1] *Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Х-Я., ШУА., УБ., 2008, 3278 х., т.3211. Эрсдэл-эрсдэх цйлийн нэр, эрсдэл багатай-эрсдэх нь бага, эрсдэлтэй-эрсдэл ихтэй.*

нэгдүгээрт "*гамшгийн эрсдэлийг ойлгох*"[2]-ийг эрэмбэлсэн байгаагаас харж болно.Энэхүү баримт бичигт өгсөн ойлголтоос:"... эрсдэлийн менежментийн бодлого, үйл ажиллагаа нь *эрсдэлийг тууний бүх хэмжээс буюу эмзэг байдал, чадавх, хүн ам, эд хөрөнгийн өртөх байдал, аюулын шинж чанар болон хүрээлэн буй орчны хүрээнд* ойлгосон ойлголтод үндэслэх ёстой. *Ийм мэдлэгийг эрсдэлийн үнэлгээ хийх, урьдчилан сэргийлэх, аюулыг бууруулах, бэлэн байдлыг хангах, хор уршгийг цр дүнтэй арилгах зорилгод ашиглах боломжтой*" гэсэн эрсдэлийн талаарх танин мэдэхүйн нийтлэг ойлголт, түүний аюулгүй байдлыг хангахад гүйцэтгэх үүргийн ач холбогдлын үндэс тодорхойлогдож байна.

Энэ нийтлэг ойлголтын өнцгөөс хөгжил болон аюулгүй байдлын хамаарлын харилцан шүтэлцээ бүхий зүй тогтлыг олон талаас нь харж болно. Тухайлбал, манайд тулгамдсан асуудлын нэг болсон ядуурлаар жишээ авбал: *нэгд,* ядуурал бол нийгэмд заналхийлж буй объектив аюул занал мөн; *хоёрт,* ядуурал бол байгалийн аюулт үзэгдэл, халдварт өвчин, зохион байгуулалттай гэмт хэрэг зэрэг олон аюул заналд өртөх эмзэг нөхцөл байдлыг бий болгоно; *гуравт,* ядуурал өөрөө эдийн засгийн хямрал, засаглалын сул дорой байдал, ажилгүйдэл, төрийн өндөр албан тушаалтнуудын авлигад автагдсан зэрэг объектив, субъектив олон хүчин зүйлүүдийн үр дагавар байж болно.

Тогтвортой хөгжил.Тогтвортой хөгжлийн талаар нэгэн ижил утга агуулгыг илэрхийлсэн хэд хэдэн тодорхойлолт байна. Тухайлбал, *нэгд*, тогтвортой хөгжил нь байгаль, нийгмийн аль ч төвшний ямар ч төвөгтэй системийн хөгжлийг хангахдаа түүнийг аюулгүй байдлыг хадгалж, өнөөгийн болон хойч үеийнхээ "амьдралын чанар"-ыг хэвийн төвшинд байлгах үйл явц; *хоёрт*, тогтвортой хөгжил гэдэг нь ирээдүй хойч үеийнхээ хэрэгцээгээ хангах боломжийг алдагдуулахгүйгээр өнөөдрийн хэрэгцээг хангахыг хэлнэ"[3]; *гуравт*,... тухайн үеийнхээ эрэлт, хэрэгцээг хангахын дээр ирээдүйн залгамж үеийнхэнд эрэлт хэрэгцээгээ хангахад нь аливаа дарамт учруулахааргүй тийм хөгжлийг тогтвортой хөгжил гэнэ"[4].

Энэ системлэг ойлголтын хүрээнд дэлхийн хамтын нийгэмлэгээс хэрэгжүүлсэн аюулгүй байдал ба хөгжлийн харилцан уялдааны зохицуулалтыг нөхцөлдүүлсэн синергетикийн үйл явцын хоёр тодорхой баримтын жишээ бол *нэгд*, "эрсдэлгүй амьдрах" гэсэн бүтэшгүй оролдлогоос татгалзаж "эрсдэл дунд амьдарч сурах" асуудал дэвшигдэж, үр дүнд нь аюулгүй байдлыг хангах систем дэх эрсдэлийг ойлгох, эрсдэлийг бууруулах удирдлагын параметрийг өөрчлөх замаар тогтвортой хөгжлийг хангах хэрэгцээ, шаардлага бий болсон; *хоёрт*, аюулгүй байдлыг хангах системийн хүрээнд дэлхийн нийтээр хамтын хөгжлийн механизмыг бий болгох эхлэл тавигдаж, үр дүнд нь: Бразилын нийслэл Рио де Жанейро хотноо 1992 онд болсон "Хөгжил, хүрээлэн буй орчин" сэдэвт дэлхийн

---

2 Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх СЕНДАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ. УБ., 2016, 58 х., т.9, 14

3 Бидний хамтын ирээдүй, Хүрээлэн буй орчин ба Хөгжлийн даян дэлхийн коХ миссын тайлан, 1987.

4 Брутландын Комиссын 1987 оны тайлан.

бага хурлаар "Тогтвортой хөгжил" загварыг баталсан явдал юм. Энэ нь аюулгүй байдал ба хөгжлийн харилцан хамаарлын зохицуулалтыг эрсдэлийг бууруулах өнцгөөс харж боловсруулсан шийдэл юм.



Зураг. Тогтвортой хөгжлийн загвар

Тогтвортой хөгжлийн гурвалжин загвар нь аюулгүй байдлын үүднээс *нийгмийн хөгжил*, *эдийн засгийн хөгжил*, *экосистемийг хадгалах* гэсэн гурван асуудлыг нэг нь нөгөөгөө золиослохгүй байхаар харилцан хамааралд нь зохицуулах чухал шийдэл юм.

Өнөө үед НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 2015 оны 9 дүгээр сарын 25-27-нд болсон 70 дугаар чуулганд оролцсон 160 гаруй улсын Төр, засгийн тэргүүн, 30 гаруй улсын Гадаад хэргийн сайд нарын баталсан 2030 он хүртэл хэрэгжүүлэх "Тогтвортой хөгжил" хөтөлбөрийг улс орон бүр аюулгүй байдал – хөгжлийн асуудлаа цогцоор шийдэх механизм болгон ажиллаж байна. Энэхүү хөтөлбөр 17 зорилго, 169 зорилтыг дэвшүүлсэн бөгөөд 2017 оны 3 дугаар сард НҮБ-ын Статистикийн комиссын 48 дугаар чуулганаар тогтвортой хөгжлийн зорилтыг дүгнэх 244 шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байна. Манай улс "тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030" баримт бичгийг боловсруулан баталж, хэрэгжүүлж эхэлсэн боловч "Алсын хараа 2050"-ыг баталснаар хүчингүй болгоод байна.

Тогтвортой хөгжлийн боловсрол. Тогтвортой хөгжлийг нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн гурван талаас цогцоор авч үзэх соёлын цагаан толгойд сургах үүрэг боловсролд оногдсон. Боловсрол бол хүн төрөлхтний амьдарч байгаа ертөнцийг өөрчлөх, түүнд гарч буй өөрчлөлт, шинэчлэлд дасан зохицох талаарх хүч чармайлтын гол үндэс, тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх нийтлэг хандлагыг олж тогтоох гол түлхүүр нь болсон. Тиймээс ч НҮБ боловсролыг тогтвортой хөгжлийн үндэс гэдэгт суурилан 2005-2014 оныг Тогтвортой хөгжлийн боловсролын 10 жил болгон зарлаж, "Тогтвортой хөгжлийн боловсролын 10 жил" баримт бичгийг боловсруулан хэрэгжүүлсэн. Энэхүү баримт бичигт "*Тогтвортой хөгжлийн боловсрол нь хүн бүрт өнөөгийн болон хойч үеийнхээ төлөө соёлын ялгаатай байдлыг хүндэтгэн, байгаль орчин, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, нийгмийн шударга ёсыг хангаж, эдийн засгийн хувьд амьдрах чадвартай байж, мэдлэг мэдээлэлтэйгээр шийдвэр гаргах эрх мэдэл олгож буй явдал юм*"[5]гэж тодорхойлсон байдаг.

[5] *UNESCO, Shaping the future We want: Decade of Education for Sustainable Development (2005-2014), DESD Monitoring and Evaluation Final Report, Paris, 2014, pp.20.*

Өнөөгийн харилцан холбоотой, харилцан хамааралтай болж байгаа дэлхий дээр гарч буй өөрчлөлтүүд нь нарийн төвөгтэй байдлыг гүнзгийрүүлж, зөрчил, ёс бус үзэгдэл, цоо шинэ мэдлэг бий болгож байна. Иймд тогтвортой хөгжлийн боловсрол улс орны хувьд өнгөрсөн болон өнөөгийн байдлаа үнэлсэн, ирээдүйгээ үнэн зөв төсөөлсөн урьдчилсан үнэлгээн дээр тулгуурлан аюулгүй байдал, хөгжлийн стратегээ төлөвлөн хэрэгжүүлэх мэдлэг, түүнийг эзэмшсэн байхтай холбоотой асуудал юм.

БОЛОВСРОЛ	**МЭДЛЭГ**
Боловсрол – урдаас бодож төлөвлөсөн, чиг зорилготой, зохион байгуулалттай суралцах үйл ажиллагаа.	Мэдлэг – суралцах үйл ажиллагаагаар дамжуулан олж авсан мэдээлэл, ойлголт, ур чадвар, үнэт зүйлсийн баримжаа, зан үйл.
Бертран Рассел Афинчуудын танин мэдэхүйн онолыг шинжилснийхээ дүнд “мэдлэг гэдэг бол нотолгоогоор баталгаажсан үнэн бодомж мөн. Нотолгоо байхгүй цагт мэдлэг байхгүй” гэсэнтэй маргах шаардлагагүйг эрдэмтэд онцолсон байдаг.[6]	

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Даяаршил улс үндэстний бусдаас хамаарах эмзэг байдлыг нэмэгдүүлж, нөгөө талаас гадаад нөөц боломжийг ашиглан үндэсний ашиг сонирхлоо бататгах боломж олгож байна.” гэсэн нь *нэг талаас* даяаршлын эрсдэлийг танин мэдэх, *нөгөө талаас* энэ мэдлэг дээрээ тулгуурлан эрсдэлийг тооцох замаар үндэсний аюулгүй байдлаа бэхжүүлэх боломж буйг харуулж байна.

Энэ үүднээс тогтвортой боловсролын хүрээнд үндэсний аюулгүй байдлыг хангах зарчмаас хоёр зарчимд онцгой анхаарал хандуулах нь зүйтэй юм: *нэгд*, мэдлэгт суурилах: “Аюулгүй байдалд хандах хандлага, түүнийг хангах үйл ажиллагаа нь мэдлэг, мэдээлэл, дүн шинжилгээнд суурилна.”; *хоёрт*, бодитой хандах: “Болзошгүй аюул, сорилтыг бодитой тодорхойлж, тэдгээрийг гэтлэн даваха хязгаарлагдмал нөөц, боломжийг ур дүнтэй дайчилна” гэсэн зарчмууд юм. Эдгээр зарчим тогтвортой хөгжлийн боловсролоос олж авсан мэдлэгийн ур дүнд хэрэгжих болно.

Үндэсний аюулгүй байдлын ба түүнийг хангах үйл ажиллагааны систем нь өргөн хүрээтэй мэдлэг, мэдээлэл шаардсан, түүнд хандах мэдлэггүй байдал улс орныг сүйрэлд хүргэж болох нарийн төвөгтэй систем юм. Системийг дараах ерөнхий бичлэгээр илэрхийлж болно.

Үндэсний аюулгүй байдлын систем:

$$\sum S_{yab} : \left\{ \{S_d\}, \{S_g\} \right\}, \qquad (1)$$

Энд,

- $\sum S_{yab}$ – Үндэсний аюулгүй байдлын систем;

[6] *Монголын нийгмийн өөрчлөлт. Монгол Улсын шинжлэх ухааны академи философи, социологи, эрхийн хүрээлэн. УБ., 2013, 499 х., т.9*

- $\{S_d\}$ – Дотоод аюулгүй байдлын систем/үндэсний аюулгүй байдлын системийн дэд систем/;
- $\{S_g\}$ – Гадаад аюулгүй байдлын систем /үндэсний аюулгүй байдлын системийн дэд систем/;
- $\{\{S_d\},\{S_g\}\}$– Дотоод болон гадаад аюулгүй байдлын системүүд, тэдгээрийн хоорондын хамаарлыг тооцсон үр дүнгийн төлөв байдлын цогц.
- Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны систем:
- $\sum S_{үабх}: F\left(\{\{X_{S_d}\},\{X_{S_g}\},\{X_{S_d\,,S_g}\}\}\right)$, (2)
- Энд,
- $\sum S_{үабх}$ – Үндэсний аюулгүй байдлыг хангах систем;
- $\{X_{S_d}\}$ – Дотоод аюулгүй байдлыг хангах системийг бүрдүүлэгч элементүүдийн харилцан хамаарлын цогц;
- $\{X_{S_g}\}$ – Гадаад аюулгүй байдлыг хангах системийг бүрдүүлэгч элементүүдийн харилцан хамаарлын цогц;
- $\{X_{S_d\,,S_g}\}$ – Дотоод, гадаад аюулгүй байдлыг хангах системүүдийн хоорондын харилцан хамаарлын цогц;

$F\left(\{\{X_{S_d}\},\{X_{S_g}\},\{X_{S_d\,,S_g}\}\}\right)$ – Үндэсний аюулгүй байдлыг хангах системийн дотоод ба гадаад аюулгүй байдлыг хангах системийн элементүүд хоорондын болон хоёр системийн хоорондын харилцан хамаарлыг тооцох үйл ажиллагааны үр дүн.


Үндэсний аюулгүй байдлын хангах системийн үйл ажиллагааны үр дүн үндэсний аюулгүй байдлыг хангах системийн танин мэдэхүйн, өөрөөр хэлбэл системийн үр дүнгийн функц $F(\{X_s\})$-ийг хангах онол, арга зүй болон тэдгээрийн практик хэрэгжилтээс хамаарах зүй тогтолтой байна.

Үндэсний аюулгүй байдлыг хангах танин мэдэхүйд гаргасан алдаа юунд хүргэдгийг ЗХУ-ын өөрийгөө сүйрүүлсэн үндсэн шалтгаануудын сургамжаас харж болох юм. Анхдагч үндсэн хоёр шалтгаан нь: *нэгд*, аюулгүй байдлыг хангах системийг байгуулагчдын мэдлэггүй байдал. *хоёрт*, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны системийн зарчмууд болон системийн зүй тогтлуудыг үл ойшоосон байдал байсан гэж судлаачид үзсэн байдаг юм.[7]Ийм сургамжийн үйл явцын зураглалыг зураг дээр үзүүллээ.

Ийм гашуун сургамж давтагдахаас зайлсхийн тогтвортой хөгжих арга замын талаар ОХУ-ын Төрийн Думын дарга С.Е. Нарышкин: "*Өнөөдөр геополитикийн шинж чанартай мэргэжлийн бөгөөд бариmтад*

[7] *Гагаринов А. В., Кобзев П. М., Котляр А. А. Энтропогенная системная катастрофа XX века: сущность, причины, последствия. Экономика: экономичная теория бизнес информ. №5, 2015, www.business-inform.ne*

үндэслэгдсэн урьдчилсан үнэлгээ маш тулгамдаж, шаардагдаж байна. Аливаа нөхцөл байдал ямар чиглэлд, ямар динамикаар өөрчлөгдөж болохыг урьдчилан ойлгосноор олон сорилтоос өрсөж, түүнчлэн стратегийн төлөвлөлтөд, мөн хууль гаргах хүрээнд алдаа, хийдэл гаргахаас зайлсхийж болно"[8] гэж онцолсон байдаг.




Энэ арга замын шийдлийн үйл явцыг дараах хоёр арга зүйн бүдүүвчээс харж болно.


Эхний арга зүйн бүдүүвч нь улс орны тогтвортой хөгжлийн асуудал нь өнгөрсөн үеийн туршлага, сургамж болон өнөөгийн байдлын шинжилгээн дээр тулгуурлан болзошгүй эрсдэлийг тооцсон ирээдүйн хөгжлийн

[8] *Военно-политические аспекты прогнозирования мирового развития: аналитич. доклад / А. И. Подберезкин, Р. Ш. Султанов, М. В. Харкевич [и др.]; Моск. гос. ин-т междунар. отношений (ун-т) МИД России, Центр военно-политических исследований. — М.: МГИМО–Университет, 2014. С. 3.п/*

стратегийг тодорхойлж, түүний хэрэгжилтийн явцын үнэлгээг тогтмол хийж, стратегийн төлөвлөлтөө тодотгож байх тасралтгүй үйл явц болохыг үзүүлж байна.

Хоёр дахь бүдүүвчийн хувьд үндэсний үнэт зүйлс ба ашиг сонирхлын си стем нь гадны нөлөөллийн хүчин зүйлс болон үндэсний нөөц, боломжтой шууд харилцан хамааралтай байна.





Тэдгээрийн хоорондын хамаарлын *төвд улс орны эрх баригчдын үнэлгээ, ойлголт дээр тулгуурлан гаргах шийдвэрийн зангилгаа* оршиж байна.

Иймд бодлогын гол зорилго, үндсэн үүргийг тодорхойлох ба үндэсний нөөц, боломжийг хуваарилах хоёр бүлэг асуудлыг эрх баригчид шийдвэрлэх учраас тэдгээрийн үндсийг бүрдүүлэгч үндэсний үнэт зүйлс ба эрх ашгийн систем бүрэн объектив шинжтэй ч субъектив нөлөөлөлд ноцтой өртдөг байна. Өөрөөр хэлбэл, эрх баригчдын зүгээс тэдгээрийг дутуу үнэлэх эсвэл тэдний мэдлэг, мэдээлэлтэйгээр шийдвэр гаргах эрхийг боловсролоор олж авч чадаагүй байдал нь чиглэсэн зорилгыг болон үндэсний нөөцийн ашиглалтын бүтээмж ба хөгжлийг гажуудуулах, үндэсний аюулгүй байдалд сүйрэл авчрах хүнд үр дагаварт хүргэж болно. Мэдээжээр энэ нь үндэсний аюулгүй байдлыг хангахад олон тулгамдсан асуудлыг бий болгоно.

Үндэсний аюулгүй байдлын гадаад аюулгүй байдлыг хангах дэд системийн хувьд манай улс геополитик, гадаад зах зээлээ тэлэх агуулгаар их гүрнүүдийн бодлогыг анхааралтай ажиглаж, түүнд нийцүүлэн шуурхай хариу үзүүлэх стратеги болон үндэсний аюулгүй байдлын ба гадаад бодлогын үзэл баримтлалд заасан даяаршлын хүчин зүйлийг харгалзах, мэдлэгт суурилах, бодитой хандах зэрэг зарчмыг баримтлан тулгамдан гарч ирсэн асуудлыг хоёр хөрш болон "гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд зохицуулах боломжтой юм. Гагцхүү ийм боломжийг хэрхэн ашиглах нь улс орны эрх баригчдын үнэлгээ ба ойлголтоос, өөрөөр хэлбэл субъектив хүчин зүйлсээс ихээхэн хамааралтайг дээр тайлбарласан билээ.

Харин дотоод аюулгүй байдлын хангалтаас үүдсэн үндэсний аюулгүй байдлын тулгамдаж буй асуудал, шалтгааныг тэдгээрийн субъектив эх үүсвэр талаас нь тогтвортой хөгжлийн боловсролын агуулга "*хүн бүрт өнөөгийн болон хойч үеийнхээ төлөө соёлын ялгаатай байдлыг хүндэтгэн, байгаль орчин, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, нийгмийн шударга ёсыг хангаж, эдийн засгийн хувьд амьдрах чадвартай байж, мэдлэг мэдээлэлтэйгээр шийдвэр гаргах эрх мэдэл олгож буй явдал*"-*тай холбон* дараах логик гаргалгаагаар илэрхийлж болно.

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого /2014-2024/ -д "*Боловсрол нь иргэн бүрийн насан туршийн амьдралын чанарыг дэмжин баталгаажуулах, улс орны нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан технологийн хөгжлийн тулхүүр хүчин зүйл, үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгаа хэмээн үзэж, Монгол Улсын төрөөс боловсролыг нийгмийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.*" гэж заасан байдаг. Боловсролыг тэргүүлэх салбар болгон хөгжүүлэхийн учир холбогдол нь түүнийг "*... улс орны нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан технологийн хөгжлийн тулхүүр хүчин зүйл, үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгаа...*" болгоход оршиж буй нь харагдаж байгаа бөгөөд НҮБ-аас тодорхойлсон тогтвортой хөгжлийн боловсролын эцсийн хүлээгдэж буй үр дүнг илэрхийлж байна.

Ер нь бид манай улсын тогтвортой хөгжлийн боловсролын үр дүнг "*боловсрол хөгжлийн тулхүүр болж чадаж байна уу?*", "*боловсрол үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгаа болж чадаж байна уу?*" гэсэн асуултад хариулт өгөх олон шалгууруар хэмжиж, үндэсний

аюулгүй байдлыг хангахад тулгамдсан асуудлыг тодорхойлох боломжтой юм. Тухайлбал, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын зөвхөн хоёр заалтыг авч үзэхэд *Монгол Улсын иргэн: монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа болсон үндэсний тууx, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлж чадаж байна уу?, үндэсний үнэт зүйлээрээ бахархагч, тэдгээрийг хайрлан хамгаалагч, тээн хөгжүүлэгч байж чадаж байна уу?, улс, үндэстнийхээ ирээдүйн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулах идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна уу?* зэрэг асуултад дотоод орчны бодит байдал шалгуур нь болж, шалтгаан нь тогтвортой хөгжлийн боловсролтой холбосон логик гаргалгаагаар тогтоогдох болно.

Нарийн судалгаа шаардагдахгүй, ард түмний амьдрал дээр тодорхой мэдрэгдэж байгаа аюулгүй байдлын дотоод орчны бодит байдлаас дараах тулгамдсан асуудлуудыг харж болно. Үүнд: Монгол Улсын байгаль орчны бохирдол, доройтол улам нэмэгдэж, байгалийн нөөцийн зохисгүй ашиглалт ихсэж байгалийн онгон дагшин байдлыг алдагдуулсан, хувиараа хөдөлмөр эрхлэх орчин муу, эдийн засаг олон тулгууртай болоогүй, бүсчилсэн хөгжил байхгүй, хот хөдөөгийн ялгаа ихсэж, хязгаар нутаг болон хөдөө эзгүйрч хүн ам нь нийслэл хотод төвлөрсөн, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвар болон дэд бүтцийн хөгжил сул, ажилгүйдэл, ядуурал өсөж, баян хоосны ялгаа нэмэгдсэн, гэмт хэрэг, хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээ нэмэгдэх хандлагатай болсон, хүнсний аюулгүй байдлын бие даасан байдал алдагдсан, нөөц баялгийн үр ашиггүй үрэлгэн хэрэглээ, техник технологийн хоцрогдол нэмэгдсээр байна. Түүнчлэн хүн амын өвчлөл, нас баралт өндөр байна.

Яагаад гэдгийн учир шалтгаан төрийн бодлогын залгамж чанар алдагдсан, засаглалын сул дорой байдал гадаадын хөрөнгө оруулалтыг цргээсэн, намчирхаж улс төржсөн байдал бодлогын тогтворгүй байдлыг бий болгосон, төрийн албаны мерит зарчим алдагдаж хүнд суртал, авлига газар авсан, соёлын үнэт зүйлсийн нөлөө алдагдсан, хууль шүүх болон хяналтын байгууллагын нэр хүнд унасан зэрэг олон хүчин зүйлээс хамаарч байна.

Ийм шалтгаанд хүргэсэн субъектив хүчин зүйлсийн үндэс суурийг *нэгд*, тогтвортой хөгжлийн боловсролын үр дүн талаасаа шаардлага хангахгүй хүмүүс; *хоёрт*, эдгээр хүмүүсийн оролцоо бүхий байгууллага, нам эвсэл, бизнес бүлгийн үндэсний аюулгүй байдалд харш ажиллагааны сүлжээ бүрдүүлж байна.

Нэгд. Тогтвортой хөгжлийн боловсролын үр дүн талаасаа шаардлага хангахгүй хүмүүсийг авч үзвэл:

1. Эрх барих байгууллагад болон төрийн албанд тухайн ажлын ажлын байрны шаардлага хангахгүй дараах шинж чанар бүхий хүмүүс цөөнгүй байна:

- боловсролын хувьд тухайн албанд тэнцэх мэдлэг, мэдээлэлтэйгээр шийдвэр гаргах эрх олж авч чадаагүй хүмүүс;

- нийгмийн шударга ёсыг сахих чадваргүй ёс зүйн доголдолтой өнөө ба хойч үеийнхээ төлөө бус дараагийн сонгуулийн төлөө ажилладаг хүмүүс;
- бурууг мэдэвч засах аргыг олдоггүй бусдыг дагалдагч хүмүүс; зааг ялгааг нь олохоо больсон хүмүүс.

2. Нийгэмд эх оронч үндэсний үзлээ гээсэн зөвхөн ашиг хонжоог эрхэмлэсэн хүмүүс байна:

- зориуд санаатайгаар, зорилго чиглэлтэйгээр улс орноо худалдахад бэлэн хэсэг бүлэг;
- эмх замбараагүй байдлыг ашиглан ашиг олохыг эрмэлзсэн хэсэг бүлэг.

Хоёрт. Байгууллага, нам эвсэл, бизнес бүлгийн үндэсний аюулгүй байдалд харш ажиллагааны сүлжээг судлаачид дараах байдлаар тодорхойлсон байна:

- *Хууль тогтоох байгууллага*: Авлигад "ээлтэй" бодлого, хууль эрх зүйн орчин "бүрдүүлэх", халдашгүй байдал гэх мэт "хамгаалалтын" нөхцөл бий болгох зэргээр үйлчилдэг;
- *Гүйцэтгэх байгууллага*: Хуулийн хэрэгжилтийг гажуудуулан завхруулах, хууль бус давуу байдал олгох зэргээр үйлчилдэг;
- *Шүүх байгууллага*: Хуулийн өмнө тэгш байх зарчим, шударга ёсыг алдагдуулж, "дуулгаваргүй"-г номхотгох, "халдашгүй"-г хамгаалах зэргээр үйлчилдэг;
- *Улс төрийн нам*: Сонгуулийн дэмжлэгийн хариу барих, бодлого боловсруулах, томилгоо зэрэгт "эргэдэг хаалга"-ны зарчмаар үйлчилдэг;
- *Бизнесийн бүлэглэл*: Улс төртэй хутгалдах замаар олигарх бүлэглэл үүсгэх, улс орны эрх ашиг, аюулгүй байдлыг хохироосон бизнес төслийг хэрэгжүүлж, том хөрөнгө оруулалтыг хяналтдаа авах, байлгах зэргээр үйлчилдэг;
- *Хэвлэл мэдээлэл*: Олон нийтийн "тархи угаалт"-ыг явуулж, "Хаалтын гэрээ" байгуулах зэргээр авлигачдыг хаацайлах үйлчилгээ үзүүлдэг харилцан уялдаа бүхий тогтолцоог бүрдүүлсэн байна.

Дээр тодорхойлсон тулгамдсан асуудал, тэдгээрийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлстэй тэмцэхэд учрах саад бэрхшээл нь өнөөгийн хамгийн том сорилтыг бий болгож байна. Дараах арга замыг санал болгож байна. Үүнд: *нэгд*, тогтвортой хөгжлийн боловсрол олгох тогтолцооны шинэчлэлийг боловсролын салбарт хэрэгжүүлэх; *хоёрт*, бүхий л түвшний ажлын байранд боловсролоор тухайн ажлын байрандаа мэдлэг, мэдээлэлтэйгээр шийдвэр гаргах эрх олж авсан хүмүүсийг ажиллуулах мерит зарчмыг мөрдөх; *гуравт*, улс их хурлын гишүүн болон хариуцлагатай албанд тогтвортой хөгжлийн боловсролын үүднээс шалгуур тогтоох; *дөрөвт*, үндэсний аюулгүй байдлыг хангах удирдлага, зохицуулалтыг системийн

хандлагаар авч үзэж, системийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нэгдмэл чанар (α) ба бие даасан байдал (β) хоёрын хоорондын зохистой харьцааг системийн гол хууль $(\alpha + \beta = 1)$–ийн дагуу тогтоох замаар шийдвэрлэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх. Чингэхдээ үндэсний аюулгүй байдлыг хангах системийн бүрэлдэхүүн хэсгүүдийн ихээхэн нэгдмэл чанарыг хангахыг эрмэлзсэн туйлширсан оролдлогын үед систем бүрэлдэхүүн хэсгүүдийн шинжийг дарангуйлж, тэдний зарим чухал шинжийг үгүй хийх, эсрэгээрээ тэдэнд ихээхэн бие даасан байдал олгох тохиолдолд зөрчил, сөргөлдөөн бий болох ба системийн нэгдсэн шинж илрэхгүй өөрөөр хэлбэл, үндэсний аюулгүй байдлыг хангах нэгдмэл удирдлага, зохицуулалт алдагддаг болохыг анхаарах; *тавд*, аюулгүй байдлын орчны үнэлгээг ажлын хэсэг байгуулах замаар, эсвэл төслийн ажлын хүрээнд гүйцэтгэх бус тодорхой үечлэлтэйгээр тогтмол хийж, тодотгох үүрэг бүхий аюулгүй байдлын судалгааны нэгжтэй болох; *зургаад*, "субординацийн хууль"-ийн дагуу аливаа салбарын бодлого үндэсний аюулгүй байдлыг хангах системийн эрх ашигтай нийцэж байх нь дараах харилцан уялдаа бүхий дөрвөн тулгуур баримт бичгийн агуулга дээр үндэслэн боловсруулагдсанаар илэрдэг зүй тогтлыг ажил хэрэг болгох: *нэгдүгээрт*, Үндсэн хуулийн заалтад нийцэж байх; *хоёрдугаарт*, Үндсэн хуулийн заалтуудын утга агуулгад тулгуурлан боловсруулагдсан "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын холбогдох заалтуудтай нийцэж байх; *гуравдугаарт*, Үндсэн хууль болон Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын заалтуудын утга агуулгад тулгуурлан боловсруулагдсан "Гадаад бодлогын үзэл баримтлал"-ын холбогдох заалтуудтай нийцэж байх; *дөрөвдүгээрт*, эдгээр гурван баримт бичгийн утга агуулгад тулгуурлан боловсруулагдсан "Батлан хамгаалах бодлогын үндэс"-ийн холбогдох заалтуудтай нийцэж байх явдал юм.

Дүгнэлт. Манай улсын дотоод аюулгүй байдал хамгийн анхаарал татсан асуудал болоод байна. Засаглалын сул дорой байдал, өөрөөр хэлбэл субъектив хүчин зүйлсийн нөлөөгөөр ийм нөхцөл бий болж байна. Тогтвортой хөгжил, тогтвортой хөгжлийн боловсрол болон тэдгээрийг хэрэгжүүлэх арга механизмыг ойлгохгүй байгаа явдал нь аюулгүй байдал, түүнд хандах системийн хандлагад сөргөөр нөлөөлж байна. Үүнийг засах залруулахад тулгарч буй асуудлууд өнөөгийн хамгийн том сорилт болж байна.

Эшлэл авсан ашигласан материалын жагсаалт:

1. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Х-Я., ШУА., УБ., 2008, 3278 х., т.3211.
2. Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх сендайн үйл ажиллагааны хүрээ. УБ., 2016, 58 х.
3. Бидний хамтын ирээдүй, Хүрээлэн буй орчин ба Хөгжлийн даян дэлхийн комиссын тайлан, 1987.
4. Брутландын Комиссын 1987 оны тайлан.

5. UNESCO, Shaping the future We want: Decade of Education for Sustainable Development (2005-2014), DESD Monitoring and Evaluation Final Report, Paris, 2014.
6. Монголын нийгмийн өөрчлөлт. Монгол Улсын шинжлэх ухааны академи философи, социологи, эрхийн хүрээлэн. УБ., 2013, 499 х.
7. Гагаринов А. В., Кобзев П. М., Котляр А. А. Энтропогенная системная катастрофа XX века: сущность, причины, последствия. Экономика: экономичная теория бизнес информ. №5, 2015, www.business-inform.ne
8. Военно-политические аспекты прогнозирования мирового развития: аналитич. доклад / А. И. Подберезкин, Р. Ш. Султанов, М. В. Харкевич [и др.]; Моск. гос. ин-т междунар. отношений (ун-т) МИД России, Центр военно-политических исследований. — М.: МГИМО−Университет, 2014. С. 3.п/

ОРШИН ТОГТНОХУЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ЭХ ОРОНЧ ҮЗЭЛ

Б.Өлзийхуяг
ҮБХИС-ийн Эрдэм шинжилгээ, нийгмийн түншлэл хариуцсан дэд захирал, доктор(Sc.D), профессор, хурандаа

***Key words**: security, existence, civic ability, defense ethos, patriotism, realism and idealism, upbringing, morality*

***Abstract:** The development of a citizen with a purposeful goal, good morals, and the ability to protect himself and others from any danger is a very important goal of society. This article summarizes the results of a comparative analysis of the historical traditions and philosophical realist and idealist theories that our ancestors instilled in the minds of the people, and the study of the origins of defense and patriotism.*

Удиртгал

Монгол Улсын иргэн бүр төр улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, хүн ам удмын сан, соёл иргэншлийн аюулгүй байдлыг бататган бэхжүүлэх, эх орноо хамгаалах хуулиар хүлээсэн үүрэгтэй. Иргэд, нэн ялангуяа хүүхэд залуучуудад энэ үүргийг нь ухааруулан ойлгуулж; эх орон, тусгаар тогтнол, эх хэл, үндэсний түүх, соёлоороо бахархах; дээдлэн хүндэтгэж үе дамжуулан үлдээх; газар нутаг, байгаль орчноо хайрлах сэтгэлийг төрүүлэх; иргэдийн ажиллаж, амьдрах таатай орчин нөхцлийг бүрдүүлэх замаар улс орныхоо тогтвортой хөгжлийг хангаж, тусгаар тогтнолынхоо баталгааг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага урган гарч байна.

Үүний тулд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны *“Эх оронч үндэсний үзлийг дээдлэх”, “Мэдлэгт суурилах”* гэсэн зарчмууд болон “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгийн 5.3-т *“бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзэл, хүмүүжил олгох хичээлийн хөтөлбөрийг тусгаж, хэрэгжүүлнэ”*, “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр (2019)-т тусгагдсан *“Монгол Улсын язгуур эрх ашгийг бодлогын бүх түвшинд эн тэргүүнд тавих, монгол хүний хөгжил, эх оронч ухамсар, хандлага, монгол ахуй, өв соёл, зан заншлыг сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх”*

гэсэн зааltууд, тэдгээрийг хэрэгжүүлэх онол, арга зүйн үндэслэлийг боловсруулах нь чухал юм.

Эдүгээ дэлхийн хүн ам ихэд залуужин хүн ба нийгмийн харилцаа, хамаарал улам нарийн төвөгтэй болж байна. Шинжлэх ухаан, технологийн хөгжлийн нөлөөгөөр нийгмийн амьдралын бүх салбарт "хүний хүчин зүйл"-ийн үүрэг улам өсч байна. Үүний зэрэгцээ нийгэмд ардчиллын хэм хэмжээ, соёлжсон хүмүүнлэг харилцаа, хүний эрх, эрх чөлөө, нэр хүндийг эрхэмлэх хандлага давамгайлах болсон нь хувь хүнд өөрийгөө илэрхийлж, авьяас чадвар, эрдэм боловсролоор нийгэмд байр суурия олох таатай нөхцөл, боломжийг бүрдүүлэв. Нөгөө талаас, дэлхийн хүн төрөлхтөн өнөө үед төрөл бүрийн зөрчил мөргөлдөөн, гамшиг, оношлогдох, эмчлэгдэх арга ухаан нь нээгдээгүй нийтийг хамарсан цар тахал зэргийн аюул эрсдэлийн нөлөөн дор аж төрөх болсон.

Ийм цаг үед чиглэсэн зорилготой, ёс суртахуунтай, аливаа эрсдэл аюулаас өөрийгөө болон бусдыг хамгаалах чадвартай иргэнийг төлөвшүүлэх нь нийгмийн нэн чухал зорилт болж байна. Тиймээс ч иргэнд мэдлэг боловсролыг амьдрах арга ухаан, ёс суртахууны хүмүүжил төлөвшлийн хамт цогцоор олгох нь олон улсын боловсролын хөгжлийн тэргүүлэх чиг хандлага болжээ.

Оршин тогтнохуй ба иргэний чадвар

Улс орны оршин тогтнохын үндэс амин чухал дархлаа нь тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал; хил хязгаар, нутаг дэвсгэрийн халдашгүй, бүрэн бүтэн байдал; соёл иргэншлийн болон хүн ам удмын сангийн аюулгүй байдлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх явдал юм.

Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хангах үндсэн арга болох улс төр, дипломатын үйл ажиллагааг үндэсний эрх ашиг, харилцааны түүхэн уламжлалд тулгуурлахын зэрэгцээ даян дэлхийн тогтвортой хөгжлийн онол, парадигмд үндэслэх шаардлага бий болсон. "Мэдлэгийн эдийн засаг", "зөөлөн хүч", "хиймэл оюун", "мэдлэгийн менежмент", "мэдлэгт суурилсан хөгжил", "хүний төлөө инноваци" зэрэг шинэ ойлголт, категориуд маш эрчимтэй орж ирлээ. Эдгээр нь чухамдаа тогтвортой хөгжлийн бодлого, зорилтыг хэрэгжүүлэхэд шинжлэх ухаан, технологийн болон боловсролын хүчин зүйлсийн үүрэг роль улам бүр өссөөр буйн илэрхийлэл юм[9].

Хүний хүчин зүйлийн үүрэг өсөн нэмэгдэх нь улс орны аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах үйл хэрэгт бүр ч илүүтэй иларч буй билээ. Батлан хамгаалах бодлогын нийгмийн чиглэлийн үндэс нь Монгол Улсын хүний хөгжил учир манай улсын хувьд хүн амын эрүүл мэнд, боловсрол, сэтгэл зүй, бие бялдрын хүмүүжлийг дээшлүүлэх, нийт иргэд, залуучуудыг эх оронч үзлээр хүмүүжүүлэх, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх (Б.Ө) нь улс орноо батлан хамгаалах төрийн бодлогын салшгүй бүрэлдэхүүн хэсэг мөн[10].–

[9] *Монгол Улсын ШУА-ийн 2019 оны 12-р сарын Их чуулганы илтгэл*

[10] *Дашзэвэг Ц. Батлан хамгаалах бодлого, зэвсэгт хүчний байгуулалт, удирдлагын*

Батлан хамгаалах бодлогын нийгмийн чиглэлд “бүс нутгийг хөгжүүлэх, хүн амын амьдрах нөхцөл, суурьшлын бүс, дэд бүтэц бий болгох, боловсрол, соёл, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах эдийн засаг, нийгмийн цогц бодлогыг хэрэгжүүлэх”, “эх орноо батлан хамгаалах үйл хэрэгт иргэн бүрийн оролцоог хангаж, цэргийн алба хаах тогтолцоог боловсронгуй болгоно”[11] гэсэн төрийн бодлогын чиглэлийг суулгасан нь түүнийг хэрэгжүүлэх арга зүйн үндсийг боловсруулж, туршин хөгжүүлэхийг судлаачдаас зүй ёсоор шаардаж байгаа юм.

Байгаль, нийгэмд болж буй хурдтай өөрчлөлтүүдтэй холбоотойгоор гадаадын орнуудын боловсролын нэр томьёонд *“XXI зууны чадварууд”* гэх ойлголт шинээр гарч, бодлого боловсруулагч, боловсрол судлаачдын дунд дэмжсэн, эргэлзсэн маргаан мэтгэлцээн, хэлэлцүүлэг ихээхэн өрнөж байна[12].

Эдгээр чадварууд нь а) өөрчлөлтийг соргог мэдэрч, шийдвэр гаргах (өөрчлөлтөөс үүдэн гарч болох сөрөг үр дагаврыг сааруулахад чиглэсэн оновчтой шийдвэрийг хурдан гаргах, гаргасан шийдвэрийнхээ хариуцлагыг хүлээх); б) ур чадвар, авъяасаа хөгжүүлэх (бид ямар нэг зүйлийг хийж, бүтээхэд суралцдаг); в) хандлагаа өөрчилж (бид ямар нэгэн зүйлд хандах арга барил болон оюун санааны байр сууриа өөрчлөхөд суралцах), хувь хүний хувьд төлөвших; г) хамтран ажиллаж (бид хамтдаа ямар нэгэн үр дүнд хүрэхэд суралцах), эрсдэл аюулаас өөрийгөө болон бусдыг хамгаалах гэсэн 4 бүлэгт багцлагдаж болохоор байгаа юм.

Нөгөө талаас, олон мянган жил зэрэгцэн амьдарч байгаа ОХУ, БНХАУ болон бусад үндэстнүүдийн цэрэг, улс төр, шинжлэх ухаан, боловсрол, соёлын бодлогын өөрчлөлт шинэчлэл нь цөөн тоот монголчууд бидэнд цаашид үндэстний хувьд тэдэнтэй мөр зэрэгцэн одоогийн байдлаараа оршин тогтнохын тулд тэдгээрийн зүй тогтлыг заавал харьцуулан судлах, оновчтой хувилбарыг тогтоох хэрэгцээ бий болсон.

Эдгээр улс орнууд оршин тогтнохуйн аюулгүй байдлаа бэхжүүлж иргэд, хүүхэд залуучууддаа эх оронч үзэл, хүмүүжил төлөвшүүлэх талаар өөр өөрийн хууль эрх зүй, тусгайлсан хөтөлбөр, үзэл номлолын хүрээнд шинэчлэн хэрэгжүүлсээр байна. Тухайлбал, 2020 оноос боловсруулж эхэлсэн ОХУ-ын иргэдийн эх оронч хүмүүжлийн шинэ хөтөлбөрийн агуулгад оросын ард түмний уламжлалт үнэт зүйлсийг өнөөгийн нийгмийн амьдралын суурь үнэт зүйлстэй[13] холбож үзэх талаар заалт оруулж хүмүүжлийн ажлын арга зүй, хандлагаа өөрчилж байна.

БНХАУ-ын батлан хамгаалах боловсролын агуулгад “Эх оронч үзэл бол батлан хамгаалах боловсролын гол чухал үндэс болно. Улс орон, нэг үндэстэн оршин тогтноход батлан хамгаалах үзэл санаа чухал бөгөөд бүх улсын ард иргэдийг нэгтгэх явдал бол батлан хамгаалах мэдлэг,

шинэчлэл. УБ., 2019. т.31.

[11] “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс”–ын 5.2, 5.3, 5.5 заалт.

[12] Harary Yuval Noah, 2018. Lessons for the XXI Century, pp97.

[13] Путин В.В Программа патриотического воспитания должна основываться на базовых ценностях https://tass.ru/obschestvo/7325009.

ур чадварын боловсрол юм”[14] гэжээ. Эндээс үзэхэд БНХАУ нь Батлан хамгаалах боловсролын тухай хууль боловсруулан мөрдөж, бүх нийтэд батлан хамгаалах боловсролыг системтэйгээр олгож, улсын дотоод аюулгүй байдлын үндсийг бүрдүүлэх болсон.

Японы боловсролын хуулинд “иргэдийн боловсрол бол хувь хүний өөрийн асуудал, харин хүмүүжил бол төрийн хэрэг” [15] гэсэн байдаг. Энэ бүхнээс үзэхэд хүний төлөвшил, хүмүүжлийн асуудалд түлхүү анхаарч буй нь олон улсын нийтлэг чиг хандлага болжээ.

Манай улсын хувьд иргэддээ чанартай боловсрол олгох зорилгын хүрээнд эх оронч үндэсний үзэл, хүмүүжил төлөвшүүлэхийг төрийн бодлого (“Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”)-ын түвшинд хэрэгжүүлж буй нь олон улсын чиг хандлагад бүрэн нийцсэн алхам гэж үзэж байна.

Эх оронч үзэл, хүмүүжил нь Монгол Улсын иргэний эх орон, төр, ард түмнээ дээдлэн хүндэтгэх, газар нутаг, байгаль дэлхийгээ хайрлах, үндэс угсаа, түүх, соёл иргэншил, үнэт зүйлсээрээ бахархах үзэлд тулгуурлан улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, халдашгүй дархан байдлыг хамгаалах үйл хэрэгт оролцох, улс орныхоо тогтвортой хөгжил, дэвшлийн төлөө оюун ухаан, сэтгэл, авьяас билиг, эрдэм боловсрол, хүч чадлаа зориулах гэсэн хүсэл эрмэлзлэл, тэсвэр хатуужил, чадвар, чадамжийн цогц юм.

Батлан хамгаалах үзэл санаа ба эх оронч үзэл

Үзэл санаа бол “утга”, “учир холбогдол”, “мөн чанар”-ыг тэмдэглэсэн философийн нэр томъёо бөгөөд сэтгэхүй, ахуй гэсэн категориудтай нягт холбоотой[16]. Батлан хамгаалах үзэл санааг хэдий чинээ сайн томьёолно түүнийг төлөвшүүлэх, боловсролын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх үйл явцад эерэгээр нөлөөлөх болно. Уг чанартаа бидний өвөг дээдэс үндэс угсаа, улс гэрийг үүсгэн, төрийн бүрэн эрхт байдлыг бататган хамгаалахын төлөө олон зуун жил тэмцэхдээ улс орноо батлан хамгаалах үзэл санааг ард иргэдийн ухамсарт нэвт суулгадаг байжээ.

Тухайлбал, Хүннүгийн хаан Модун Шаньюйгийн эх нутаг газар шороогоо бат хамгаалах үзэл, Алунгоо хатны эв эеийг дээдлэх, нэгдэл нягтралыг эрхэмлэх үзэл, Эргүнэ хунгийн домгийн сэтгэлгээнээс үүдэлтэй үндэс угсаа, язгуур гарлыг чандлан сахих үзэл, нийт монголчуудын олон зуун жил уламжлан баяжуулж үеэс үед өвлөн ирсэн мөнх тэнгэр, эзэн дээдэс, төр улсаа гүнээ бишрэн хүндэтгэх, шүтэх ёс уламжлал, сэтгэлгээ, эх орноо хамгаалах үзэл нь монголчуудын ухамсар сэтгэхүйд бат шингэж ирсэн. Чухамдаа монголчуудын бусдаас хараат бус байх, төр улсын бүрэн бүтэн нэгдмэл байдлыг хангах, нутаг дэвсгэрээ хамгаалах, батжуулах үзэл чиг хандлага бий болж энэ нь Чингис хааны айлдвар, хэлсэн үг, зарлиг, цааз бичгүүдэд тусгагдах болжээ.

[14] 全民国防教育. 读本. 北京.*2009*. 页*83*.
[15] *Бэгз.Н. Монголын боловсрол судлалын шинэ парадигм. УБ.,2013. т.15.*
[16] *Философийн толь. УБ. 1990. т.436.*

“Чингисийн билиг-т “Алд бие минь алжааваас алжаатугай. Ахуй төр минь бүү алдартугай. Бүтэн бие минь зовбоос зовтугай. Бүрэн улс минь бүү задартугай” хэмээн тусгаар төрийн бүрэн бүтэн халдашгүй дархан нэгдмэл байдлыг хамгаалах тухай тусгагджээ. Энэ бол монголчуудын улс орноо батлан хамгаалах язгуур сэтгэлгээ мөнөөс мөн. Төв Азийн нүүдэлчин аймгууд, Монгол угсаатнуудын нүүдэллэн амьдрах арга нь байнгын зөрчил тэмцлийг бий болгож нөхцөлдүүлж байсан. Нүүдэллэн амьдрах арга нь оршин буй газар нутаг, байгаль цаг уур, амьдралын хэв маягаасаа шалтгаалан монголчуудын өөрсдийгөө хамгаалах тогтолцоог бүрдүүлсэн нэн тулгамдсан мөнхийн шинжтэй асуудал байжээ.

Монголчууд ардын аман зохиол, оньсого таавар, ертөнцийн гурав, үлгэр домог, туульс зэрэгт оюуны хүмүүжлийг олгохдоо зориг баатарлаг явдлыг эрхэмлэн шүтэж, үлгэрлэн дууриах үзлээр үр хүүхдээ хүмүүжүүлж ирсэн нь үе үеийн амьдралын философи болж байсан. Эдгээр өгүүлэмжүүд нь хүний дотоод мөн чанар, сэтгэл санаа оюун ухааны хөгжилд батлан хамгаалах үзэл санааг суулгаж байсны илрэл юм. Ингэж хүний оюун ухаан, сэтгэл санааны хүчин чадлыг танин мэдэж, бие бялдарын боловсролтой хослуулан олгох замаар эрхэмлэн дээдлэх үзэл бүрэлдсэн нь оюун ухаан, бие бялдарын хүмүүжил олгох сэтгэлгээнд гарсан том дэвшил юм.

Тэгвэл монголчууд биднийг хүчирхэг болгож байсан далд хүч нь юунд оршиж байсан вэ? гэдгийг сайтар тунгаан бодох учиртай болж байна. Төр улс гэдэг нь тодорхой хил хязгаар, засаг захиргаа, хүн амтай нутаг дэвсгэр бөгөөд түүний хүч нь тухайн ард түмний оюуны дундаж чадамж, тэдний материаллаг ба оюуны нөөцийг дайчилж чадах чадамжийн түвшингөөр хэмжигдэнэ. Оршин буй бүс нутаг, амьдралын хэв маяг нь монголчуудыг эх нутаг, төр улсаа шүтэх нарийн шүтэлцээтэй болгосон. Ийнхүү монголчуудын уламжлалт амьдрах сэтгэлгээ, эх орноо гэсэн үзэл санаа нэгдэн нийлж, ихээхэн хүчийг бий болгож байжээ.

Хүн төрөлхтөн даяаршиж буй эрин зуунд монгол хүний батлан хамгаалах үзэл санаа хэр төлөвшин тогтсон вэ? хэмээн асуувал бид хариулах аргагүй байдалд орж байна. Учир нь өнөө үеийн хүүхэд залуучуудын ухамсар ёс суртахуун, эх оронч үзэл санаа бүрэн гүйцэд төлөвшин тогтоогүй байна. Өөрөөр хэлбэл, дэлхий ертөнц ямар байх бол, бид хэрхэн зохицох вэ гэж хандах биш, харин бид ямар байлгавал зохих вэ? гэдгийг бодож томьёолох хэрэгтэй гэсэн үг. Бидний барих гол чиг үзэл баримтлалын үндэс үүнд л орших учиртай.

Үүний тулд философийн реалист болон идеалист үзэл онолуудад харьцуулсан шинжилгээ хийж, батлан хамгаалах үзэл санаа, эх оронч үзлийн уг гарвал үндсийг тогтоох нь зүйн хэрэг юм.

Хүчний тухай номлодог онол бол реализм юм. Энэхүү онолд улс төрийн нэгжүүдийн хоорондын харилцаа нь эсрэг тэсрэгийн нэгдлийн дагуу ашиг сонирхлын зөрчилд хүргэдэг бөгөөд үүнээс үүдэн улс орнуудын хооронд сөргөлдөөн, хямрал мөргөлдөөн, дайн дажин, эмх замбараагүй байдал мөнхийн шинжтэй гардаг хэмээн үздэг. Реалистуудын хувьд улсуудын

туйлын зорилго нь дайсагнасан эмх замбараагүй орчинд аюулгүй байх явдал юм. Үүнээс улбаалан үндэсний аюулгүй байдлаа хангах тухай бодлого нь өөрийн хүч чадлаа тооцоолоход хүргэдэг гэж үздэг.

"Улс төрийн философи" зохиолд хүмүүс хоорондын зөрчил сөргөлдөөн нь аливаа хүн шууд халдах аюул тулгараагүй байсан ч ирээдүйн хамгаалалтаа бэлдэхийн тулд бусад хүмүүс рүү довтлох болно. Үүнд дараах гурван шалтгаан оршиж байдаг. *Нэгдүгээрт,* эд хөрөнгө хуримтлуулах *хоёрдугаарт,* аюулгүй байдлаа хадгалах *гуравдугаарт,* нэр хүндтэй болох"[17] зэрэг болно гэжээ. Энэ нь байгалийн хуулийн дагуу амьд үлдэхийн тулд хүчтэй байх тухай номлосон хэрэг юм. Эндээс өнөөдөр аюулгүй байдлын тухай бодохгүй байсан ч нөгөө нэгэн бодож байх учир хүссэн ч хүсээгүй ч биднийг сэрэмжлэхээс аргагүй зүй тогтолтой гэдгийг л сануулж буй.

Идеализмын гол төлөөлөгч Гегелийн үзлээр бүх ертөнцийн үйл ажиллагаа оюун санааны хүрээнд явагддаг гэж үздэг. Оюун санааны гэсэн нь үзэл санааны хүрээ юм. Энэ үндэслэл нь үзэл суртал гэдэг үзэгдлийн улс төртэй холбогдсон холбоог ойлгох үндэс болно. Ашиг сонирхолгүй явагддаг зүйл нэгээхэн үгүй билээ. Ашиг сонирхол нь янз бүрийн үзэл санааны хэлбэрээр илэрдэг. Жагсаалын цэрэг ч тулалдаанд орохдоо ямар нэг үзэл санаагаар зоригжсон байдаг. Үүнд л хүний мөн чанар оршино.

Оюун санаа гэдэг бол бидний бодол төсөөлөл юм гэж зарим философич үздэг. Бид юмыг сайхан учир хайрладаг биш харин бид хайрладаг учир тэр нь сайхан гэж хэлсэн үнэт чанарын бодомж юм. Энд бид аливаа үйлийн үнэлэлт нь тэдгээрийн объектив нэгэн чанараас биш тэдгээрт хандах бидний субьектив харилцаанаааас урган гарч байна гэдгийг хэлсэн хэрэг. Тиймээс бид ард иргэдийг хэрхэн улсын иргэн болгож хүмүүжүүлж чадах эсэхээс улсын оршин тогтнох аюулгүй байдал ч ихээхэн шалтгаална гэсэн үг. Монгол хүний эх орноо хайрлах, хамгаалах ухамсар сэтгэхүйн үйл дээр нь тулгуурлан зангидаж бүх нийтийн батлан хамгаалах үзэл санааг төлөвшүүлэн бэлтгэх ёстой гэсэн гаргалгаа эндээс гарах учиртай.

Ийнхүү философийн реалист болон идеалист үзэл онолуудад шинжилгээ хийснээр монголчуудын батлан хамгаалах үзэл санааны гол үндэс нь оюун санаа, хүчний тэнцвэртэй харьцаан дээр тогтож ирсэн гэж үзэх үндэстэй юм.

Дүгнэлт

Монголчууд бид өөрсдийгөө тэнгэрээс заяат манлайлагч ард түмэн гэж үздэг сэтгэлгээ нь биднийг хүчтэй болгож, эзэн дээдэс, төрийг онцгойлон хүндэтгэн дээдлэх шүтэлцээг бий болгожээ. Монголчууд эрт үеэс болзошгүй аюулын эсрэг сөрөн зогсох хүч тэнхээтэй, хүчирхэг байсны гол үндэс бол "хүчирхэг удирдагч, хүчтэй төрийг шүтэж байсан үзэл сэтгэлгээ, хүмүүжилд байна" хэмээн үзэж, энэ нь монголчууд бидний батлан хамгаалах хүч чадлын эх ундарга ч гэж үзэх үндэстэй юм.

[17] *Поздняков Э.А. Улс төрийн философи.УБ.,2001.т.108.*

Манай ард түмний батлан хамгаалах үзэл санааны гол үндэс нь үеэс үед оршин ирсэн байгаль цаг уур, газар зүйн онцлог, түүнтэйгээ зохицсон амьдралын хэв маяг тэдний сэтгэл зүйн хэв шинжийг бүрдүүлж, өөрөө өөрийгөө байнга хамгаалах, оршин буй орон зай болох эх нутаг, газар шорооныхоо төлөө амиа өгөхөд бэлэн ухамсар сэтгэхүй болон тэдгээрийг бүрнээ ойлгосон ухаалаг удирдагчдын үзэл санааны оновчтой хослолд оршиж байжээ.

Аливаа хүчийг гаднаас биш өөрсдийн оюун ухаан, бие сэтгэлээс эрэн олж, түүндээ түшиглэж эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах, аюулгүй байдлыг хангах нь батлан хамгаалах үзэл санаа ба эх оронч үзлийн философи үндэслэл болно. Энэ санаанд түшиглэн эх орноо батлан хамгаалах, аюулгүй байдлаа хангах нь XXI зууны монгол иргэний үндсэн шинж байх юм.

Хүний хөгжил, аюулгүй амьдралын чанарыг баталгаажуулсан батлан хамгаалах мэдлэг чадвартай, эх оронч монгол хүн төлөвшүүлэх үйл явц нь тасралтгүй, насан туршийн бөгөөд ард иргэдийн хүчин чармайлт болон төрийн хүчтэй бодлого, үйл ажиллагаагаар хэрэгжих болно.

Эшлэл авсан, ашигласан материалын жагсаалт:

1. Монгол Улсын ШУА-ийн 2019 оны 12-р сарын Их чуулганы илтгэл
2. Дашзэвэг Ц. Батлан хамгаалах бодлого, зэвсэгт хүчний байгуулалт, удирдлагын шинэчлэл. УБ., 2019.
3. Монгол Улсын их хурлын 2015 оны 85 дугаар тогтоолын хавсралт. Монгол Улсын
4. батлан хамгаалах бодлогын үндэс
5. Harary Yuval Noah, 2018. Lessons for the XXI Century.
6. Путин В.В Программа патриотического воспитания должна основываться на базовых ценностях https://tass.ru/obschestvo/7325009.
7. 全民国防教育.读本.北京. 2009.页83.
8. Бэгз.Н. Монголын боловсрол судлалын шинэ парадигм. УБ.,2013.
9. Философийн толь. УБ. 1990.
10. Поздняков Э.А. Улс төрийн философи.УБ.,2001.

ДЭЛХИЙН СОЦИАЛИСТ СИСТЕМ ДЭХ ХҮЙТЭН ДАЙН: ЗӨВЛӨЛТ, ХЯТАД, МОНГОЛЫН ГУРВАЛЖИН

Д.Уламбаяр
ХИС-ийн Олон улсын харилцаа, нийгэм судлалын сургуулийн захирал доктор(Ph.D), профессор

Keywords: *Central Committee, Politburo, conflict, nuclear test, atom bomb, H bomb test, intercontinental ballistic missile, incident, defense, tension and diplomatic relations, etc.,*

Abstracts: *This article defines on documentary basis about main causes of Sino-Soviet ideological split tensioned rapidly till border conflict since early 1960s, China nuclear program, the USSR attempt to set contacts with Republic of China or Taiwan and his Holiness the 14th Dalai lama, tension of Mongolia and China relations during the 1970s, and marshal Lin Biao's incident, who was Second First Vice Chairman of the CPC.*

I. Зөвлөлт, Хятадын харилцаа хурцадсан нь

1960-аад оны эхнээс ХКН социализм байгуулах зүй тогтол, арга зам, олон улсын ажилчны болон коммунист хөдөлгөөн, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний талаар ЗХУКН, социалист хамтын нөхөрлөлийн орнуудаас зарчмын ялгаатай байр суурь баримтлах болсон юм. Энэ бодлого, байр суурь Зөвлөлт-Хятадын харилцаанд ноцтой саад болж эхэлсэн байна.

1961 оны 10 дугаар сард хуралдсан ЗХУКН-ын XXII хурал ойрын 25 жилийн хугацаанд ЗСБНХУ-д коммунизмын материал техникийн баазыг байгуулж дуусгах, коммунист нийгмийн харилцааг боловсронгуй болгох, коммунист бие хүнийг төлөвшүүлэх стратегийн зорилгын хүрээнд чадлынхаа хэрээр хийж, хэрэгцээнийхээ хэрээр хүртэх, оюуны болон биеийн хөдөлмөр, хот ба хөдөө, ажилчин ба тариачин ангийн хоорондын ялгааг арилгах, сэхээтний давхаргыг хөгжүүлэх, коммунист ёсоор аж төрөх зорилтыг дэвшүүлсэн ЗХУКН-ын III Программыг баталсан юм. Их хурлаар хэлэлцэгдсэн нэг том асуудал нь 1956 оны 2 дугаар сард хуралдсан ЗХУКН-ын XX их хурлаас Сталиныг тахин шүтэх, түүний

хор уршгийг хэлэлцсэн асуудлыг дахин хурцаар хөндөн тавьсан явдал юм. Энэ асуудал ХКН-ын эгдүүцлийг хөдөлгөжээ. Учир нь Хятадад Мао Цзедуныг тахин шүтэх үзэл газар авч байсан цаг байсан юм. 1966 онд Хятадад өрнөсөн "соёлын хувьсгал" ч Зөвлөлт-Хятадын харилцаанд ноцтой сөрөг нөлөө үзүүлэв.

1969 оны 3 дугаар сард Приморийн хязгаарын Пожарский дүүрэгт багтах Уссури мөрний Даманы аралд (0,74 км^2) (Чжэньбао-дао буюу "эрдэнэс" гэсэн үг ажээ Д.У) болсон зэвсэгт мөргөлдөөн Зөвлөлт-Хятадын харилцаа туйлдаа хүртэл хурцадсаныг харуулав. 1860 оны Бээжингийн гэрээгээр Уссури мөрний цаад эрэг дагуу Хятадын хил оршдог жижиг арал нь ЗХУ-ын нутаг дэвсгэрт тооцогддог байжээ. 1919 оны Версалийн бага хурлаас гаргасан заарчмын дагуу усан замын тээвэр ашигладаг мөрний дундах хуурай газрыг усан замын бүсэд тооцоохгүй байх ёстой тул хятадууд Бээжингийн гэрээг дангаараа өөрчлөхөөр шийдвэрлэсэн байв. Энэ арлын байгалийн гол баялаг нь үнэ цэнэтэй үлэмж арвин усны хадлан (заливной луг) байжээ. 1969 оны 3 дугаар сарын 2-15-ны хооронд болсон мөргөлдөөний төгсгөл үед Зөвлөлтийн тал дөнгөж зэвсэглэлд орж байсан шинэ зэвсэг болох «БМ-21 Град» бөөнөөр галлах пуужингийн тийрэлтэт систем ашигласан байна. Тухайн үеийн зөвлөлтийн Правда болон Известия сонины мэдээллээр бол тэр үед Даманы арал дээр байсан хятадын 700 гаруй цэргийг газартай нь тэгшилсэн ажээ. Хоёр долоо хоног үргэлжилсэн энэхүү мөргөлдөөнд зөвлөлтийн 58 цэрэг амь үрэгдэж, 100 гаруй цэрэг хүнд шархадсан байна. Энэ тулаанд зөвлөлтийн 5 офицер байлдагч ЗХУ-ын баатар цолоор нэхэн шагнагджээ.[18]

2010 онд *Le Figaro* сонин энэ мөргөлдөөний үед ЗХУ цөмийн цохилт өгөхөд бэлэн байсан гэсэн эх сурвалжийг дэлгэсэн байдаг. Хамгийн ноцтой нь БНХАУ 1964 оны 10 дугаар сарын 16-нд Шиньжан мужийн Лоб нуурын цөлд анхны цөмийн бөмбөгийн туршилт хийсэн явдал байв. 1950-иад онд ЗХУ цөмийн зэвсгийн нууцаас БНХАУ-тай хуваалцаж албан ёсны гэрээ хэлэлцээ явагдаж байсан бөгөөд хятадын цөөнгүй цөмийн физикчид Москвагийн ойролцоо Дубна дахь Цөмийн судалгааны институтэд бэлтгэгдэж төгссөн байжээ.

Хууль эрхзүйн талаасаа хятадуудын зөв байсан гэж үздэг байна. Хил голын голдирлоор байдаг бөгөөд арал эхлээд зөвлөлтийн талд байж, тэр үед голын урсгал өөрчлөгдөөд, арал хилийн нөгөө талд орсон ажээ. ЗХУ 1991 оны 5 дугаар сарын 19-нд Даманы арлыг БНХАУ-д албан ёсоор шилжүүлэн өгчээ.

Зөвлөлт-Хятадын хилийн энэхүү зэвсэгт мөргөлдөөн Монгол-Хятадын харилцаанд шууд нөлөөлж, хурцадмал байдал 1970-аад оны туршид үргэлжилсэн тухай хойно өгүүлнэ.

БНХАУ 1964 оны 10 дугаар сарын 16-нд Шиньжан-Уйгурын цөл дэх Лоб нуурын орчимд анхны атомын бөмбөгийн туршилт хийж, 1965 оны

[18] *Мусалов Андрей. Даманский и Жаланашколь. Советско-китайский вооруженный конфликт 1969 года.-М.: Экспринт, 2005. -ISBN 5-94038-072-7. стр. 336-369*

5 дугаар сарын 14-нд хоёр дахь туршилтаа хийжээ. Аль аль нь уран 235 байсан бөгөөд иймэрхүү нэг бөмбөг бүтээхэд 350 сая ам. доллар болж байжээ.

Оросын хятад судлаач др. проф. Александр В.Панцовын тэмдэглэснээр БНХАУ-ыг цөмийн зэвсэгтэй болоход ЗХУ туслах тухай асуудал 1954 оны намар Никита С.Хрущёвыг Хятадад айлчлах үеэр анх хөндөгджээ. 1955 оны 4 дүгээр сарын 27-нд Москвад байгуулсан "Цөмийн физикийн судалгааг хөгжүүлэх, УАА-д атомын эрчим хүчийг ашиглах талаар Хятадад туслах тухай хэлэлцээр", 1956 оны 4 дүгээр сарын 7-нд Бээжин хотноо байгуулсан "Аж үйлдвэрийн зарим салбарыг (55 үйлдвэрийг шинээр барих, түүний дотор пуужин, атомын зэвсэг хийх үйлдвэр байгуулахад туслах) хөгжүүлэх талаар Хятадад туслах тухай хэлэлцээр", 1958 оны 8 дугаар сарын 8-нд Москвад гарын үсэг зурсан "ЗХУ-аас Хятадад техникийн туслалцаа үзүүлэх тухай хэлэлцээр"-үүд Хятадын анхны атомын бөмбөгийг бүтээхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэжээ.[19]

1950-1960 оны хооронд Хятадын цөмийн хөтөлбөрт зөвлөлтийн 10 мянган мэргэжилтнүүд шууд болон шууд бусаар оролцож, хятадын 11 мянган мэргэжилтэн, 1 мянга гаруй эрдэмтэд ЗХУ-д цөмийн физикийн чиглэлээр суралцаж, мэргэжил дээшлүүлсэн байна.[20]

Хятад 1967 оны 6 дугаар сарын 17-нд устөрөгчийн бөмбөгийн анхны туршилтаа амжилттай хийж, 1968 оны 12 дугаар сарын 27-нд хоёр дахь удаагаа, 1969 оны 9 дүгээр сарын 29-нд гурав дахь удаагийн туршилтыг хийжээ.[21] "Атомын бөмбөгөөс устөрөгчийн зэвсэг турших хүртэл АНУ 6 жил 4 сар, Англи 4 жил 7 сар болсон байна. Тэгвэл хятад анхны атомын бөмбөгөөс устөрөгчийн бөмбөгийн туршилт хүртэл 2 жил 8 сарын хугацаа зарцуулав гэж 1969 оны 9 дүгээр сарын 29-нд Синьхуа агентлаг сайрхан мэдэгдэж байжээ. Мэргэжилтнүүдийн тооцоолсноор эдгээр туршилтыг хийхэд БНХАУ нийтдээ 6 тэрбум ам. доллар буюу 15 тэрбум юань зарлагджээ. Гэтэл тухайн үеийн Хятадын гадаад худалдааны эргэлт дөнгөж 4 тэрбум орчим ам. доллар байжээ. Ураны нөөц Хятадад хомс байсан боловч гол нөөц нь Шиньжанд байршилтай учир Өрөмч хотод ураны хүдэр баяжуулах үйлдвэр, харин түүнтэй хиллэдэг Ганьсу мужийн Ланьчжоу хотын орчимд уран баяжуулах үйлдвэр нь байрладаг байжээ.

Хятад 1970 оны 1 дүгээр сарын 30-нд анхныхаа хиймэл дагуул DF-4-ийг, 4 дүгээр сарын 24-нд хоёр дахь удаагаа амжилттай хөөргөжээ. "Dong Fang Hong" буюу "Дорно зүг улайрав" буюу "Мао-1" нэртэй 173 кг жинтэй хиймэл дагуул дэлхийг 114 минутад нэг бүтэн тойрч, "Дорно зүг улайрав" хэмээх дууны хөгжмийг дамжуулсан байна.[22] 1971 оны 10 дугаар сард DF-5 тив хоорондын баллистик (12 мянган км) пуужингийн анхны туршилтыг хийж, 1980 онд зэвсэглэлд авчээ. Эдгээр нь Мао Цзедуны

[19] *А.В.Панцов. Мао Цзэдун. (Жизнь замечательных людей) М.: «Молодая гвардия», 2007, стр. 115-116*

[20] *История ядерной программы Китая* https://ria.ru/20150115/1042543537 html

[21] *Peking Review. №44, 1968*

[22] *Eastern Horizon. Vol. IX, №2 1970*

үзэл санааны их ялалт, хятадын сансрын болон пуужингийн техникийн хөгжлийн сайн гарааны бэлэг тэмдэг гэж Синьхуа агентлаг тухайн үедээ дүгнэж байжээ.

Цөмийн зэвсэг, алсын тусгалтай баллистик пуужин бүхий олон зуун сая хүн амтай гүрэнтэй хуурай замаар олон зуун км газар нутгаар хаяа хатган хиллэх болсон нь ЗХУ-ын хувьд Өрнөдөөс гадна Дорнодоос цоо шинэ ноцтой аюул буй болсныг харуулсан юм.

Энэ үед ЗХУ Тайваньтай харилцаагаа сэргээх хувилбарыг ч авч үзэж эхэлжээ.

Энэ нь Хятадыг АНУ-тай, Зөвлөлтийг Энэтхэг улстай, ЗХУ-ыг АНУ-тай харилцаагаа сайжруулан хөгжүүлэх шаардлагатайг харуулсан юм.

1960-аад оны сүүлчийн улирлаас Зөвлөлт-Хятадын харилцаа эрс хурцдах болсон үед ЗХУ Тайваньтай албан бус шугамаар харилцаж эхэлжээ. Үүнд: Москва дахь "Western media outlets"-ийн төлөөлөгч "New York Times", Лондонгийн "The Evening News" сонины сэтгүүлч КГБ-ын нууц туршуул, Виктор Луи (Victor Louis 1928-1992) чухал үүрэг гүйцэтгэжээ. Тэрбээр "Wang Ping" нэрээр Японы нийслэл Токиод Тайваний ТТГ-ын шугамаар холбоо тогтоож 1968 оны 10 дугаар сард Тайбэйд зочилж, Батлан хамгаалахын сайд Зян Зинго (Chiang Ching-kuo Чан Кайшигийн төрсөн том хүү) лугаа уулзаж, 1969 оны 5 дугаар сар, 1970 оны 3 дугаар сард Австрийн нийслэл Вена хотноо Тайваний дипломатуудтай нууц уулзалтуудыг зохион байгуулж байжээ. Уулзалтын агуулгад Маогийн дэглэмийг түлхэн унагаах, хамтын ажиллагааны нууц гэрээ байгуулах, шинэ Хятадын төрийн системд Коммунист намын нэрийг хэрэглэх албагүй, Гоминьдан, Коммунист намын нэгдсэн Засгийн газар нь шилжилтийн шинж чанартай байх, хоёр талын харилцааг "Элчин сайдын зиндаа"-нд дээшлүүлэх, Москва, Тайбэй хоёрт харилцан хэвлэл мэдээллийн газар байгуулах зэрэг өргөн хүрээтэй асуудлууд тусгагдаж байжээ.[23]

1990 оны намар Хятадын БНУ-ын Гадаад хэргийн дэд сайд Чан Циао-ен (Chang Hsiao-yen) 1970-аад оны эхээр Вашингтонд Зөвлөлтийн дипломатуудтай холбоо тогтоож байсан талаар хэвлэлийн бага хурлын үеэр мэдэгдсэн юм. 1992 оны 4 дүгээр сарын 11-нд Хятадын БНУ-ын Гадаад хэргийн сайд Чиен Фу (Chien Fu) Оросын *Известия* сонинд ярилцлага өгөхдөө: АНУ-ын нийслэлд Зөвлөлтийн элчин сайд А.Добрынинтэй "close ties" тогтоосон тухай тэмдэглэсэн байна.[24]

1995 оны 5 дугаар сард Taipei *China News*-ийн сэтгүүлч Lien-ho Pao Хятадын БНУ-ын Засгийн газрын Мэдээллийн агентлагын захирал агсан

---

[23] *Shin Kawashima. «The Little Dragon and the Bear: Soviet-Taiwanese Relations». Woodrow Wilson Center, Cold War International History Project, History and Public Policy Program. 17 December 2002*

[24] *Peter M.Ivanov. «Russian-Taiwanese Relations: Current State, Problems, and Prospects of Development»-Contemporary Asian Studies Series. Number 2-1996 (133) School of Law University of Maryland, pp.2-3*

Jimmy Wei-гийн мэдээллийг үндэслэн 1960 оны сүүлч, 1970-аад оны эхээр КГБ-ын агент Виктор Луи лугаа холбоо тогтоож байсан талаар дэлгэрэнгүй бичсэн юм. Түүнд Виктор Луи Батлан хамгаалахын сайд Зян Зингогийн орос эхнэр Faina Chiang Fang-Liang лугаа 3-4 удаа захидлаар харилцаж байсан тухай мэдээ орсон байна.

Түүнчлэн 1968 оны 10 дугаар сард Хятадын БНУ-ын Боловсролын яамны сайд асан Ku Shu-hsu Москвад нууц айлчлал хийж байсан, 1970-аад оны эхээд Пескадорын арал дээр ЗХУ-ын тэнгисийн цэргийн бааз байгуулах хүсэлт Чан Кай-шид ирж байсан, 1975 оны 5 дугаар сард Тайваний хоолойгоор Зөвлөлтийн Номхон далайн флотын байлдааны хөлөг өнгөрөхөд Тайбэй зөвшөөрөл өгч байсан, 1978 онд Хятадын БНУ ЗХУ-тай дипломат харилцаа тогтоох боломжтой гэсэн Москвад тархсан цуурхал, 1978 оны 11 дүгээр сард Зөвлөлтийн худалдааны хөлөг онгоц Тайваний Макунг (Makung) боомтод ирсэн тухай мэдээ, 1982 оны 8 дугаар сард Москвад зохиогдсон Олон улсын эрүүл мэндийн байгууллагын их хуралд Тайваний 18 зүрхний эмч нар төлөөлөгчөөр оролцож байгаа тухай, 1987 онд Москва хотноо зохиогдсон эмэгтэйчүүдийн сагсан бөмбөгийн олон улсын тэмцээнд Гоминьдан намын ТХ-ны Байнгын хорооны гишүүн, Тайбэй хотын Захиргааны дарга Chang Chien-pang тэргүүтэй төлөөлөгчид оролцож байсан зэрэг баримтууд байгааг Петер Иванов өгүүлэлдээ тэмдэглэсэн байна.[25]

Харин Зөвлөлт-Америкийн харилцаа огцом сайжирмагц тэрхүү албан бус харилцаагаа зогсоожээ.

Дээрхийн гэгээн XIV Далай лам 1979 оны 6 дугаар сарын 15 буюу билгийн тооллын XVI жарны шороон хонин жилийн зуны эхэн сарын 20-ны билигт сайн өдөр Монгол Улсад Азийн Буддистууд Энхтайвны төлөө олон улсын V бага хурлын хүндэт зочноор уригдан анх удаа заларчээ. Түүнийг Монголын бурхан шажинтны төв Гандантэгчэнлин хийдийн тэргүүн хамба, Азийн буддистууд Энхтайвны төлөө бага хурлын Ерөнхийлөгч номч мэргэн гавж С. Гомбожав[26] урьжээ. Тухайн үед Нью-

[25] *Ibid. p.4-6*

[26] **Самаагийн Гомбожав** *(1902-1980) нь Сэцэн хан аймгийн Харцага чин вангийн хошууны нутагт 1902 онд төрсөн. 1913 оноос Их Хүрээний буддын гүн ухаан судалдаг Идгаачойнзинлин дацанд сууж буддын гүн ухааны шастир номонд ихэд суралцжээ. 1935 онд буддын гүн ухааны таван ботьь шашдираар ном хаялцаж, гавжийн дамжаа барьжээ (докторын зэрэг хамгаалжээ Д.У). Түүний багшлах, ном заах эрдэм энэ цэээс эхэлсэн байна. 1935 оноос буддын гүн ухаанд нэвтэрсэн лам нар лугаа хамтран "Лам нарын сэтгүүл"-ийг гаргах тухай Засгийн газарт өргөх бичиг айлтгаж, улмаар 1936 оны 4 дүгээр сарын 20-нд Ардын Сайд нарын Зөвлөлийн Ерөнхий сайдаас гаргасан 51-р тушаалаар "Лам нарын сэтгүүл"-ийн анхны дугаар хэвлэгдэн гарч, эрхлэгчээр нь ажиллах болжээ. 1951-1960 онд Шинжлэх ухааны хүрээлэн, Улсын Төв номын сангийн Түвд номын сан хөмрөгийн эрхлэгч, 1960 онд Гандантэгчэнлин хийдийн тэргүүн хамба ламаар өргөмжлөгджээ. 1961 онд Гандантэгчэнлин хийдийн Тэргүүлэгчдийн хурлын шийдвэрээр хамба лам С.Гомбожавт "Номч мэргэн" (профессор Д.У) цол олгожээ. 1961 оноос хавсран МУИС-д шинээр нээгдсэн түвд хэлний салбарт түвд хэл, шашны гүн ухаанаар багшилж байв. 1970*

Делид Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар ажиллаж байсан доктор Б.Балдоо Дээрхийн гэгээн XIV Далай ламыг Монголд хүндэт зочноор урихад ихээхэн хүчин чармалт гаргаж байжээ.

Тэрбээр Монголд залрах замдаа ЗХУ-аас виз авч ирсэн байх бөгөөд энэ үед ЗХУКН-ын Төв Хороо БНХАУ-тай тааламжгүй харилцаатай байсан Дээрхийн гэгээн XIV Далай ламтай холбоо тогтоох сонирхолтой байжээ. КГБ-ын нууц төлөөлөгч дээрх Виктор Луи өөрийн номондоо бичихдээ: "1979 оны 6 дугаар сард XIV Далай ламыг Монголд айлчлах үед Далай ламыг Улаанбаатар хотод суурьшиж, Улаанбаатарыг Буддын шашны төв болгохыг санал болгосон. Чингэвэл Монголд шарын шашныг дахин сэргээж, Төвд орны ганц залгамжлагч болох байв"[27] гэжээ. Энэ нь ЗХУ Далай ламыг Хятадын эсрэг ашиглах сонирхолтой байсныг гэрчилж байгаа юм. ЗХУ "Азийн Буддистууд Энхтайвны төлөө бага хурал"-ыг Улаанбаатар хотноо зохион байгуулахыг дэмжиж байжээ. Тиймээс ч Хятадын тал тус бага хурлыг Хятадын эсрэг суртал ухуулгадаа ашиглаж байна гэж шүүмжилж байжээ.

Хүйтэн дайны үед ЗХУКН-тай ойртох нь хүний эрх, шашны эрх чөлөө, ардчилалыг дээжлэгч Өрнө дахинд болгоомжлол төрүүлэх эрсдэлтэй байсан тул Дээрхийн гэгээн XIV Далай лам "найрсгаар татгалзаж" байжээ. Түүнийг Шереметьевийн нисэх буудалд Бүх Оросын Үнэн алдартны шашны тэргүүн XIV Патриарх, Москвагийн Сүм хийдийн тэргүүн I Пимен угтан авч байжээ. Дээрхийн гэгээн XIV Далай лам Монголд айлчлах хугацаандаа Монголын Бурхан шашны төв Гандантэгчэнлин хийдэд сүсэгтэн олонд "Гандан лхавжаа", "Есөн мөрт мигзэм", "Дөрвөн мөрт мигзэм" айлдан сүсэгтэн олны хамтаар маань уншиж "Язгуурын гурван бурханы тарни"-ийн лүн хайрлаж, Азийн Буддистууд Энхтайвны төлөө олон улсын V бага хуралд айлтгал өргөж байжээ. 1969 онд Монголын бурхан шажинтны төв Гандантэгчэнлин хийдийн тэргүүн хамба, номч мэргэн гавж С.Гомбожавын санаачлан үндэс суурийг нь тавьсан Азийн Буддистууд Энхтайвны төлөө бага хурал "Зэвсэг барин тэмцсэн дайсагнагч талууд цэцэг барин золгох болтугай" (May the Weapons of Torture they hold turn to Flowers) гэсэн эрхэм уриатай ажгуу.

1970-аад онд Алс Дорнодод явуулж байсан бодлогын гол чиглэл нь БНХАУ-ыг «хазаарлан барих» явдал болов. Тиймээс зөвлөлт, хятадын хилийн дагуу цэргийн хүч болон Номхон далайн флотоо бэхжүүлэхийн зэрэгцээ Хятадын өмнөд хэсэгт зөвлөлтийг дэмжигч орнуудын (социалист

онд Гандантэгчэнлин хийдийг түшиглэн Шашны дээд сургуулийг санаачлан үндэс суурийг тавьж, Монгол болон Зөвлөлт Буриадаас шавь-оюутнуудыг элсүүлэн сургаж шашны дээд боловсрол олгож эхэлжээ. Түүний 70 насны ойг тохиолдуулан төр засгаас "Хөдөлмөрийн гавъяаны улаан туг"-ийн одонгоор шагнажээ. 1969 онд Азийн Буддистуудын Энхтайвны Бага хурлыг үндэслэн байгуулж, анхны Ерөнхийлөгчөөр ажиллаж байв. Гандантэгчэнлин хийдийн тэргүүн хамба ламаар 20 жил ажиллаж байгаад 1980 онд жанч халжээ.

[27] *Victor Louis. The Coming Decline of the Chinese Empire. N.Y.: Times Books, 1979, pp. xv, 47-50*

Вьетнам, ардчилсан Лаос, Кампучи) гинжин цуваа байгуулж бүслэлт буй болгохыг эрмэлзэж байв. Чухам тийм учраас Бээжин болон Хойд Солонгосын дэглэм хоёрын харилцаа улам бүр ойртон нягтарч байгаад ЗХУ сэтгэл түгшин ажиглаж байжээ. 1973 онд ЗХУ БНАСАУ-д зэвсэг нийлүүлэхээ зогсоож, БНХАУ анх удаагаа тус улсад зэвсэг нийлүүлэгч гол орон болсон байна.[28]

Бодлогын өөр нэг чиглэл нь Хятадын эсрэг үзэл суртлын тэмцлийг бүх салбарт идэвхжүүлж, ***маоизмын*** мөн чанарыг уудлан илчилж, бутцохих явдал байсан юм.

II. Монгол, Хятадын харилцаа хурцадсан нь

БНМАУ-ыг Варшавын гэрээнд элсүүлэх Ю.Цэдэнбал, Н.Хрущев нарын оролдлого бүтэлгүйтсэний дараа Зөвлөлт, Хятадын харилцааны хурцадмал байдалтай холбогдуулан 1965 оны 12 дугаар сарын 1-нд МАХН-ын ТХ-ны Улс Төрийн Товчооны хурал болж, "маш нууц" тогтоол батлаж, НТХ-ны Улс Төрийн Товчооны гишүүн Ц.Дүгэрсүрэн, Н.Жагварал, С.Лувсан, Д.Майдар, Д.Моломжамц, Ж.Самбуу, Ю.Цэдэнбал, орлогч гишүүн Н.Лувсанравдан, Б.Лхамсүрэн нар гарын үсгээ зуржээ. Түүнд:

"1. Дорнотод байдал хурцдаж олон улсын хооронд түгшүүрт байдал улам хүчтэй болж байгааг харгалзан тус улсын батлан хамгаалалтыг улам зузаатгах нь зүйтэй гэж үзсүгэй. Үүний тул ЗХУ-ын Зэвсэгт хүчнээс зохих ангийг гаргаж тус улсын нутагт байрлуулан өөрийн зардлаар барьж байх тухай хүсэлтийг ЗХУКН-ын Төв Хороо, Зөвлөлтийн Засгийн газарт тавих нь зүйтэй гэж үзсүгэй" гэжээ.

Тогтоолд гарын үсэг зурсан даруйд тухайн өдрөө МАХН-ын ТХ-ны Нэгдүгээр нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга Ю.Цэдэнбалаас ЗХУКН-ын ТХ-ны Нэгдүгээр нарийн бичгийн дарга Л.И.Брежнев, ЗСБНХУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга А.Н.Косыгин нарт маш нууц захидал илгээжээ.[29] Түүнд:

- "Дорнодод олон улсын байдал хурцдаж байгааг харгалзан улс орныхоо батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэх арга хэмжээ авч байна.
- ЗХУ-ын сэтгэл харамгүй тусламжаар Монголын ардын армийг орчин үеийн зэвсэг техникээр хангаж, армийн бие бүрэлдэхүүнийг зөвлөлтийн мэргэжилтнүүд сурган бэлтгэж байна. Гэхдээ гэнэтийн халдан түрэмгийлэл үйлдвэл эдгээр арга хэмжээ нь хангалттай баталгаа болж чадахгүй.
- Эдгээрийг харгалзан БНМАУ-ын батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэх зорилгын үүднээс ЗСБНХУ-ын Зэвсэгт хүчнээс цэрэг гаргаж, ЗХУ өөрийн зардлаар Монголд байршуулан, тэдгээр

[28] *Christopher Andrew, Oleg Gordievsky. KGB: The Inside Story of its Foreign Operations from Lenin to Gorbachev. Hodder & Stoughton. London, Sydney, Auckland and Toronto.: 1991, pp.421-422*

[29] *Д.Баярхүү. Улс төрийн Товчооны хурлын протокол, Маш нууц, 1965 оны 12 дугаар сарын 1. http://www.baabar.mn 2014.04.04*

цэргийг орчин үеийн байлдааны хүчирхэг зэвсэг техникээр хангаж, ахуй соёл, аж ахуй болон бусад зайлшгүй объектуудаар хангалт хийхийг хүсч байна.

- Цэрэг байрлуулах газрын тухай болон бусад тодорхой асуудлыг жич хэлэлцэе.
- Манай хүсэлтийг ЗХУКН-ын Төв Хороо, Зөвлөлт Засгийн газар ойлгон хүлээн авч наашгай шийдвэр гаргана гэдэгт хатуу итгэж байна" гэжээ.

Дээрх хурал болон захидал илгээсэн нь Л.И.Брежнев тэргүүтэй ЗСБНХУ-ын нам, засгийн төлөөлөгчдийн БНМАУ-д хийх албан ёсны айлчлалаас сар хагасын өмнө бөгөөд айлчлан ирсэн төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд ЗСБНХУ-ын Батлан хамгаалах яамны сайд ЗХУ-ын маршал Р.Я. Малиновский оролцсон нь анхаарал татаж байв.

1966 оны 1 дүгээр сарын 15-нд Улаанбаатар хотноо Монгол, Зөвлөлтийн удирдагч Ю.Цэдэнбал, Л.И.Брежнев нарын гарын үсэг зурсан «Найрамдал, хамтын ажиллагаа ба харилцан туслалцах тухай Гэрээн»-д:

- Социалист хамтын нөхөрлөлийн батлан хамгаалах хүч чадлыг хэлбэрэлтгүй бэхжүүлэх зорилттой уялдуулан хоёр этгээдийн батлан хамгаалах чадварыг хангахад харилцан туслалцах тухай;
- Найрсаг уламжлал ба НҮБ-ын Дүрмийг мөрдлөг болгон хоёр этгээдийн аюулгүй байдал, тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор цэргийнхийг оролцуулан бүх талын зайлшгүй арга хэмжээг хамтран авах тухай;
- Улс түмний энхтайван, аюулгүй байдлыг ханган бэхжүүлэх, зэвсгийг бүх нийтээр бүрэн хураах, колоничлолыг устгах, Азийн улсуудын хооронд найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэхэд чиглэсэн бодлогыг СССР, БНМАУ хоёр тууштай явуулан, дэлхийн бөмбөрцөгийн энэ бүс нутагт империалист түрэмгийллийн аюулаас сэргийлж, тийм аюулыг арилгахын төлөө хамтран тэмцэнэ хэмээн тус тус заажээ.

Дурьдсан заалтууд 1960-аад оны II хагаст Зөвлөлтийн цэрэг Монголд дахин орж ирж байрших эрхзүйн үндэс болсон байна. 1966 оны 1 дүгээр сард БНМАУ, ЗСБНХАУ-ын хооронд Найрамдал, хамтын ажиллагаа ба харилцан туслалцах тухай Гэрээний дараа байгуулсан хэд хэдэн эрхзүйн баримт бичиг гарсан байна. Юуны өмнө цэрэг оруулж байрлуулахыг бататгаж 1967 оны 3 дугаар сарын 4-нд гарын үсэг зурсан "БНМАУ-ын нутаг дэвсгэрт Зөвлөлтийн цэргийг байрлуулах тухай" Засгийн газар хоорондын хэлэлцээрийг нэрлэх хэрэгтэй. Дурьдсан хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн дагуу БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 59 дүгээр тогтоол 1969 оны 8 дугаар 11-нд гарч, зөвлөлтийн цэргийн анги нэгтгэлүүдэд 410.073.42 га (Дөрвөн зуун арван мянга гаруй буюу бараг хагас сая гектар) газар олгожээ. Мөн 1969 оны «БНМАУ-ын иргэний хамгаалалтыг бэхжүүлэхэд тусламж үзүүлэх тухай Засгийн газар хоорондын нууц хэлэлцээр», 1971 оны «Цэргийн техникийн нэгдсэн засварын газар байгуулах тухай

нууц солилцох бичиг», «БНМАУ-д тусгай объект байгуулахад буцалтгүй тусламж үзүүлэх тухай Засгийн газар хоорондын нууц хэлэлцээр", 1981 оны «БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр ураны орд газрыг ашиглах тухай нууц хэлэлцээр» зэргийг дурдаж болно. [30]

ХКН хэдийгээр МАХН-ын XV их хуралд төлөөлөгч илгээгээгүй боловч, харин 1966 оны 7 дугаар сард Ардын хувьсгалын 45 жилийн ойн баярын арга хэмжээнд төлөөлөгч илгээж байжээ.[31]

1967 оны 11 дүгээр сарын 7-нд Октябрийн хувьсгалын 50 жилийн ойн баяраар БНМАУ урд өмнө болж байгаагүй цэргийн сүрт парадыг зохион байгуулж, байлдааны тийрэлтэт пуужин, олон төрлийн шинэ зэр зэвсгийг үзүүлжээ.[32] ЗХУ, Дорнод Европын социалист орнуудын цэргүүдийн төлөөлөл хүртэл энэ цэргийн парадад оролцсон байна.[33]

1963 оноос өмнө БНМАУ-ын жилийн төсөвт батлан хамгаалахын зардал ойролцоогоор 5-6 орчим хувь эзэлдэг байжээ. Энэ үеэс Монгол Улс батлан хамгаалах зардлаа засаг захиргааны зардалтай хамт төсөвт тусгадаг болсон байна. 1967 оны үед батлан хамгаалах зардал цэрэг, олон нийтийн аюулгүй байдал, Засгийн газрын засаг захиргааны зардлын хамт төсвийн 11 хувьд хүрч байсан гэж судлаач Алан Сандерс зохиолдоо бичиж байв.[34]

БНХАУ Варшавын гэрээний орнуудын дээд түвшний уулзалт болсон 1969 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн*"Жэньминь Жибао"* сонинд бичихдээ: "ЗХУ социалист орнуудын хязгаарлагдмал тусгаар тогтнолын онолыг номлож, ЭЗХТЗ болон Варшавын гэрээг бусад улс гүрнийг түрэмгийлэх багаж хэрэгсэл болгон ашиглаж байна" хэмээгээд Гадаад Монголыг Зөвлөлтийн колони болгож байна гэж буруутган шүүмжилжээ.[35]

1969 оны 7 дугаар сарын 6-ны өдөр Хятадын Синьхуа агентлагийн Бээжингийн цахилгаан мэдээнд: Зөвлөлтийг Гадаад Монголтой тэгш бус гэрээ хэлэлцээр байгуулж, Гадаад Монголд их хэмжээний цэрэг оруулсан бөгөөд "мэргэжилтэн", "зөвлөх" хэмээх нэрийн дор Гадаад Монголын нам, төр, цэргийн эрхийг удирдаж байна гэж шүүмжилжээ. БНХАУ нь Монгол-Зөвлөлтийн "Найрамдал, хамтын ажиллагаа, харилцан туслалцах гэрээ"-г Гадаад Монголыг бүх талаар түрэмгийлэх гэрээ хэмээгээд, Гадаад Монголын дотоод бодлого, дипломат харилцааг бүрмөсөн Зөвлөлтийн хяналтад оруулж байна. Эдийн засгийн тухайд олон улсын хамтын ажиллагаа болон социалист орнуудын "нэг цогц эдийн засаг" гэсэн нэрийдлийн дор Гадаад Монголд төмөрлөг

---

[30] *Мөн тэнд*

[31] *Лань Мэйхуа. Цэдэнбалын үеийн Монгол, Хятадын харилцаа (1952-1984) УБ.: 2019, 80 дахь тал*

[32] *Hart, Joe. "Mongolia: 20th Year of Economic Planning"-Asian Survey. Vol. 8, No. 1, (January 1968): pp. 25-26*

[33] *The New York Times, January 3, 1968, p. 1, The London Times, January 3, 1968, p. 1*

[34] *Sanders Alan J.K. The People's Republic of Mongolia. London.: Oxford University Press, 1968, p. 44*

[35] *Лань Мэйхуа. Цэдэнбалын үеийн Монгол, Хятадын харилцаа (1952-1984) УБ.: 2019, 88 дахь тал*

боловсруулах үйлдвэр байгуулахыг хориглоод зогсохгүй машин техник үйлдвэрлэхийг зөвшөөрөхгүй, зөвхөн мал аж ахуйг зөвшөөрч, Гадаад Монголыг Зөвлөлтийн мал аж ахуйн бааз болгосон. ЗХУ тусламжаа ихээр нэмэгдүүлэх нэрийн дор Гадаад Монголд "барилгын трест"-ийг байгуулж, Монголыг дангаараа эзэгнэхийг завдаж байна гэжээ. Тус цахилгаан мэдээнд мөн цэргийн талаар Зөвлөлтөөс Гадаад Монголыг БНХАУ-ыг эсэргүүцэх түшиц газар болгохоор оролдож байна[36] гэжээ. Хятадын энэхүү шүүмжлэл нь Монгол, Зөвлөлтийн найрамдлыг сулруулах зорилготой өдөөн хатгалаг байсан ч дотор нь үнэнийн хувьтай зүйл ч байсан юм.

1970 оны 7 дугаар сард Монгол, Хятадын тал "1970 оны харилцан бараа нийлүүлэх гэрээ"-нд Улаанбаатар хотноо гарын үсэг зурсны дараа 10 дугаар сард Ю.Цэдэнбал хэлэхдээ: БНМАУ БНХАУ-тай харилцаагаа эргэн сайжруулахын тулд дипломат төлөөлөгчдөө элчин сайдын зэрэгт хүргэхийг хүсэж байна хэмээн мэдэгджээ.

Дипломат харилцаа 1967 оны 4 дүгээр сард тасалдаад гурван жил болсоны дараа 1970 оны 10 дугаар сард элчин сайд нараа харилцан томилж ЗСБНХУ-ын элчин сайд Василий С.Толстиков (1970-1978 онд Бээжинд ажилласан), БНХАУ-ын элчин сайд Лью Синьчжуань (Liu Xinquan 1970-1976 онд Москвад ажиллажээ) үүрэгт ажилдаа оржээ.

Харин БНМАУ, БНХАУ хоёр элчин сайд нараа харилцан томилсон нь 1971 онд тохиов. 1971 оны 8 дугаар сард БНХАУ-аас БНМАУ-д суух элчин сайд Сю Вэний (Xu Wenyi 1971-1974 онд ажилласан) АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга Ж.Самбууд ИЖБ-ээ барив. БНХАУ-д шинээр томилогдсон элчин сайд С.Сосорбарам бээр томилогдсоноосоо хойш 3 сарын дараа Бээжинд хүрэлцэн очжээ. Учир шалтгаан нь 1971 оны 9 дүгээр сард Хятадын цэргийн нисэх онгоц Монголд сүйрсэнтэй холбоотой байв. Чингээд элчин сайд С.Сосорбарам 1971 оны 12 дугаар сарын 13-нд галт тэргээр Бээжинг зорьжээ. Түүнийг Бээжинд хүрэлцэн ирсний орой Гадаад хэргийн сайд Цзы Пэнфэй (Ji Pengfei) хүлээн авч уулзажээ. С.Сосорбарам 1960-1963 он ГЯЯ-ны орлогч, 1963-1966 онд ГЯЯ-ны 1 дүгээр орлогч сайдаар ажиллаж байх цаг дор, 1962-1964 онд БНМАУ, БНХАУ-ын хооронд явагдсан хилийн хэлэлцээнд Монголын талыг тэргүүлж байсан бол Хятадын талыг Гадаад яамны орлогч сайд мөнөөх Цзы Пэнфэй тэргүүлж байжээ. Элчин сайд С.Сосорбарам маргааш нь Гуанчжоу хотод хүрэлцэн очиж, БНХАУ-ын даргын үүрэг гүйцэтгэгч Дон Биви (Dong Biwi)-д ИЖБ-ээ гардуулжээ. Ёслолын чанартай ярианы үеэр Дон Биви даргаас хэлсэн үгэндээ хоёр орны хооронд оршиж байгаа үзэл суртлын санал зөрөлдөөнтэй байдал нь хоёр улсын төрийн харилцаанд нөлөөлөх ёсгүй гэж цохон тэмдэглэж байжээ. ИЖБ-ээ барьсны дараа Хятадын албаны зарим хүмүүстэй ёслолын чанартай танилцах уулзалт хийж байхад бараг уулзсан хүн бүр Дон Биви даргын хэлсэн дээрх үгийг давтаж байсан байх бөгөөд тухайн үед социалист орнуудаас Хятадад сууж байсан элчин сайд нар ярихдаа Хятадын тэр үеийн албан тушаалтнууд социалист орны хүмүүстэй уулзахад амны уншлага мэт

[36] *Мөн тэнд*

энэ тухай ярьдаг гэж байжээ. Харин БНХАУ-ын орлогч дарга Дон Биви 1972 оны хавар БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга Ж.Самбуу таалал төгссөнтэй холбогдуулан ЭСЯ-нд өөрийн биеэр ирж эмгэнэлийн дэвтэрт гарын үсгээ зурж хүндэтгэл үзүүлсэн нь хоёр талын харилцаанд эерэг уур амьсгал оруулах гэсэн дипломат жесть байсан юм билээ хэмээн С.Сосорбарам бээр дурьтгалдаа бичсэн байна.[37]

Монголын талтай хятад ажилчдын талаар хэлэлцээ хийж байсан, элчин сайд Жан Цаньмин (Zhang Canming 1963-1967 онд ажиллаж байсан) 1967 оны 1 дүгээр сард нутаг буцаад эргэж ирээгүй, Монголын элчин сайд Д.Цэвэгмэд 1967 оны 8 дугаар сард эх орондоо бүрмөсөн буцаж ирснээс хойш дөрвөн жил тасраад байсан элчин сайдын түвшний дипломат харилцаа ийнхүү сэргэв. Гэсэн хэдий боловч БНХАУ-ын даргын үүрэг гүйцэтгэгч Дон Бивитэй уулзсаныг эс тооцвол Хятадын удирдах албаны хүмүүсээс нэгэн ч түүнийг хүлээн авч уулзан, хоёр орны харилцааны асуудлыг хөндөж яриагүй нь тухайн үеийн Монгол, Хятадын харилцааны шинж чанар ямар байсныг харуулж байна.

Ю.Цэдэнбал 1971 оны 6 дугаар сард хуралдсан МАХН-ын XVI их хурлын тайлан илтгэлд тэмдэглэхдээ: БНМАУ хэдийгээр БНХАУ-тай улс хоорондын харилцаагаа сайжруулах хэрэгтэй байгаа боловч хоёр талын нам хоорондын харилцааны тал дээр Зөвлөлтийн талыг тууштай баримталж, БНХАУ-ыг буруутган шүүмжилсээр байх болно гэжээ. Бид олон улстай найрсаг харилцаагаа бэхжүүлэхийн хамт ирээдүйд БНХАУ-тай айл хөршийн сайн харилцааг сэргээхийг хичээнэ, гэвч Хятадын дэлхийн коммунистуудын эгнээг эвдэх гэсэн үйл ажиллагаа, империализмын гар хөл болж буй явдлыг эсэргүүцэж, тэдэнтэй зарчмын тэмцэл өрнүүлэх болно гэжээ.[38] Хятадын удирдагчид үндсэрхэх үзэл болон Зөвлөлтийн эсрэг үзлээр өөрийгөө зэвсэглэж, социалист улсуудаас БНХАУ-ыг ангижруулан салгаж байгааг буруушаажээ. МАХН-ын XVI их хуралд ЗХУКН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга К.У.Черненко тэргүүтэй төлөөлөгчид оролцсон бол ХКН төлөөлөгчдөө ирүүлээгүй ажээ.[39]

1972 оны үед БНМАУ-ын цэрэг ойролцоогоор 30 мянган хүнтэй байсан бол Монголд байрлуулсан Зөвлөлтийн цэрэг 500 мянгад хүрсэн[40] гэж Беркелей дэх Калифорний их сургуулийн Зүүн Ази судлалын институтээс эрхлэн гаргадаг *Asian Survey* эрдэм шинжилгээний сэтгүүлийн судлаач Уильям Р.Хитон бичсэн нь хэтрүүлсэн тоо юм. Жоу Энлай 1971 оны 10 дугаар сард Бээжинд Хенри Киссижертэй уулзах үеэр ЗХУ Гадаад Монголд 300 мянган цэрэг байрлуулсан тухай өгүүлж байжээ.[41] Япон улс

[37] *С.Сосорбарам. Хал цэж, халуун чулуу долоосон минь. Дурсамж. УБ., 2009, 111-112 дахь тал*

[38] *МАХН-ын XVI их хурал. УБ., 1976, 31 дэх тал*

[39] *Лань Мэйхуа. Цэдэнбалын цеийн Монгол, Хятадын харилцаа (1952-1984) УБ.: 2019, 92-93 дахь тал*

[40] *William R.Heaton. "Mongolia: In the Troubled Satellite"-Asian Survey. Vol. 13, No. 2 (February 1973). p. 249*

[41] *Negotiating U.S.-Chinese Rapprochement. New American and Chinese Documention Leading Up to Nixon's 1972 Trip. National Security Archive Electronic Briefing Book No. 70*

ЗХУ-ыг Гадаад Монголд 200 мянган цэрэг оруулсан гэж тооцоолж байжээ. Тухайн үед ЗХУ-ын Алс Дорнодын бүс нутгийн цэргийн хүч 30-40 дивиз байсан. Тэгэхлээр ЗХУ-ын нэг дивиз барагцаалбал 10.000-11.000 хүнтэй байсан гэж Тайваний судлаач др. Лань Мэйхуа зохиолдоо бичсэн байна.[42]

1973 оны сүүлийн хагаст Зөвлөлт-Хятадын харилцаа дахин хурцдав. Мөн оны зун Зөвлөлт, Хятадын хэлэлцээнд хилийн асуудлаар тохиролцож чадаагүй, бүр санал зөрөлдөж, улмаар Кремль төлөөлөгчөө эгүүлэн татахад хүрч байжээ. 1973 оны 6 дугаар сард Зөвлөлтийн удирдагч Л.И.Брежнев БНХАУ-тай "Харилцан үл довтлох гэрээ" байгуулах санал гаргасан боловч Хятадын тал хүлээж авсангүй.

1973 оны 8 дугаар сард хуралдсан ХКН-ын X их хуралд Жоу Энлай үг хэлэхдээ: Зөвлөлтийн цэргийг Гадаад Монголоос гарахыг шаардав. БНМАУ ч Жоу Энлайн шаардлагыг няцааж, БНХАУ цэргийн хэргийн явдлаар улайран хөөцөлдөж, үүгээр өөрийн дотоод бэрхшээлээ халхлан нууж байна гэжээ.[43]

1981 оны хавар хуралдсан МАХН-ын XVIII их хуралд оролцсон ЗХУКН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны гишүүн, НТХ-ны нарийн бичгийн дарга М.С.Горбачев хэлсэн үгэндээ: БНМАУ ба холбоотнуудаа батлан хамгаалах явдал нь ЗХУ-ын ариун нандин үүрэг мөн гэж онцлон тэмдэглэсэн байна.[44] Мөн оны 6 дугаар сард ЗХУ-ын БХЯ-ны сайд маршал Д.Устинов тэргүүтэй төлөөлөгчид Улаанбаатар хотод айлчлах үед түүнд Монголд байрлаж буй Зөвлөлтийн цэргүүдийн нөхцөл байдлын талаар танилцуулж, мөн ч төрийн дээд шагнал "БНМАУ-ын баатар" цол, алтан таван хошуу, Сүхбаатарын одонгоор шагнав.[45]

1982 оны 3 дугаар сард Л.И.Брежнев Ташкент хотод үг хэлэхдээ БНХАУ-тай харилцаагаа хэвийн болгох яриа хэлэлцээг үргэлжлүүлэхдээ гуравдагч орнуудад хохирол учруулахгүй хэмээн онцлон мэдэгдсэн байна.[46]

Хятадын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайдын орлогч Дэн Сяопин 1979 оны 1 дүгээр сарын сүүлчээр АНУ-д албан ёсны айлчлал хийж ирээд удаагүй мөн оны 2 дугаар сарын 17-нд БНХАУ-ын цэргийн хүч Кампучийг "түрэмгийлсэн" БНСВУ-ыг хашраах үүднээс тус улсад халдан довтолсон нь олон улсын харилцаанд томоохон асуудал үүсгэв. Үүнтэй холбоотойгоор Өвөрбайгалийн цэргийн тойргоос зөвлөлтийн цэргийн тодорхой анги салбарууд Монголд нэмэлтээр дахин орж иржээ.

Хятад-Вьетнамын дайны үеэр Украин, Белорусаас нисэх хүчний хэд хэдэн хороодыг Монгол руу татаж ирсэн ба Хятадын ар шилэн дээр (хойд хил дагуу) цэргийн сүрийг үзүүлэх замаар энхтайван, шударга

---

[42] *Лань Мэйхуа. Мөн тэнд.*

[43] *Ram Rahul. "Mongolia between China and Mongolia"-Asian Survey. Vol. 18, No.7 (July 1978) p. 663*

[44] *Sanders Alan. "New Faces at the Top"-Far Eastern Economic Review. Vol. 112, No. 26, (June 1981), p. 11*

[45] *Sanders Alan. "The Sabre-Rattling Bear"-Far Eastern Economic Review. Vol. 113, No. 30 (July 17, 1981), p. 16; Yearbook on International Communist Affairs (1982), p. 214*

[46] *Daily Report. (Soviet Union), FBIS, March 25, 1982, p. R7*

ёсыг сэргээн тогтоох амаргүй үүргийг өөртөө хүлээсэн байдаг. ЗХУКН-ын ТХ-ноос гаргасан шийдвэрийн дагуу 1979 оны 3 дугаар сарын 12-26-нд хоёр 7 хоногийн турш хил орчмын цэргийн тойргууд, Монгол дахь ерөнхий цэргийн арми, Номхон далайн флотыг дайчлан тийнхүү сүрийг үзүүлэх цэргийн хээрийн ба далайн сургууль хийжээ. Нийт 20 гаруй дивизийг Хятадын хойд хилийн орчимд тоглолтод оролцуулсан ба чингэхдээ 200 мянган цэрэг, 2600 танк, 900 нисэх онгоцыг хөдөлгөж, далайд байлдааны 80 хөлөг онгоцыг гаргажээ. Үүнд: Монголын тал хээр, говьд явагдсан сургуулилт анхаарал татсан байна. Монголын армиас гадна зөвлөлтийн армийн 6 дивиз оролцсоноос гурав нь эргэж нутаг буцалгүй Монголд үлджээ. Монголын нутагт хоёр бригад, агаарын гурван дивиз орж ирээд эргээд гарсан байдаг. Сибириэс Монгол руу 2000 км маршилсан дайчилгааны хээрийн сургууль хамтдаа явагдаж төмөр зам, агаарын зам, хуурай замын бүх гарцыг ашиглажээ. Хятадын хилийн районуудад контрудар өгөх, контратак хийх цэргийн тактикийг тэр үед боловсруулсан цэргийн урлагийн гайхамшигт тоглолт болсон хэмээн дүгнэж байжээ.

1970-аад оны эхээр Монгол-Хятад, Зөвлөлт-Хятадын харилцаанд учир битүүлэг ноцтой хэрэг явдал гарсан нь Мао Цзедуныг залгамжлагч гэгдэж байсан ХКН-ын дэд дарга маршал **Линь Бяо** нарын сууж явсан Англи улсад үйлдвэрлэсэн Trident-IE 256 дугаартай цэргийн нисэх онгоцны сүйрэл юм. 1971 оны 9 дүгээр сарын 12-ны үдэш дээрх онгоц Бээжингийн нисэх онгоцны буудлаас хөөрч, эхлээд зүүн урагш нисэж байгаад эргэж, чанх хойд зүг рүү жолоогоо эргүүлжээ. Онгоц Өвөр Монголыг өнгөрч, БНМАУ-ын хилийг Сүхбаатар аймгийн Асгат сумын нутгаар зөрчин орж ирсэн агаад тун удалгүй Хэнтий аймгийн Бэрхийн уурхайгаас 14 км зайтай, Суваргын хөндийд 02.30 цагт унаж, сүйрсэн байна.

Энэхүү онгоцны сүйрлийн талаар өнөөг хүртэл баттай нотлогдоогүй олон янзын хувилбар байдаг. КГБ-ын Мэдээлэл шинжилгээний газрын дарга асан дэслэгч генерал Н.Леонов "Известия" сонинд 1995 онд өгсөн нэгэн ярилцлагадаа: "Хамгийн том оньсого бол Хятадын БХЯ-ны сайд Линь Бяогийн үхэл юм. Түүний сууж явсан онгоц Бээжингээс хөөрч Монгол Улсын нутагт унаж осолдсон. ...Бас нэг таамаглал бол сайдыг ЗХУ руу нисч байхыг мэдсэн түүний бие хамгаалагч онгоцон дотор "гал нээсэн" байж болох юм. Гэвч Маогийн үе залгамжлагч байж болохуйц хүний энэ аялалын гол зорилго ийнхүү хэнд ч мэдэгдэлгүй өнгөрсөн юм" гэжээ. Гэтэл өөр нэг баримтад өгүүлэхдээ: "ХКН-ын ТХ-ны орлогч дарга, БХЯ-ны сайд асан Линь Бяо, түүний гэргий Ей Цюнь нар уг онгоцонд сууж яваад амь үрэгдсэнийг тэдний цогцост хийсэн шинжилгээгээр нотолсон байдаг. Маршал Линь Бяо, Мао Цзедуны эсрэг хуйвалдаан зохиож тэр нь бүтэлгүй болсон учир ЗХУ-д зугатан очихоор тийнхүү нисч явсныг Зөвлөлтийн тал хүлээж авбал Зөвлөлт-Хятадын харилцаанд тааж мэдэшгүй уршиг тарьж мэдэхээр байсан учир түүний сууж явсан онгоцыг Монголын нутагт буудан унагаж, өөрсдөө нэр цэвэр гарснаар барахгүй, бас хятадын удирдагчдыг ч түвэг бэрхшээлтэй хэрэг явдал, хэл амнаас аварсан гэж голдуу Өрнөдөд бичсэн байдаг. Энэ бол Trident-IE 256

дугаартай онгоцны сүйрлийг тайлбарласан олон хувилбаруудын нэг нь юм. Нөгөө талаас зөвлөлт, монголын тал сүйрлийг нотлохдоо онгоц гагцхүү нисгэгчийн алдаанаас болж унасан, өөр хөндлөнгийн юу ч нөлөөлөөгүй гэж үзсэн байдаг бол Хятадын албаны хүмүүс хожим монголчууд болон бусад улсын албаны хүмүүст хэлэхдээ онгоцыг Монголд буудаж унагасан гэдгийг нотолсон байдаг байна.[47]

Trident-IE 256 дугаартай онгоц ЗХУ-ын хил нэвтрэхийн өмнө Чита мужийн Өвөр Байгалийн цэргийн тойргоос онгоцыг хүлээж авах боломжгүй гэсэн шийдийг аваад буцаж эргэж урьд зүг рүү нисч явахдаа Өндөрхааны орчим Суваргын хөндийд осолдсон тухай ЗХУ-ын Гадаад яамны орлогч сайд Михайл Капица МАХН-ын ТХ-ны Улс төрийн товчооны гишүүн, ТХ-ны нарийн бичгийн дарга Д.Моломжамцтай Москвагаас хамт нисч явахдаа ярьсан байна. [48]

Тухайн үед Монголын нутагт Хятадын онгоц сүйрч, тэр тухай сонинд товч мэдээ нийтлэхээр ГЯЯ Улаанбаатарт суугаа БНХАУ-ын Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Сюй Вэнь Ий-д урьдчилан мэдэгдэхэд тэрбээр талархаж, мэдээ гаргах нь Монголын Засгийн газрын хэрэг, гагцхүү мэдээний агуулга нь хоёр орны харилцааг хэвийн болгох үзэл санаанд харшлахгүй байгаасай гэж хүсч байна гэсэн нь тэр үед анхаарууштай үг байсан юм" гэж тухайн үед ГЯЯ-ны 1 дүгээр орлогч сайдаар ажиллаж байсан ахмад дипломатч Д.Ёндон дурсжээ.[49] Ийнхүү БНМАУ-д хятадын нисэх онгоц сүйрсэн тухай товч мэдээ "Үнэн" сонинд 1971 оны 9 дүгээр сарын 30-нд нийтлэгдэж[50], БНХАУ байгуулагдсаны ойн өмнөх өдөр хэвлэл, мэдээллийн агентлагууд дэлхий даяар шуугиан тараасан нь олон жил үргэлжилсэн дуулиант хэргийн маргааны эхлэл болжээ.

Линь Бяогийн төрийн эргэлт хийхээр бэлтгэж байсан төлөвлөгөөг "Төсөл 57" гэж нэрлэж байсан байх бөгөөд Жоу Эньлайн саналаар дурдсан төлөвлөгөөг 1972 онд ХКН-ын төв хэвлэл *Жэньминь жибао*-д бүрэн эхээр нь нийтэлжээ.[51]

1973 оны 8 дугаар сард хуралдсан ХКН-ын X их хурал дээр Мао Цзедун "Намын эсрэг Линь Бяогийн бүлэг", "Хувьсгалын эсрэг хуйвалдаан", түүнийг бут цохисон тухай баримтыг хэрэг явдал өнгөрөөд 2 жил болсны дараа албан ёсоор ил гаргаж тавьсан юм. Энэ мэдээллээр бол 1970 оны 8 дугаар сард хуралдсан ХКН-ын 9 дэх удаагийн чуулганы ТХ-ны II бүгд хурал дээр Линь Бяо "төрийн эргэлт" хийхийг оролдсон, мөн 1971 оны 9 дүгээр сарын 8-нд зэвсэгт үймээн зохион байгуулж Мао Цзедуны амь насанд халдан, өөрийн Төв Хороог буй болгохыг хүсч, хуйвалдаан бүтэлгүй болсны дараа 1971 оны 9 дүгээр сарын 13-нд ЗСБНХУ руу нисч

[47] *Hannam, Peter, and Lawrence, Susan V. "Solving a Chinese Puzzle: Lin Biao's Final Days and Death, After Two Decades of Intrigue". U.S. News & World Report. January 23, 1994*

[48] *М.С.Капица. «КНР: три десятилетия — три политики» М., 1979, стр. 216 М.С.Капица. «На разных параллелях. Записки дипломата» М., 1996, стр. 102*

[49] *Д.Ёндон. Том хориг. УБ., 2007, 55 дахъ тал*

[50] *"Үнэн" сонин. 1971.09.30*

[51] 林彪集团*"571*工程*"*纪要全文

яваад, түүний сууж явсан онгоц БНМАУ-ын нутаг Хэнтийн аймгийн Өндөрхаан хотын орчим унаж сүйрсэн гэжээ. 1973 оны 8 дугаар сарын 24-нд ХКН-ын X их хурал дээр тавьсан илтгэлдээ Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Жоу Эньлай дээрх баримтыг мөн тэмдэглэсэн байна.[52] 1970-аад онд ЗХУ тэргүүтэй социалист хамтын нөхөрлөлийн орнууд БНХАУ-ыг НАТО-гийн 16 дахь гишүүн болов хэмээн сүр дулиантай сурталчилж байв. Энэ нь БНХАУ-ыг социалист системээс улам бүр хөндийрүүлэх болж, энэ нь харилцаагаа сайжруулах хэрэгт том саад болж байсан юм.

Чингээд 1976 оны 1 дүгээр сард Варшавт зохион байгуулагдсан ЗХУ, социалист хамтын нөхөрлөлийн орнуудын коммунист, ажилчны намуудын үзэл суртлын асуудал эрхэлсэн нарийн бичгийн дарга нарын зөвлөлгөөнөөр БНХАУ-ыг муучлан бичихээ зогсоохоор шийдвэрлэсэн байна.

Дээрх үйл явдлууд нь Өрнөдийн ном бүтээлүүдэд нэрлэснээр "социалист систем дэх хүйтэн дайн"-ы тод илрэл болсон юм.

Эшлэл авсан, ашигласан материалын жагсаалт

1. OPEN LETTER OF THE CENTRAL COMMITTEE OF THE COMMUNIST PARTY OF THE SOVIET UNION TO ALL PARTY ORGANIZATIONS, TO ALL COMMUNISTS OF THE SOVIET UNION July 14, 1963 **Source:** *The Polemic on the General Line of the International Communist Movement.* Peking: Foreign Languages Press, 1965; pp. 526-586. The open letter was originally published in Russian in *Pravda* on July 14, 1963.
2. Sino-Soviet Split Document Archive *A Proposal Concerning the General Line of the International Communist Movement,* T June 14, 1963, The Letter of the Central Committee of the Communist Party of China in Reply to the Letter of the Central Committee of the Communist Party of the Soviet Union of March 30, 1963, Source: *A Proposal Concerning the General Line of the International Communist Movement. The Letter of the Central Committee of the Communist Party of China in Reply to the Central Committee of the Communist Party of the Soviet Union of March 30, 1963.* Peking: Foreign Languages Press, 1963; pp. 1-61. Transcription: Maoist Documentation Project. HTML: Adjusted by marxists.org, April 2010.
3. Malcolm Byrne, Vladislav Zubok. The Intervention in Afghanistan and the Fall of Dĕtente. A Chronology. The National Security Archive, THE CARTER-BREZHNEV PROJECT.
4. "The Rise and Fall of Dĕtente", Professor Branislav L. Slantchev, Department of Political Science, University of California – San Diego.: 2014

[52] *Иванюк, Иван. Маршал Линь Бяо Разбился в Монголии. Красная Звезда. 7 Май 1994 Козыревь Андрей. Дело Линь Бяо: Загадка Почти Разрешена. Московская Правда. 24 Марта 1994 Дмитриев, Юрий. Последный полет Китайского Маршала. Труд. 9 Апрель 1994*

5. “The Crisis of Dėtente in Europe”. N.Y.: 2008
6. Bowkerl, Mike & Williams, Phil. Superpower Dėtente: *A Reappraisal*. SAGE Publications.: 1988
7. Suri, Jeremi. Power and Protest: Global Revolution and the Rise of Dėtente. Harvard University Press.: 2003
8. Sarotte, M. E. Dealing with the Devil: East Germany, Dėtente and Ostpolitik, 1969–1973. University of North Carolina Press.: 2001
9. Kevorkov, Vyacheslav (2010). Виктор Луи: человек с легендой (Victor Louis: Man with the Legend). Семь Дней (Sem’ Dnei). ISBN 978-5-88149-449-0.
10. Кулик Б.Т, “Советско-Китайский раскол, причины и последствия”. М., 2000 с.212-213
11. ГХТА. Ярианы тэмдэглэл, Хувийн архивын баримт ХН-2, 6-8 дахь тал
12. Д.Ёндон. Том хориг. УБ.: 2007
13. Ж.Бор. Д.Уламбаяр. Монголын дипломатын нэвтэрхий толь бичиг. Дэд боть. К-Р, УБ.: 2014

ЦӨМИЙН ЗЭВСЭГ ХОРИГЛОХ ГЭРЭЭ БА ТҮҮНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ, ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛСОН ҮЙЛ ЯВЦ

Р.Нямдаваа
БХЭШХ-ийн Аюлгүй байдал батлан хамгаалах судлалын төвийн ЭША, докторант

Keywords: *Nuclear weapons, Treaty on the Prohibition of Nuclear Weapons, International Law, United Nations, nuclear-weapon states, Non-nuclear-weapon states, ratification, enter into force*

Abstract: *As Honduras ratified Treaty on the Prohibition of Nuclear Weapons, the treaty has met the requirement to enter into force. According to the text of treaty, that majority of UN member states agreed in 2017, the treaty will enter into force 90 days after the 50th ratification. Even though it is least likely for nuclear-weapon states and their allies to ratify and implement the treaty, having legally binding treaty to comprehensively prohibit nuclear weapons is a huge success that could lead towards total elimination of nuclear weapons. The paper includes the concept of the nuclear ban treaty, progress until its entry into force and further possibility of its implementation.*

Оршил

Хүн төрөлхтний түүхэн дэх хамгийн хөнөөлт зэвсэг буюу цөмийн зэвсэг анх бүтээгдсэн цагаас хойш олон улсын харилцаанд асар их хэмжээний өөрчлөлтийг дагуулсан билээ. АНУ 1945 онд цөмийн зэвсгийг туршиж, улмаар Дэлхийн хоёрдугаар дайныг бүр мөсөн дуусгахын тулд Японы Хирошима, Нагасаки хотуудад цөмийн цохилт өгсөн цагаас хойш олон улсын харилцаа болон их гүрнүүдийн гадаад бодлогыг тодорхойлох чухал хүчин зүйлүүдийн нэг нь цөмийн зэвсэг болсон.

Анх АНУ цөмийн зэвсэг хэрэглэснээс хойш улс орнууд цөмийн зэвсэг хэчнээн аюултай болохыг мэдэх болж, ийм зэвсэгтэй болохыг эрмэлзэх болсноор "цөмийн хувьсгал" эхлэв.[53] Цөмийн зэвсэг бүтээгдсэнээс хойших үеийг бүхэлд нь "цөмийн эрин үе" гэж тодорхойлох нь ч бий.

Цөмийн зэвсэг бүтээгдэхээс өмнө дэлхийн нөлөө бүхий гүрнүүд ашиг сонирхол нь хөндөгдсөн гэж үзвэл хүссэн үедээ дайныг өдөөх хандлага олон улсын харилцаанд зонхилж байсан.

[53] *John Lewis Gaddis et al, "Cold War Statesmen Confront the Bomb: Nuclear Diplomacy since 1945", Oxford University Press, 1999, ISBN 0-19-829469-9, p.37*

Харин дэлхийн бодлогыг тодорхойлогч их гүрнүүд цөмийн зэвсгийг эзэмшсэнээр аль нь ч нөгөөдөө онц ноцтой хор, хөнөөл учруулах боломжтой болж, цөмийн зэвсэг ашиглавал дайн бүх талд ашиггүй байх магадлал өндөр болсон нь дайн гарах эрсдэлийг бууруулсан гэж Кеннет Уолц тэргүүтэй олон улсын харилцааны нео-реалист дэг сургуулийн голлох судлаачид үзэж байна.Тухайлбал Уолц л гэхэд цөмийн зэвсгийн тоо хэмжээ нэмэгдэх тусам тогтвортой байдал хангагдах тухай санааг дэвшүүлж байлаа.[54]

Мөн "аюулгүй байдлын баталгаа", "цөмийн шүхэр" гэх мэт ойлголтууд бий болж голлох их гүрнүүд дундаж болон жижиг улсуудад цөмийн баталгаа өгөх болсон нь ч дайн, түрэмгийлэл багасахад хүргэсэн гэх санааг Констанс Барудос[55], Жозеф Грейко тэргүүтэй судлаач нар дэвшүүлсэн байдаг.[56]

Гэвч нөгөө талаас цөмийн зэвсэг, цөмийн технологи нь олон улсын аюулгүй байдалд хамгийн ихээр заналхийлж буй хүчин зүйлүүдийн нэг тул цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх, хорогдуулах, хориглох, бүрэн устгах тухай асуудал олон жилийн туршид хөндөгдөж байна.

Цөмийн зэвсгийг анх туршсан цагаас цагаас эхлэн энэхүү хөнөөлт зэвсгийг хяналтгүй дэлгэрэхээс сэргийлэх тухай асуудал идэвхтэй хөндөгдсөөр ирсэн. [57]

Харин Кеннет Болдинг тэргүүтэй судлаач нар нео-реалист дэг сургуулийн судлаачдын цөмийн зэвсгээр тогтвортой байдлыг тогтоох тухай санааг бүхэлд нь үгүйсгэдэг[58] бол Роберто Галуччи[59], Граэм Аллисон[60] нар цөмийн зэвсгээр тогтвортой байдлыг хангах тухай ойлголт нэгэнт хоцрогдсон гэж үзэж байна.

Тиймээс энэхүү хөнөөлт зэвсэг оршин байх нь мөн чанартаа олон улсын аюулгүй байдалд заналхийлж байгаа гэж үзэх хандлага хөгжиж буй, цөмийн зэвсэггүй орнуудын судлаачдын дунд зонхилж байгаагийн зэрэгцээ Япон тэргүүтэй их гүрнүүдийн цөмийн хамгаалалтанд байдаг

---

[54] *Kenneth Waltz, "The Spread of Nuclear Weapons: More May Better," Adelphi Papers, Number 171 (London: International Institute for Strategic Studies, 1981)*

[55] *Constance Baroudos- "Nuclear Weapons Enable Peace" Lexington Institute, 2015.05.06 https://www.lexingtoninstitute.org/nuclear-weapons-enable-peace/*

[56] *Arun Vishwanathan- "Understanding Nuclear Proliferation: A Theoretical Analysis", Liberal Studies Journal, Vol.1, Issue 1, 2016, ISSN 2455-9857, p.113*

[57] *Benjamin Joseph Bonin- "Balance of Threat, Balance of Mind: Nuclear Rivalry and Arms Control" University of New Mexico, 2016.02.01, p.6 Benjamin J. Bonin, Balance of Threat, Balance of Mind: Nuclear Rivalry and Arms Control, a doctoral dissertation, (Albuquerque, New Mexico: 2015), p. 6.*

[58] *Harry Kreisler "National Security through Stable Peace" Conversation with Kenneth Boulding, 1987.03.16* http://globetrotter.berkeley.edu/conversations/Boulding/kboulding-con2.html

[59] *Robert Gallucci "Averting Nuclear Catastrophe: Contemplating Extreme Responses to U.S. Vulnerability". Annals of the American Academy of Political and Social Science.2006.09, Issue 607:, p.51–58.*

[60] *Graham Allison"How to Keep the Bomb From Terrorists". Newsweek. 2009.03.13,* http://www.thedailybeast.com/newsweek/2009/03/13/how-to-keep-the-bomb-from-terrorists.html

зарим орны судлаачдын дунд ч цөмийн зэвсгийг устгах ёстой гэж үзэх хандлага хүчтэй хэвээр байна.[61]

Түүнчлэн 1968 оны Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээгээр хүлээн зөвшөөрөгдөөгүй ч хожим цөмийн хөтөлбөр хэрэгжүүлж, цөмийн зэвсэгтэй болсон дөрвөн орон байгаагийн зэрэгцээ одоогоор цөмийн зэвсэггүй ч богино хугацаанд бүтээх боломжтой олон улс байгаа нь цөмийн зэвсэг дэлгэрэх бодит эрсдэлтэй хэвээр байгаа гэж үзэхэд хүргэж байна.

Цөмийн зэвсэг ямар нэг байдлаар тархах нь цөмийн сөргөлдөөн гарах магадлалыг эрс нэмэгдүүлж, санаатай болон санамсаргүй байдлаар цөмийн аюул нэмэгдэхэд хүргэдэг. Энэ нь цөмийн их гүрнүүдийн хоорондох тэнцвэрт нөлөөлдөг.

Мөн АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөх асан, нэрт судлаач Хенри Киссинжер аливаа бүс нутгийн аль нэг орон цөмийн хөтөлбөр хэрэгжүүлж эхлэх нь бүс нутагт нь бүхэлд нь тогтворгүй байдлыг бий болгодог гэх санааг дэвшүүлж, жишээлбэл Иран, Умард Солонгос цөмийн хөтөлбөр хэрэгжүүлснээрээ бүс нутгийн бусад орнуудад ч ижил зам сонгох сэдэл өгнө гэж үзжээ. [62]

Тиймээс цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх, хорогдуулах, цаашлаад бүрэн хориглох шаардлагатай гэж үзэх судлаачид ч олон бий.

Цөмийн зэвсэг байгаа цагт түүнийг хэрэглэх буюу түүгээр далайлгах |айлган сүрдүүлэх|, хими, биологийн, тэр ч байтугай зарим төрлийн ердийн зэвсгийг хэрэглэсний хариуд цөмийн зэвсэг хэрэглэх, цөмийн зэвсэгтэй улс “буу алдах” явдал гарахгүй гэсэн баталгаа үгүй.[63]

Цөмийн туршилтаас гадна цөмийн зэвсгийг тээгч технологиуд асар хурдацтай хөгжин гарч ирж буй нь цөмийн зэвсгийн тархалтын аюулыг нэмэгдүүлж байна.[64]

Энэ хугацаанд Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээ олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр баталгаажиж, хүчин төгөлдөр болж, дэлхийн бараг бүх улс энэ гэрээг дагаж мөрдсөөр байгаа, Цөмийн туршилтыг бүрэн хориглох гэрээ хүчин төгөлдөр болоогүй ч тус гэрээний байгууллагын бэлтгэл ажлыг хангах хороо дэлхий даяар 337 байгууламжаас бүрдсэн цөмийн туршилтыг хянах сүлжээг бий болгосон[65] зэрэг тодорхой амжилтыг дурдах нь зүйтэй. |энэ тоог ишлэлд байгаа вэб сайтаас авсан гэж ойлголлоо, огноо?|

[61] *Hiromichi Umebayashi, Tatsujiro Suzuki- “A Northeast Asia Nuclear Weapon-Free Zone at the New Stage of the Development in Global Nuclear Disarmament and Non-proliferation” Korea Observer, Vol. 47, No. 4, Winter 2016, pp. 963-976*

[62] *Henry Kissinger- “World Order” New York, 2014, p.340*

[63] *Ж.Энхсайхан- “Монголын Цөмийн ирээдүй буюу тус улсын цөмийн аюулгүй байдал, хэтийн төлөв” Улаанбаатар, 2015, 53-р тал*

[64] *С.Баясгалан- “Олон улсын аюулгүй байдал ба Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид статус” Улаанбаатар, 2017, 18-р тал*

[65] *Preparatory Commission for the Comprehensive Nuclear-Test-Ban Treaty Organization (CTBTO Preparatory Commission)* https://www.nti.org/learn/treaties-and-regimes/ctbto-preparatory-commission/

Харин Цөмийн зэвсгийг бүрэн хориглох гэрээг хэлэлцэн батлах тухай асуудал 2010 оноос эхлэн идэвхтэй яригдаж, 2017 онд гэрээний төсөл батлагдсан бол 2021 оны нэгдүгээр сард хүчин төгөлдөр болохоор боллоо.

Их гүрнүүд болон тэдгээрийн цөмийн хамгаалалтанд байдаг улс орнууд гэрээнд нэгдэж, соёрхон батлахгүй, тэр утгаараа дагаж мөрдөхгүй нь үндсэндээ тодорхой ч НҮБ-ын хүрээнд Цөмийн зэвсгийг бүрэн хориглох гэрээ хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн нь энэ чиглэлд гарч буй томоохон амжилт юм.

Үндсэн хэсэг

Дэлхийн эдийн засгийн хүчин чадал өндөртэй, техник, технологи, шинжлэх ухаан өндөр хөгжсөн улс орнууд цөмийн хөтөлбөр хэрэгжүүлэх бодит боломжтой, түүнээс үүдэлтэйгээр цөмийн зэвсгээр уралдах явдал газар авахыг ч үгүйсгэхгүй зэрэг нь цөмийн зэвсгийг бүрэн хориглох асуудал хөндөгдөх эх үндэс болсон. Энэ үзэл Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээний хэрэгжилтийг хянан хэлэлцэх 2010 оны бага хурлын баримт бичигт тодорхой хэмжээнд тусгалаа олсон билээ.[66]

Түүнчлэн цөмийн зэвсэг террорист бүлэглэлүүдийн гарт орох бодит эрсдэл нэмэгдсээр байгаа, эдийн засаг, технологийн хүчин чадал харьцангуй сул улс орнууд ч цөмийн зэвсэг бүтээх боломж байгаа нь Пакистан, Умард Солонгосын жишээнээс харагдсан нь ч үүнд түлхэц өгсөн.

Цөмийн зэвсгийг хориглох тухай асуудал энэхүү зэвсэг анх бий болсоны дараахнаас хөндөгдөж ирсэн одоо хүчин төгөлдөр болж буй олон улсын гэрээний төслийг боловсруулах үйл явц 2010 оны бага хурлын дараагаар эхэлсэн.

Цөмийн зэвсэгтэй таван гүрэн буюу НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн таван орон буюу АНУ, ОХУ, Их Британи, Франц, БНХАУ-ын хувьд цөмийн зэвсгийг бүрэн хориглох олон улсын гэрээтэй байхыг анхнаасаа ил болон далд хэлбэрээр эсэргүүцсээр ирсэн.

Тиймээс цөмийн зэвсэгтэй гүрнүүд хүлээн зөвшөөрөгүй цагт цөмийн зэвсгийг хориглох нь хийсвэр зүйл гэж үзэж байсан зарим судлаачид цөмийн зэвсгийг бүрэн хориглох гэрээ байгуулж, хүчин төгөлдөр болох боломжгүй, хүчин төгөлдөр болсон ч бодит нөхцөл байдал дээр хэрэгжих боломжгүй гэж үзэж, илүү хэрэгжих боломжтой зорилт тавих ёстой гэж үзэж байлаа. [67]

Харин жижиг улс орнууд, тэр дундаа цөмийн зэвсэггүй бүсийн орнууд цөмийн зэвсгийн асуудлыг хүмүүнлэгийн үр дагаварын талаас харж, хэд хэдэн удаагийн Засгийн газар хоорондын яриа хэлэлцээг зохион байгуулсан билээ.

[66] *"Final document of 2010 Review Conference of the Parties to the Treaty on the Non-Proliferation of Nuclear Weapons" New York, 2010* https://undocs.org/NPT/CONF.2010/50%20(VOL.%20III)

[67] *Article36- "Banning nuclear weapons without the nuclear armed states" Briefing Paper. 2013.10* https://article36.org/wp-content/uploads/2013/10/Banning-without.pdf

Цөмийн зэвсгийг хүмүүнлэгийн талаас нь авч үзэх энэхүү шинэлэг хандлагын талаар 2013 онд Осло хотноо хэлэлцэхэд 128 улс оролцсон бол 2014 онд Мексикийн Наярит хотноо болсон хуралд 146 улсын төлөөлөгч, 100 гаруй иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл оролцсон байна. 2014 оны 12 дугаар сард Австрийн нийслэл Вена хотноо хуралдсан 3 дахь хуралд 158 орны төлөөлөгч, мөн бараг ийм тооны иргэний нийтмийн байгууллага оролцжээ.

Харин НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн гишүүн 5 орон цөмийн зэвсгийн холбогдолтой асуудлыг аажмаар, алхам алхмаар шийдвэрлэх хэрэгтэй гэж үзэн, Ослогийн бага хурлыг хэт яаравчлан хийлгэж буй хурал хэмээн бойкотлон оролцоогүй боловч Наяритын бага хуралд зарим нэг нь ажиглагчаа илгээв.[68] Наяритын бага хурлыг цөмийн зэвсгийг хориглох чиглэлд гарсан түүхэн үйл явдал дүгнэдэг бөгөөд энэхүү бага хурлын үеэр дэлхийн улс орнуудын олонх нь цаашид цөмийн зэвсгийг хориглох олон улсын гэрээ байгуулах чиглэлээр яриа хэлэлцээг эрчимжүүлэхээр тохиролцсон бол хурлын дарга энэхүү хурлын үр дүнд цөмийн зэвсгийг хориглох үйл явцаас "ухрах замгүй болсон" гэж дүгнэж байлаа.[69]

Цөмийн зэвсэгтэй гүрнүүд болон тэдгээрийн ихэнх холбоотнууд анхнаасаа Цөмийн зэвсгийг хориглох гэрээтэй холбоотой аливаа бага хурал, хэлэлцүүлэг, арга хэмжээнд оролцохгүй байх, оролцсон ч ажиглах үүрэгтэйгээр харьцангуй доогуур түвшний албан тушаалтнуудыг оролцуулах чиглэл баримталж байлаа. Хэдий тийм ч бусад улс орнууд 2 жилийн дотор явагдсан 3 удаагийн бага хурлын үеэр энэ асуудлаар тодорхой ойлцолцолд хүрч чадсан.

Харин гэрээг батлахад гол үүрэгтэй оролцож байсан Ирланд, Австри, Өмнөд Африк тэргүүтэй зарим цөмийн зэвсэггүй улс орны Засгийн газрууд, цөмийн зэвсгийг устгах чиглэлээр ажилладаг олон улсын болон иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс өмнө нь биологийн болон химийн зэвсгийг олон улсын гэрээ, конвенциор хориглосон тул цөмийн зэвсгийг ч хориглох боломжтой гэж үзэж байв.

Цөмийн зэвсгийн аюулыг хүмүүнлэгийн талаас нь авч үзсэн гурван удаагийн удаагийн уулзалтын дараагаар буюу 2014 онд цөмийн зэвсэггүй улс орнууд цөмийн зэвсэг хориглохыг Цөмийн зэвсгийг хориглох гэрээ нь мөн чанартаа Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээний 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэх үр дүнтэй алхам хэмээн тодорхойлж, тайлбарлаж эхэлсэн.

Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудал хөндөгдөхөд 6 дугаар зүйл буюу гэрээний оролцогч бүх талууд "цөмийн зэвсгээр хөөцөлдөх явцлыг аль болох богино хугацаанд зогсоож, олон улсын хатуу, үр дүнтэй хяналтын дор цөмийн зэвсгийг бүрэн хураах гэрээг байгуулах чиглэлээр ажиллах үүрэг хүлээх"[70] заалт

[68] *Ж.Энхсайхан- "Монголын Цөмийн ирээдүй буюу тус улсын цөмийн аюулгүй байдал, хэтийн төлөв" Улаанбаатар, 2015, 54-р тал*

[69] *PAX for Peace-"Nayarit point of no return: Mexico conference marks turning point towards nuclear weapon ban" 2014.02.15* https://www.paxforpeace.nl/stay-informed/press/nayarit-point-of-no-return-mexico-conference-marks-turning-point-towards-nuclear-weapon-ban

[70] *"Treaty on the Non-Proliferation of Nuclear Weapons" 1968, Moscow, London, Washington*

хэрэгжихгүй байна гэх шүүмжлэл Хүйтэн дайн дууссан цагаас хойш улам бүр эрчимжиж байна.[71]

АНУ, ОХУ тэргүүтэй их гүрнүүдийн хувьд илүүдэл цөмийн зэвсгээ хорогдуулснаа Үл дэлгэрүүлэх гэрээний 6 дугаар зүйлийг дагаж мөрдөх чиглэлд авч хэрэгжүүлсэн алхам гэж тайлбарладаг ч мэргэжилтнүүд цөмийн зэвсэгтэй гүрнүүд энэ зүйл, заалтыг биелүүлэх чиглэлд хангалтгүй ажилласан гэж нийтээрээ дүгнэдэг.[72]

Тиймээс цөмийн зэвсэггүй орнууд болон цөмийн зэвсгийг хориглох гэрээг дэмжиж байсан улс орнуудын хувь гэрээг байгуулах асуудлыг цөмийн эрх зүйн чиглэлийн гол баримт бичиг бол Үл дэлгэрүүлэх гэрээтэй холбон авч үзсэн нь оновчтой алхам байсан.

Харин нөгөө талаас цөмийн зэвсэгтэй орнууд цөмийн зэвсэг хориглох гэрээ нь мөн чанартаа Үл дэлгэрүүлэх гэрээний оролцогч улс орнуудын хооронд хагарал үүсгэж, Үл дэлгэрүүлэх гэрээний ач холбогдлыг бууруулж, Үл дэлгэрүүлэх дэглэмд аюул учруулна гэж тайлбарлаж эхэлсэн. [73]

Гэрээ батлагдсаны дараагар АНУ, Франц, Их Британи хамтран гэрээ олон улсын харилцааны бодит байдалтай нийцэхгүй байгаа тул тус гэрээнд нэгдэн орохгүй гэдгээ мэдэгдэж байсан[74] бол бусад цөмийн зэвсэгтэй орнууд ч гэрээтэй холбоотой уулзалт, яриа хэлэлцээнд оролцохоос зайлсхийж байсан. Мөн эдгээр гүрнүүдийн цөмийн хамгаалалтад байдаг НАТО-ийн орнууд болон Япон, Австрали тэргүүтэй бусад тивийн орнууд ч гэрээг дэмжихээс анхнаасаа цааргалсаар ирсэн.

Харин цөмийн зэвсэггүй орнууд Цөмийн зэвсгийг хориглох гэрээ нь Үл дэлгэрүүлэх гэрээтэй зэрэгцэн орших төдийгүй тус гэрээг "дэмжих" гэрээ болно гэсэн байр сууриндаа бат зогсоор байлаа.

Улмаар дэлхийн улс орнуудын нэг хэсэг нь буюу цөмийн зэвсэгтэй орнууд болон тэдгээрийн холбоотнууд Цөмийн зэвсэг хориглох гэрээг үгүйсгэж, шаардлагагүй хэмээн үзэж байсан бол нөгөө талаас дэлхийн улс орнуудын олонх нь буюу цөмийн зэвсэггүй орнууд энэ гэрээг зайлшгүй шаардлагати хэмээн үзэж байв.

НҮБ-ын Ерөнхий Ассемблей 2015 онд энэ асуудлаар ажлын хэсэг байгуулж[75], 2016 оны 8 дугаар сард "цөмийн зэвсгийг хориглох болон

D.C., Article 6

[71] *Davis Simon- "Article VIOf The Non-Proliferation Treaty Is A Pactum De Contrahendo And Has Serious Legal Obligation By Implication"* https://www.law.upenn.edu/journals/jil/jilp/articles/2-1_Simon_David.pdf

[72] *Enkhsaikhan Jargalsaikhan- "Nuclear non-proliferation and disarmament at the crossroads – a Mongolian perspective" Global Change, Peace & Security, 2018. Volume 30, p.251-260*

[73] *Sharon Squassoni- "Lessons from Global Disarmament Efforts for Regional Nuclear Non-proliferation" Blue Banner NGO, Institute for Strategic Studies- "International conference on Nuclear Disarmament issues: Global and Regional Aspects" Ulaanbaatar, 2017, p.89*

[74] *"Joint Press Statement from the Permanent Representatives to the United Nations of the United States, United Kingdom and France following the adoption of a treaty banning nuclear weapons" 2017.07.07*

[75] *UN General Assembly resolution 70/33, adopted 7 December 2015*

бүрэн устгах чиглэлээр эрх зүйн хүрээнд зайлшгүй дагаж мөрдөх баримт бичгийг байгуулах" чиглэлээр 2017 онд хэлэлцүүлэг явах зөвлөмжийг гаргажээ.

Энэхүү зөвлөмж дээр үндэслэн, Ерөнхий Ассемблейн Нэгдүгээр хороо буюу Зэвсэх хураах болон Олон улсын аюулгүй байдлын асуудал эрхэлсэн хороо 2017 онд Цөмийн зэвсгийг хориглох гэрээний асуудлаар хэлэлцээ хийж эхлэх тогтоолыг хэлэлцэн батлахад дэлхийн 123 улс дэмжсэн түүхтэй.

Улмаар 2017 оны 3 сарын 27-31-нд "Цөмийн зэвсгийг хориглох, бүрэн устгахад чиглэсэн заавал дагаж мөрдөх баримт бичгийг хэлэлцэх НҮБ-ын бага хурал" буюу эхний олон талт яриа хэлэлцээ НҮБ-ын хүрээнд зохион байгуулагдахад 132 улс оролцсон. Эхний хэлэлцүүлгийг зохион байгуулахад идэвхтэй оролцсон Засгийн газрын болон иргэний төлөөлөгч нар тус гэрээний төслийг тухайн оны 6, 7 дугаар сард батлах боломжтой гэсэн ерөнхий шийдэлд хүрч, гэрээний эхний төслүүд ч удалгүй бэлэн болж эхэлсэн билээ.

Харин 2017 оны 6 сарын дунд үеэс хоёр дахь бага хурал эхэлж, НҮБ-ын гишүүн 193 улсын олонх нь буюу 121 нь хэлэлцүүлэгт оролцжээ. [76]

Улмаар 20 гаруй хоногийн туршид хэлэлцүүлэг өрнөж, гэрээний 2, 3 дахь төслүүдийг боловсруулж, хэлэлцсэний эцэст урьдчилан товлоод байсны дагуу 2017 оны 7 сарын 7-нд Цөмийн зэвсгийг хориглох гэрээний эхийг батласан.

Хэдийгээр энэхүү гэрээний эх болон төслийг хэлэлцэх үйл явц, санал хуралтад цөмийн зэвсэгтэй гүрнүүд болон тэдгээрийн холбоотнууд оролцоогүй ч НҮБ-ын гишүүн орнуудын олонх нь буюу 122 орон гэрээг дэмжиж, эхийг нь батлаж чадсан билээ.

Тус хэлэлцүүлэгт НАТО-ийн гишүүн нэг л орон оролцсон нь Нидерланд улс байсан бөгөөд гэрээний эхийг батлахад ганцаараа татгалзсан санал өгсөн.

Энэхүү гэрээнд нэгдэн орсон улс орнууд цөмийн зэвсгийг хориглох чиглэлээр тодорхой үүрэг хариуцлага хүлээхээр тусгасан бөгөөд үндсэн зарчим нь гэрээнд нэгдсэн аливаа улс цөмийн зэвсгийг "хөгжүүлэх, турших, үйлдвэрлэх, боловсруулах болон бусад замаар олж авах, эзэмшихийг хориглох"[77] заалт дээр тулгуурлаж байна.

Гэрээний эх батлагдаж, НҮБ-ын хүрээнд Цөмийн зэвсгийг хориглох гэрээ бий болсон нь зэвсэг хураах чиглэлд гарсан томоохон амжилт байсан. Энэхүү үйл явцад НҮБ тэргүүтэй олон улсын байгууллагууд, тодорхой жижиг улс орнууд голлон идэвхтэй оролцсоноос гадна иргэний нийгмийн байгууллагууд онцгой үүрэг гүйцэтгэсэн.

[76] *United Nations, ed. "United Nations Conference to Negotiate a Legally Binding Instrument to Prohibit Nuclear Weapons, Leading Towards their Total Elimination – Partici pants". 5 July 2017.*

[77] *"Treaty on the Prohibition of Nuclear Weapons" New York, 2017.07.07, 1.1.a*

Тэр дундаа Швейцарийн Женев хотод төвтэй “Цөмийн зэвсгийг устгах олон улсын кампанит ажил” байгууллага нь гэрээ батлагдахад гол нөлөө үзүүлсэн тул тухайн онд Нобелын Энх тайвны шагналыг хүртэж байв.[78]

Харин гэрээний эхийг хэлэлцэх үйл явцад идэвхтэй оролцсон мэргэжилтнүүдийн хувьд Австри, Ирланд, Бразил, Индонези, Мексик, Нигер, ӨАБНУ, Тайланд гэсэн орнууд гэрээний эх батлагдахад гол нөлөө үзүүлсэн гэж дүгнэдэг.

Ямартай ч 6 жил орчмын туршид үргэлжилсэн хүчин чармайлтын үр дүнд гэрээний эхийг батласан ч гэрээ хүчин төгөлдөр болох асуудал хурцаар тавигдсаар байв. Учир нь гэрээнд зааснаар НҮБ-ын гишүүн 50 орон гэрээг соёрхон батласнаас 90 хоногийн дараа гэрээ албан ёсоор хүчин төгөлдөр болох зохицуулалттай. [79]

Гэрээний эх батлагдсанаас 2 сарын дараа буюу 2017 оны 9 сарын 20-ноос эхлэн гэрээн гарын үсэг зурах боломжтой байхаар зохицуулсан бөгөөд НҮБ-ын гишүүн 50 орчим орон тухайн өдөр нь гэрээнд гарын үсэг зурсан. Харин одоог хүртэл буюу 3 жил гаруйн хугацаанд гэрээнд нийтдээ 84 улс албан ёсоор гарын үсэг зураад байна.

Гэтэл эдгээр орнуудын ихэнх нь гэрээнд гарын үсэг зурсан ч соёрхон батлалгүй байсаар гэрээ хүчин төгөлдөр болж чадалгүй өдийг хүрсэн. Үүнд тухайн улс орнуудад үйлчилдэг олон улсын гэрээ, конвенцийг хууль тогтоох байгууллагаар соёрхон батлах дэг, дотоод улс төрийн уур амьсгал нөлөөлснийг үгүйсгэхгүй. Түүнчлэн их гүрнүүдийн зүгээс ч ил болон далд хэлбэрээр гэрээг хүчин төгөлдөр болох үйл явцад саад учруулах оролдлого хийсэн гэж мэргэжилтнүүд үздэг.

Анх гэрээний эхийг батласны дараа энэ чиглэлийн мэргэжилтнүүд богино хугацаанд гэрээ хүчин төгөлдөр болох боломжтой гэж үзэж 50 улс соёрхон батласны дараа хүчин төгөлдөр болохоор тусгасан нь их ч биш, бага ч биш зохистой тоо гэж үзэж байлаа.

Гэтэл бодит нөхцөл байдал дээр гэрээний эхийг дэмжиж, батласан улс орнуудын ихэнх нь гэрээг соёрхон батлалгүй азнаснаас шалтгаалан энэ үйл явц 3 жил гаруй үргэлжлж байна. Улмаар 2020 оны 10 дугаар сард Тувалу, Ямайк, Науру болон Гондурас улсууд гэрээг соёрхон батласнаар Цөмийн зэвсгийг хориглох гэрээ 2021 оны 1 сард хүчин төгөлдөр болох нөхцөл бүрдлээ. [80]

Мэдээж энэхүү гэрээнд Үл дэлгэрүүлэх гэрээгээр хүлээн зөвшөөрөгдсөн цөмийн зэвсэгтэй улс орнууд болон бусад цөмийн зэвсэг эзэмшигч улсууд, түүнчлэн их гүрнүүдээр аюулгүй байдлаа хангуулдаг буюу “цөмийн шүхрийн” орнууд, түүнчлэн их гүрнүүдээс ихээхэн хамааралтай жижиг улс орнууд нэгдэн орох магадлал туйлын бага.

---

[78] *The Nobel Peace Prize 2017,* https://www.nobelprize.org/prizes/peace/2017/summary/

[79] *“Treaty on the Prohibition of Nuclear Weapons” New York, 2017.07.07, 15.1*

[80] *United Nations Treaty Collection- “Treaty on the Prohibition of Nuclear Weapons”* https://treaties.un.org/Pages/ViewDetails.aspx?src=TREATY&mtdsg_no=XXVI-9&chapter=26&clang=_en

Гэхдээ 10 орчим жилийн хугацааг дамнан үргэлжилсэн үйл явцын үр дүн НҮБ-ын хүрээнд хүчин төгөлдөр Цөмийн зэвсгийг хориглох гэрээ хэрэгжиж эхэллээ.

Их гүрнүүд болон тэдгээрийн холбоотнууд гэрээнд нэгдэх орохгүй бол гэрээг заавал дагаж мөрдөх үүрэг хүлээхгүй ч НҮБ-ын хүрээнд хүчин төгөлдөр эрх зүйн зохицуулалт байх нь их гүрнүүдэд урт хугацаандаа улс төрийн шахалт болох боломжтой юм.

Түүнчлэн зарим эрдэмтдийн хувьд цөмийн зэвсэггүй орнууд энэ асуудлаар нэгдмэл байх нь их гүрнүүдэд шахалт үзүүлэхэд хамгийн чухал хүчин зүйл гэж үздэг. Гэвч зарим цөмийн зэвсэггүй орнууд аюулгүй байдлын хувьд болон бусад талаараа их гүрнүүдээс хамааралтай байгаа нь эдгээр орнуудын дунд хуваагдал үүсч, зарим нь цөмийн зэвсэгтэй улсуудыг дэмжихэд хүргэж байна.

Ямартай ч энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсноор хүн төрөлхтөн НҮБ-ын хүрээнд өмнө нь хими, биологи зэрэгтодорхой төрлийн зэвсэглэлийг хориглож чадсан бол дараагийн томоохон алхам буюу олон улсын гэрээ, конвенциор цөмийн зэвсгийг хориглох чиглэлд томоохон ахиц гарлаа.

Дүгнэлт

Цөмийн зэвсэг, цөмийн технологи олон улсын харилцааг үндсээр нь өөрчилж, анх 1945 онд энэхүү зэвсгийг амжилттай туршсан цагаас хойш олон улсын аюулгүй байдал цөмийн зэвсгээс ихээхэн хамааралтай болсон.

Цөмийн зэвсэг бүтээгдэж, дэлхийн нөлөө бүхий гүрнүүд, тэр дундаа сөргөлдөгч талууд энэхүү зэвсгийг эзэмшсэнээр аль нь ч нөгөөдөө ноцтой хохирол учруулах боломжтой болсон тул их гүрнүүдийн хооронд том хэмжээний дайн, зэвсэгт мөргөлдөөн гарахаа больсон, тэр утгаараа цөмийн зэвсэг олон улсын харилцаанд “тэнцвэржүүлэгч”-ийн үүргийг гүйцэтгэж байгаа гэж үзэх хандлага одоо ч энэ салбарын эрдэмтдийн дунд оршсоор байна.

Гэвч нөгөө талаасаа цөмийн зэвсгийн аюул, заналыг хүмүүнлэгийн талаас нь авч үзвэл энэ зэвсэг оршин буй нь өөрөө бүхий л хүн төрөлхтний хувьд аюул учруулж байгаа гэж үзэх бүрэн үндэстэй.

Тиймээс цөмийн зэвсгийг хориглох ёстой, тэгэхийн тулд энэ зэвсгийг хориглох олон улсын эрх зүйн заавал дагаж мөрдөх зохицуулалт шаардлагатай гэж үзэх хандлага ч 2011 оноос илт газар авч, хэд хэдэн удаагийн бага хурал, уулзалтууд зохион байгуулагдсан.

Эдгээр арга хэмжээний үр дүнд, 2015 оноос НҮБ-ын Ерөнхий Ассемблей энэ асуудалд онцгой анхаарч, улмаар Цөмийн зэвсгийг хориглох гэрээний эхийг 2017 онд батласан билээ.

Тус гэрээнд заасны дагуу 50 улс гэрээг соёхон батласнаар хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээний эх батлагдсанаас хойш 3 жил гаруйн хугацаанд хүчин төгөлдөр болох үйл явц үргэлжлэсний эцэст, Гондурас улс энэ оны 10 дугаар сард гэрээг соёрхон батласнаар гэрээ ирэх оны 1 сард албан ёсоор хүчин төгөлдөр болох гэж байна.

Анх НҮБ-ын гишүүн 122 оронд гэрээний эхийг дэмжсэн байтал эдгээр орнуудын зарим нь гэрээнд нэгдэх, улмаар соёрхон батлахаас цаараалсаар байсан нь гэрээ хүчин төгөлдөр болох үйл явц илт сунжрахад хүргэсэн. Үүнийг их гүрнүүдийн зүгээс жижиг улс орнуудадад үзүүлсэн шахалт болон бусад улс төрийн хүчин зүйлтэй холбон тайлбарлах судлаачид ч бий.

Мэдээж их гүрнүүдийн хувьд анх гэрээ боловсруулах тухай асуудал хөндөгдөж эхлэхээс л энэ гэрээг ил болон далд хэлбэрээр эсэргүүцэж байсан. Тэр утгаараа цөмийн асуудал хэт яарч хандаж болохгүй, энэ төрлийн гэрээ бодитоор хэрэгжих боломжгүй гэх мэт байр суурийг баримталсаар ирсэн.

Их гүрнүүдээс гадна аюулгүй байдлын хувьд болон бусад талаараа тэднээс хамааралтай улс орнууд гэрээний хэлэлцүүлэгт анхнаасаа оролцоогүй бөгөөд цаашдаа ч нэгдэх, соёрхон батлах магадлал маш бага юм. Тэр утгаараа гэрээнд нэгдээгүй нөхцөлд дагаж мөрдөх үүрэг хүлээхгүй. Тиймээс энэ гэрээг бодит үр дүнгүй гэх санааг ч зарим судлаач илэрхийлдэг.

Гэвч энэ гэрээний гол ач холбогдол нь НҮБ-ын хүрээнд заавал дагаж мөрдөх гэрээ батлагдаж, хүчин төгөлдөр болж, цөмийн зэвсгийг хориглосноороо их гүрнүүдэд улс төрийн шахалт үзүүлэхэд оршино гэж үзэх үндэс бий.

Цаашдаа гэрээнд илүү олон улс нэгдэх, соёрхон батлах тусам, өөрөөр хэлвэл цөмийн зэвсэггүй улс орнууд энэ асуудлаар нэгдмэл байх тусам гэрээ бодит үр өгөөжөө өгөх нөхцөл бүрдэнэ ч гэж дүгнэх боломжтой.

Эшлэл авсан, ашигласан материалын жагсаалт

1. John Lewis Gaddis et al, “Cold War Statesmen Confront the Bomb: Nuclear Diplomacy since 1945”, Oxford University Press, 1999, ISBN 0-19-829469-9,
2. Kenneth Waltz, “The Spread of Nuclear Weapons: More May Better,” Adelphi Papers, Number 171 (London: International Institute for Strategic Studies, 1981)
3. Constance Baroudos- “Nuclear Weapons Enable Peace” Lexington Institute, 2015.05.06 https://www.lexingtoninstitute.org/nuclear-weapons-enable-peace/
4. Arun Vishwanathan- “Understanding Nuclear Proliferation: A Theoretical Analysis”, Liberal Studies Journal, Vol.1, Issue 1, 2016, ISSN 2455-9857, p.113
5. Benjamin Joseph Bonin- “Balance of Threat, Balance of Mind: Nuclear Rivalry and Arms Control” University of New Mexico, 2016.02.01, p.6 Benjamin J. Bonin, Balance of Threat, Balance of Mind: Nuclear Rivalry and Arms Control, a doctoral dissertation, (Albuquerque, New Mexico: 2015), p. 6.

6. Harry Kreisler “National Security through Stable Peace” Conversation with Kenneth Boulding, 1987.03.16 http://globetrotter.berkeley.edu/conversations/Boulding/kboulding-con2.html
7. Robert Gallucci “Averting Nuclear Catastrophe: Contemplating Extreme Responses to U.S. Vulnerability”. Annals of the American Academy of Political and Social Science.2006.09, Issue 607:, p.51–58.
8. Graham Allison”How to Keep the Bomb From Terrorists”. Newsweek. 2009.03.13, http://www.thedailybeast.com/newsweek/2009/03/13/how-to-keep-the-bomb-from-terrorists.html
9. Hiromichi Umebayashi, Tatsujiro Suzuki- “A Northeast Asia Nuclear Weapon-Free Zone at the New Stage of the Development in Global Nuclear Disarmament and Non-proliferation” Korea Observer, Vol. 47, No. 4, Winter 2016, pp. 963-976
10. Henry Kissinger- “World Order” New York, 2014, p.340
11. Ж.Энхсайхан- “Монголын Цөмийн ирээдүй буюу тус улсын цөмийн аюулгүй байдал, хэтийн төлөв” Улаанбаатар, 2015, 53-р тал
12. С.Баясгалан- “Олон улсын аюулгүй байдал ба Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид статус” Улаанбаатар, 2017, 18-р тал
13. Preparatory Commission for the Comprehensive Nuclear-Test-Ban Treaty Organization (CTBTO Preparatory Commission) https://www.nti.org/learn/treaties-and-regimes/ctbto-preparatory-commission/
14. “Final document of 2010 Review Conference of the Parties to the Treaty on the Non-Proliferation of Nuclear Weapons” New York, 2010 https://undocs.org/NPT/CONF.2010/50%20(VOL.%20III)
15. Ж.Энхсайхан- “Монголын Цөмийн ирээдүй буюу тус улсын цөмийн аюулгүй байдал, хэтийн төлөв” Улаанбаатар, 2015, 54-р тал
16. PAX for Peace-“Nayarit point of no return: Mexico conference marks turning point towards nuclear weapon ban” 2014.02.15 https://www.paxforpeace.nl/stay-informed/press/nayarit-point-of-no-return-mexico-conference-marks-turning-point-towards-nuclear-weapon-ban
17. “Treaty on the Non-Proliferation of Nuclear Weapons” 1968, Moscow, London, Washington D.C., Article 6
18. Davis Simon- “Article VIOf The Non-Proliferation Treaty Is A Pactum De Contrahendo And Has Serious Legal Obligation By Implication” https://www.law.upenn.edu/journals/jil/jilp/articles/2-1_Simon_David.pdf
19. Enkhsaikhan Jargalsaikhan- “Nuclear non-proliferation and disarmament at the crossroads – a Mongolian perspective” Global Change, Peace & Security, 2018. Volume 30, p.251-260
20. Sharon Squassoni- “Lessons from Global Disarmament Efforts for Regional Nuclear Nonproliferation” Blue Banner NGO, Institute for Strategic Studies- “International conference on Nuclear Disarmament

issues: Global and Regional Aspects" Ulaanbaatar, 2017, p.89

21. "Joint Press Statement from the Permanent Representatives to the United Nations of the United States, United Kingdom and France following the adoption of a treaty banning nuclear weapons" 2017.07.07
22. UN General Assembly resolution 70/33, adopted 7 December 2015
23. United Nations, ed. "United Nations Conference to Negotiate a Legally Binding Instrument to Prohibit Nuclear Weapons, Leading Towards their Total Elimination – Participants". 5 July 2017.
24. "Treaty on the Prohibition of Nuclear Weapons" New York, 2017.07.07, 1.1.a
25. The Nobel Peace Prize 2017, https://www.nobelprize.org/prizes/peace/2017/summary/
26. "Treaty on the Prohibition of Nuclear Weapons" New York, 2017.07.07, 15.1
27. United Nations Treaty Collection- "Treaty on the Prohibition of Nuclear Weapons" https://treaties.un.org/Pages/ViewDetails.aspx?src=TREATY&mtdsg_no=XXVI-9&chapter=26&clang=_en

УЛАМЖЛАЛТ БА УЛАМЖЛАЛТ БУС АЮУЛ НЬ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН УХААНЫ НЭГ СУДЛАГДАХУУН БОЛОХ НЬ

П.Цэдэв
БХЭШХ-ийн Батлан хамгаалах дүн шинжилгээний төвийн ЭША доктор(Ph.D), профессор
С.Бямбасүрэн
Докторант

Keywords: Threat, jeopardize, security, traditional, and non-traditional threat disaster.

Abstract: It reviews that a traditional and non-traditional threat would be the subject of security science. It insights a concept and essence of the security science, while it to know what would be a study and subject the security science. It also covers a definision and classification of a traditional and non-traditional threat. It also studies that a threat, jeopardize, disaster are the subject of the non-traditional threat.

Оршил

Аливаа улс орон иргэдээ гадаад, дотоодын аюул, заналт хүчин зүйлээс хамгаалах үүрэгтэй, тогтолцоотой билээ.

Шинэ зуун эхлээд тавын нэгдээ орж буй хэдий ч хүн терөлхтний аюулгүй амар тайван амьдрах орчин тийм ч таатай биш, урьдын уламжлалт аюул заналтай зэрэгцэн уламжлалт бус аюулын цоо шинэ төрөл хэлбэр үүсэх нь ч элбэг болсоор байна. Ийм учраас уламжлалт бус аюулын талаар авч үзэх шаардлага гарч байна.

Уламжлалт ба уламжлалт бус аюул нь аюулгүй байдлын ухааны судлагдахуун болох асуудлыг авч үзэхдээ юуны өмнө аюулгүй байдлын онолын үндсийг судалж мэдэх хэрэгтэй юм. Мөн уламжлалт бус аюулын судлагдахуун нь аюул, занал, гамшиг мөн болох нь авч үзнэ.

1. Аюулгүй байдлын онолын асуудалд

Хүн амыг гамшиг, гэнэтийн бусад аюул, үй олноор устгах зэвсгийн хөнөөлөөс хамгаалах нь батлан хамгаалах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд нэгдсэн төлөвлөлт, нэгдмэл тогтолцоотой[81] байна гэжээ.

[81] *Монгол Улсын Их Хурлаар 2015 онд батлагдсан "Монгол Улсын батлан хамгаалах бодлогын*

Аливаа үг ухагдахууныг боловсруулахдаа юуны өмнө ойлголтын аппарат /тогтоц/-ыг шинжлэн үзэх хэрэгтэй болдог.

Цэргийн нэрт онолч Карл фон Клаузевиц 19-р зууны эхээр Карл фон Клаузевец (Клаузевиц 1816 оноос эхлээд 1831 онд 51 настайдаа нас барах хүртлээ "Дайны тухай" гэдэг алдарт бүтээлээ туурвижээ. Түүний бэлэвсэн эхнэр Мария нь 1832 онд уг бүтээлийг анх хэвлүүлсэн байдаг) Өөрийн мөнхийн бүтээлдээ бичихдээ "Аливаа онолын нэн тэргүүний зорилт бол бүрхэг, онцгой ихээр будлиантсан ойлголт төсөөллүүдийг журамлах нэгдмэл ойлголтод оруулах явдал юм. Нэр томьёоны болон ойлголтуудын талаар зөвшөөрөлцсөн тохиолдолд л зөвхөн авч үзэж буй асуудалд амжилт олох болно[82]" гэжээ.

Шинжлэх ухааны мэдлэгийн тогтолцоонд өөрийн байр суурийг эзэлдэг аюулгүй байдлын ерөнхий онол байдаг.

Нэрт академич В.И.Вернадский "Хүн геологийн хүчин зүйл болж хувирснаас, хүн төрөлхтнийг мөхлийн ирмэгт аваачсан глобаль чанартай асуудлууд олноор бий болсон" гэж урьдчилан хэлсэн нь өнөө үед улам бүх баталгаажиж байна[83]. Тэрбээр "одоо цагт, хүн төрөлхтөн өөрийгөө сөнөөн устгахад хүргэхгүйн төлөө тэмцлээс илүү эрхэм, хүмүүнлэг үүрэг байхгүй[84]" гэж тэмдэглэсэн юм.

Аюулгүй байдлын ухааныг ШУ-ны доктор, профессор О.Үржин, доктор, профессор Ч.Улаанхүү нарын олон судлаачид хүн төрөлхтний үйл ажиллагаагаар үүссэн аюулаас хүмүүс ба хүрээлэн буй орчны хамгаалагдсан байдлын тухай мэдлэгийн систем бөгөөд бие даасан шинжлэх ухааны салбар ухаан байх ёстой[85] гэдэг дүгнэлтэд хүрч байна.

Аюулгүй байдлын онол - хүн, нийгмийн амьдрал үйл ажиллагаа, амьдрахуйн аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэх эрх зүй, зарчим, чиглэл, нөхцөл байдлын тухай бодьтой төсөөлөл мэдлэг олгох үндсэн үзэл санааны тогтолцоо юм[86] гэжээ.

Аливаа шинжлэх ухаан нийгмийн ухамсарын нэг хэлбэрийн хувьд хүний ажиллагааны хүрээтэй холбогддог учраас бүх шинжлэх ухаан, шинжлэх ухааны болон практик чиглэл нь хүний амьдрал үйл ажиллагааг хангахад чиглэдэг зүй тогтлын дагуу хүн төрөлхтөний хөгжлийн явцаар аюулгүй байдлыг хангах асуудал нь хэмжээний илэрхийллийн хувьд хүн, нийгэм, улс, дэлхийн аюулгүй байдал болж өргөжсөн бөгөөд XXI зуунд аюулгүй байдал гариг ертөнцийн асуудал болоод байна.

Тиймээс ч *аюулгүй байдал судлалын судалгааны гол объект нь улс, нийгэм, хувь хүмүүсийг оролцуулсан хүн төрөлхтөн, харин судлах*

үндэс", 2.6 заалт

[82] *Клаузевиц К. О войне. М.: Гос. ВИ НКО СССР, 1936. – Т. I.*

[83] *Үржин о нарын, "Гамшгаас хамгаалах менежментийн үндэс, УБ., 2017, 6 талд*

[84] *Н.С.Шатский, А.Л.Яншин "Изучая научное наследие", стр 12*

[85] *БХЭШХ, Үржин О, Монгол Улсын аюулгүй байдал: онол, аргазүй, орчны шинжилгээ, Аюулгүй байдлын ерөнхий онол, аргазүйн үндэс, УБ., 2019, 5 талд*

[86] *Улаанхүү Ч, Аюулгүй амьдралын үндэс, УБ., 2016, 36 талд*

зүйл нь ноосферийн[87]хүрээнд өөрсдийн амьдрал цйл ажиллагаа болон амьдрах орчин нөхцөлийн аюулгүй байдлыг хангах талаарх тэдгээрийн ажиллагаа юм.

Соёл иргэншил талаас нь тайлбарлавал, аюулгүй байдал судлалын судалгааны обьект нь хүн, нийгэм, соёл иргэншил, судлах зүйл нь олон төрлийн бцх аюул занал, янз бүрийн нөхцөл байдал, хөгжил, орон зай, цаг хугацааны хүчин зүйлс дэх хүн, нийгэм, соёл иргэншлийн аюулгүй байдал юм[88].

Өнөө үед аюул заналын илрэлийн янз бүрийн хүрээ, хэмжээ, хүн ба хүн төрөлхтний аюулгүй байдлыг хангах янз бүрийн чиглэлийн онол, арга зүй, туршилт, хавсрага судалгаа болон боловсруулалтын талаарх нийтлэлийн агуулга нь аюулгүй байдал судлал үүсэн тогтнох шатандаа оршиж байгааг харуулж байна[89] гэж дүгнэсэн нь чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Шинжлэх ухааны ойлголт болон туршилтаас үүдэлтэй баримт сэлтүүдийн нийлбэр цогцын өвөрмөц хураангуй нь аливаа шинжлэх ухаан бүрийн хүрээнд аюулгүй байдал судлалын судлагдахууны талбарыг бүрдүүлж өгдөг. Иймд шинжлэх ухааны асуудлын бүх цогцыг багтаах зорилгоор аюулгүй байдлын тухай шинжлэх ухааныг секьюритолог гэж нэрлэх нь зүйтэй[90]гэж үзсэн байдаг. “Секьюритолог” нэршил нь латины securitas-аюулгүй байдал ба грекийн logos-үг, сургаал гэсэн үгнээс бүрдсэн, тиймээс “аюулгүй байдлын тухай шинжлэх ухаан” гэж орчуулагддаг. Өөрөөр хэлбэл, секьюритолог (бид цаашид “аюулгүй байдал судлал” гэж нэрлэж хэрэглэв) бол хүн төрөлхтөн болон хүний амьдрал үйл ажиллагааны аюулгүй байдлын тухай шинжлэх ухаан мөн[91].

[87] *Ноосфер нь биосферийн хуулиуд ба хүн төрөлхтний ухамсартай цйл ажлын харилцан ажиллагааны цр дүнд бий болсон байдал мөн. Ноосфер нь нийгэм ба байгалийн харилцан ажиллагааны хүрээ ба тцүний хязгаар дахь хүн төрөлөхтний ухамсартай цйл ажиллагаа хөгжлийн тодорхойлогч хүчин зүйлс болно. Өнгөрсөн зууны төгсгөлд В.И.Вернадский хими, биологи, антрополог ба бусад шинжлэх ухааны амжилтийн цндсэн дээр хүн төрөлхтний цйл ажиллагаа дэлхийн бүрхүүлийн хөгжлийн геолого-өөрчлөгч (хувиргагч) цндсэн хүчин зүйлс болно гэсэн дүгнэлтэд хүрсэн. Эндээс биосфер болон нийгмийн хөгжлийн хамтын судалгаа, тэдгээрийн хүн төрөлхтнийг хамгаалах болон аюулгүй хөгжилд захирагдах нь зайлшгүй болохыг харж болно. Биосфер аажмаар шинэ байдалд шилжих болно. Үцнийг хожим (20-иод онуудад) Э.Леруа ноосфер гэж нэрлэсэн. Академич Н.Н.Моисеевын үзэж байгаагаар Вернадскийн биосферийн хөгжлийн тухай, тцүний ноосферийн байдалд шилжих боломжийн тухай сургааль нь тцүний цндсэн цйл явц “Ухааналр” тодорхойлогдох цед XX зууны шинжлэх ухааны орчин цейн “дэлхийн зураглал”-д оруулсан чухал хувь нэмрийн нэг мөн юм.*

[88] *Үржин О, Монгол Улсын аюулгүй байдал: онол, аргазүй, орчны шинжилгээ УБ., 2019, 6 талд*

[89] *Үржин О, Монгол Улсын аюулгүй байдал: онол, аргазүй, орчны шинжилгээ УБ., 2019, 6 талд*

[90] *Ярочкин, В. И.Секьюритология : Наука о безопасности жизнедеятельности. – М. : Ось-89, 2000 . – 400 с. - ISBN 5-86894-317-1.*

[91] *Мөн тэнд*

Аюулгүй байдлын ерөнхий онол байх бөгөөд тэр нь аюулын бүх төрлийг судалдаг. Гэхдээ түүнийг ямар ч салбарын аюулгүй байдлыг хангах нэгдсэн нэг зарчимтай, ерөнхий, түгээмэл онол гэж ойлгож болохгүй. Учир нь аюулгүй байдлын судалгааны салбарууд нь маш олон, аюулын шинж чанар нь өөр өөр байдаг учраас тэлгээрийн талаар нэгдсэн мэдлэгийг үүсгэнэ гэдэг нь зохиомол зүйл болно[92].

Судлаач миний үзэж байгаагаар *аюулгүй байдал судлалын ухаан гэдэг* нь байгалийн болон техногений аюул заналын чиг хандлага, шинж чанарын талаарх судалгаа, шинжлэх ухааны хууль, зарчмуудын цэгцтэй тогтолцоо болж, аюул занал үүсэх, хүн, нийгэм, байгаль орчинд хэрхэн нөлөөлөх, түүнээс хүн ам, хүрээлэн байгаа орчныг хамгаалах зүй тогтол, улс орны аюулгүй байдлын хүчний байгуулалт, аюул заналаас урьдчилан сэргийлэх, тэмцэх-хариу арга хэмжээг авах, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, хүмүүнлэгийн үйл ажиллагааг явуулах аргын тухай иж бүрэн мэдлэгийн систем юм гэж ойлгож болно. Энэхүү аюулгүй байдал судлалын ухааныг хөгжүүлэх шаардлага тавигдаж байдаг.

Аюулгүй байдал судлал нь өөрийн ерөнхий шинжлэх ухааны статусаар суурь-хавсарга шинж чанарын орчин цагийн цогц шинжлэх ухаан мөн[93].

Аюулгүй байдал судлалын *суурь судалгааны утга санаа* нь тэрээр өнөөгийн байгаа шинжлэх ухааны аль ч салбарын авч үзэхгүй байгаа тийм салбарын зүй тогтлыг судалж, танин мэдэхэд оршиж байна.

Аюулгүй байдал судлалын *хавсарга шинж чанар* нь суурь судалгааны үндсэн дээр бусад тусгай шинжлэх ухаанд тулгуурласан тийм практик боловсруулалтууд хийгддэгт оршиж байна.

Аюулгүй байдал хүн төрөлхтний үйл ажиллагаанаас ангид өөрөө оршин тогтнохгүй. Тэр нь өөрийгөө хамгаалах ба хөгжих үүрэгтэй нийгмийн амьдралын бүх талтай нягт холбоотой. Аюулгүй байдлын төрөл бүрийн (эдийн засгийн, улс төрийн, экологийн, мэдээллийн, цэргийн гэх мэт) үзэл санаа олон шинжлэх ухаанаар боловсруулагдаж байна.

Зөвхөн онолын үндэслэлтэй суурь ухагдахуун, ойлголтын тодорхойлолт л аливаа асуудалд харилцан ойлголцол болон нэгдсэн хандлага бий болгож чаддаг ба норматив, эрх зүйн баримт бичгүүдэд тусгалаа олдог.

Аюулгүй байдал судлалын “аюулгүй байдал” гэсэн хамгийн ерөнхий суурь ухагдахуун олон үйл явцад хэрэглэгддэг бөгөөд мөн чанарын хувьд *нэг талаас*, аюулгүй байдлын зөвхөн тодорхой тохиолдолд байдаг онцгой шинжийг агуулахын зэрэгцээ *нөгөө талаас*, төрөл бүрийн салбарт энэ ухагдахууныг ашиглах боломжийг нөхцөлдүүлж байдаг.

ШУ-ны доктор, профессор О.Үржингийн дүгнэлтээр “аюулгүй байдлын ерөнхий онол, арга зүйгээр шинжилбэл, хүйтэн дайны дараах үед аюулгүй байдлын системийн онол,арга зүйд нэг том өөрчлөлт гарч,

[92] *Эрдэнэчимэг Б, Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого, УБ., 2016, 30 талд*

[93] *Л.Үржин, Монгол Улсын аюулгүй байдал: онол аргазүй, орчны шинжилгээ, УБ., 2019, 13 талд*

түүнийг дагасан синергетик буюу аяндаацэгцрэх тогтолцооны дараах үйл явц өрнөсөн. Өөрчлөлтийн хувьд, төр улсын аюулгүй байдалд голлон төвлөрдөг "үндэсний аюулгүй байдал" нь хувь хүн,хамтын нийгэмлэгийг тэргүүнд тавьдаг "хүний аюулгүй байдал" болон хувирсан явдал"[94] юм.

Аюулгүй байдлын онол, арга үндэс түүний ойлголт, мөн чанарын талаар ШУ-ны доктор, профессор О.Үржин, доктор, дэд профессор Б.Эрдэнэчимэг нар Монгол Улсын аюулгүй байдал: онол, аргазүй, орчны шинжилгээ[95] бүтээлдээ нэлээд тодорхой авч үзсэн байна. Эдгээр эрдэмтийн "Судалгаанаас үзэхэд "аюулгүй байдал"-ын хамгийн ерөнхий ухагдахуун харилцан хамаарал бүхий гурван төлөв байдлыг илэрхийлсэн байна. Үүнд:

1. аюулаас ангид, өөрөөр хэлбэл аюул байхгүй байдал;
2. аюулаас хамгаалагдсан байдал;
3. хөгжлийн нөхцөл бүрдүүлсэн байдал" гэж үзсэн байна.

Эхний төлөв байдлыг хэл шинжлэлийн философи утга талаас өгсөн тодорхойлолтын өнцгөөс үзвэл: *нэг талаас* "аюулгүй-аюул байхгүй, айж эмээх, сандрах түгшүүргүй; аюулгүй байдал-осол, түгшүүргүй байх; аюулгүй байдал-осол, түгшүүргүй байх төлөв"[96] гэж зөвхөн аюул байхгүй байдлыг илэрхийлсэн бол *нөгөө талаас* "аюулгүй байдал-аюул байхгүй, бүтэн байлгах, найдвартай байдал"[97] гэж аюул байхгүй, хамгаалагдсан байдал, хөгжлийн нөхцөл бүрдүүлсэн байдал зэргийг аль алиныг нь багтаасан илүү өргөн цогц хүрээгээр илэрхийлэгдэж байна[98] гэжээ.

Үндэсний аюулгүй байдлын тогтолцооны онол-үзэл санааны үндэсний тодорхой хэсэг нь ихэвчлэн улсын хэмжээний бусад ерөнхий баримт бичгүүдэд тусгалаа олсон байдаг. Ийм баримт бичиг нь тухайн улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Батлан хамгаалах тухай, Зэвсэгт хүчний тухай, Онц байдлын тухай, Орон нутгийн хамгаалалтын тухай, Гамшгаас хамгаалах тухай хуулиуд, Батлан хамгаалах улс орны эдийн засаг, нийгэм-улс төрийн болон оюун санааны хөгжлийн урт хугацааны төлөвлөгөө (хөтөлбөр), Төрийн батлан хамгаалах бодлогын үндэс, Төрийн цэргийн номлол, цэргийн байгуулалтыг хөгжүүлэх, Зэвсэгт хүчний байгуулалтыг боловсронгуй болгох хөтөлбөрүүд хамаарна. Эдгээр баримт бичгүүдэд нийгмийн амьдралын бүхий л хүрээний болон түүний тодорхой салбарын хууль, эрх зүйн үндсийг хэдий чинээ сайн тусгаж өгнө, үндэсний аюулгүй байдлын тогтолцооны үзэл баримтлал, онолын үндэс төдийчинээ боловсронгуй болж, үр дүнтэй хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

---

[94] *Монгол Улсын аюулгүй байдал: онол, аргазүй, орчны шинжилгээ, 2019. УБ., 24 талд*

[95] *Монгол Улсын аюулгүй байдал: онол, аргазүй, орчны шинжилгээ, 2019. УБ., 5-24 талд*

[96] *Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, А-Г., ШУА, УБ., 2008, 594 х:, и. 176.*

[97] *Далийн тайлбар толь байгаа ухагдахууны "бүтэн байлгах" гэдгийг хамгаалагдсан байдал, найдвартай байдал гэдгийг тогтвортой хөгжлийн ойлголттой дүйцүүлэн тайлбар хийсэн байна.*

[98] *Монгол Улсын аюулгүй байдал: онол, аргазүй, орчны шинжилгээ, 2019. УБ., 17 талд*


Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд, үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зарчмуудад[99]: Эх оронч үндэсний үзлийг дээдлэх, Төр, иргэний хамтын ажиллагаа, Аюулгүй байдлын бодлого цогц, Мэдлэгт суурилах, Бодитой хандах, Даяаршлын хүчин зүйлийг харгалзах байх гэсэн 6 байдлаар тодорхойлсон байдаг.

Аюулгүй байдлын бодлого цогц байх зарчмыг "Монгол Улсын "оршин тогтнохуйн аюулгүй байдал", "эдийн засгийн аюулгүй байдал", "дотоод аюулгүй байдал", "хүний аюулгүй байдал", "хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал", "мэдээллийн аюулгүй байдал" харилцан уялдаатай хангагдсанаар үндэсний аюулгүй байдал баталгаажна[100]" гэж заасан байна.

Аюулгүй байдлын ойлголт, хүчин зүйлс хүрээ улам баяжсаар байна. Тухайлбал, анх Копенгагены Их Сургуулийн профессор Б.Бузан хамтрагч О.Вейверийн хамт 1983 онд "People, States and Fear" /Ард түмэн, Төр, Айх аюул/ хэмээх бүтээлдээ уламжлалт аюулгүй байдлын ойлголт халагдаж, орчин цагт аюулгүй байдал нь цогц ойлголт болсон байна. Энэ онол нь тухайн үедээ ихээхэн шуугиан тарьж байсан бөгөөд одоо ч ач холбогдолоо алдаагүй гэж үзэж байна.

Түүний аюулгүй байдлын цогцойлголтын онол /Security compleh theory)-оор цэргийн, улс төрийн, эдийн засгийн, социеталь (нийгмийн), инвайронменталь /экологи хүрээлэн буй байгаль орчин/ гэсэн 5 төрөл, хүчин зүйлс ньаюулгүй байдлыг цогцоор тодорхойлоход хүргэж байна.

Профессор Б.Бузаны Аюулгүй байдлын төрлийг 1дүгээр зургаар үзүүлэв.



1дүгээр зураг. Аюулгүй байдлын төрөл.

Дээрх төрөлд хамрах хүчин зүйс, холбогдох зорилтыг 1 дүгээр хүснэгтээр тодорхойлсон байна.

[99] *Монгол улсын үндэсний аюулгүй байдлынүзэл бариmтлал, 1.2 дахъ заалт*
[100] *Аюулгүй байдлын бодлого цогц байх зарчим1.2.3. заалт*

1 дүгээр хүснэгт

Аюулгүй байдлын төрөлд хамрах хүчин зүйсийг тодорхойлсон байдал.

№	Аюулын төрөл	Холбогдох судлах зүйл
	Цэргийн	*Төр улс эсвэл бусад улс төрийн оролцогч* Дайн, цөмийн зэвсэг, зэвсэглэлээр хөөцөлдөх, ашиг сонирхлын зөрчил, сөргөлдөөн
	Улстөрийн	*Бүрэн эрхт байдал* **Энэ аюул нь** аль ч улсын санаа зовох асуудал юм. Төр нь улс төрийн нэгдэл болдог учраас энэхүү нэгдэл сулрах нь цэргийн аюултай эн зэрэгцэнэ. Төрийн аюулгүй байдал нэн тэргүүнд төрийн тогтвортой байдал, түүний удирдлагын систем, мөн үзэл суртал зэргээс шууд хамаарна.
	Эдийнзасгийн	*Пүүс, компани, фирм, цйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага* **Энэ аюул** нь эдийн засгийн өөрийн мөн чанараас хамааран тодорхойлоход хамгийн түвэгтэй. Зах зээлийн эдийн засаг дахь тоглогчдын үйл ажиллагаа бол эрсдэлтэй, харгис өрсөлдөөн хийгээд тодорхойгүй байдал. Б.Бузан эдийн засгийн болон цэргийн аюулгүй байдлын хоорондын чухал холбоог анхаарсан юм.
	Социеталь ((нийгмийн	*/Хамтын бцлэг /шашин, цндэстэн* **Энэ аюул** нь нийт нийгэм, хүмүүсийн өөрийн адилтгал (identity), түүний бүрэлдэхүүн хэсэгтэй холбоотой. Зарим төр адилтгал, соёлын ялгааны учрыг олж чадахаа байдаг.
	Хүрээлэн буй орчин (экологийн)	Биосфер дэх үйл явц, хүрээлэн буй байгаль орчин/ / ...хүмүүсийн хоорондын харилцаа экологиийн **Энэ аюул** бол дулаарал, цөлжилт, ган, зуд, үер, гал түймэр, орчны бохирдол, озоны давхраа цоорох гэх мэт олон аюулыг дурьдаж болно.

Дээрх хүснэгтээс үзэхэд, аюулгүй байдлын төрөлд хамрах хүчин зүйс нь цэргийн, улс төрийн, эдийн засгийн, социеталь (нийгмийн), инвайронменталь /экологийн/ аюулгүй байдал гэсэн төрлүүдтэй байна.

Аюулгүй байдал гэдэг нь аюул заналхийлэлээс ангижрах хүсэл эрмэлзэл ба аливаа улс орон, нийгэм нь өөрсдийн дайсагнасан гэж үздэг тухайн өөрчлөлтөөс өөрийн халдашгүй бие даасан байдал болон үйл ажиллагааны бүрэн бүтэн байдлаа хадгалах чадвар юм. Аюулгүй байдлын доод түвшин нь эсэн мэнд амьдрах явдал боловч амьдралын нөхцөл байдлын талаарх олон талт асуудлы гаюулгүй байдлын хүрээнд хамруулах нь зүйтэй[101] юм.

[101] *Buzan B. New Pattern of Global Security in Twenty First Century"// International Affairs. Vol. 67.No. 3. London: RIIA, 1991. P. 431–451.*

2. Уламжлалт бус аюулын судлагдахуун нь аюул, занал, гамшиг мөн болох нь

Монгол хэлд "Аюул" гэсэн категори буюу ухагдахууныг хэл шинжлэлийн хувьд "гамшиг зовлон учруулж болох хор хөнөөл, гай"[102] гэж мөн чанарыг нь илэрхийлсэн байдаг. Харин ойлголт хэрэглээ талаас нь авч үзвэл "Аюул-хүн амын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах, нийгэм-эдийн засгийн үйл ажиллагааг тасалдуулах эсвэл хүрээлэн буй орчинг доройтуулах ноцтой үйл явдал, үзэгдэл, эсвэл хүний үйл ажиллагаа юм.

Аюулд ирээдүйд гамшиг учруулах нуугдмал нөхцөл байдал хамрагдаж болох бөгөөд янз бүрийн гаралтай: байгалийн (геологийн, ус, цаг уурын, биологийн) эсвэл хүний үйл ажиллагаанаас үүссэн (хүрээлэн буй орчны доройтол, технологийн аюул) байж болно"[103] гэж олон улсын хамтын нийгэмлэгээс тодорхойлсон байна. Түүнчлэн манай зарим судлаачдын бүтээл[104] болон хуулинд[105] ойролцоо томьёолол өгч эргэлтэд оруулсан байна.

Аюул, осол гэсэн үгийн утга санааг Лонгманы толь бичигт аюул /hazard/-ыг "аюултай байж болох ямар нэг зүйл", осол (accident)-ыг "хэн нэгний санамсаргүй байдлаас үүдэж хэн нэгэн хүн гэмтэх эсвэл ямар нэг эд зүйл эвдрэх нөхцөл" гэж тайлбарлан бичсэн бол википедия нэвтэрхий тольд "аюул нь амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд заналхийлэх түвшинг илэрхийлэх нөхцөл байдал, осол (accident) нь гол төлөв санаачлага болон шаардлага хангах байдал дутагдсантай холбоотойгоор үүсдэг санаандгүй болон төлөвлөөгүй үзэгдэл юмуу нөхцөл байдал хэмээн тайлбарлажээ.

Аюул гэдэг нь сөнөөх, сүйтгэх шинж чанар бүхий обьект, хүчин зүйлсийн зүгээс хүн, амьд байгаль, ямар нэгэн зүйлд хор хохирол учруулах магадлалын ойлголт юм[106]. Аюулын хоршоо үг нь "аюул занал - айдас түгшүүр" юм. Занал бол аюулын илүү тодорхой бөгөөд шууд хэлбэр юм. Аюул ба занал нийгмийн аюулгүй байдлын янз бүрийн түвшинг өөртөө төлөөлнө. Занал бол зөрчлийн хамгийн хурцдамал шат.[107]

Аюул бол ирээдүйд аюул занал учруулж болох ч, байнга далд байдалд байдаг нөхцөл байдал болно. "Аюул" бол бүрэн ойлгогдох бөгөөд

---

[102] *Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. А-Г., ШУА., УБ., 2008, 594 х., т.175.*

[103] *Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх СЕНДАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ. УБ., 2016, 58 х., т. 4.*

[104] *О.Үржин, П.Цэдэв Гамшгаас хамгаалах үндэс /Ажилтан албан хаагчдад зориулав/. УБ., 2017, 163 х. ""Байгаль орчны болон нийгэм, эдийн засгийн доройтол, хүний эрүүл мэнд, амь нас эрсдэх, мал амьтан хорогдох, эд хөрөнгө сүйрэх, хүрээлэн буй орчинд хохирол учруулж болзошгүй аливаа үзэгдэл, тохиолдол, хүний бууруутай үйл ажиллагаа зэргийг аюул гэнэ".*

[105] *Гамшгаас хамгаалах тухай хууль,. УБ., 2003, заалт 4.1.5. ""Аюул" гэж хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй аюулт үзэгдэл, осол, хүний бууруутай үйл ажиллагааг хэлнэ"*

[106] *Улаанхүү.Ч, Аюулгүй байдлын онол арга зүйн асуудал, УБ., 2014, 15 талд*

[107] *Энх-Амгалан Д. "Уламжлалт бус аюул, түүний нийгэмд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга зам", дисс. 2016, 19 талд*

хөнөөх шинж чанарыг агуулсан обьектив ба субьектив хүчин зүйлүүд байгаагаар тодорхойлогдоно. Аюул үр дүнд аюулын байдал муудаж болох сөрөг нөлөөллийн бодитой байгаа боломжийг өөртөө төлөөлнө. Аюулын дарааллын шинж нь түүний эчнээ, ирээдүйд холбогдсон байдагт оршино. Аюул нь "сөрөг үзэгдэл" явагдах үед эсвэл тийм боломж арилсаны дараа, эсвэл эсрэгээр түүний хэрэгжсэнээр алга болно (өөрөөр хэлбэл аюул гэж ангилагдахаа болино)[108].

Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын гаргасан судалгаа [109]- гаар аюулыг 3 ангилан үзжээ.

Нэгд, ***гаднаас ирэх аюул****/* үй олноор хөнөөх зэвсэг, цэргийн аюулаас гадна геополитикийн дарамт, шахалт; нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд учирч буй аюул; хилийн маргаан; хөрш зэргэлдээ улсууд дахь тогтворгүй байдлын нөлөө гэх мэт/.

Хоёрт, ***дотоод аюул****/* сул үр нөлөөгүй засаглал болон түүний доройтож буй чадавхын асуудал тухайлбал, авилга, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй хавсарсан засаглалын сул институц; эдийн засаг, санхүүгийн сул хямрал; байгалийн болон хүний хүчин зүйлээс үүдэлтэй гамшиг,эдийн засгийн сэдэлтэй гэмт хэрэгтүүнээс үүдсэн айдас ...гэх мэт/.

Гуравт, ***үндэстэн дамнасан аюул*** / терроризм, зохион байгуулалттай гэмт хэрэг, хууль бус наймаа, кибер аюул, цөмийн гамшиг;дэлхийн экологийн өөрчлөлт, хөрс, усны доройтол, хүнсний болон бусад нөөцийн хомсдол/ гэжээ.

Түүнчлэн үндэстэн дамнасан бусад аюулд байгалийн нөөцийн хомсдол, авилгын өндөр түвшин зэргийг хамруулан авч үзсэн байна.

Аюулд ирээдүйд гамшиг учруулах нуугдмал нөхцөл байдал хамрагдаж болох бөгөөд янзбүрийн гаралтай: байгалийн (геологийн, ус, цаг уурын, биологийн) эсвэлхүний үйл ажиллагаанаас үүссэн (хүрээлэн буй орчны доройтол, технологийн аюул) байж болно" гэж Хеогийн үйл ажиллагааны баримт бичиг тодорхойлсон[110] байна. Түүнчлэн манай зарим судлаачдын бүтээл[111] болон хуулинд[112] ойролцоо томьёолол өгөн эргэлтэд оруулсан байна.

---

[108] *Кортунов.С.В. Становление политики безопасности: Формирование политики национальной безопасности России в контексте глобализации. М.: Наука, 2003. стр. 37-38.*

[109] *ЕАБХАБ-ын бүс нутаг дахь аюулын тухай ойлголт, Судалгаа*


[110] *Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйлажиллагааны хүрээ.УБ., 2016, 58 х„ т. 4.*

[111] *О.Уржин, П.Цэдэв Гамшгаас хамгаалах үндэс /Ажилтан албан хаагчдад зориулав/. УБ., 2017, 163 х. ""Байгаль орчны болон нийгэм, эдийн засгийн доройтол, хүний эрүүл мэнд, амь нас эрсдэх, мал амьтан хорогдох, эд хөрөнгө сүйрэх, хүрээлэн буй орчинд хохирол учруулж болзошгүй аливаа үзэгдэл, тохиолдол, хүний бууруутай үйл ажиллагаа зэргийг аюул гэнэ".*

[112] *Гамшгаас хамгаалах тухай хууль,. УБ., 2003, заалт 4.1.5. ""Аюул" гэж хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй аюулт үзэгдэл, осол, хүний бууруутай үйл ажиллагааг хэлнэ"*

Монгол Улсын орон нутгийн хамгаалалтын тухай хуульд “уламжлалт аюул” гэж дайсан этгээдээс учруулах цэргийн аюулыг[113] хэлнэ гэсэн бол “уламжлалт бус аюул[114]” гэж байгалийн болон хүний хүчин зүйлээс учрах цэргийн бус аюулыг хэлнэ заажээ. Энэ байдлаа үзэхэд аюулыг дараа байдлаар ангилж болно.

Зарим улс, орнуудын судлаачид аюулыг уламжлалт болон уламжлалт бус аюул гэж ангилаж байна. Аюулыг ангилсан байдлыг 1дүгээр зургаар үзүүлэв.



1 дүгээр зураг. Аюулын ангилал.

Бодит байдалд ямар нэгэн тодорхой аюул, эсвэл аюулын магадлал байнга оршиж байдаг. Аюулын хамгийн хурц хэлбэр нь дайн, зэвсэгт мөргөлдөөн, хувьсгал, үймээн самуун, байгалийн аюул болон нийтийг хамарсан гамшиг юм.

Уламжлалт бус аюулын ерөнхий нэр томьёоллыг өргөн утгаар нь “гамшиг” гэсэн байдлаар ойлгож, түүнтэй тэмцэх арга, ажиллагааг зохион байгуулах нь уламжлалт бус аюулын бодлого, цэл ажиллагааны зохицуулалтын үндсийг бүрдүүлж болно.

Дэлхийн хэмжээнд өнгөрсөн 10 жилийн хугацаанд гамшгийн улмаас олон хүний амь нас үрэгдэж, хүн ам, олон нийт, улс орны аюулгүй байдал, сайн сайхан аж байдалд сөргөөр нөлөөлсөн байна.

Нийтдээ 700 гаруй мянган хүн амь насаа алдаж, 1.4 сая гаруй хүн гэмтэж бэртэн 23 орчим сая хүн орон гэргүй болсон байна.1.5 тэрбум гаруй хүн гамшигт ямар нэг байдлаар нэрвэгджээ.Эмэгтэйчүүд, хүүхэд, эмзэг бүлгийн иргэд харилцан адилгүй өртсөн байна. Нийт учруулсан хохирлын хэмжээ нь 1.3 их наяд ам.доллар болжээ[115].

[113] *Монгол Улсын орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 4.1.4. зүйлд*
[114] *Монгол Улсын орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 4.1.5. зүйлд*
[115] *НҮБ “ Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн цэл ажиллагааны хүрээ” баримт бичиг, 4 талд*

Монгол Улсад жилд дунджаар 3500 орчим аюулт үзэгдэл, осол гарч үүний улмаас 200 гаруй хүн амь насаа алдаж, 700 орчим хүн гэмтэж бэртэн, 950 мянган орчим толгой мал хорогдож ойролцоогоор 70 гаруй тэрбум төгрөгийн шууд хохирол учирч байна. Манай улсад 2004-2019 онд буюу сүүлийн 15 жилийн хугацаанд дунджаар 3707 удаа аюулт үзэгдэл осол тохиолдсон бөгөөд цаашид өсөх хандлагатай байгаа нь харагдаж байна. Энэ хугацаанд жилд дунджаар 220 хүн нас барж, 574 хүн бэртэж гэмтэжээ. Нийт 3707 гамшиг ослын 3187 буюу 94.8 хувь нь обьектын түймэр 173 буюу 5,1 хувь нь ой хээрийн түймэр, нийт 90,6 хувийг гал түймрийн гаралт эзэлж байна.[116] Жилд дунджаар 1632 гэр орон сууц, 3 сая га талбай шатаж, 440 гэр байшин нурж сүйдсэн байна. Ой, хээрийн түймэр болон обьектын түймэрт эндэж нас барсан хүний тоог харьцуулсан байдлаас үзэхэд 2004-2019 онд ой, хээрийн түймэрт зөвхөн 34 хүн буюу жилд дунджаар 2 хүн нас барсан байхад обьектын түймэрт мөн энэ хугацаанд нийт 1003 хүн буюу жилд дундаар 66 хүн нас барсан байна. Эдийн засгийн хохирлын хувьд жилд дунджаар 86.4 тэрбум төгрөгийн хохирол учирч байна.

Дээрх хохирол учруулж байгаа байдал нь уламжлалт бус аюулыг судлах шаардлага байгааг харуулж байна.

Дүгнэлт

Аюулгүй байдал судлалын судалгааны гол обьект нь улс, нийгэм, хувь хүмүүсийг оролцуулсан хүн төрөлхтөн, харин судлах зүйл нь ноосферийн хүрээнд өөрсдийн амьдрал үйл ажиллагаа болон амьдрах орчин нөхцөлийн аюулгүй байдлыг хангах талаарх тэдгээрийн ажиллагаа болно.

Аюулгүй байдлын цогц ойлголтын онолоор цэргийн, улс төрийн, эдийн засгийн, социеталь (нийгмийн), инвайронменталь /экологи хүрээлэн буй байгаль орчин/ гэсэн 5 төрөл, хүчин зүйлс нь аюулгүй байдлыг цогцоор тодорхойлоход хүргэж байна.

Олон Улсын гаргасан судалгаагаар аюулыг гаднаас ирэх болон дотоодын, үндэстэн дамнасан гэж 3 ангилж болно.

Уламжлалт аюул нь дайсан этгээдээс учруулах цэргийн аюул (дайны аюул;байлдааны ажиллагаа, зэвсэгт мөргөлдөөн; цөмийн зэвсгийн хөнөөл; зэвсэглэлээр хөөцөлдөхийн аюул; эзлэн түрэмгийлэх ажиллагаа; ашиг сонирхлын зөрчил, сөргөлдөөн ...гэх мэт)- ыг судлана.

Уламжлалт бус аюул нь байгалийн болон хүний хүчин зүйлээс учрах цэргийн бус аюул (байгалийн болон экологийн аюул; техногений аюул; биологийн /хүн, малын гоц халдварт өвчин/ аюул;терроризм ба үндэстэн дамнасан гэмт хэрэг; нийгмийн аюул/ядуудал, өлсгөлөн, мансуурах бодис, авилга, хэл, соёл, шашны эстремизм, дүрвэгсэд, кибер халдлага/ ... гэх мэт.) –ыг судлана.

---

[116] *Д.Бадамсүрэн, Монгол улсад 2004-2016 онд тохиолдсон аюулт үзэгдэл, ослын статистикийн эмхэтгэл. УБ хот, 2017 он.*

Уламжлалт бус аюулын ерөнхий нэр томьёоллыг өргөн утгаар нь “гамшиг” гэсэн байдлаар ойлгож, түүнтэй тэмцэх арга, ажиллагааг зохион байгуулах нь уламжлалт бус аюулын бодлого, үйл ажиллагааны зохицуулалтын үндсийг бүрдүүлж болно.

Манай оронд тохиолдож буй гамшгийн төрөл, тоо, учирсан хохирол, түүнтэй тэмцэж буй арга хэмжээ нь уламжлалт бус аюулыг цаашид судлах шаардлага байгааг харуулж байна.

Эшлэл авсан ашигласан материалын жагсаалт:

1. Монгол улсын үндэсний аюулгүй байдлынүзэл баримтлал, 1.2 дахь заалт
2. Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хууль,. УБ., 2003
3. Монгол Улсын Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 4.1.4. зүйлд
4. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, А-Г., ШУА, УБ., 2008
5. БХЭШХ, Уржин О, Монгол Улсын аюулгүй байдал: онол, аргазүй, орчны шинжилгээ, Аюулгүй байдлын ерөнхий онол, аргазүйн үндэс, УБ., 2019
6. Улаанхүү Ч, Аюулгүй амьдралын үндэс, УБ., 2016
7. Эрдэнэчимэг Б, Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого, УБ., 2016
8. Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх СЕНДАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ. УБ., 2016
9. Улаанхүү.Ч, Аюулгүй байдлын онол арга зүйн асуудал, УБ., 2014
10. Энх-Амгалан Д. “Уламжлалт бус аюул, түүний нийгэмд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга зам”, дисс. 2016
11. ЕАБХАБ-ын бүс нутаг дахь аюулын тухай ойлголт, Судалгаа
12. Кортунов.С.В. Становление политики безопасности: Формирование политики национальной безопасности России в контексте глобализации. М.: Наука, 2003.
13. Б.Бузан,“People, States and Fear”, 1983.
14. Buzan B. New Pattern of Global Security in Twenty First Century”// International Affairs. Vol. 67. No. 3. London: RIIA, 1991.

ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

Д.Баасандамба
ЗХЖШ-ын Доктор (Ph.D), хурандаа

Key words: *armed forces, organizational structure of the armed forces, military organizational structures, armed conflicts, strategic mobility, essential task lists,*

Summary: *Improving of the military organizational structure, belongs to issues framework of the reform of the Armed Forces, reforming the structure and composition of the military in line with the development vision, mission, activities, and staffing new functions of the military organizations.*

Цэргийн аюулгүй байдлыг хангах шаардлагыг бүрэн хангасан, улсын цэрэг-эдийн засгийн чадавхад нийцсэн, өгөгдсөн үүргийг өндөр бүтэмжтэй биелүүлэх чадвартай зэвсэгт хүчний байгуулж, бэхжүүлэх нь улс орон бүрийн аюулгүй байдлын тэргүүн зорилтуудын нэг болж байна.

Үүний тулд зэвсэгт хүчин, түүний зохион байгуулалтын бүтэц, бүрэлдэхүүнийг үндэслэлтэй тогтоох аргачлал, арга зүйг мэргэжилтнүүд эрэлхийлж, шаардлагатай цэргийн хүч, хэрэгслийн оновчтой хувилбаруудыг тодорхой үндэслэл, нотолгоотой гаргаж ирэхийг эрмэлзэх болсон.

Цэргийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц нь өөрчлөгдөн буй зэвсэгт тэмцлийн шинж чанар, шинжлэх ухаан, улс төрийн бодлого, нийгэм, эдийн засаг зэрэг гадаад, дотоод хүчин зүйлээс хамаарч байнга хувьсаж байдаг.

Зэвсэгт хүчний шинэчлэлийн хүрээнд цэргийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийг боловсронгуй болгох нь Зэвсэгт хүчний хөгжлийн алсын хараа, эрхэм зорилго, үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдөх үед зохион байгуулалтын бүтцийг шинэ чиг үүрэгтэй уялдуулах, бүтэц, бүрэлдэхүүнийг шинэчлэн томьёолох, зэвсэг, техникийн нөхөн хангалтын болон хангалт, дэмжлэгийн үйл ажиллагааны тогтолцоог өөрчлөх (нэмэх, өргөтгөх), орон тоог нэмэгдүүлэх (бууруулах) зэрэг арга хэмжээнүүдийг өөртөө агуулна.

Шинэ зууны цэргийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн онцлог нь бүхэлдээ шинжлэх ухааны судалгаа, математик загварчлал, эрсдэл, үр ашгийн тооцоололд тулгуурласан тун нухацтай, илүү эрс шийдэмгий, нөгөө талаас илүү тогтвортой бодлого, зорилтод үндэслэгдэх болсонд оршиж байна.

Ялангуяа цэргийн шинэчлэлийн бодлогын хүрээнд өөрчлөлтийн удирдлагын чадавхыг бий болгох (өөрчлөлтийг хэрэгжүүлэх механизм, эсэргүүцлийг даван туулах аргыг сонгон авах, өөрчлөлтийн төлөвлөгөө боловсруулах, түүнийг гүйцэтгэх чадвар) асуудал эхлээд яригдах ёстой. Орчин үеийн ойлголтоор өөрчлөлтийн удирдлага гэдэг нь гадаад, дотоод орчны зүгээс үзүүлэх өөрчлөлтийн нөлөөллийг сайтар тооцож, улмаар хүлээн зөвшөөрч одоогийн төлөв байдлаас, ирээдүйн зорилтот төлөв байдалд хүрэхэд чиглэгдсэн удирдлагын үйл явц[117] гэж үзэж байна.

21-р зууны эхэн үед ихэнх улс орнуудад зэвсэгт хүчний бүтэц, бүрэлдэхүүнийг шинэчлэхтэй холбогдсон үндсэн чиглэл, зарчмуудаа эргэж харах тодорхой урьдчилсан нөхцөлүүд бий болжээ. НАТО-гийн Балкан дахь цэргийн ажиллагаа (1999), АНУ ба түүний Афганистан дахь холбоотнуудын ажиллагаа (2001 - 2012), АНУ, Их Британийн Ирак дахь цэргийн ажиллагаа (2003) энэ үйл явцад чухал нөлөө үзүүлсэн. Түүнчлэн Гүрж (2008), Ливи (2011), Сири (2011-2012) -д болсон үйл явдлууд нь улс орнуудын үндэсний аюулгүй байдлыг хангах, цэргийн байгуулалтыг бодлого, үйл ажиллагаанд дорвитой шинэчлэлт хийх шаардлагатайг харуулсан.

Монгол Улсын батлан хамгаалах бодлого, эрх зүйн шинэчлэлийн практик алхмуудын нэг болох Зэвсэгт хүчний зохион байгуулалтын бүтцийг шинэчлэх асуудалтай уялдуулан харьцуулсан санал, дүгнэлтээ толилуулахыг эрхэм болголоо.

Дайн, зэвсэгт мөргөлдөөний шинж чанарын өөрчлөлт, цэрэг-улс төрийн арга, хэрэгслийн хувьсал нь аливаа улс орны цэрэг, армийн бүтцийг өөрчлөх гол нөхцөл болж, өнөө үед зэвсэгт хүчин нь тусгай хүчний (түргэн байрлах хүчний), кибер аюулгүй байдлын, сансрын, пуужингийн довтолгооноос хамгаалах, нисгэгчгүй нисэх хэрэгслийн зэрэг шинэ төрөл, мэргэжлийн командлал, нэгтгэл, анги, салбаруудаар эгнээгээ өргөтгөж байна.

Эдгээр өөрчлөлт нь улс орны аюулгүй байдал, тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, ард иргэдийн аюулгүй байдлыг хангах, үндэсний улс төр, цэргийн бодлогыг хэрэгжүүлэх олон талт тогтолцоо буюу агаар, сансар, хуурай газар, кибер орон зайд хамгаалалт, цохилт, мэдээлэл, удирдлага, тагнуулын нэгдмэл чадавхыг бүрдүүлэх эрмэлзэлтэй шууд холбоотой гэж үзэж болно.

Цэргийн урлагийн түүхээс харахад дараах хүчин зүйлүүд нь аль ч улс орны цэргийн зохион байгуулалтад нөлөөлж ирсэн байна. Тухайлбал,

- цэргийн шинжлэх ухаан, цэргийн урлагийн хөгжлийн хүрсэн түвшин;
- тухайн улсын батлан хамгаалах бодлого, цэргийн номлол;

[117] Ч.*Ундрам* - Байгууллагын өөрчлөлтийн менежмент

- зэвсэгт хүчнийг бүрдүүлэх, түүнийг бие бүрэлдэхүүн, байлдааны техник, зэвсгээр нөхөн хангах эдийн засаг, дайчилгааны болон бусад чадавх;
- зэвсэгт хүчний байлдааны техник, зэвсгээр тоноглогдсон түвшин;
- болзошгүй дайсны зэвсэгт хүчний төлөв байдал, хөгжлийн чиглэл;
- цэргийн ажиллагааны тодорхой нутаг дэвсгэрийн физик, газарзүйн болон бусад шинж чанарууд.

Зэвсэгт хүчин, бусад цэрэг, цэргийн байгууллагыг байгуулж, бэхжүүлэх асуудал нь Зэвсэгт хүчний байгуулалтын үндсэн чиглэлийн нэг бөгөөд өөрийн гэсэн зүй тогтол, аргачлал, арга зүйд үндэслэгдэж байдаг.

Цэргийн байгууллагыг байгуулах, шинээр өөрчлөн зохион байгуулах нь төрөл, тусгай мэргэжлийн цэргийг өөрчлөн байгуулах (шинээр байгуулах)-аас эхлээд тэдгээрийн нэгтгэл, анги, салбарын зохион байгуулалтын бүтэц, орон тоог боловсруулах үйл явцыг хамарсан дээрээс доош буюу бодлогын, доороос дээш буюу хэрэглээ төвт үйл ажиллагааг хамарч байна.

Энэхүү зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэх үйл явцыг хэрэгжүүлэхдээ юуны өмнө харгалзан үзэх хэд хэдэн хүчин зүйл байгааг дурдах нь зүйтэй. Үүнд:

Нэгдүгээрт, зэвсэгт хүчин, цэргийн байгууллага нь бэлэн байдлын ямар түвшинд байх буюу гадаад, дотоод орчин, цэргийн аюул, заналын түвшин, эрсдэл, сорилтоос урган гарсан нөхцөл, байдлын үнэлгээ;

Хоёрдугаарт, хамгаалалт (гал, цохилт, мэдээлэл-сэтгэл зүйн ажиллагаа г.м) , хариу арга хэмжээ авах боломжийг тооцсон үнэлгээ;

Гуравдугаарт, цэргийн хөдөлгөөнт байдал, гал, цохилт, маневрын боломжийг ямар хэмжээнд хүргэхийг тодорхойлсон таамаглал, дүн шинжилгээ;

Дөрөвдүгээрт, бие бүрэлдэхүүн, зэвсэг, техникээр нөхөн хангах чадавх, цэргийн эдийн засаг, материал, техникийн нөөцийг тооцсон шинжилгээ хамраана.

Нэг. Зэвсэгт тэмцлийн шинж чанар ба цэргийн байгууллагын өөрчлөлт

Шинэ төрлийн цэргийг бий болгох, цэргийн нэгтгэл, ангиудыг байгуулах, өөрчлөх нь бодлого, үзэл баримтлал буюу юунд, хэрхэн яаж хэрэглэх, нөгөө талаас хэрхэн, яаж хэрэглэх зорилгод нийцсэн хүч хэрэгслийг бүрдүүлэх, тийм шаардлагад нийцсэн бүтэц, орон тоог одоо байгаа болон ирээдүйд бүрдүүлэх нөөцөд тулгуурлан бий болгох явдал юм.

Америкийн цэргийн бодлого нь мэдээллийн технологи, шинэ төрлийн техник, зэвсгийн үр дүнг ашиглан байлдааны талбарт төрөл, мэргэжлийн цэргүүдийн чадавхыг нэгтгэх замаар “нэгдмэл”, илүү үр дүнтэй ажиллах боломжийг бий болгоход чиглэж байна. АНУ-ын Штабын дарга нарын

хорооноос “системүүдийн систем” гэсэн онолыг боловсруулсан бөгөөд энэ нь хүчийг төвлөрүүлэх үзэл баримтлалаас үр дүнтэй, хүчтэй цохилтод суурилсан хандлага руу шилжих боломжийг олгосон[118].

Шинэ үзэл баримтлалыг цэрэг-стратегийн баримт бичигт нэн даруй тусгаж, АНУ-ын хуурай замын хүчний зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийг мэдээллийн технологийн хамгийн сүүлийн үеийн ололт, амжилтыг ашиглан хуурай замын цэргийн дивизийн бүтцийг өөрчлөх, удирдлага, хөдөлгөөнт чанарын хувьд сайжруулах зорилго дэвшүүлсэн.

АНУ-ын арми шинэ хэлбэрийн бүтцэд шилжсэн онцлог нь корпус, дивизийн оронд илүү маневрлах чадвартай цохилтын бригадууд буюу “бригадын тактикийн бүлгүүд”-ийг байгуулж, хамгийн сүүлийн үеийн технологиор тоноглогдсон зохион байгуулалтын үндсэн нэгж болгох явдал байв. Нэгтгэл, ангиудын бүтцийн шинэчлэл нь хүний тоонд өөрчлөлт оруулаагүй боловч хүч, хөдөлгөөнт чанарыг ихээхэн нэмэгдүүлсэн бөгөөд бригадын тактикийн бүлгүүд нь тагнуул, материал, техникийн хангалт, их буу, агаарын довтолгооноос хамгаалах зэрэг дивизийн түвшний дэмжлэг үзүүлэх нэгжүүдээс хараат бус болжээ.

Гэвч бодит байдал дээр АНУ-ын хуурай замын хүчний зохион байгуулалтын бүтцэд дахин өөрчлөлт орж эхэлсэн бөгөөд бригад, батальонууд чанарын хувьд өөрчлөгдөж, 2013 оноос хойш бригадын тактикийн бүлэг тус бүрийн хэмжээ бага зэрэг багасаж (4500-4000 хүн), дивизүүдийн бие даасан штабыг аажмаар “сэргээж” эхэлсэн байна. Энэ нь бие даасан бригадын тактикийн бүлэг нь дэлхийн хэмжээнд өргөн хүрээний цэргийн ажиллагаанд оролцох зориулалттай “экспедицийн шинж чанар”-ыг агуулж байсан ч өгсөн үүрэг даалгаврыг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй гэдэг нь нотлогдсонтой холбоотой[119].

ОХУ-ын хувьд мотобуудлагын цэргийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэхдээ агаараар шилжүүлэн бүлэглэхэд зохицсон, өндөр маневрлах чадвартай, байлдааны ажиллагааг тусгай чиглэлд бие даан явуулах, нэг төрлийн байлдааны ажиллагаанаас нөгөөд богино хугацаанд шилжилт хийх, байлдааны ажиллагааны район, чиглэлийг хурдан өөрчлөх, богино хугацаанд хүч хуралдуулах болон хүч задлах боломжтой[120] болгон өөрчилж байна.

Томоохон гүрнүүдийн зэвсэгт хүчний шинэчлэлийн хүрээнд хийгдэж буй цэргийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлт нь дараах зарчмуудад үндэслэгдэж байна. Үүнд,

1. Санаачилгыг гартаа авах, түүнийг барих;
2. Цэрэг, зэвсэг, галаар маневрлах;

---

[118] *Igor Prokopiev. Reforming the U.S. Army Organization at the End of the 20th and the Beginning of the 21st Centuries. Institute for the U.S. and Canadian Studies, RAS. DOI: 10.18254/S0000019-7-1, 2018*

[119] *Schadlow N. 2016. For the U.S. Army, It's Not About the Story // War on the Rocks, 12.07.2016.*

[120] *Основы теории и методологии строительства Вооруженных Сил. – М.: Воентехиниздат, 2002, стр. 83.*

3. Сонгосон чиглэлд шийдэмгий хүч хуралдуулах, дайсныг дэс дараалан бут цохих;
4. Дайсанд, түүний ажиллагааны бүх гүнд хөнөөл үзүүлэх
5. Төрөл, тусгай мэргэжлийн цэргийн хүч хэрэгслийг уялдуулан хэрэглэх;
6. Цэргийг найдвартай хамгаалах, хамгийн бага хохирлоор амжилтад хүрэх;
7. Идэвхтэй мэдээллийн тэмцэл явуулах зэрэг болно.

Эдгээр зарчмууд нь үндсэндээ цэргийн хөдөлгөөнт чанарыг дээшлүүлэхтэй шууд уялдаатай байгааг харж болно.

Хоёр. Үүрэг ба цэргийн байгууллагын өөрчлөлт

Цэргийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэх үйл явц нь ЦАХ, салаа, салбар, анги бүрийн гүйцэтгэх үүрэгтэй уялдах бөгөөд энд, нэгдүгээрт, болзошгүй үүрэг, даалгаварт нийцүүлэн анги, байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоог өөрчлөх, хоёрдугаарт, анги, байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоонд нийцсэн үүрэг, даалгаврыг тогтоож өгөх гэсэн хувилбаруудтай байж болно.

Цэргийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоо нь "зорилтот-үр дүнд чиглэсэн" үүргийн агуулгыг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх арга, тактик, ажиллагааны хувилбар, норматив боловсруулах үндэслэл болно. Үүнийг хөгжүүлэхэд "Нэн чухал үүргийн жагсаалт"-ыг боловсруулах барууны цэргийн мэргэжилтнүүдийн аргачлал илүү дөхөмтэй байж болох юм.


Нэн чухал үүргийн жагсаалт (НЧҮЖ) гэж хууль эрх зүй, цэргийн номлол, цэргийн стратегийн болон байлдааны дүрмийн хүрээнд цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага, командлалаас тогтоосон, нэгтгэл, анги, салбар, ЦАХ-ийн тайван болон байлдааны цагийн орон тоо, бүтэц, зохион байгуулалтаараа гүйцэтгэх үндсэн болон тусгай үүргүүд, тэдгээрийн агуулга, шалгуур, үзүүлэлтийг тодорхойлсон баримт бичгийг ойлгоно.

Цэргийн байгууллагын зориулалт, бүтэц, орон тоо, бэлэн байдал, цэргийн сургалттай уялдсан НЧҮЖ нь ЦАХ, нэгж, анги, салбарын байлдаанд заавал гүйцэтгэх тодорхой, хэмжигдэхүйц, ялгаатай үйл ажиллагаа ба үйлдэл[121] бөгөөд тодорхой стандарт, шалгуур үзүүлэлт, байлдааны дүрэм, зааврууд нийцэж, нэгтгэл, анги, салбарын зохион байгуулалтын бүтэц, орон тоотой нягт уялддаг байна.

Нэгтгэл, анги, салбарын үүргийн жагсаалт нь тэдгээрийн гүйцэтгэвэл зохих үндсэн (стратегийн чиглэл, бүс, байршил, онцлогт нийцсэн ерөнхий үүрэг) үүрэг, тэдгээрийг биелүүлэх арга, тактик болон цэргийг

[121] *Mission Essential Task List (METL) Development*. https://www.globalsecurity.org/military/library/., *Chapter 2;*

байлдаанд бэлтгэх арга хэмжээний зорилт, үндсэн агуулгыг тодорхойлно (зураг-1).



1 дүгээр зураг. Нэгтгэл, анги, салбарын цүргийн жагсаалтыг боловсруулах аргачлал

Гурав. Цэргийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоог боловсруулах аргачлал

Цэргийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийн шинэчлэлийн хүрээнд шаардагдах бүрэлдэхүүнийг тодорхойлох аргачлалыг "эцсийн үр дүнг олж авахын тулд тодорхой дарааллаар ашигласан арга зүйн хандлага, зарчим, шалгуур, алгоритм, арга, математикийн загвар, тооцооллын даалгаврын цогц[122]хэмээн тодорхойлжээ. Аргачлалын гол зорилго нь цэргийн аюулгүй байдлыг хангах шаардлагад нийцсэн, улсын цэрэг-эдийн засгийн чадавхыг хангасан зэвсэгт хүчний шаардлагатай бүрэлдэхүүн хэсгийн оновчтой хувилбаруудыг нотлоход оршдог байна.

Гадаадын цэргийн мэргэжилтнүүдийн дүгнэлт, төрийн батлан хамгаалах бодлогод, Зэвсэгт хүчин, цэргийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийн шинэчлэлийн хүрээнд шаардлагатай бүтэц, бүрэлдэхүүнийг тодорхойлох асуудлыг дараах үе шатаар хэрэгжүүлдэг. Үүнд,

- анхны өгөгдөхүүнийг бэлтгэх;
- цэргийн байгууллагын бүтэц, бүрэлдэхүүний цэрэг-стратегийн үндэслэлийг боловсруулах;
- боломжит хүн, зэвсэг, техник, бусад хэрэгслийн нөөцийг тогтоох;
- зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах;
- зэвсэгт хүчний төсвийг шинэчлэн тогтоох.

Цэргийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хүрээнд Зэвсэгт хүчний шаардлагатай бүрэлдэхүүнийг тодорхойлох анхны өгөгдөхүүнд:

[122] *Основы теории и методологии строительства Вооруженных Сил Российской Федерации. Военно-теоретический труд. –М;. 2002. С. 98.*

- болзошгүй зэвсэгт тэмцлийн хувилбаруудын таамаглал
- болзошгүй дайсны цэргийн бүлэглэл, хүч хэрэгслийн таамаглал
- цэргийн зэвсэглэл техникийн нөөцийн чанар, байдал
- санхүү, эдийн засгийн нөөцийг дайчлах боломжийг хамааруулж үзнэ.

Түүнчлэн цэргийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийг хийхийн тулд:

- улсын эдийн засгийн боломж;
- цэргийн нэгтгэл, ангиудын үүрэг, тэдгээрийг биелүүлэх нөхцөл;
- болзошгүй дайсны хүч хэрэгсэл, түүний байлдааны боломж, ажиллагааны арга, хэлбэр;
- зэвсэгт тэмцлийн шинж чанартай уялдсан өөрийн цэргийн ажиллагааны арга, хэлбэр;
- тавигдсан үүргүүд, тэдгээрийг биелүүлэх ажиллагааны арга, хэлбэр болон улсын хүн ам, материаллаг баялгийн боломжтой уялдсан бие бүрэлдэхүүн, зэвсэг, техник, материал хэрэгслийн хангалтын норм, хэрэгцээ
- цэргийн шинжлэх ухааны судалгаа болон цэргийн бодит ажиллагаа, цэргийн хээрийн сургуулиудын туршлагад хийсэн дүн шинжилгээг эхний шатанд харгалзан үзнэ.

Цэргийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийг өөрчлөх, Зэвсэгт хүчний шаардлагатай бүрэлдэхүүнийг тодорхойлоход улсын цэрэг-эдийн засгийн боломж ихээхэн үүрэгтэй бөгөөд энэ нь өөрийн гэсэн аргачлалтай явагддаг байна[123] (зураг-2).



2 дугаар зураг. Зэвсэгт хүчний шаардлагатай бүрэлдэхүүнийг тогтоохын тулд цэрэг-эдийн засгийн хэрэгцээг тооцох аргачлал

[123] *Основы военного строительства государства. ВАГШ РФ, 2015.*

Цэргийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийг өөрчлөх, зэвсэгт хүчний шаардлагатай бүрэлдэхүүнийг тодорхойлохдоо зохион байгуулалтын бүтцийн хоёр ба түүнээс дээш хувилбарыг харьцуулсан дүн шинжилгээнд үндэслэдэг байна.

Харьцуулсан дүн шинжилгээ нь тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу бүтцийн хувилбаруудад логик харьцуулалт хийж, оновчтой бүтцийг сонгох; математикийн болон сүлжээний загварыг ашиглан бүтцийг үнэлэх, түүний оновчтой байдлыг тодорхойлох; шинжээчдийн судалгааг ашиглах аргуудаас бүрддэг.

Харьцуулсан шинжилгээний хамгийн үр дүнтэй арга бол математик загварчлал болон дуураймал загварыг ашиглах явдал бөгөөд үүний үр дүнд байгууллагын зохион байгуулалтын бүтцийн үр нөлөөг урьдчилан таамаглахыг эрмэлзэх нь чухал.

Цэргийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийг урьдчилан таамаглахын ач холбогдол нь байгууллагын бүтцийн хөгжлийн чиг хандлага, хэв маягийг тодорхойлох, зохион байгуулалтын хэлбэрийг өөрчлөх боломжийг тодорхойлох; шинэ бүтэц бий болох явцыг хянах, тэдгээрийн бүтэц, бүрэлдэхүүн хэсгийн гүйцэтгэх даалгавар, чиг үүргийг боловсруулахад оршдог[124] байна.

Харьцуулсан үнэлгээ хийх, цэргийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийн үр нөлөөг урьдчилан таамаглахын тулд байлдааны ажиллагааг дуурилган үзүүлэх математик загварчлалыг ашиглах боломжтой бөгөөд энэ нь бүтцийн хувилбаруудын сул талыг олж илрүүлэх, тэдгээрийг арилгах зөвлөмжийг боловсруулах, янз бүрийн зэвсэглэл, техник, удирдлагын хэрэгслийн үр нөлөөг үнэлэх; зохион байгуулалтын бүтцийн байлдааны үр ашгийн үзүүлэлтийг тодорхойлох боломжийг олгодог.

Цэргийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц, түүнд шаардлагатай бүрэлдэхүүнийг тодорхойлсны дараа нэгтгэл, ангиудыг нөхөн хангах, бүрдүүлэх, үүрэг гүйцэтгэхэд бэлтгэх нөөцүүдийн хэмжээ, хангалт хийх арга зам, эх үүсвэрийг Зэвсэгт хүчний хөгжлийн урд, дунд хугацааны хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгадаг ба үүнийг батлан хамгаалах төсөв, хөрөнгө оруулалт, батлан хамгаалах аж үйлдвэрлэл, цэргийн зардлын ангилал тус бүрээр тодорхойлдог байна.

Дүгнэлт

Зэвсэгт хүчний зохион байгуулалтын бүтэц, бүрэлдэхүүн, хүч чадал нь зэвсэгт тэмцлийн өөрчлөгдөж буй шинж чанар, цэргийн зэвсэг, техник, технологийн шинэчлэл, цэрэг-улс төрийн бодлоготой байнга уялдаж байх ёстой.

Зэвсэгт хүчний шинэчлэлийн хүрээнд цэргийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоог боловсруулах аргачлалын гол зорилго нь цэргийн аюулгүй байдлыг хангах шаардлагад нийцсэн, улсын цэрэг-эдийн

[124] *Гирин А.В. Организационно-штатная структура объединений, соединений и частей Сухопутных войск. 2011.*

засгийн чадавхтай уялдсан зэвсэгт хүчний шаардлагатай бүрэлдэхүүн хэсгийн оновчтой хувилбаруудыг тодорхойлоход оршино.

Цэргийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоог боловсруулах нь туршилт, судалгааны болон бодит байлдааны ажиллагааны туршлага, сургамжид үндэслэсэн төр, нийгмийн болон цэргийн байгууллагын хамтарсан, цогцолбор арга хэмжээ, цэрэг-эдийн засгийн чадавхыг бүхэлд нь хамарсан урт хугацааны, олон талт үйл явц бөгөөд цэргийн гүйцэтгэх үүрэг, даалгавар, Зэвсэгт хүчний хөгжлийн урт хугацааны хөгжлийн зорилго, цэргийн стратегийн шаардлагад тулгуурладаг байна.

БАТЛАН ХАМГААЛАХ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ, ТҮҮНИЙ МӨН ЧАНАРЫН АСУУДАЛД

Х.Орхончимэг
БХЭШХ-ийн Аюулгүй байдал батлан хамгаалах судлалын төвийн ЭША, доктор(Ph.D)

Key words: *Defense education, training methodology, training pith*

Summary: *In order to develop an optimal version of defense education training technology, there is a need to define the components such as training goals, content, learning process, and assessments of students' knowledge and skills in a mutually agreed manner. Therefore, the purpose of this article is aimed at considering the issues of training methodology and its' pith in connection with the need to develop methodological issues of defense education training that provide the needs and requirements of the society nowadays.*

Батлан хамгаалах боловсролын агуулга, арга зүйг судлан тодорхойлсон судалгааны ажлыг зохих түвшинд зарим эрдэмтэд судалж, судалгааны өгүүлэл, ном бүтээлдээ хэсэгчилсэн судалгааны үр дүнг нийтэлж байна. Тухайлбал боловсролын хэрэгцээ шаардлагын тухай Н.Бэгз[125], батлан хамгаалах боловсролын шинэ тогтолцоог боловсруулах тухайд

[125] *Бэгз.Н.Глобальчлалын цейин Монгол улсын боловсролын хөгжлийн онол арга зүйн үндсэн асуудлууд. УБ.,2001; Боловсролын хөгжлийн онол аргазүйн асуудлууд.УБ., 2008; Монголын боловсрол судлалын шинэ парадигм. УБ., 2013; Батлан хамгаалах боловсролын агуулгыг хэрэгжүүлэх арга зүйн асуудлууд. Батлан хамгаалах боловсролын агуулга, арга зүйн асуудлууд сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл.УБ.,2019. т.15–17.*

Б.Өлзийхуяг[126], Ш.Паламдорж[127], Т.Соронзонболд[128] нарын бичсэн бүтээл, өгүүллүүдийг нэрлэж болох юм. Боловсролын хэрэгцээ шаардлага, боловсролын онол арга зүй болон боловсролын чанар ба үнэлгээ, хүний хөгжлийн хамаарлын судалгаанууд зохих түвшинд хийгдсээр ирсэн. Манай улсад цэргийн мэргэжилтэн бэлтгэдэг боловсрол, сургалтын тогтолцоо олон зуун жилийн явцад боловсрогдон хэрэглэгдэж ирэхдээ тухайн эрин цаг үеийнхээ нийгмийнхээ эрэлт, хэрэгцээ шаардлагыг зохих түвшинд хангаж ирснийг бидний туулж өнгөрүүлсэн түүх бэлхнээ харуулдаг. Тус өгүүлэлд глобалчлагдан өөрчлөгдөж буй өнөө үеийн нийгмийн эрэлт, хэрэгцээг хангасан батлан хамгаалах боловсролын агуулгыг нарийвчлан тодорхойлсон судалгаа хийх, онол арга зүйн асуудлуудыг боловсруулах шаардлага бий болсон зэрэгтэй уялдан батлан хамгаалах боловсрол сургалтын арга зүй,технологи түүний мөн чанар нь ямар байх тухай асуудлыг авч үзэхийг зорилоо.

Сургах зүйн онолын үзэл баримтлалын дагуу боловсруулсан батлан хамгаалах боловсролын сургалтын агуулгыг хэрэгжүүлэх нь сургалтын арга зүй, технологийг хэрхэн сонгож авснаас ихээхэн шалтгаална. Батлан хамгаалах боловсролын сургалтын технологийн оновчтой хувилбар боловсруулахын тулд сургалтын зорилго, агуулга, сурах сургах үйл явц, суралцагчдын мэдлэг чадварын үнэлгээ зэрэг бүрэлдэхүүн хэсгүүдийг харилцан зохицсон нэгэн утгатайгаар тодорхойлох шаардлага гарна.

Батлан хамгаалах боловсролын агуулгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд эрдэмтэн судлаачдын оролцоог илүүтэй ашиглах, эх орноороо бахархах сэдлийг төрүүлж чадахуйц шинжлэх ухааны ном бүтээл туурвих ажлыг нийгмийн аль нэг салбар хариуцах биш бүх нийтийн (төрийн болон төрийн бус байгууллагууд) оролцоотойгоор тодорхой цаг хугацаанд багтааж бус цаашид уламжлал болон тогтохуйцаар зохион байгуулж хэрэгжүүлэх явдал юм.

Монгол Улсын иргэдийн эх оронч үндэсний үзлийн төлөвшлийн харьцааг залуу, дунд, ахмад үетэй харьцуулан үзэхэд ойлголтын болоод төлөвшлийн нэлээд зааг ялгаа байгаа нь судалгааны дүнгээс харагдаж

[126] *Өлзийхуяг.Б. Батлан хамгаалах боловсрол тууний хэрэгцээ шаардлага. Засгийн Газрын хэрэгжүүлэгч академи. Удирдах эрдэм сэтгүүл. УБ.,2009,т.163. Цэргийн боловсролын хөгжлийн чиг хандлага. Батлан хамгаалах судлал сэтгүүл.УБ.,200, Синергетик ба батлан хамгаалах боловсролын тогтолцоо. Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал сэтгүүл.№24 (34).УБ.,2017. Батлан хамгаалах боловсролын сурган, сэтгэл зүйн зарим асуудал. Аюулгүй байдал батлан хамгаалах судлал сэтгүүл.№28(38). УБ.,2019.т.147–153. Батлан хамгаалах боловсролыг тогтолцооны хандлагын үүднээс судлах нь. Батлан хамгаалах боловсролын агуулга, арга зүйн асуудлууд сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ.,2019.т.7–14.*

[127] *Паламдорж.Ш. Батлан хамгаалах боловсрол судлал, тууний онол арга зүйн асуудал. Аюулгүй байдал батлан хамгаалах судлал сэтгүүл. №27(37). УБ.,2019.т.26; Батлан хамгаалах боловсролыг хууль, эрх зүй, ёс суртахуунд тулгуурлан олгох нь. Батлан хамгаалах боловсролын агуулга, арга зүйн асуудлууд сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл.УБ.,2019.т.18–22.*

[128] *Соронзонболд.Т, Хандсүрэн.Б, Орхончимэг.Х. Батлан хамгаалах боловсрол нийгмийн хэрэгцээ, шаардлага. Аюулгүй байдал батлан хамгаалах судлал сэтгүүл. №27(37). УБ., 2019.т.131-137*

байна. Иймээс өнгөрсөн, одоо, ирээдүй үеийн залгамж холбоог нягтруулж, эх оронч үндэсний ардчилсан нэгдсэн үнэлэмж, ойлголт, үзэл санаа, чанарыг дээшлүүлэх, үнэлэмжийн нэгдсэн ойлголтыг бий болгох асуудлыг тодорхой хөтөлбөр төлөвлөгөөний дагуу шийдвэрлэж, батлан хамгаалах боловсролын агуулгаар олгох нь зүйтэй гэж үзэж байна. Үүний тулд эх оронч үндэсний үзлийг хэт үндсэрхэг үзэлтэй адилтган үзэж байгаа хандлага залуучуудын зарим хэсгийн дотор ажиглагдах болсон учир эдгээр ойлголтуудын зарчмын ялгааг ойлгуулах зорилгоор мэдээллийн бүхий л хэрэгслүүдээр идэвхтэй сурталчлах шаардлагатай байна.

Сургалтын технологи гэж сургах зүй, сэтгэл зүй болон удирдлагын ухааны зүй тогтолд тулгуурлан боловсруулсан аливаа үйлийг гүйцэтгэх хамгийн оновчтой эрэмбэ, дэс дараа түүний хувилбар юм. Сургалтын үйл ажиллагааны оновчтой хувилбарыг батлан хамгаалах боловсролын тогтолцооны хандлага загварчлалаар шинээр боловсруулж буй тул тэрхүү тогтолцоо үүсгэгч бүтцийн элементүүд нь сургалтын зорилго, агуулга, сургалтын үйл явцын цогцолбор, суралцагчдын хүрсэн байх түвшин бөгөөд эдгээр ойлголтыг сургалтын үйл ажиллагаа тогтолцооны үзэл баримтлалын үүднээс дотоод мөн чанарыг нь илрүүлсний үндсэн дээр тодорхойлох шаардлагатай юм. Бүтцийн элементүүдийн хоорондох олон төрлийн, олон эрэмбийн холбооноос тогтолцоо үүсгэгч гол холбоог ялгаж тодорхойлох нь чухал болно.

Суралцагчдын мэдлэг, чадвар, дадлын болон оюуны хөгжлийн түвшин, сургалтаар дэвшүүлж буй зорилтод чиглэсэн сургагч, суралцагчийн хамтарсан зорилго, зохион байгуулалттай үйл ажиллагааг сургалт гэдэг. Батлан хамгаалах боловсрол олгох сургалт бол иргэдэд эх орноо батлан хамгаалахад шаардлагатай цэргийн мэргэжил, боловсрол, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэл олгох зорилгод тулгуурлах учир зохион байгуулалтын үйл ажиллагаа үүнд чиглэнэ.

Сургалтын арга зүй гэдэг ухагдахууныг хэд хэдэн утгаар ойлгон хэрэглэх болсон. Сургалтын арга зүй нь явцуу утгаараа тодорхой нэг судлагдахууныг сургагч заах явцдаа ямар арга, хэрэглэгдэхүүнийг яаж хэрэглэхийг тэмдэглэсэн ойлголт юм. Сургалтын арга зүй нь өргөн утгаараа сургалтын ямар хэрэгцээ, зорилгыг хангахын тулд түүнийг ямар зарчмаар яаж хэдий хугацаанд зохион байгуулж үнэлэх зэргийг багтаасан цогц ойлголт. Сургалтын арга зүй өнөө үед ихээхэн өөрчлөгдөж байгаа нь дараах хүчин зүйлүүдтэй холбоотой. Үүнд:

-Нийгмийн үнэт зүйл үнэлэмжийн тогтолцоо ихээхэн өөрчлөгдсөн;

-Мэдээлэл холбоо харилцааны технологи эрчимтэй хөгжсөн;

-Боловсролын зорилго, зарчим зэрэг нь суралцагчдад шинжлэх ухааны өргөн мэдлэг олгох бус, амьдрал, ажил хөдөлмөртөө хэрэгтэй мэдлэг чадвар, хандлага төлөвшил олгох, тэдэнд өрсөлдөх чадвар төлөвшүүлэх шаардлага гарч ирсэнтэй ихээхэн холбогдож байна.

Суралцагч төвтэй сургалтын технологийн оновчтой хувилбар боловсруулахын тулд сургалтын зорилго, агуулга, сурах–сургах үйл явц, суралцагчдын мэдлэг, чадварын үнэлгээ зэрэг бүрэлдэхүүн хэсгүүдийг

харилцан зохицсон нэгэн утгатайгаар тодорхойлох хэрэгтэй. Эдгээр бүрэлдэхүүн хэсгүүдийг зөв оношлон тодорхойлохын тулд сургалтын технологи, түүний зарчмуудыг сайтар судлах хэрэгтэй болдог.

Сургалтын арга зүйг хэрэгжүүлэх чухал үйл бол сургалтын аргыг хэрэглэх асуудал болно. Сургалтын арга бол сургалтын технологийн чухал элемент буюу түүний үндэс нь мөн. Арга гэж юу болохыг тодруулж үзье. Философийн толь бичигт арга бол зорилгод хүрэх арга зам, тодорхой байдлаар зохион байгуулагдсан үйл ажиллагаа гэж ерөнхий байдлаар тодорхойлжээ. Арга бол сурган хүмүүжүүлэх ухаанд хамгийн их судлагдсан асуудал ч энэ талын ойлголт нэг мөр болсон зүйлгүй маргаантай хэвээр байна.

Суралцагчдын нас бие сэтгэцийн боломжид тохируулан судалж буй үзэгдлийн мөн чанарыг танин мэдүүлэх замыг сургалтын арга гэж үзэх тал бий. Сургалтын агуулга, танин мэдэх ба практик ажлын зорилго, хийх үйлдлийн шинж байдал, болон суралцагчдын суралцах үйл ажиллагааны арга замыг сонгож авах нь сургалтын аргын олон янз байдлыг шаардана.

Батлан хамгаалах боловсрол олгох сургалтын арга олон янз байх боловч дараах нийтлэг зорилтыг хангасан байх шаардлагатай. Үүнд:

-Суралцагчид батлан хамгаалах мэдлэг эзэмшихийн хамт бодит байдлыг өөрчлөн хувиргах танин мэдэхүйн арга болон эзэмшсэн мэдлэгээ хэрэглэх арга барилд сурах замаар онолыг практик ажиллагааны чадвар, дадалтай холбож чаддаг болох;

- Эх орноо батлан хамгаалахын учир утгыг монгол хүн гүн ойлгож, аливаа үзэгдэл, үйл явцыг үнэлж дүгнэхдээ эх орныхоо эрх ашгийг тэргүүн зэрэгт тавьж чаддаг эрдэм ухаан чадварыг суралцагчдад эзэмшүүлэх;

-Батлан хамгаалах боловсролын судлагдахуун нь тэдний зайлшгүй эзэмших ёстой цаашдын аюулгүй аж төрөх арга зам гэдгийг ухамсарладаг болсон байх зэрэг болно.

Батлан хамгаалах боловсролын сургалтын арга зүй гэдэг бол Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, арга ухаан, хүмүүжил, ёс суртахууны ухамсар төлөвшүүлэх сургалтын хэрэгцээ, зорилго, агуулгыг хэрэгжүүлэх стратеги, зарчим, арга хэрэгслийн нийлбэр болно.

Иймд батлан хамгаалах боловсролын агуулгыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд Батлан хамгаалах боловсролын сургалтын технологийн үндсийг боловсруулахад дараах онцлогуудыг харгалзан үзэх нь чухал. Үүнд:

1.Батлан хамгаалах боловсролын агуулгыг олгох тогтолцооны бүтцийн онцлог;

2.Батлан хамгаалах боловсролыг эзэмшүүлэхэд суралцагчдын нас, сэтгэхүй, бие бялдрын онцлогт тохирсон арга зүй;

3.Батлан хамгаалах боловсролыг олгох суралцагчдын боловсролын түвшин;

4.Батлан хамгаалах боловсролын сургалтын орчин,үнэлгээ.

Орчин үеийн ардчилсан нийгэмд сөрөг үзэл хандлага оршсоор байгаагийн нэг шалтгаан бол хүний төрөлх мөн чанарыг дутуу дулимаг ухаарч ойлгосон явдал юм. Ямар арга замаар монгол хүнийг танин мэдэх, хүнтэйгээ хэзээ, хэрхэн ажиллах, хүнийг ирээдүйд хэрхэн бэлтгэх асуудал өнөөг хүртэл нарийн судлагдаагүй, түүнийг авч үзэх, нийгэм улс төр эдийн засгийн чиг баримтлал ч үгүй гэж манай нийгэм судлаачид тэмдэглэдэг нь бидний өмнө шийдэх ёстой олон асуудал байгааг харуулна.

Сурган хүмүүжүүлэх ухаан, сэтгэл судлал, сургах арга зүйн судалгааны талбарт хуучин нэг хэвийн үзэл онол хүчтэй байсан нь монгол хүний мөн чанар, хүмүүний амьдралын учир утгыг сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаанд харгалзах талаар зарчмын хувьд учир дутагдалтай байсантай холбоотой. Монгол хүний мөн чанарыг танин мэдэх судалгааны ажлаа аливаа сургалт судалгаатайгаа хослуулан явуулах нь онцгой ач холбогдолтой төдийгүй энэ цаг үеийн гарцаагүй шаардлага болж байна. Амьдралаас урган гарч байгаа энэхүү бодит хэрэгцээ шаардлагыг ханган шийдвэрлэхэд бага ч атугай нэмэр болох үүднээс, хүнийг хүн болгож байгаа хамгийн гол хүчин зүйлийг ахуй амьдрал, сургалт, судалгаанд харгалзахтай уялдан шүтэлцсэн асуудлуудаар өмнөх болон орчин үеийнхээ дотоод гадаад сэтгэгчдийн эрдэмтэн, судлаачдын бүтээлд ч бас шинэлэг сэтгэлгээгээр хандаж, монгол хүний өвөрмөц онцлогийг аливаа сургалтад харгалзах тухай батлан хамгаалах боловсролын арга зүйн үндэслэлийн нэгэн хувилбар боловсруулсан юм.

Сургалтын технологи боловсруулахдаа монгол хүн аливаа үзэгдэл юмсын гол чанарыг эрхэмлэдэг логик сэтгэхүйн уламжлалыг харгалзах хэрэгтэй юм. Өөрөөр хэлбэл, сургалтад дедукцийн аргаар хандана гэсэн үг. Дедукц нь шинэ мэдлэгийг хүлээн авах зэвсэг төдийгүй бэлэн мэдлэгийг зохион байгуулах хэрэгсэл болно. Шинжлэх ухааны үнэн зөв үндэслэлтэй уялдуулан шүтэлцүүлсэн боловсрол л улс орны батлан хамгаалах хүч чадавхи, хөгжил, аж амьдралыг хамгаалах нэн чухал хүчин зүйл болох билээ.

1.Төр, нийгэм, ард иргэдийн хэрэгцээ: Суралцагчдын хэрэгцээ сонирхолд нийцүүлэн батлан хамгаалах сургалтыг хэрхэн явуулах тухай асуудал чухал. Хүн бүрт нас насны онцлогт тохирсон хэрэгцээ байнга үүсэж байдаг. Хүн хүүхэд насандаа нийгмийн амьдралд дасан зохицох, аюулгүй амьдрах арга барил эзэмшдэг бол дунд насандаа сурсан мэдсэн зүйлээ амьдралд хэрэглэх, төр, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, өтөл насандаа амьдралаас олж авсан мэдлэг чадвараа үр хойчдоо өвлүүлэх, дүгнэлт хийхэд чиглэж байдаг. Иймээс тэдэнд нас, насны онцлогт нь тохирсон батлан хамгаалах боловсролын сургалт хэрэгтэй. Хүн бүхэн үндэс угсаа, оршин байх орон зайгаа хамгаалах төрөлхийн шинжтэй байдаг бөгөөд гагцхүү хэрхэн хамгаалах мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлэх асуудал тулгарч байдаг.

2. Батлан хамгаалах сургалтын зорилго *бол* XXI зууны монгол иргэдийг бүх талын хөгжил төлөвшилтэй, хүмүүнлэг ёс суртахуунтай, монгол орны өвөрмөц онцлог, нийтлэг шинж хандлагад тохирч нийцсэн бүтээлчээр хэрэглэгдэх мэдлэг боловсролтой, бүтээлч чадамж, өрсөлдөх чадвартай, аюулгүй амьдрах арга ухаантай, эх орноо хайрлах ухамсар сэтгэхүйтэй хүн болгож хүмүүжүүлэн сургах явдал юм. Энэ зорилгыг хэрэгжүүлэхэд монгол хүнийг сайтар судлан таньж, монгол хүний өвөрмөц чанар, онцлог, хэрэгцээ, сонирхол, чадварт тохирсон үндэсний батлан хамгаалах боловсролыг тэдэнд эзэмшүүлэх явдал чухал. Иймд батлан хамгаалах боловсролын суурь мэдлэг, аюулгүй амьдрах ухаан арга барил чадвар дадлыг эзэмшүүлэх, монгол хүний эх орон үндэс угсаагаа тэргүүн зэрэгт тавьж чаддаг эрхэм чанарыг төлөвшүүлэхэд оршино.

3. Батлан хамгаалах боловсролын сургалтын агуулга *нь* шат шатандаа өвөрмөц онцлогтой тогтолцооны хэсгүүдээс бүрдэнэ. Батлан хамгаалах боловсрол бол заавал олгох албан ёсны боловсрол байх тул суралцагчдын заавал эзэмших хичээлийн агуулгыг 6 түвшинтэй тэдгээрийн хоорондын уялдаа холбоог хангасан байхаар тусгаж байгаа болно.

4.Багшийн сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаа бол батлан хамгаалах сургалтад чухал үүрэгтэй. Учир нь багш нарын үйл ажиллагааны үр дүнгээс эх оронч үндэсний ардчилсан үзэл сэтгэлгээтэй монгол хүнийг бэлтгэх, төлөвшүүлэх, цаашлаад үндэсний аюулгүй байдалд үзүүлэх дотоод аюулгүй байдлын үндэс бүрдсэн эсэх нь шалтгаалах тул хариуцлагатай үйл ажиллагаа болно.

5.Суралцагчдын сурах үйл ажиллагаа нь нийгэм, цаг үе хувьсан өөрчлөгдөх тусам ихээр өөрчлөгдөж байна. Тэдний бодол сэтгэхүй, үйл хөдлөлд нөлөө үзүүлэгч хүчин зүйлүүд олон төрөл, хандлага чиглэлтэй болов. Иймд батлан хамгаалах боловсролыг олгохдоо бүх хүчин зүйлийг тооцох хэрэгтэй. Мэдээлэл технологи цахим хэрэглээний өсөлт нь суралцагчдын ухамсарт хүчтэй нөлөө үзүүлэх төлөвтэй байгаа тул суралцагч мэдээллийг задлан шинжлэгч, нэгтгэн дүгнэгч болж, улмаар мэдлэгийг өөрөө бүтээгч байна хэмээн цахим нөлөөллийг тооцож батлан хамгаалах боловсролын сургалтыг зохион байгуулах хэрэгтэй.

6. Батлан хамгаалах боловсролын сургалтын арга зүй *бол* батлан хамгаалах боловсролын чухал хэсэг болно. Батлан хамгаалах боловсролын агуулга нь түвшин бүрдээ өвөрмөц онцлогтой, зохих системтэй байхаар тусгаж буй тул тэдгээрт тохирсон сургалтын арга зүйн үндсийг тодорхойлохоор тусгаж байна. Ингэхдээ бидэнд батлан хамгаалах боловсролыг монгол хүн бүрт олгогдох насан туршийн боловсрол байна гэж тооцож буй тул тэдний нас насны онцлогт тохирсон арга зүйг сонгох хэрэгцээ мөн үүсэж байгааг харгалзах нь чухал байна.

7.Сургалтын хэлбэр бол Батлан хамгаалах боловсрол сургалтын хэлбэрийг ганцхан танхимын сургалтаар олгох нь хангалтгүй байна. Иймд бүх нийтийн ба сургуулиар олгох боловсрол гэж 2 хэлбэрээр олгохоор боловсруулж байна. Бүх нийтийн батлан хамгаалах боловсролыг шинжлэх

ухаан, урлаг уран зохиолын бүх төрлийн ном бүтээл, мэдээллийн бүхий л хэрэгслүүдийн үйл ажиллагааны агуулгад тусгаж хэрэгжүүлнэ. Сургуулиар олгох батлан хамгаалах боловсролыг батлан хамгаалалтын бодлого, үйл ажиллагаатай уялдуулж төлөвлөхдөө онолын болон практик боловсрол гэж ангилан үзэх нь зүйтэй юм. Онолын боловсролд батлан хамгаалах онол, улс орноо батлан хамгаалах мэдлэг, батлан хамгаалах хууль, үзэл баримтлал, цэрэг дайны онолын тухай мэдлэг багтана. Практик боловсролд батлан хамгаалах ур чадварт суралцуулах агуулга багтана. Онолын ба практик боловсролын уялдааг хангахад агуулгыг нь зөв оновчтой тогтоох хэрэгтэй. Онол ба практикийн харьцааг зөв хувиарлах нь чухал. Хэрвээ онолыг анхааранд практикийг орхигдуулбал онол сайн байлаа ч хэрэглээ болохгүй. Онолгүй бол практик ур дүн муутай их хүч хөдөлмөр, хэрэгсэл шаардагдсан их ажил болно.

8.Батлан хамгаалах сургалтын ур дүн үнэлгээг сургалтын чанар, мэдлэг, арга туршлага, хандлагад гарсан бодит ахиц өөрчлөлтөөр үнэлэх нь зүйтэй. Батлан хамгаалах боловсрол нь нийгмийн тэргүүлэх салбар болно гэж үзэж, томоохон үүрэг хариуцлага хүлээдэг байхаар ур дүн үнэлгээг тооцох нь зүйтэй. Үүргийн биелэлт нь боловсролын хүртээмж, чанар, ур ашгаар цогц хэмжигдэх учиртай. Боловсролын чанарын параметрийг авч үзэхийн өмнө чанар, боловсролын чанар гэж юуг авч үзээд байгааг тодотгох ёстой юм. Батлан хамгаалах боловсрол эзэмшиж буй хүний олж авбал зохих мэдлэг, чадвар, дадал нь юуны өмнө монгол хүний зайлшгүй эзэмшсэн байх суурь чадварууд, хөдөлмөрийн үйл ажиллагааны аль нэг салбарт ажиллахад шаардлагатай мэргэжлийн чадвар, мөн улс нийгэмд үзүүлэх нөлөө, ур чадварыг заавал эзэмшүүлэх явдал юм.

Дүгнэлт: батлан хамгаалах боловсролын сургалтын арга зүй, технологи түүний мөн чанарын асуудлыг багцлан үзэхэд батлан хамгаалах боловсролын сургалтын арга зүй гэдэг бол Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, боловсрол, хүмүүжил, ёс зүйд сургаж, төлөвшүүлэх сургалтын хэрэгцээ, зорилго, агуулгыг хэрэгжүүлэх бодлого, зарчим, арга хэрэгслийн нийлбэр болно.

Батлан хамгаалах боловсрол олгох сургалт бол иргэдэд эх орноо батлан хамгаалахад шаардлагатай цэргийн мэргэжил, боловсрол, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэл олгох зорилгод тулгуурлах учир зохион байгуулалтын арга үйл ажиллагаа үүнд чиглэнэ гэдгийг тодорхойлов. Батлан хамгаалах боловсролын сургалт нь хоорондоо уялдаа холбоо бүхий төр, нийгэм, иргэдийн хэрэгцээ, батлан хамгаалах сургалтын зорилго, арга зүй, багшийн сургах зүй, суралцагчдын сурах үйл ажиллагаа, сургалтын хэлбэр, батлан хамгаалах боловсрол олгох сургалтын ур дүн гэсэн бүтэцтэй хэсгүүдээс бүрдэнэ хэмээн үзэж, тус бүрийн нь онцлогийг нь тодорхойлов.

Эшлэл авсан, ашигласан материалын жагсаалт

1. Бэгз.Н.Глобальчлалын үеийн Монгол улсын боловсролын хөгжлийн онол арга зүйн үндсэн асуудлууд. УБ.,2001; Батлан хамгаалах боловсролын агуулгыг хэрэгжүүлэх арга зүйн асуудлууд.Батлан хамгаалах боловсролын агуулга, арга зүйн асуудлууд сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл.УБ.,2019

2. Өлзийхуяг.Б. Батлан хамгаалах боловсролыг тогтолцооны хандлагын үүднээс судлах нь. Батлан хамгаалах боловсролын агуулга, арга зүйн асуудлууд сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ.,2019

3. Паламдорж.Ш. Батлан хамгаалах боловсрол судлал, түүний онол арга зүйн асуудал. Аюулгүй байдал батлан хамгаалах судлал сэтгүүл. №27(37).УБ.,2019, Батлан хамгаалах боловсролыг хууль, эрх зүй, ёс суртахуунд тулгуурлан олгох нь. Батлан хамгаалах боловсролын агуулга, арга зүйн асуудлууд сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ.,2019

4. ҮБХИС. Батлан хамгаалах боловсрол түүний агуулга арга зүйн үндсэн асуудлууд. Төслийн тайлан.УБ.,2020

5. Соронзонболд.Т, Хандсүрэн.Б, Орхончимэг.Х. Батлан хамгаалах боловсрол нийгмийн хэрэгцээ, шаардлага. Аюулгүй байдал батлан хамгаалах судлал сэтгүүл. №27(37). УБ., 2019

АНУ БА МОНГОЛ УЛСЫН ЦЭРГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ХЭТИЙН ТӨЛӨВ

Б.Баатарсүрэн
БХЭШХ-ийн Батлан хамгаалах дүн шинжилгээний төвийн ЭША, доктор(Ph.D)

Key words: Foreign Policy, Defense Relationship, Military Cooperations, Third neighbor

Abstract: The relationship between Mongolia and the USA have been improving steadily and has developed into a strategic partnership. One of the main reasons for this flourishing partnership is the importance of human rights for both democratic nations. The roles and responsibilities of the respective armed forces play a pivotal role in the relationship. The Mongolian Armed Forces views the United States as a leading nation and takes initiatives to extend and improve the relationship between the two nations. The United States has expressed interest in developing a more cohesive partnership through exercises in peacekeeping, Special Forces training, expansion of the Air Force, personnel development and humanitarian efforts.

Удиртгал

Хориннэгдүгээр зуунд түншлэлийн харилцааны ач холбогдол улам бүр өссөөр байна. Нэг орны аюулгүй байдал бүс нутгийн, магадгүй дэлхий дахины нөхцөл байдал, улс орнуудын гадаад бодлогын чиг хандлагатай холбоотой болж байгааг бид өнөөгийн олон улсын харилцааны зарим үйл явдлуудаас бэлхэнээ харж байна. Бүхий л салбарт улс гүрнүүдийн хоорондын хамаарал хийгээд бодлого, чиглэлийн уялдаа холбоо улам бүр өсөн нэмэгдэж байна. Иймээс аливаа чухал асуудлыг, түүний дотор энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах, хүн төрөлхтөний сэтгэл санааг чилээж байгаа глобал асуудлууд, түүнчлэн хөгжлийн асуудлыг ч өргөн хүрээнд харж, хариуцлагатай, ухаалаг хандах явдал чухал болжээ.

Монгол Улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, бүгд найрамдах улс мөн хэмээн үндсэн хуулиндаа тунхагласан бол, энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого явуулна хэмээн гадаад бодлогын үзэл баримтлалдаа тодорхойлсон юм. Хууль хэрэгжүүлэхдээ

бид үндсэн хуулиа үндэс болгодог бол гадаад бодлого хэрэгжүүлэхдээ гадаад бодлогын үзэл баримтлалыг үндэс болгодог. Монгол Улсын хувьд 1994 оны 6 дугаар сарын 30-ны өдөр УИХ-аас Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын болон Гадаад бодлогын үзэл баримтлал, Цэргийн номлолыг батлан гаргаснаар төрийн цэргийн бодлого шинэчлэгдэж энэхүү шинэчлэл нь олон улсын харилцаа, зах зээлийн эдийн засгийн харилцаа, төрийн ардчилсан тогтолцоонд гарсан өөрчлөлтийг тусгасан нийгмийн захиалга байсан гэж үзэж болно.

Монгол Улсын гадаад бодлого нь улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан-технологи, соёл, хүмүүнлэгийн гадаад бодлого, гадаадад байгаа иргэдийн эрх ашгийг хамгаалах, гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах бодлого гэсэн харилцан уялдаа бүхий үндсэн хэсгүүдээс бүрдэнэ.[129] Монгол Улсын гадаад бодлогын зорилго нь дэлхийн улсуудтай найрсаг харилцаатай байж, улс төр, эдийн засгийн болон бусад салбарын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлэх, хөгжил дэвшлийг хурдасгах замаар улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататгах явдал мөн[130] гэж тодорхойлсон бол АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, оронтой холбоотой "гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх; ... Дэлхий, бүс нутагт нөлөө бүхий улсуудтай харилцаа, хамтын ажиллагааг түлхүү хөгжүүлэхийг зорихын хамт аль нэг улсаас хэт хамааралтай буюу хараат байдалд орохоос сэрэмжилнэ[131] гэсэн зорилтуудыг үндэслэн Монгол Улсын АНУ-тай өрнөж буй батлан хамгаалах салбарын харилцааны өнөөгийн байдал, цаашдын төлөвийн талаар энэхүү судалгааны ажлаар тодорхойлохыг зорьж байна.

Судалгааны хэсэг

Өнөөдөр Монгол Улс дэлхийн олон оронтой дипломат харилцаа тогтоосон, мөн олон улсын нэлээд байгууллагын хүрээнд идэвхтэй ажиллаж байна. Монгол Улс АНУ-ын хооронд тогтоосон дипломат харилцаа 33 жилийн турш бат бэх байж, Батлан хамгаалах, эрүүл мэнд, шинжлэх ухаан, хөдөө аж ахуй, хууль, эрхзүй, эрчим хүч, тээвэр геодези, зураг зүй, байгаль орчны хамгааллын салбарт хамтын ажиллагаа хөгжиж, холбогдох салбарын байгууллагууд хамтран ажилласаар ирсэн. Үүний гол шалтгаан нь бидний суурь үнэт зүйлс буюу хоёул ардчилсан улс учраас хүний эрхийг дээдэлдэгт оршиж байна гэж үзэж болно. Тухайн улстай хөгжүүлж буй хоёр талын харилцааны агуулга, ач холбогдол, даацаас нь хамааруулж бид өнөөдөр дараах 4 эрэмбээр түншлэлийн харилцаагаа ялгаж, эрэмбэлж байна. Үүнд:

---

[129] *Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, 2011. (Монгол Улсын Их Хурлын 2011 оны 10 дугаар тогтоолын хавсралт)*

[130] *Мөн тэнд*

[131] *Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, 2011. (Монгол Улсын Их Хурлын 2011 оны 10 дугаар тогтоолын хавсралт)*

1. Стратегийн түншлэлийн харилцаа (ОХУ, БНХАУ, Япон, АНУ)

2. Иж бүрэн түншлэлийн харилцаа (БНСУ, Энэтхэг, АНУ, ХБНГУ, Түрк)

3. Өргөн хүрээтэй түншлэлийн харилцаа (Канад, Австрали, Казакстан)

4. Түншлэлийн харилцаа (бусад орон)

АНУ-Монгол Улсын хооронд 1987 онд албан ёсоор дипломат харилцаа тогтсон ч хоёр улсын харилцааны түүхийг сөхөн харвал 20 дугаар зууны эхэн үетэй холбогдоно. Тухайлбал Монгол Улс 1911 онд тусгаар тогтнолоо тунхагласныхаа дараа тусгаар тогтнолоо их гүрнүүдээр хүлээн зөвшөөрүүлэх гэсэн хэд хэдэн алхмыг хийсэн байдаг.

Олноо өргөгдсөний 2 дугаар оны намрын сүүл сарын 20 буюу 1912 оны 10 дугаар сарын 29-ний өдөр Гадаад хэргийн яамнаас ноот бичгийг үйлдэж Франц, Англи, Герман, АНУ, Бельги, Япон, Дани, Голланд болон Австри зэрэг есөн улсын элчин нарт илгээсэн байна. Уг ноот бичигт "харилцан гэрээ байгуулан худалдаа нэвтрүүлж улсын найрамдлыг зузаатгамуу" гэсэн саналыг дэвшүүлжээ. Гэвч тэдгээр 9 улсын нэг нь ч хариу ирүүлээгүй юм.[132]

Монгол Улсын Гадаад явдлын яамны орлогч сайд, нэгдүгээр орлогч сайдаар 20 жил ажилласан Д.Ёндон АНУ, Монгол хоёр улсын дипломат харилцаа тогтоох оролдлого энэ үеэс эхэлж, 1987 онд бодит биелэлээ олсон тул энэ үйл явцыг 80 орчим жил үргэлжилсэн гэж тооцсон нь бий.

Монгол Улсын хувьд бүс нутгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцохыг тогтмол эрмэлзсээр ирсэн билээ. Тиймээс бүс нутгийн аюулгүй байдлын явагдаж буй динамик өөрчлөлтийг, хүчний харьцаа, голлох үйл явдлуудыг ажиглах, дүн шинжилгээ хийх зайлшгүй шаардлагатай байдаг билээ.

Монгол Улс АНУ-ын харилцаа анх дипломат харилцаа тогтоосон цагаасаа өдийг хүртэл тогтмол хөгжсөөр ирсэн боловч хоёр талын харилцааны зарим он жилүүдэд харилцаа бусад цаг үетэй харьцуулахад илүү хурдацтай хөгжиж байсан нь ажиглагдаж байна. 1987-1991 оны хоорондох дөрвөн жил, 2003-2008 оны хоорондох 5 жилд хоёр талын харилцаа хамгийн хурдацтай хөгжсөн гэж дүгнэж болохоор байна. Энэхүү 9 жилийн хугацаанд АНУ-ын Бүгд Найрамдах нам төрийн эрх барьж байсан дүр зураг ажиглагдаж байна. Хоёр талын харилцаа хөгжихөд олон улсын нөхцөл байдал, цаг хугацааны хүчин зүйлс зэрэг олон хүчин зүйлс нөлөөлсөн нь тодорхой ч Бүгд найрамдахчууд төрийн эрх барьж байсан нь ч нөлөөлсөн гэж үзэж болох талтай.

Өнгөрсөн 33 жилийн хугацаанд хоёр орны харилцааны түвшин зогсолтгүй ахисаар шинэ шатанд гарлаа. Тодруулж хэлбэл, 2019 оны 7 дугаар сарын 29-ний өдрөөс 8 дугаар сарын 3-ны өдрүүдэд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын АНУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр баталсан Хамтарсан тунхаглалд хоёр талын харилцаа Стратегийн түншлэлийн түвшинд хүрснийг зарласан юм.

[132] Ц.Батбаяр, "Монгол ба Их Гүрнүүд XX зуунд I боть, "Адмон" хэвлэлийн газар, УБ., 2015.

АНУ-тай харилцах харилцаа бол Монгол улсын хэрэгжүүлж буй гуравдагч хөршийн бодлогод суурилсан маш чухал харилцаа билээ. Энэ харилцаа нь стратегийн нийтлэг эрх ашиг, ардчиллын үнэт зүйлс, сайн засаглал, бүрэн эрхт байдал болон хүний эрхийг дээдлэх зарчмуудад тулгуурлан хөгжсөөр байна.

АНУ дэлхийн 16 улстай стратегийн түншлэлийн харилцаа тогтоогоод байсан бол Ерөнхийлөгч Х.Баттулгын айлчлалын явцад Америкийн тал манай улсыг 17 дахь стратегийн түншээрээ сонгосон нь Монгол Улсын нэр хүндийг олон улсын хэмжээнд өндөрт өргөлөө гэж шинжээчид дүгнэж байна.[133] 2018 оны 9 дүгээр сард Ерөнхий сайд У.Хүрэлсүх АНУ-д айлчлах үеэр хоёр тал Стратегийн түвшний өмнөх үе шат буюу "Өргөтгөсөн иж бүрэн түншлэл"-ийг тогтоож байсан бол жил хүрэхгүй хугацааны дараа харилцаа ийнхүү бүхэл бүтэн нэг шатаар ахисан юм.

Монгол улс 192 улстай дипломат харилцаа тогтоосноос өнөөдрийг хүртэл дөрөвтэй нь стратегийн түншлэлтэй байсны дээр АНУ нэмэгдсэн. Монгол Улс нь АНУ-ыг худалдааны чухал түнш, томоохон хөрөнгө оруулагч байлгах эрмэлзэлтэй. Монгол, Америкийн харилцаа, хамтын ажиллагааг эдийн засаг, хөрөнгө оруулалт, банк санхүү, худалдааны салбарт харилцан ашигтайгаар өргөжүүлэн хөгжүүлэх боломжтой гэж судлаачид үздэг.

Хоёр улсын дипломат харилцаа 1987 оноос үүдэлтэй боловч хоёр орны цэргийн харилцаа Монгол Улс социалист системээс албан ёсоор гарсны дараа буюу 1991 оноос эхэлсэн билээ.

Батлан хамгаалах салбарын хувьд батлан хамгаалах гадаад харилцаа, хамтын ажиллагаа нь цэргийн хамтын ажиллагаа, цэрэг-техникийн хамтын ажиллагаа гэсэн хоёр үндсэн хэлбэрээр хөгжиж байна. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг улс төр-дипломатын аргаар хангахад дэмжлэг үзүүлэх, батлан хамгаалах гадаад таатай нөхцөлийг бүрдүүлэх, цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, олон улсын тавцанд Монгол Улсын Зэвсэгт хүчний нэр хүнд, байр суурийг өргөжүүлж, бэхжүүлэх, бүс нутгийн аюулгүй байдлыг хангахад хувь нэмрээ оруулах, цэргийн шинэчлэлийг хэрэгжүүлэх, гадаадын тусламж, дэмжлэг авахад чиглүүлэн хөгжүүлж байна.[134]

1991 онд БХЯ дэлхийн хамгийн том 3 улстай цэргийн албан ёсны харилцаатай болж чадсан нь цаашид өөрийн гэсэн бодлоготойгоор олон улсын харилцаанд хамрагдах боломжийг бий болгож, түүнчлэн улс орны аюулгүй байдлыг улс төрийн аргаар хангах үйл ажиллагаанд цэргийнхэн өөрсдөө оролцох бололцоо нээгдсэн юм. Өнөөгийн байдлаар дэлхийн нийт 32 улстай батлан хамгаалах салбарт харилцаа тогтоон хамтын ажиллагаатай ажиллаж байгаагаас 16 улстай идэвхтэй харилцаатай, 16

[133] https://www.montsame.mn/mn/read/198005

[134] *Батлан хамгаалах гадаад харилцаа, хамтын ажиллагааны цагаан ном, УБ., 2015.*

улстай идэвхгүй харилцаатай байна. Эдгээр 32 улсаас цэрэг-техникийн хамтын ажиллагаатай 5 улс /ОХУ, БНХАУ, Украйн, Беларусь, Турк/ байна.

Монгол Улсын Батлан хамгаалах салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааны хувьд АНУ нь тэргүүлэх чиглэлийн орон бөгөөд тус улстай батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд онцгой анхааран ажилладаг. Хоёр улсын хамтын ажиллагааны бусад олон чиглэл бий. Түүний нэг нь болох цэргийн салбарт нягт хамтын ажиллагаатай. АНУ-ын Монголын энхийг сахиулагчдыг дэмжих идэвхтэй үйл ажиллагаа нь бидний хамтын ажиллагааны чухал хэсэг юм. Монгол цэргүүд дэлхийн хамгийн хүнд хэцүү хэсэгт энх тайван тогтоох үйлсэд хувь нэмрээ оруулж байгаа төдийгүй олон улсад олсон нэр хүнд нь монголчуудын бахархал болсон. Монголын энхийг сахиулагчдад сургалт, машин, тоног төхөөрөмж болон бусад олон зүйлээр АНУ-ын зүгээс тусалж байна. Түүнчлэн хоёр улс бие биенээсээ хэрхэн суралцаж, иргэд хоорондын харилцаа улам гүнзгийрч байгаа нь олон жишээнээс харагдаж байна. Тухайлбал, хууль сахиулах чиглэлийн хамтын ажиллагааны хувьд АНУ-ын Холбооны мөрдөх товчоо, мөн Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх газрын мэргэжилтнүүд Монгол Улсад ирж, хууль хүчнийхэн, цагдаагийн байгууллагын албан хаагчдад дэлхий нийтийн асуудал болоод буй хар тамхи, мансууруулах бодистой тэмцэхэд нь тусалж, туршлагаа хуваалцдаг байна.

Түүхээс үзвэл 1990 оноос 2001 оны хооронд АНУ-аас Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид болон багш нарын англи хэлний мэдлэгийг дээшлүүлэхэд үзүүлсэн тусламж хоёр орны цэргийн боловсролын харилцааны үлэмж хувийг эзэлж байсан байна.[135] Харин 2001 оноос АНУ-ын цэргийн боловсролын тусламжийн хэмжээ нэмэгдсэн ба үүний үрээр Монгол Улсын Зэвсэгт хүчний офицер, ахлагч нар цэргийн мэргэжлийн боловсролоо дээшлүүлэх боломжтой болсон билээ. Түүнчлэн 2003 оноос Монгол Улсын Засгийн газар АНУ-ын толгойлсон эвслийн цэргийн хүчний "Иракийн эрх чөлөө" болон Афганистан улс дахь "Тогтвортой эрх чөлөө" ажиллагаануудад цэргийн багуудыг илгээх шийдвэр гаргасантай холбогдуулан АНУ-ын Батлан хамгаалах яам Монгол Улсын Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагааны сургалт, бэлтгэлийг дэмжих санхүүжилтээ нэмэгдүүлэх шийдвэр гаргасан.[136]

Үүнээс гадна АНУ нь Монгол Улсын цэргийн боловсролын түвшинг нэмэгдүүлэх талаар хэд хэдэн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна. Эдгээрээс дурдвал Эвслийн Дэмжих Санаачилга (*Coalition Support Initiative*), Дэлхийн Энхийн Ажиллагааны Санаачилга (*Global Peace Operations Initiative*), Олон улсын цэргийн боловсрол, сургалтын хөтөлбөр

[135] *Christopher Pultz, "The Role of Peacekeeping in Mongolia's Military Strategy: A New Paradigm for Security", Asia Policy, Number 17, January 2014, p. 136.*

[136] *Christopher Pultz, "The Role of Peacekeeping in Mongolia's Military Strategy: A New Paradigm for Security", Asia Policy, Number 17, January 2014, p. 136.*

(*IMET*) болон Батлан хамгаалах байгуулалтын шинэчлэл санаачилга (*Defense Institute Reform Initiate*) зэрэг болно. Дээрх тусламжийн үр шимийг хүртсэн Зэвсэгт хүчний бүрэлдэхүүний тоо маш олон бөгөөд АНУ-аас Монгол Улсад суух онц бөгөөд бүрэн эрхт элчин сайдаар ажиллаж байсан ноён Жонатан Эдлтоны өөрийн "Нэгэн чухал хүчин зүйл: АНУ-Монгол улсын дипломат харилцаа, 1987-2012" номондоо өгүүлснээр 1992-2014 онд цэргийн боловсролын харилцааны хүрээнд зохион байгуулагдсан 30 орчим төрлийн 200 гаруй хурал, семинар, дадлага, сургалтад Монгол Улсын Зэвсэгт хүчний 1000 гаруй алба хаагчид хамрагдан мэдлэг, мэргэжлээ дээшлүүлсэн байна. Эдгээр төсөл, хөтөлбөрүүд болон цэргийн боловсролын идэвхтэй харилцааны үр дүнд Монгол Улсын Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний цэргийн мэргэжлийн боловсролын түвшин үлэмж нэмэгдсэн ба Зэвсэгт хүчний энхийг сахиулах ажиллагааны чадавх улам бүр өсөн нэмэгдэж байна.[137]

Монгол Улс, АНУ-ын хувьд 1991 онд анх батлан хамгаалахын атташе харилцан суулгах хэмжээнд харилцаа тогтсоноос хойш хоёр улсын батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа нь Монгол Улсын Батлан хамгаалах салбарын шинэчлэлд дэмжлэг үзүүлэх, Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагааны чадавхыг бэхжүүлэх, олон улсын энхийг дэмжих, хүмүүнлэгийн ажиллагааны чиглэлээр туршлага солилцох, хамтран үүрэг гүйцэтгэх, бүс нутгийн тогтвортой байдлын талаар ярилцаж санал солилцох зэрэг чиглэлээр тус тус хөгжиж байна.

Хоёр улсын батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааг зохицуулах зорилгоор 1996 онд "Цэргийн айлчлал, солилцооны тухай Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээр", 2003 онд цэргийн ар талын хэрэглээ, үйлчилгээний асуудлыг зохицуулах тухай "Монгол Улсын Батлан хамгаалах яам, АНУ-ын Батлан хамгаалах яам хоорондын хэрэглээ, харилцан үйлчилгээний Хэлэлцээр", 2003 онд "Олон улсын эрүүгийн шүүхийн хуулийн 98 дугаар зүйлийн талаарх Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээр"-ийг тус тус байгуулан хэрэгжүүлж байгаа[138] нь үр дүнтэй байна.

Дүгнэлт

Монгол-АНУ-ын харилцааг шинэ түвшинд буюу Стратегийн түншлэлийн түвшинд хүргэснээрээ Ерөнхийлөгч Х.Баттулгын айлчлал Монгол Улсын хувьд асар их ач холбогдолтой үйл явдал болсон байна. Хоёр тал улс төр, эдийн засаг, үндэсний аюулгүй байдал болон нийгмийн хүрээнд хамтран ажиллах бат бэх суурь дэвсгэрийг тавьж, Монгол-Америкийн харилцааг шинэ шатанд гаргасан уг айлчлалыг "түүхэн" гэж тодотгож болно.

Монгол Улс нь АНУ-ыг худалдааны чухал түнш, томоохон хөрөнгө оруулагч байлгах эрмэлзэлтэй. Монгол, Америкийн харилцаа, хамтын

[137] *Жонатан Эдлтон "Нэгэн чухал хүчин зүйл: АНУ-Монгол улсын дипломат харилцаа, 1987-2012", УБ. 2012, 118.*

[138] *Монгол Улсын Батлан Хамгаалах Яам, 2020.*

ажиллагааг эдийн засаг, хөрөнгө оруулалт, банк санхүү, худалдааны салбарт харилцан ашигтайгаар өргөжүүлэн хөгжүүлэх боломжтой гэж судлаачид үзсэн байна. Батлан хамгаалах салбарын харилцааны хувьд 2 улс 1995 оноос эхлэн хэтийн төлөвлөгөөтэй ажиллаж, цаашид "Монгол Улсын Батлан хамгаалахын шинэчлэлийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэхэд хамтарсан хөтөлбөр, төслүүдийг чиглүүлэхэд онцгойлон анхаарч байна. Түүнчлэн дараах чиглэлүүдэд талууд тодорхой ач холбогдол өгч байна. Үүнд: Энхийг дэмжих ажиллагааны чадавхыг нэмэгдүүлэх, Тусгай ажиллагааны хүчин чадлыг нэмэгдүүлэх, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, Байгууллагын болон хүний хөгжил, Хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, гамшгийн үед авран туслах ажиллагаа явуулах зэрэг чиглэлүүд байна. Ийнхүү хоёр орны батлан хамгаалах салбарын харилцааг тодорхой зорилго, чиглэлтэйгээр өргөжүүлж, хөгжүүлэх зөвлөлдөх механизмыг бүрдүүлээд байна.

АНУ НҮБ-ын ажиллагаанууд болон Афганистан дахь Монголын цэргийн оролцоонд талархаж, "Хааны эрэлд" сургалтыг хамтран зохион байгуулахад үргэлжлүүлэн оролцох бөгөөд цаашид бидний харилцааг өргөжүүлэх шинэ арга замыг эрэлхийлэх болно гэдгээ илэрхийлсээр байгаа юм. АНУ 150 гаруй жилийн турш Ази, Номхон далайн бүсэд эдийн засаг, нийгмийн дэвшлийн хүчтэй тоглогч байсаар ирсэн бөгөөд ойрын хэдэн арван жилд ч чухал үүрэг гүйцэтгэх болно хэмээн судлаачийн зүгээс дүгнэж байна.

Эшлэл авсан, ашигласан материалын жагсаалт:

1. Christopher Pultz, "The Role of Peacekeeping in Mongolia's Military Strategy: A New Paradigm for Security", Asia Policy, Number 17, January 2014, p. 136.
2. https://www.montsame.mn/mn/read/198005
3. Батбаяр. Ц, "Монгол ба Их Гүрнүүд XX зуунд I боть, "Адмон" хэвлэлийн газар, УБ., 2015.
4. Батлан хамгаалах гадаад харилцаа, хамтын ажиллагааны цагаан ном, УБ., 2015.
5. Жонатан Эдлтон "Нэгэн чухал хүчин зүйл: АНУ-Монгол улсын дипломат харилцаа, 1987-2012", УБ., 2012.
6. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, 2011. (Монгол Улсын Их Хурлын 2011 оны 10 дугаар тогтоолын хавсралт)

ДЭД БҮТЦИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ БА БАТЛАН ХАМГААЛАХ ДЭД БҮТЦИЙН ТУХАЙД

Б.Очирсүрэн
БХЭШХ-ийн Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалын төвийн ЭША, докторант, ахмад
Э.Батгэрэл
ҮБХИС-ийн Захиргаа удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн, хошууч

Key words: *development, infrastructure, defense policy, military infrastructure*

Abstract: *In this article, we will look at the development of the concept of infrastructure and its relationship with military infrastructure. Infrastructure has been around since urban development. But this concept came into scientific circulation quite a bit later. From the first it was used among the military, then in the economy, and now it is one of the defining dimensions of the development of the state. The military infrastructure is determined by the state's defense policy.*

Оршил.

Хүн төрөлхтөн XX дугаар зууны дунд үеэс эхлэн улс орон, бүс нутгийн хөгжлийн түвшинг дэд бүтэцтэй холбон авч үзсээр ирлээ. Өнөөдөр ч аливаа улс орны хөгжлийг тодорхойлох үзүүлэлтийн нэг нь дэд бүтцийн салбарын хөгжил хэвээр байна.

Шинжлэх ухааны ном, зохиол, илтгэл, өгүүлэлд дэд бүтэц гэдэг үгний утгыг тодорхой тайлбаргүйгээр хэрэглэх тохиолдол их гардаг. Ихэнх судлаачид дэд бүтцэд хамаарах ойлголтуудын зааг ялгааг нарийн гаргаагүй ямар үндэслэлээр тухайн ойлголтод багтаасан болохоо тайлбарладаггүй. Оксфордын орчин цагийн Англи хэлний тайлбар тольд "дэд бүтэц" хэмээх ойлголтыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. а. Нийгэм, аж ахуйн үндсэн бүтцийн суурь; б. Зам, гүүр, ус сувгийн хоолой гэх мэт улсын эдийн засгийн суурь байгууламжууд;
2. Ажиллагаа явуулах гэх мэт цэргийн зориулалтаар ашиглах байнгын байгууламж[139] хэмээн тодорхойлжээ.

[139] *Oxford's U.S. Dictionaries Program- "The Oxford American Dictionary of Current English" (New Amer-*

Түүхийн үүднээс судлах юм бол дэд бүтэц (лат. infra – “доод”, “доорх” мөн лат. structura “байгууламж”, “байрлал”) хэмээх орчин үеийн ойлголт нь XX дугаар зууны эхэн үед цэргийн хэллэгт хэрэглэгдэж байв. Тухайн үед энэхүү ойлголт нь зэвсэгт хүчнийг дэлгэх, байлдааны ажиллагаа явуулах, цэргүүдийн байлдааны болон оперативын бэлтгэлийг хангах нөхцөлийг бүрдүүлсэн обьект болон тусгай байгууламжийн тогтолцоог илэрхийлдэг байжээ[140]. Цэрэг дайны зориулалтаар газар орны гуу жалгыг бөглөх, гүүр, гарам барих холын аян дайны үед агт морьд услах цэг урьдчилан бэлтгэх зэрэг байлдааны ажиллагааг амжилттай явуулахад шаардлагатай олон төрлийн арга хэмжээг дэд бүтэцтэй холбон тайлбарлаж болно. Ийм үйл ажиллагааг Эртний Ром, Грек түүнээс ч өмнөх соёл иргэншилд ашиглаж байсан нь ойлгомжтой. Монголчуудын байлдан дагуулалтын үед дайн байлдаан хийхдээ тухайн газар орноос мод бэлтгэж инженерийн төхөөрөмжлөл/гүүр, гарам, оньс гэх мэт/-ийг хийдэг, зарим тохиолдолд урьдчилан бэлтгэж авч явдаг байсан байна.

Дэд бүтэц хэмээх өнөөгийн ойлголт, нэр томьёог анх Адам Смит гаргаж, тээврийн дэд бүтцийг эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэсэн гэдгийг тодорхойлж хэлэхдээ: “замгүй, тээвэргүй байсан бол нийгмийн хөдөлмөр хуваарилалт, хөдөлмөрийн үр бүтээмжийн өсөлт, үүнийг дагаад баялаг бүтээх хүчин зүйл гэж байхгүй байх байлаа” гэсэн юм.

XIX, XX зууны ихэнх хугацаанд дэд бүтэц хэмээх ойлголт нь эдийн засагт огт хэрэглэгдэж байсангүй. Карл Маркс, Альфред Маршалл, Леон Вальрас болон тухайн үеийн бусад эдийн засагчид бүтээгдэхүүн, үйлчилгээг капитал эсвэл хөдөлмөр бий болгодог, капитал гэдэг нь байгууллагын үйлдвэрлэлийн хөрөнгө хэмээн ойлгодог байв.

Дэлхийн хоёрдугаар дайны дараа хөгжлийн эдийн засаг гэсэн шинэ салбар эдийн засгийн шинжлэх ухаанд бий болсон ч дэд бүтэц хэмээх ойлголт тэр бүр хэрэглэгддэггүй байжээ. Үйлдвэрлэлийн хүчин зүйл, баялаг(капитал) хэмээх ойлголт нь хөгжлийн эдийн засгийн онолд чухал үүргийг гүйцэтгэсэн хэвээр байлаа. Удалгүй хөгжлийн эдийн засгийн онолыг үндэслэгчдийн зарим нь дэд бүтэц гэдэг ойлголтыг ялгаж салгах оролдлого хийж эхэлсэн юм. Розенстейн-Родан тэмдэглэхдээ «үйлдвэр байгуулахын тулд их хэмжээний дэд бүтцийг хөрөнгийг эсвэл дэд бүтцийг ивээн тэтгэх зайлшгүй шаардлагатай тулгардаг ба үүнийг зах зээлийн механизм цаг хугацаанд нь хэзээ ч бий болгодоггүй»[141] гэж тэмдэглэсэн байна.

Зарим эрдэмтэд “дэд бүтэц” хэмээх ойлголтыг эдийн засаг дахь төрийн оролцооны материаллаг үндсэн хэрэгсэл гэж тодорхойлсон байна.

Дэлхийн банкны судлаачдын 2004 онд боловсруулсан ажилд[142] дэд бүтцэд хамаарах илүү тодорхой заалтуудыг оруулж өгсөн бөгөөд үүнд дурдагдсан объектууд нь дараах шинжийг бүрэн эсвэл хэсэгчлэн агуулсан байх юм. Үүнд:

---

ican Edition)., New York, 1999, p. 404

[140] *https://cyberleninka.ru/article/n/infrastruktura-ponyatie-vidy-i-znachenie*

[141] *Meier, G., Seers D., (Eds.). Pioneers in Development. New York: Oxford University Press for the World Bank. -1984. - 372p.*

[142] *Prud'homme, Remy. Infrastructure and development. Washington D.C. - The Worldbank. - 2004.*

- Объект нь үндсэн хөрөнгө байх ба дангаар нь шууд ашиглах боломжгүй. Түүнийг хөдөлмөр болон үйлдвэрлэлийн бусад хүчин зүйлс (тухайлбал газар)-тэй хамт ашиглана.
- Дэд бүтцийн объектоос ирэх ашиг нь "хэлбэлзэлтэй" байх ба шат дараалан өсдөггүй. Тухайлбал, 80 хувийн ажлын гүйцэтгэлтэй гүүр эсвэл далангийн ашигтай байдал 0 хувьтай байж болно. Дэд бүтцийн эрэлт тогтмол нэмэгдэж байдагтай холбоотойгоор эрэлт нийлүүлэлтийг тэнцвэржүүлэхэд ихээхэн хүнд, эсвэл бараг боломжгүй гэж хэлж болно. Түүнчлэн дэд бүтцийн байгууламжийн газрыг сонгох, барих үйл явц нь нилээд цаг хугацааг шаарддаг учраас түүний ашиг хэлбэлзэлтэй байхаас өөр аргагүй юм.
- Дэд бүтцийн объект нь удаан хугацааны хэрэгцээнд зориулагдсан. Ашигтай хугацаа нь хэдэн арван жилээр заримдаа хэдэн зуун жилээр хэмжигддэг. Тухайлбал, Европт өнөөг хүртэл ашиглагдаж буй зарим зам сувгууд Римийн эзэнт гүрний үед баригдсан байна. Дэд бүтцийг урт настай гэсний учир нь түүнийг ашиглахын тулд санхүүжилт хийгдэж, объектын төлөв байдлыг шаардлагатай хэмжээнд барьж байх засвар үйлчилгээ хийгддэгтэй холбоотой.
- Дэд бүтэц нь тодорхой газар нутагт хамаарагддаг. Бусад төрлийн эд хөрөнгөтэй харьцуулбал дэд бүтцийн объект нь ихэнхдээ үл хөдлөх хөрөнгө байдаг. Үүнээс хамааран төрөөс дэд бүтцэд хөрөнгө оруулахдаа эдийн засаг, бүс нутгийн хөгжлийн болон бусад бодлогоо хэдэн арван жилээр түрүүлж харахыг шаарддаг.
- Дэд бүтцийн үзүүлж байгаа үйлчилгээ нь зах зээлийн механизмын үр дүнгүй байдлыг харуулж байдаг. Хэрэв үүнийг аль нэг байгууллага хувь хүн эзэмших юм бол бодит монопол үүсэх магадлалтай. Тиймээс дэд бүтцийг хөгжүүлэхэд төрийн оролцоо зайлшгүй шардлагатай.
- Дэд бүтэц, түүний үзүүлж буй үйлчилгээний хэрэглэгч нь айл өрх, албан байгууллага бөгөөд энэ нь эцсийн юм уу, хэсэг хугацааны хэрэглээ байж болно. Ийм хоёр янзын хэрэглээ нь дэд бүтцийн төрөл, цаг хугацаа орон зайнаас шалтгаалдаг бөгөөд ихэнх тохиолдолд албан байгууллага нь айл өрхүүдээс илүүтэйгээр ашигладаг.

Дэд бүтцийн талаарх ойлголт нэгдмэл болж төлөвшилгүй өнөөдрийг хүрсэн гэдгийг дээр өгүүлсэн дэд бүтцийн талаарх олон үзэл санаа илэрхийлж байна. Гэхдээ дэд бүтцийг үйлдвэрлэлийн, нийгмийн, тээврийн, инженерийн үндэсний эдийн засгийн, аялал жуулчлалын

болон батлан хамгаалах дэд бүтэц гэж ерөнхийд нь ангилж үзэж болох юм. Дэлхийн улс орнууд эдийн засгийн хөгжлийг дэмжих, ард иргэдийн аятай тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэхээс гадна улс орноо батлан хамгаалах зорилгоор дэд бүтцийн бүтээн байгуулалтыг хийдэг.

Батлан хамгаалах /цэргийн/ дэд бүтэц

Зэвсэгт хүчний байлдааны чадавх зарчмын хувьд дэд бүтцээс маш их хамааралтай. ОХУ нь улс орныхоо аюулгүй байдлыг хангах, өөрийн нөлөөний бүсээ бий болгох, бүс нутгийг ашиглах зорилгоор Арктикт цэргийн дэд бүтцийг сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжүүлж байна. ОХУ Арктикийн бүс нутгаа 2035 он хүртэл хөгжүүлэх стратегиа 2020 оны 10-р сард баталсан. Уг стратегийн гол зорилго нь Арктикийн бүс нутагт үүрэг гүйцэтгэх цэргийн хүчнийг орчин үеийн зэвсэг техник хангах, цэргийн хүчин, техник байнга байрлах боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн байна. БНХАУ нь Ази, Номхон далайн бүс нутагт өөрийн ноёрхлыг тогтоох, АНУ-ын нөлөөг багасгах зорилгоор тухайн бүс нутагт цэргийн дэд бүтцийг сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжүүлж байгаа. Шри Ланкийн боомтыг 99 жилийн хугацаатай түрээслэж худалдаа-тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах тулгуур цэг болгон хөгжүүлсэн. 2020 онд л гэхэд Спратли болон Параселийн арлууд дээр 2 судалгааны станц байгуулж, арлууд дээр радар, холбооны тагнуулын хүчин чадавхаа сайжруулахад хөрөнгө оруулалт хийж байна[143]. Дэлхийд тэргүүлэгч гүрэн АНУ-ын хувьд дэлхийн өнцөг булан бүрт цэргийн дэд бүтцийн хүчирхэг сүлжээг хөгжүүлсэн. Шаардлагатай тохиолдолд аль ч бүс нутагт өөрийн холбоотон улсуудыг дэмжих, байлдааны ажиллагаанд оролцох боломжоо тэлж, ингэснээр улсынхаа эрх ашгийг ханган, тэргүүлэгч гүрний байр сууриа хадгалж байна.

Манай улсын хувьд 1990-ээд оноос өөрийгөө бие даан батлан хамгаалах тогтолцоонд шилжиж, үүндээ тохирсон батлан хамгаалах дэд бүтцийг хөгжүүлэх шаардлага бий болсон. 2015 онд батлагдсан Батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичигт "Монгол Улс орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлнэ" гэж тусгасан. Мөн орон нутгийн хамгаалалтын зарчим, удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, дэд бүтэц нь дайчилгааны сургалт явуулах болон нөөц бүрдүүлэх тогтолцоотой уялдсан байна гэж тодорхойлж өгсөн байдаг. Монгол Улсын хувьд бодитой дайсан байхгүй ч гэсэн улс орныхоо аль ч өнцөг буланд шаардлагатай тохиолдолд, богино хугацаанд шилжин байрлах боломжтой байх нь манай улсын батлан хамгаалах дэд бүтцийн хөгжлийн шалгуур үзүүлэлт гэж үзэж байна.

ОХУ ***батлан хамгаалах дэд*** бүтцийн объектыг дараах дөрвөн бүлэгт ангилж үздэг байна[144]. Үүнд:

1. тусгай зориулалтын цэргийн дэд бүтцийн объект;

[143] *Б.Эрдэнэчимэг. "Хятадын цэрэг, батлан хамгаалах бодлого шинэ зуунд" УБ. 2020.*

[144] *https://cyberleninka.ru/article/n/sostav-struktura-sostoyanie-i-perspektivy-ispolzovaniya-obektov-voennoy-infrastruktury/viewer*

2. ерөнхий зориулалтын цэргийн дэд бүтцийн объект;

3. хос зориулалттай дэд бүтцийн объект;

4. дэд бүтцийн бусад объект.

Тусгай зориулалтын цэргийн дэд бүтцийн объект нь цэргийн хүчин, анги нэгтгэл, цэргийн бүлэглэл өөрсдийн зориулалтын дагуу байлдааны үүрэг биелүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд зориулагдсан байгууламж юм. Энэ нь цэргийн дэд бүтцийн үндсэн суурь болдог байна. Эдгээрт: удирдлагын төв, агаарын болон пуужингийн довтолгооноос урьдчилан сэргийлэх системийн объектууд; сансрын, радио болон радиотехникийн тагнуулын болон сэтгэлзүйн тэмцлийн объектууд; стратегийн зориулалттай пуужинт цэрэг, АДХ цэргийн болон Агаар сансрын хүчний байрлах газар орны объектууд; цэргийн аэродром; флот болон флотилийн бааз; холбооны зангилаа; цэргийн, оперативийн нөөц болон төв нөөцийн бааз, агуулах; бэхлэлт хориглолт; цэргийн зориулалттай шугам хоолой /трубопроводы/.

Ерөнхий зориулалттай цэргийн дэд бүтцийн объектод цэргийн хүчин, анги нэгтгэл, цэргийн бүлэглэл өдөр тутмын үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд зориулагдсан байгууламжууд хамаардаг байна. Үүнд: цэргийн хотхон; полигон; сургалтын төв/газар нутаг/; техник засварын байр; эмчилгээ-сэргээн засах, цэргийн эмчилгээний болон цэргийн сургалтын байгууллага, холбооны зангилаа болон шугам сүлжээ гэх мэт;

Хос зориулалттай дэд бүтцийн объектод улс орны батлан хамгаалах чадавхад чухал ач холбогдолтой иргэний объектыг хамруулдаг байна. Аливаа аюул, заналхийлэл, түрэмгийллийн үед эдгээр нь Зэвсэгт хүчний мэдэлд шилжиж байлдааны үүрэг гүйцэтгэхэд ашиглагддаг байна. Үүнд: нисэх онгоцны буудал; тэнгисийн/гол, мөрний/ боомт; зам харилцаа холбоо /төмөр зам, авто зам, агаар болон усан зам, дамжуулах хоолойн сүлжээ/; сансрын дэд бүтцийн объектууд; холбоо, эрчим хүч, усны шугам сүлжээ, түүхий эд олборлох объектууд; энхийн болон байлдааны цагт иргэний болон цэргийн зориулалттай бүтээгдэхүүн нийлүүлдэг үйлдвэр, аж ахуй нэгж; засвар-сэргээн засварлах үйлдвэр, аж ахуй нэгж, иргэний хамгаалалтын объектууд, иргэний зориулалттай эмнэлэгийн байгууллагын сүлжээг болон бусад объектууд багтдаг байна.

Дээрх гурван бүлэгт багтах дэд бүтцийн объектууд нь Зэвсэгт хүчин, бусад цэрэгжсэн байгууллага, цэргийн бүлэглэлийг ашиглах, тэдгээрийн бэлтгэл сургуулилтыг хангахад зориулагдсан, улс орны дэд бүтцийн объектын нийлбэр бөгөөд батлан хамгаалах дэд бүтцийг бүрдүүлэгч болдог байна.

Батлан хамгаалах дэд бүтцийн үндсэн хэсэг нь цэргийн дэд бүтэц ба үүнийг улс орноо хамгаалах зорилгоор газар нутгаа оператив төхөөрөмжлөлийн хүрээнд олон яам, агентлагийн тусламжтайгаар байгуулдаг байна. Цэргийн дэд бүтцийг оросын цэргийн нэвтэрхий толь бичигт дараах байдлаар тайлбарлажээ.

Цэргийн дэд бүтэц[145]:

- Зэвсэгт тэмцлийн үед цэргийн хүчин стратегийн, оператив-стратегийн, оперативын болон байлдааны үүргээ гүйцэтгэх боломжоор хангаж, энхийн цагт цэргийг байрлуулах, өдөр тутмын бэлтгэл, сургалт болон цэргийн үйлдвэрлэл үйлчилгээг зохион байгуулж явуулах нөхцөлөөр хангахад зориулагдсан цэргийн объект, байгууламжийн цогц юм. Цэргийн дэд бүтэц нь дараахаас бүрдэнэ: удирдлагын байр, цэргийн байр, аэродром, тэнгисийн цэргийн бааз, пуужингийн байр, холбооны систем, газар орны инженерийн байгууллын систем, полигон, агуулах болон бусад байгууламжаас бүрдэнэ.

- Цэргийн дэд бүтцийн объектийг байгуулах нь цэргийн хүчний байнгын бэлэн байдлыг хангах, хөдөлгөөнт байдал болон амьд гарах өндөр чадамжийг нэмэгдүүлэх, мөн өдөр тутмын үйл ажиллагаа болон байлдааны ажиллагаа явуулах үеийн бүх талын хангалтыг тасралтгүй зохион байгуулахад оршино. Цэргийн дэд бүтцийн объектыг байгуулах/ сайжруулах/ үйл ажиллагаа нь гадаад болон дотоодын цэргийн аюул байдлын заналхийллийн төвшнөөс шалтаалан ОХУ-ын газар нутгийг батлан хамгаалах зорилгоор оперативын байгууламж байгуулах Холбооны улсын хөтөлбөрийн хүрээнд цаг хугацааны боломжит хугацаанд урьдаас зохион байгуулагддаг.

- Стратегийн зориулалттай пуужинт хүчний/СЗПХ/ цэргийн дэд бүтцийн чухал бүрдэл хэсэг нь удирдлагын пунктууд (СЗПХ-ний Төв удирдлагын пункт,) байнгын байрлалын пункт, байлдааны эхлэх цэг, техникийн байрлалууд, пуужингийн дивиз, холбооны зангилаа, аэродром, хадгалалтын бааз, полигон, цэргийн-сургалтын байгууллага гэх мэт.

Зэвсэгт хүчний үйл ажиллагааг хангадаг дэд бүтцийн объектуудыг ашиглах мөн түүнчлэн өөрийн хэмжээний хүрээнд эрх мэдлээ хэрэгжүүлэх нь Батлан хамгаалах яамны үндсэн үйл ажиллагааны нэг мөн. Батлан хамгаалах яаманд ашиглагддаг дэд бүтцийн ихэнх объектууд нь хөдөлгөөнт бус буюу төхөөрөмжлөгдсөн барилга, байгууламжаас бүрддэг. Үүнд: бие бүрэлдэхүүн болон ар тал хангалтын байнгын байрлал; удирдлагын төв; суурин холбооны сүлжээний объект гэх мэт.

Манай улсын хувьд батлан хамгаалах дэд бүтцийг сайжруулах, хөгжүүлэх нь тулгамдсан асуудал мөн. Зөвлөлт холбоот улсын үед хийгдсэн цэргийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг сэргээн засварлаж, өнөөгийн батлан хамгаалах бодлогод нийцсэн дэд бүтцийг хөгжүүлэх. Сүүлийн жилүүдэд Барилгын цэргийг хөгжүүлж байгаа нь батлан хамгаалах дэд бүтцийг хөгжүүлэхэд боловсон хүчнээ бэлтгэж байгаагийн илэрхийлэл гэж үзэж байна.

[145] *http://encyclopedia.mil.ru/encyclopedia/dictionary/details_rvsn.htm?id=12803@morf-Dictionary*

Дүгнэлт

Монгол Улс сүүлийн жилүүдэд дэд бүтцийн томоохон төсөл хэрэгжүүлж байгаа. Эдгээр туршлагадаа тулгуурлан цаашид хос зориулалттай дэд бүтцийн ажлыг үе шаттай, чанартай гүйцэтгэх нь орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлэхэд чухал нөлөөтэй гэж үзэж байна. Дэд бүтцийг хөгжүүлэх нь төсөв хөрөнгө шаарддаг ажил бөгөөд ихэнх тохиолдолд зөвхөн төр үүнийг бий болгох ёстой болдог. Хос зориулалттай дэд бүтцийн ажлыг хийж гүйцэтгэхдээ батлан хамгаалах асуудал эрхэлсэн төв байгууллаас мэргэжлийн санал, зөвлөгөөг авч гүйцэтгэж байх нь чухал юм.

ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ЕВРОПИЙН ХОЛБООНЫ ОРОЛЦООНЫ ЦААШДЫН ХАНДЛАГА

Ц.Гандорж
БХЭШХ-ийн Цэргийн урлаг судлалын
төвийн дарга, доктор(Ph.D), хурандаа

Key words: *UN, European Union, Peace Support Operation, SWOT analysis*

Abstract: *Chapter VIII of the UN Charter deals with regional arrangements for maintaining peace and security. For this tasks EU and some other regional organizations contributes in Peace Support Operations under UNSC resolutions. For further commitments EU should adapt its legitimacy for contribution and cooperation with UN and other regional organizations.*

Европын Холбоо (ЕХ) 1958 онд байгуулагдсан бөгөөд нийт 28 улс гишүүнээр элссэн, хамгийн сүүлд Хорват улс 2013 онд элсжээ. 2003 оноос цэргийн болон иргэний ажиллагааг Европын Аюулгүй байдал, Батлан хамгаалах бодлого (ESDP) хэрэгжиж эхэлснээр эхлүүлсэн байдаг. Энэхүү бодлогод *нэгд,* хүмүүнлэгийн болох аврах, *хоёрт,* энхийг дэмжих, *гуравт*, зэвсэг хураах, *дөрөвт,* терроризмтой тэмцэх үед дэмжлэг үзүүлэх, *тавд,* аюулгүй байдлын салбарт өөрчлөлт хийх зэрэг үеийн ажиллагаануудад оролцоно гэж тодорхой тусгасан байна[146]. Үүний дагуу ЭДА-нд оролцож эхэлсэн бөгөөд хамгийн анхны ажиллагааг Македони улс болон Босни-Герцогоин улс дахь НАТО-ийн явуулж байсан “Concordia” болон “SFOR” ажиллагаануудыг 2004 оны сүүлээр хүлээн авч “EUFOR”-ийн “Алти” ажиллагааг эхлүүлсэн байна. “Алти” ажиллагаанд эхэндээ 7000 гаруй цэргийн бүрэлдэхүүнийг оролцуулж эхэлсэн бол 2019 оны 03 дугаар сарын байдлаар 600 цэргийн алба хаагч болтлоо буурчээ. Тэдний гол үүрэг нь Боснигийн зэвсэгт хүчнийг сургаж, бэлтгэх явдал байна.

ЭДА-нд Европын холбооны энгийн алба хаагчид түлхүү оролцож байна. Өнөөдрийн байдлаар цэргийн 6, энгийн 11 ажиллагаа явагдаж нийтдээ 4000 гаруй алба хаагч оролцож байна.

[146] *Thierry Tardy. The European Union and UN peace Opeartions:What Global-Regional Peace and Security Partnership, Cedric de Coning, Mateja Peter, United Nations Peace Operations in Changing Global Order, Springer Nature Switzerland AG, 2019. P 234 ISBN 978-3-319-99105-4;*

Өнөөгийн ЭДА-нд Европы холбооны оролцож буй байдлыг 1 дүгээр хүснэгтэд харууллаа.

1 дүгээр хүснэгт

Европийн Холбооны ЭДА-нд оролцож буй байдал
(2019 оны 12 сарын байдлаар)[147]

Ажиллагааны нэр:	**Эхэлсэн он:**	**Хүн, хүчний тоо:**	**Тайлбар**
EUFOR ALTEA (Босни-*(Герцоговин	оны 11 сараас 2004	600	*- Цэргийн ажиллагаа
(EUBAM (Молдав, Украйн	оны 10 сараас 2005	50	
(EUBAM RAFAH (Палестин	оны 11 сараас 2005	8	
(EUPOL COPPS (Палестин	оны 01 сараас 2006	72	
(EUMM (Гүрж	оны 10 сараас 2008	200	
EU NAVFOR (Атланта, *(Сомали	оны 12 сараас 2008	200	
(EULEX (Косово	оны 02 сараас 2008	503	
(EUTM (Сомал	оны 04 сараас 2010	203	
(EUCAP (Сомал	оны 07 сараас 2012	93	
(EUCAP SAHEL (Нигер	оны 08 сараас 2012	100	
(EUBAM (Ливи	оны 05 сараас 2013	17	
*(EUTM (Мали	оны 02 сараас 2013	506	
(EUAM (Украйн	оны 12 сараас 2014	300	
*(EUCAP (Мали	оны 01 сараас 2015	140	
*(EU NAVFOR (Мэд	оны 10 сараас 2015	580	
*(EUTM RCA (Төв Африк	оны 07 сараас 2016	181	
(EUAM (Ирак	оны 10 сараас 2017	51	
Нийт: 17		**3804**	

ЕХ Африк, Ази, Европийн улс орнуудад 17 цэргийн болон энгийн ажиллагаа явуулж байгаагаас 6 нь цэргийн ажиллагаа буюу тэнгисийн бүс газруудын аюулгүй байдлыг хангах болон тухайн улсын зэвсэгт хүчнийг сургаж, бэлтгэх зэрэг үүргүүдийг явуулж байна. Үүнээс гадна Молдав, Украйн гэсэн 2 улсад явагдаж буй ажиллагааг Ерөнхий Аюулгүй Байдал, батлан хамгаалах бодлого (ЕАББХБ)-с удирдлагаар хангаж чиглүүлдэггүй байна.

147 https://eeas.europa.eu/headquarters/headquarters-homepage/430/military-and-civilian-missions-and-operations_nl;

2 дугаар хүснэгт

ЕХ-ны ЭДА-ны идэвхжилийг харуулсан үзүүлэлт (Ихээс бага руу)

Хэлбэр, цар хүрээ	ЕХ
Агаарын цохилт	-
Шийдэмгий (robust) цэргийн ажиллагаа + зэвсэг хэрэглэсэн	-
Шийдэмгий, цогц тогтворжуулах ажиллагаа	Artemts, Concordia, Althea, EUFOR DR Congo
Хүмүүнлэгийн шийдэмгий дэмжлэг	EUFOR Chad/CAR EUFOR CAR/Bangul
Энгийн иргэдийг хамгаалах шийдэмгий дэмжлэг	-
Дээрэмчний эсрэг ажиллагаа	Atalanta
Хүмүүнлэгийн дэмжлэгийн ажиллагаа	-
Цогц, шийдэмгий бус ажиллагаа	-
Иргэний цагдаагийн ажиллагаа	EUPM Bosnia, EUPOL PROXIMA Macedonia, EUPT Kosovo, EUPOL Kinshasa, EUPOL COPPS Palestinian Territories, EUPOL Afghanistan
Хяналтын ажиллагаа	EUMM Yugoslavia, AMM Indonesia, EUMM Georgia
Урьдчилан сэргийлэх ажиллагаа	-
Цэргийн бие бүрэлдэхүүний сургалт	EUTM Somalia, EUTM Mali
Хууль сахиулах, хил зохицуулах ажиллагаа	EUJUST Themis Georgia, EUJUST LEX Iraq, EUSR BST Georgia, EUBAM Rafah, EUBAM Ukraine/ Moldova, EUSSR Guinea-Bissau, EULEX Kosovo, EUAVSEC S Sudan8 EUCAP Sahel Niger, EUCAP Nestor Horn of Africa, EUBAM Libya
Шилжилтийн үеийн ажиллагаа	-
Иргэний мандаттай ажиллагаа	-

Дээрх хүснэгтээс үзэхэд ЕХ агаарын цохилт, зэвсэг хэрэглэх зэрэг байлдааны ажиллагааны хэлбэрүүдээс бусад хэлбэр болох бага, дунд түвшний цар хүрээтэй ажиллагаанд оролцож байна.

НАТО-ийн адил VII бүлгийн зааltын дагуу түргэн байрлах хүчин (Europian Rapidly Deployable Military Force (Battle Group)) -ийг ЕХ 2005 оноос бий болгосон ба энэхүү хүчин 1500 ЦАХ-тай, 5-20 хоногийн дотор дэлгэн байрлах чадвартай байна. Энэхүү түргэн байрлах хүчин 120 хоног

байрлаж, тогтворжуулсны дараагаар НҮБ-ын энхийг сахиулах хүчнээр солигдох зохицуулалтыг хийсэн байна[148].

ЭДА-нд ЕХ-ны оролцож буй байдал, цаашдын хандлагад "SWOT шинжилгээ" хийж үзэхэд дараах байдалтай байна.

ЕХ-ны давуу тал:

1. Улс төрийн хувьд:
   - НҮБ-ын АЗ-ийн мандатыг биелүүлэхэд улс төр, стратегийн хувьд бүрэн боломжтой. Энэ нь цэргийн ажиллагаанаас илүүтэйгээр энгийн ажиллагаа түлхүү оролцуулж буйтай холбоотой бөгөөд гол төлөв хүмүүнлэгийн тусламж, хөгжил, санхүүгийн дэмжлэг, бүтээн байгуулалтын ажиллагаанд оролцдогоороо онцлог байна.
2. Байгууллагын хувьд:
   - ЕХ байнгын ажиллагаатай цэргийн байгууллагагүй бөгөөд ямарваа нэг ажиллагаанд аль нэг улсыг тэргүүлэх эрх олгодог. Энэ нь тухайн улсын засгийн газар удирдлагаар хангах, бусад орнууд цэрэг илгээх үүрэг хүлээдэг нь хурдан, шуурхай зохион байгуулах боломжийг олгодог байна.
3. Чадавх, ажиллагааны боломжийн хувьд:
   - Энгийн, цэргийн чадамж дээр суурилсан, бусад байгууллагаас хараат бус. Мөргөлдөөний бүх шатанд улс төр-дипломат, нийгэм, эдийн засаг, цэргийн зэрэг бүх төрлийн ажиллагааг явуулах боломжтой.

ЕХ-ны сул тал:

1. Улс төрийн хувьд:
   - Герман, Англи, Франц гэсэн гурван улс голлох байр суурь эзэлдэг тул аливаа шийдвэрт нөлөө үзүүлдэг.
   - ЕХ-ны улс орнуудын хоорондын үл итгэлцэл(scepticism) ажиллагааг явуулах шийдвэр гаргахад хүндрэлтэй. Үүнд Англи улс ЕХ-ноос гарах асуудал нэг хүчин зүйл нь болж байна.
   - Үндэсний ашиг сонирхол шийдвэр гаргах явцад нөлөө үзүүлдэг.
2. Байгууллагын хувьд:
   - Стратегийн түвшинд ЕХ-ны бүтэц ихээхэн хүндрэлтэй. Үүний илрэл нь засгийн газар хоорондын тусгаарлалтай холбоотой байна.
   - Цэргийн ажиллагааг явуулахад байнгын төлөвлөлт дутмагаас болж хурдан хугацаанд дэлгэн байрлуулахад хүндрэлтэй байна.
3. Чадавх, ажиллагааны боломжийн хувьд:
   - Өндөр түвшний цар хүрээтэй ажиллагааг явуулах боломж бага буюу тагнуул, холбоо зэрэг мэдээллийн хэрэгслүүд дутмаг байна.
   - Түргэн байрлах хүчин нь бэлэн байдалд байгаа хэдий ч одоогоор нэг ч удаа дэлгэн байрлаагүй байна.

[148] *Мөн тэнд pg 112;*

Боломж:

1. Улс төрийн хувьд:

- Африкийн улс орнуудад НҮБ-ын АЗ-ийн мандатыг хэрэгжүүлсээр байна. Франц, Англи зэрэг тэргүүлэх улс орнуудын найрсаг харилцаа нь шийдвэр гаргахад эерэг, хялбар байх болно.

2. Байгууллагын хувьд:

- Тэргүүлэгч орны концепц ажиллагааг явуулахад хялбар бөгөөд цаашдын төлөвлөлт, бэлтгэл ажил зэрэг хөгжилд давуу талтай байна.

3. Чадавх, ажиллагааны боломжийн хувьд:

- ЕХ-ны цэргийн харилцааг сайжруулах нь иргэн, цэргийн хэрэгслүүдээс гадна цаашдын дэлгэн байрлалтад сайжирна.

Эрсдэл:

1. Улс төрийн хувьд:

- НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн шийдвэргүйгээр ажиллагааг явуулах боломж байхгүй.

2. Байгууллагын хувьд:

- Санхүү, төсөв болон цэргийн хүчний нөөц хязгаарлагдмал, ихэнх улс орнууд шаардлагатай тооны цэргийн бүрэлдэхүүнийг илгээх, Афины механизмын дагуу нэгдсэн төсөв, санхүүг нэмэгдүүлэхээс царгалцгаасаар байна.

3. Чадавх, ажиллагааны боломжийн хувьд:

- ЕХ-ны цэргийн чадавхыг нэмэгдүүлэхгүй тохиолдолд ЕХ-ноос явуулах ажиллагаа хязгаарлагдмал хэвээр байна.

ЭДА-нд ЕХ оролцож буй байдал, хандлагад хийсэн энэхүү SWOT шинжилгээнээс хэдийгээр өндөр түвшний эрчимтэй ажиллагаанд оролцоход хязгаарлагдмал байгаа боловч олон талт арга замаар үйл ажиллагаа явуулж байгаа нь ихээхэн үр дүнгээ өгч байна.

ЭДА-нд ЕХ-ны оролцож буй байдал цаашдаа хууль эрх зүйн хүрээнд хязгаарлагдмал байдалтайгаар үргэлжлэх хандлагатай байна. Үүнд Европийн зарим улс орнуудын үндсэн хуулийн заалтад өөрчлөлт оруулснаар НҮБ-ын АЗ-ийн мандат дахь заалтуудыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ гэж үздэг байна.

ЕХ НҮБ-тай 2019-2021 онд энх тайван, аюулгүй байдал, хямралт үеийн менежментийн чиглэлээр хамтын ажиллагааны хэтийн төлөвийг тодорхойлоод байгаа бөгөөд НҮБ-ын энхийн ажиллагаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээ буюу А4Р-ийг бүрэн дэмжиж стратегийн түншлэлийн харилцааг бэхжүүлж хамтран ажиллах найман тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон байна[149]. Эдгээр тэргүүлэх чиглэлүүдэд:

1. Хамтын ажиллагааны хүрээнд жендерийн хэтийн төлөвийг уялдуулах, нэгтгэх зорилгоор НҮБ-Европын Холбооны Эмэгтэйчүүд,

[149] *Reinforcing the UN-EU Strategic Partnership on Peace Operations and Crisis Management: Priorities 2019-2021*
https://peacekeeping.un.org/en/reinforcing-un-eu-strategic-partnership-peace-operations-and-crisis-management-priorities-2019-2021;

Энх тайван, Аюулгүй байдлын платформыг байгуулах;

2. Үйл ажиллагааны хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд харилцан мэдээлэл солилцох, хоорондын уялдаа холбооны бат бэх байдлыг хангах;

3. Үйл ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэхэд нэгдмэл чиглэл удирдамжтай байх;

4. ЕХ-ны гишүүн орнуудын НҮБ-ын ЭДА болон НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын энхийг дэмжих ажиллагаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээ (А4Р) санаачлагыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах, дэмжлэг үзүүлэх;

5. Зэвсэгт мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх, улс төрийн үйл явц, шийдвэрлэх арга хэрэгслийг дэмжихийн тулд түүнд шаардлагатай хэрэгслүүдийг тодорхойлох, мөн улс төрийн харилцаа, стратегийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

6. Цагдаагийн байгууллага, хууль дээдлэх засаглал, аюулгүй байдлын салбар дахь шударга ёс, хамтын ажиллагааг эрчимжүүлэх, иргэний шуурхай хариу арга хэмжээ авах чиглэлээр хамтран ажиллах боломжийг үнэлэх, дүгнэх;

7. Африкийн тэргүүлсэн ЭДА-г дэмжих, хамтын ажиллагааг өргөжүүлэх, АХ-НҮБ-ЕХ гэсэн гурван талт хамтын ажиллагааг ЭДА, зэвсэгт мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэхэд болон бүс нутгийн стратегийн түвшинд гүнзгийрүүлэх;

8. Сургалт, чадавхийг дээшлүүлэх, үүнд дадлага, сургуулийг нэмэгдүүлж, сайжруулах чиглэлээр хамтын ажиллагаагаа бэхжүүлснээр ажиллагааны газар оронд үүрэг гүйцэтгэлтийг сайжруулах зэрэг ажлууд тусгагдсан байна.

Эдгээр тэргүүлэх чиглэлүүд нь улс төрийн шийдэлд хүрэх, амлалтаа тууштай хэрэгжүүлэхийн тулд ЕХ-ны гишүүн орнуудтайгаа нягт яриа хэлэлцээг явуулах, мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх, терроризм, түүнээс хамгаалах үүрэг хариуцлага гэх мэт НҮБ-Европын Холбооны бусад стратегийн түншлэлийг нөхөх зэрэг ач холбогдолтой байна.

Эшлэл авсан, ашигласан материалын жагсаалт:

1. *Thierry Tardy. The European Union and UN peace Opeartions:What Global-Regional Peace and Security Partnership, Cedric de Coning, Mateja Peter, United Nations Peace Operations in Changing Global Order, Springer Nature Switzerland AG, 2019. p234,ISBN 978-3-319-99105-4;*
2. https://eeas.europa.eu/headquarters/headquarters-homepage/430/military-and-civilian-missions-and-operations_nl;
3. *Reinforcing the UN-EU Strategic Partnership on Peace Operations and Crisis Management: Priorities 2019-2021, https://peacekeeping.un.org/en/reinforcing-un-eu-strategic-partnership-peace-operations-and-crisis-management-priorities-2019-2021;*

НҮБ-ЫН ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГАА, ТУЛГАМДАЖ БАЙГАА АСУУДАЛ

Т.Мөнх-Оргил
БХЭШХ-ийн Цэргийн урлаг судлалын төвийн ЭША,
доктор (Ph.D.), дэд хурандаа

Key words:*United Nations, Peacekeeping operations, Security Council, General Assembly, protection of civilian, security, conflict, challenges.*

Abstract: *United Nations is one of the key international organization to keep and develop a global peace and security. It is defined that accomplishments and success of this system is invaluable. However this system has facing various challenges and problems. In order to promote and develop international peace and security it is crucial for identifying problems, challenges and finding solutions to ways forward. This article describes current Unites Nations facing challenges in level of strategy, operation and tactic.*

Нэг. НҮБ-ын ЭДА, ололт амжилт

Дэлхийн I дайны дараа 1919 онд Версалийн гэрээгээр "Үндэстнүүдийн холбоо"-г байгуулсан хэдий ч гишүүн улсууд хамтын аюулгүй байдлыг хангахад нэгдмэл байр суурьтай байж чадаагүйн улмаас Дэлхийн II дайнаас урьдчилан сэргийлж чадаагүйгээр барахгүй дайны эсрэг хамтдаа баттай нэгдэж тэмцээгүй юм. Иймээс Дэлхийн II дайны үед АНУ-ын ерөнхийлөгч Франклин Рузвельт[150] анх НҮБ байгуулах санаачлагыг гаргаснаар 26 улсын төлөөлөгчид нэгдэж, дайны дараа 50 улсын төлөөлөл НҮБ-ын дүрмийг баталснаар 1945 оны 10 дугаар сарын 24-ний өдрийг албан ёсоор НҮБ-ын өдөр болгож зарласан юм[151]. НҮБ-ын гол зорилго нь дэлхийн улс орнуудын энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах, түүнийг зөрчигчдийн эсрэг хамтын арга хэмжээ авах, үндэстэн хооронд нөхөрсөг харьцааг бий болгох, олон улсын хамтын ажиллагаа, үүний дотор эдийн засаг, нийгэм, соёл, хүмүүнлэг, хүний эрхийг хүндэтгэх асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, эдгээр зорилгыг биелүүлэхэд гишүүн улс орнуудыг холбогч гол цөм нь болж өгөхөд оршдог. БНӨСУ 2011 оны 7 дугаар сарын 14-нд НҮБ-д элссэнээр, нийт 193 гишүүн оронтой болжээ. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл (АЗ), Ерөнхий Ассемблей (ЕА), Нарийн бичгийн дарга нарын газар (НБДНГ), Эдийн засаг нийгмийн

[150] http://www.un.org/en/sections/history/history-united-nations/index.html
[151] http://www.un.org/en/sections/history/history-united-nations/index.html

зөвлөл (ЭЗНЗ), Олон улсын шүүх (ОУШ) гэсэн гол байгууллагууд ЭДА-ны талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээнд шийдвэр гаргахад голлох үүрэгтэй байдаг.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга (ЕНБД) нь ЭСА-г зохион байгуулан явуулах талаар өөрийн санал, зөвлөмжийг боловсруулан гаргадгаас гадна үйл ажиллагааны явцын талаарх мэдээ, мэдээлэлээр АЗ-ийг хангах үүрэг хүлээдэг. АЗ нь олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах талаар гол хариуцлагыг хүлээж, урьдчилан сэргийлэх, албадлагын арга хэмжээг НҮБ-ын нэрийн өмнөөс авч явуулах онцгой үүргийг гүйцэтгэдэг. АЗ нь байнгын болон байнгын бус гишүүн орнуудын төлөөлөлөөс бүрдэнэ. АЗ-ийн Байнгын гишүүн оронд БНХАУ, Франц, ОХУ, ИБУИНВУ болон АНУ байна. АЗ-ийн байнгын бус гишүүдийг ЕА сонгохдоо олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахиулах хийгээд НҮБ-ын бусад зорилтыг хэрэгжүүлэх үйлст оруулж байгаа хувь нэмэр болон мөн газар зүйн шударга, тэгш хуваарилалтын зарчмыг үндэслэн хоёр жилийн хугацаагаар сонгодог. АЗ-ийн Байнгын гишүүн орнууд вето (шийдвэр, тогтоолд хориг тавин унагах) тавих эрхтэй юм. ЕА нь НҮБ-ын бүх гишүүн улс орнуудын төлөөлөлөөс бүрдэх бөгөөд олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалахтай холбогдсон асуудлыг хэлэлцэх, шийдвэрлүүлэхэд оролцдог бөгөөд ЕА-н шийдвэр нь гишүүн улсууд болон АЗ-д хүргүүлэх санал байна. ЕА-аар хэлэлцэх асуудлыг эрэмбээр нь чухал буюу энгийн гэж ангилах бөгөөд чухал асуудлуудыг гуравны хоёр, энгийн асуудлуудыг олонхийн саналаар шийдвэрлэдэг.

НҮБ-ын Дүрмийн 39 дүгээр зүйлд зааснаар АЗ нь энх тайванд заналхийлсэн юмуу түүнийг зөрчсөн, мөн түрэмгийлэл үйлдэгдсэн эсэхийг тогтоож шаардлагатай бол ЭДА-г явуулдаг. НҮБ-ын энхийн ажиллагаа гэсэн ойлголт нь тус байгууллагын мандаттай болон зөвшөөрөлтэйгээр хэрэгжүүлж буй урьдчилан сэргийлэх дипломат ажиллагаа, энхийг тогтоох ажиллагаа, энхийн бүтээн босголт, энхийг сахиулах ажиллагаа, энхийг хүчээр сахиулах ажиллагаанууд ыг бүхэлд нь хамруулж байна. Эдгээрийн дотроос урьдчилан сэргийлэх дипломат ажиллагаа, энхийг тогтоох ажиллагаа, энхийн бүтээн босголтын үйл явц нь улс төр-дипломатын идэвхтэй ажиллагаа байдаг бол энхийг сахиулах ажиллагаа, энхийг хүчээр сахиулах ажиллагаанууд нь улс төр, цэргийн хүчний оролцоо бүхий цогц шинжийг агуулсан ажиллагаа юм[152].

НҮБ-ын Дүрмийн VI, VII, VIII бүлгийн дагуу ЭДА-г явуулж байна. Тухайлбал VI бүлэгт маргааныг тайван замаар шийдвэрлэхийн тулд улс төр, дипломат, гэрээ хэлэлцээр, зуучлал, эвлэрүүлэх, шүүх зэрэг арга хэрэгслүүдийг ашигладаг. VII бүлэгт энх тайванд аюул заналхийлсэн, учруулсан, тусгаар улсын бүрэн бүтэн байдалд түрэмгийлсэн үйлдэл зэрэгт талуудад тохирсон арга хэмжээг буюу улс төр, эдийн засгийн хориг арга хэмжээ авах, эсхүл хүч хэрэглэх гэж заасан байдаг. VIII бүлэгт тухайн бүс нутагт улс орнуудын хооронд үүссэн маргааныг тайван замаар шийдвэрлэх асуудлыг бүсийн зохицуулалтаар энх тайван, аюулгүй байдлыг сахиулах, энэ нь НҮБ-ын зорилго, зарчимд

[152] *"Монгол Улс энхийг дэмжих цйлсэд: Туршлага, сургамж". УБ., 2012. т.16.*

нийцсэн байх ёстой гэж заасан. АЗ-ийн тогтоолоор НҮБ-ын дүрмийн VI бүлгийн дагуу явагдаж буй ЭДА нь зарим тохиолдолд VII бүлгийн заалтын агуулгыг хэрэгжүүлж болдог. Өөрөөр хэлбэл НҮБ-ын болон хүмүүнлэгийн үйл ажиллагаанд оролцож буй албан хаагчид нь өөрийгөө болон бусдыг хамгаалахын тулд зэвсэг хэрэглэх эрхтэй ба ажиллагаа болгон тодорхой эрх үүрэг, хариуцлагыг тусгасан мандаттай байдаг.

АЗ нь НҮБ-ын байгууллагууд дундаас гаргасан шийдвэрээ хэрэгжүүлэх эрхтэй цорын ганц байгууллага юм. АЗ-ийн тогтоол нь ЭДА-г зохион байгуулж явуулахыг АЗ-ийн байнгын 5 гишүүн болон түүнээс дээш тооны гишүүд хүлээн зөвшөөрсөн үед хүчин төгөлдөр болж мөрдөгддөг эрх зүйн үндсэн баримт бичиг юм. АЗ-ийн тогтоол хүчин төгөлдөр болж хэрэгжихэд НҮБ-ын Дүрмийн заалтуудаас гадна сөргөлдөгч талуудын санал, хүсэлт чухал үүрэг гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл олон улсын энх тайван аюулгүй байдалд заналхийлсэн аливаа асуудлыг зохицуулахын тулд НҮБ-ын АЗ нь НҮБ-ын Дүрмийн VI бүлгийн 34 дүгээр зүйлийн дагуу магадлан шалгах, 39 дүгээр зүйлийн дагуу аливаа зөрчил буюу түрэмгийллийн үйлдлийг тодорхойлох эрхтэй бөгөөд сөргөлдөгч талууд НҮБ-ыг хөндлөнгийн гуравдагч этгээд болж маргааныг эв зүйгээр шийдвэрлэж өгөх талаар түүнд хүсэлт гаргах нь энхийн ажиллагааг эхлүүлэх үндэс болж өгдөг.

НҮБ өөрийн бүтцэд харьяалалын байнгын цэрэг, цагдаагийн хүчингүй бөгөөд гишүүн орнуудын оролцоотойгоор ЭДА-нд үүрэг гүйцэтгүүлэх нэгжийг бүрдүүлэн тактикийн түвшинд ажиллагаа явуулдаг. ЭДА-г шинээр дэлгэн явуулахын тулд НҮБ-ын АЗ-ийн гишүүн улс орнуудын төлөөлөл саналыг авч, мандатын эрхийг олгодог. Ажиллагааны мандат нь нэг төрлийн удирдлагын баримт бичиг бөгөөд зорилго нь стратегийн өргөн хүрээнд, улс төр, дипломатын өндөр түвшинд удирдамж өгөхөд чиглэгдэхээс гадна ЭДА-г зохион байгуулах, төлөвлөх, удирдах үндсийг бүрдүүлнэ. Энхийн ажиллагаа дараах 3 төрлийн мандатын дагуу явагдаж байна. Үүнд;

-АЗ-ийн 1325 (2000) тогтоолоор эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдал;

-АЗ-ийн 1612 (2005) тогтоолоор хүүхэд, зэвсэгт мөргөлдөөнийг;

-АЗ-ийн 1674 (2006) тогтоолоор зэвсэгт мөргөлдөөнд энгийн иргэдийг хамгаалах зэрэг болно.

ЭДА-д оролцож буй цэрэг, цагдаагийн хүчин мандатаар заагдсан үүргүүдийг биелүүлэхийн зэрэгцээ мандатад үндэслэн боловсруулагдсан хүч хэрэглэх дүрмийг дагаж мөрддөг. ЭДА-ны явцад энгийн иргэдийн амь насыг хамгаалах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, НҮБ-ын бие бүрэлдэхүүн, объектуудыг хамгаалах, аюулгүй байдлыг хангах асуудлыг шийдвэрлэхэд цэргийн хүч ашиглах тохиолдол байдаг. НҮБ-ын АЗ-ийн тогтоолоор олгогдсон мандатыг хэрэгжүүлэхийн тулд тухайн ЭДА-ны удирдлага эсхүл үндэсний цэргийн багийн захирагч даргад энхийн ажиллагааны үед зэвсэг хэрэглэх нөхцөл, хязгаарлалт тогтоосон эрхзүйн

баримт бичгийг хүч хэрэглэх дүрэм (ХХД) гэнэ.

ЭДА-ны хамгийн чухал эрх зүйн бичиг баримтын нэг нь Цэргийн хүчний статусын гэрээ (ЦХСГ) бөгөөд зорилго нь ЭДА-г зохион байгуулагч байгууллага, энхийн ажиллагааны бие бүрэлдэхүүнээс цэрэг хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт энхийн ажиллагаа явуулах үеийн хууль эрхзүйн хэм хэмжээг тогтоох, түүнийг сахиулах, түүнчлэн цэрэг хүлээн авагч улсын Засгийн газар, ард иргэд болон энхийн ажиллагааны бие бүрэлдэхүүний хоорондын харилцааг зохицуулахад чиглэгддэг. НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны газар (ЭСАГ) нь өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангах, цэрэг илгээгч болон төсөв бүрдүүлэгч улс орнуудтай харилцаа, холбоо тогтоох, АЗ-өөс гарсан шийдвэрийг сөргөлдөгч талууд биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг үүрэг хүлээдэг. НҮБ-ын ЭСАГ нь ажиллагааны алба, хууль, эрх зүй, аюулгүй байдлын,цэргийн асуудал хариуцсан алба, бодлого, дүн шинжилгээ сургалтын хэлтэс гэсэн дөрвөн нэгжээс бүрдэж байна.

ЭДА-г ЕНБД-ын тусгай төлөөлөгч эсвэл бүс нутгийн байгууллагаас тохоон томилогдсон төлөөлөгч удирдан явуулдаг ба ажиллагаа нь ихэвчлэн цэргийн хүчин, цагдаагийн албан хаагчид, иргэний цагдаа болон энгийн албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр ажиллагааны газар оронд олгогдсон мандатын дагуу буюу аюулгүй байдлыг хангах, улс төрийн болон иргэн-цэргийн харилцааг хөгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хангах, хүмүүнлэгийн ажиллагааг дэмжихэд чиглэгддэг. ЭДА-ны үед хүмүүнлэгийн тусламж дэмжлэгийг гол төлөв хүмүүнлэгийн байгууллагууд гардан гүйцэтгэх ба цэргийн хүчин нь тэдгээрийн аюулгүй байдлыг хангах, шаардлагатай мэдээллийг харилцан солилцох чиглэлээр хамтран ажилладаг.

НҮБ-ын ЭДА анх удаа Араб, Израйлын хоорондын гал зогсоох гэрээний хэрэгжилтийг хянах зорилгоор 1948 онд НҮБ-ын Итгэлцлийг хянах байгууллагын /UNTSO/ ажиллагаа, 1949 онд Энэтхэг, Пакистаны хилийн маргаантай хоёр талын гал зогсоох гэрээний хэрэгжилтийг хянах зорилгоор НҮБ-ын Цэргийн ажиглагчийн ажиллагаа/UNMOGIP/-г явуулж эхэлсэнээр үндэс суурь нь тавигдсан. 1948-2019 оныг хүртэл таван тивд нийт нэг сая гаруй энхийг сахиулагчидыг хамруулсан 72 ажиллагаа явагдсанаас 13 ажиллагаа Хүйтэн дайны үед явагдсан байна.

Өнөөгийн байдлаар ЭДА-нд 4 тивд 14 ЭДА-нд 124 орны нийт 82863 цэрэг, цагдаагийн албан хаагч, 13000 орчим энгийн мэргэжилтэн, 1300 сайн дурын ажилтан үүрэг гүйцэтгэж байгааг задлавал Цагдаа 8854, цэргийн шинжээчид 1218, цэрэг 70738, штабын офицер 2053 байна. Үүнд цэрэг илгээгчээрээ тэргүүлэгч орнуудыг авч үзвэл: Этиоп 6639, Бангладеш 6413, Руанда 6292, Балба 5658, Энэтхэг 5404, Пакистан 4341, Египт 3113, Гана 2544, Индонез 2705,Хятад 2544, Танзани 2305, Сенегал 2249 албан хаагчийг тус тус илгээсэнээрээ жагсаалтыг тэргүүлж байгаа бол Монгол Улс 24-т (892), жагсаж байна. [153]

[153] https://peacekeeping.un.org/en/troop-and-police-contributors

ЭДА-ны үйл ажиллагааны онцлогыг товчлон үзэхэд энхийн ажиллагаа эхэн үедээ зэвсэгт мөргөлдөөнд хяналт тавих, бүс нутгийн мөргөлдөөнийг тусгаарлах зорилготой байсан бол 1980-аад оноос иргэний дайн болон дотоодын зэвсэгт мөргөлдөөнийг зохицуулах, 1990-ээд оноос НҮБ-ын дүрэм болон Зэвсэгт мөргөлдөөний тухай хуулийн дагуу мөргөлдөгч талууд энхийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж байгаа эсэхэд хяналт тавих, 2000 оноос хойш энхийг бүтээн босгох, хүмүүнлэгийн ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зэргээр үйл ажиллагааны цар хүрээгээ тэлж мөн шинж чанарын хувьд хувьсан өөрчлөгдсөөр байна.

Энэ нь олон улсын болон бүс нутгийн түвшинд гарч байгаа улс болон улс бус тоглогч нарын энх тайван аюулгүй байдалд заналхийлж байгаа аюул, түүний шинж чанартай шууд холбоотой юм. ЭДА нь НҮБ-ын болон бусад олон улсын болон тухайн улс орны албан ёсны хууль дүрэм, журам, ёс заншил, аж байдал гээд маш олон хязгаарлалтаас гадна сөргөлдөгч талуудын үл ойлголцолын талбар болсон аюултай эрсдэлтэй орчинд зөвхөн тодорхой үйл ажиллагаануудыг хүлээн зөвшөөрсөн хууль эрх зүй, ёс зүй, мандатын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг. Мөн түүнчлэн олон үндэстэн, байгууллага, бүлэг, бүрэлдэхүүн хэсгээс бүрдсэн нэг зорилго чиглэлтэй хамтын хүчийг бий болгож үүрэг гүйцэтгэх нь НҮБ-ын хувьд ихээхэн хүчин чармайлт шаарддаг. Өнгөрсөн хугацаанд явагдсан ЭДА-нд нийт 3911[154] энхийг сахиулагч амиа алдсан хэдий ч олон мянган энгийн иргэдийг хамгаалж, улс үндэснийг тусгаар тогтнох, энх тайван аюулгүй байдлыг хангахад үзүүлсэн амжилт арвин байна. Тухайлбал өнгөрсөн хугацаанд Ливан, Имен, Кипр, Бүгд Найрамдах Доминикан Улс, Ардчилсан Бүгд Найрамдах Конго Улс, Непал, Сиерра Леон, Зүүн Төмөр, Зааны Ясан Эрэг, Либер, зэрэг улсуудад гарсан сөргөлдөөн, зэвсэгт мөргөлдөөнийг энхийн замаар амжилттайгаар шийдвэрлэсэн байдаг.

НҮБ-ын ЭДА-тай холбоотой асуудлуудад эхэн үедээ түүнийг үндэслэсэн их гүрнүүд буюу голлон нөлөөлөх байр суурьтай үндсэн тоглогч байсан бөгөөд Хүйтэн дайны үед АЗ-ын байнгын гишүүн орнуудын сөргөлдөөнөөс болж зарим энхийн үйл ажиллагаанд удаашрал гарч байсан. Харин 1990 оноос хойш хамтын ажиллагааны байгууллагын хувьд удирдлага, зохион байгуулалтын хувьд боловсронгуй болж олон улсын төлөөлөл болох АЗ болон ЕА шийдвэрлэх байр суурьтай болж ЭДА-ны цар хүрээг өргөтгөж олон талт үүрэг гүйцэтгэх чиглэлийг тодорхойлсон. Хүйтэн дайнаас хойш гарсан зэвсэгт мөргөлдөөнийг ЭДА явуулсанаар 40 хувь хүртэл бууруулсан бөгөөд нилээдгүй тохиолдолд зөрчилдөөнийг яриа хэлэлцээр, улс төр, дипломтын аргыг хэрэглэн шийдвэрлэсэн байдаг. Зарим судлаачид НҮБ-ын ЭДА нь тухайн газар оронд мөргөлдөөн дахин давтагдан гарах нөхцөлийг 75-85 хувиар бууруулдаг гэж үзсэн байдаг.[155] Энэ бол ЭДА-ны амжилт гэдэгтэй хэн ч маргахгүй юм.

[154] https://peacekeeping.un.org/en/data

[155] *Joachim A. Koops, Norre Macqueen, Thierry Tardy, Paul D. Williams. The Oxford Handbook of United Nations Peacekeeping Operations, Oxford University Press.2015-7, ISBN978-0-19-968604-9;*

Нөгөө талаар хүйтэн дайны дараа явуулсан ЭДА-ны нийт мөнгөн зардлын хэмжээ илт өссөн хэдий ч барууныхны цэргийн ажиллагааг явуулснаас хамаагүй хямд байдаг[156] гэж үзсэн. 2013-2014 онд ЭДА-ны төсөв 7,54 тэрбум доллар байсан нь дэлхийн хэмжээнд цэргийн зардал болох 1,756 тэрбум долларын зардлын 0,5 хувиас бага байсан байна.[157] Мөн АНУ-ын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын судалгаагаар АНУ-ын 1 цэргийг 1 жил ажиллагаанд үүрэг гүйцэтгүүлэхэд 2 сая доллар зарцуулах бол 1 энхийг сахиулагчийн 1жил ажиллагаанд үүрэг гүйцэтгэхэд 24000 доллар зарцуулагддаг нь ЭДА нь АНУ-ын цэргийн ажиллагаанаас 8 дахин бага зардалтай гэж илтгэсэн байна.[158] Түүнээс гадна мөргөлдөөнийг энх тайваны аргаар энгийн ард иргэдэд хохирол хамгийн бага байхаар шийдвэрлэж байгаа нь ЭДА-ны давуу тал юм.

Мөн түүнчлэн зарим улс орнуудын хувьд энхийн ажиллагаанд оролцох нь НҮБ-ын бүрэн эрхт гишүүн улсын хувьд НҮБ-ын дүрмэнд заасан гишүүн орныхоо үүргийг биелүүлж олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалахад дэмжлэг үзүүлэх буй төдийгүй өөрийн үндэсний аюулгүй байдлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөлийг бүрдүүлэх улс төр-дипломатын арга хэрэгсэл гэж үзэж байна.

Хоёр.Орчин үед ЭДА-нд тулгамдаж байгаа асуудал.

ЭДА-ны амжилт, давуу талуудыг дурдахаас гадна цаашдын хөгжлийн хандлагыг тодорхойлоход түүнд тулгамдаж байгаа асуудлыг судлан шинжлэх нь цэрэг, цагдаагийн хүчийг хандивлагч улс орнуудын хувьд чухал юм. Иймд тулгамдаж байгаа асуудлыг стратегийн, оперативийн болон тактикийн түшингээр тодорхойлон дараах байдлаар гаргаж байна.

Стратегийн түвшинд асуудлыг тодорхойлохдоо удирдлагын тогтолцоо, эрх зүй, дэлхийн дэг журам болон санхүүжилт гэсэн чиглэлээр тусгалаа.

Удирдлагын тогтолцоо. ЭДА-нд явуулсан ажлын хэсгийн тайланд НҮБ-ын удирдлагын манлайлалгүй, сул дорой чадваргүй байдал[159] мөн ЭДА-ны зарим уламжлалт арга барил хоцрогдсон, үр дүнгүй, ач холбогдолгүй болж байгаа нь НҮБ-ын ЭДА-ны бүтцийг шинэчлэх, боловсронгуй болгох шаардлага байгааг харуулж байна. Тухайлбал НҮБ-ын Энхийг дэмжих ажиллагааны хэлтэс, Улс төрийн алба эрхэлсэн газар, Энхийг дэмжих зөвлөл зэрэг бүтцүүдийн хоорондын үл ойлголцол, хоорондоо тэрсэлддэг байдал стратегийн, оперативын түвшний үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.[160] Энэ нь цаашлаад тактикийн

[156] *Joachim A. Koops, Norre Macqueen, Thierry Tardy, Paul D. Williams. The Oxford Handbook of United Nations Peacekeeping Operations, Oxford University Press.2015-7, ISBN978-0-19-968604-9;*

[157] *Joachim A. Koops, Norre Macqueen, Thierry Tardy, Paul D. Williams. The Oxford Handbook of United Nations Peacekeeping Operations, Oxford University Press.2015-7, ISBN978-0-19-968604-9;*

[158] *The Devastating Impacts of Cuts to United Nations Funding,* https://globalhealth.org/wp-content/uploads/Devastating-Impacts

[159] *Report of the Advisory Group of Experts for the 2015 Review of the United Nations Peace building Architecture 29June 2015.*

[160] *Joachim A. Koops, Norre Macqueen, Thierry Tardy, Paul D. Williams. The Oxford Handbook of United Nations Peacekeeping Operations, Oxford University Press.2015-7, ISBN978-0-*

түвшинд мандатаар хүлээсэн үүргийг ажиллагааны газар оронд гүйцэтгэхэд энхийг сахиулагчдад бэрхшээл учруулахаар байна.

Эрх зүй. ЭДА-ны Цэргийн хүчний статусын гэрээ, мандат, хүч хэрэглэх дүрмийн талаарх цэрэг, цагдаагийн хүч илгээгч орнуудын нэгдсэн бус ойлголт, АЗ-ийн түвшинд шийдвэр гарган мандат боловсруулж байгаа болон газар орон дээр мандатыг хэрэгжүүлж байгаа бүтцүүдийн хоорондын уялдаа холбоогүй зөрчилдөөнтэй байдал зэрэг нь ЭДА-ны үр дүнгийн талаарх асуудлыг хурцаар өрнүүлж байна. Эзэн орны зарим институц/эрх мэдэлтэн ЦХСГ-гээр хүлээсэн үүргээ хангалттай биелүүлэхгүй байгаагаас болоод ажиллагааны газар оронд үүрэг гүйцэтгэж байгаа бие бүрэлдэхүүний хөдөлгөөн хязгаарлагдах, НҮБ-ын ар тал хангалтын үйл ажиллагаа тасалдах зэрэг таагүй байдлууд гарсаар байна. 1990 онд Рувандад болон гашуун туршлага сургамжаас болж НҮБ-ын ажиллагаанд энгийн иргэдийг хамгаалах асуудлыг чухалчилж үзэн 2010 оноос НҮБ "Энгийн иргэдийн хамгаалах ажиллагааны үзэл баримтлал"-ыг батлан хэрэгжүүлж эхэлсэн. Үүнтэй холбоотойгоор НҮБ-аас ЭДА явгдаж байгаа эзэн улсын засгийн газрын үйл ажиллагаа олон улсын хүний эрхийн тухай хуулийн хэрэгжүүлж байгаа байдал, аюулгүй байдлыг хангах салбарууд олон улсын хууль эрх зүйн баримт бичгүүдийг мөрдөж байгаа талаар тандалт, судалгаа хийсэн байна. Судалгаагаар мандат нь нэг талаар эзэн улсын засгийн газар буюу төрийн хууль ёсны эрх барьж байгаа этгээдийн өөрсдийн ард түмэн, энгийн иргэдийг хамгаалах, болон тэдний төлөө хүлээсэн үүрэг хариуцлагаас зайлсхийж НҮБ-д энэ бүгдийг даатгах нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал БНӨСУ-ын сөргөлдөгч талууд болох ерөнхийлөгч Салва Кийр, дэд ерөнхийлөгч асан Рейк Машар болон тэднийг дэмжигчид энгийн ард иргэдийн амь насыг хохироох, тамлан зовоох, дээрэмдэж байгаа нь энгийн иргэдийг "Энгийн иргэдийг хамгаалах бааз" руу дүрвэх эсвэл Этиоп Уганда болон Судан руу дүрвэх шалтгаан болж байна. Гэсэн хэдий ч үүнд БНӨСУ-ын засгийн газар хариуцлага хүлээхгүйгээр барахгүй БНӨСУ-ын засгийн газрын аюулгүй байдлыг хангах хүчин өөрөө энгийн ард иргэдийг хохироодог буруутан болж байна[161] гэж дүгнэсэн байна.

Дэлхийн дэг журам. Дэлхийн зарим хүчирхэг улс орнуудын геополитикийн болон стратегийн сонирхол, олон улсын түвшин дэх байр суурийн төлөөх өрсөлдөөн зэрэг нь НҮБ-ын стратегийн түвшинд шийдвэр гаргах явцад нөлөөлж ашиг сонирхолын зөрчилдөөнийг бий болгож байна. 1948-1988 онд НҮБ нийтдээ 13 ЭДА-г явуулсан бөгөөд тухайн ажиллагаануудад цэрэг хандивлагч ихэнх улс орнууд нь тухайн бүс нутагт ямарч стратегийн ашиг сонирхолгүй болох Канад, Энэтхэг, Гана, Скандиновын орнууд болон Ирланд байсан байна. Харин хүйтэн дайны дараа 1988 оноос хойш 57 ЭДА явуулаад байгаа ч барууны орнууд цэргийн тоогоо эрс багасгаж НАТО-гийн цэргийн ажиллагаанд хүчээ түлхүү оруулж эхэлсэн. Үүнтэй холбоотойгоор сүүлийн үед БНХАУ болон зарим

19-968604-9;

[161] *Hilde Frafjord Johnson. Protection of Civilian in the United Nations: A Peacekeeping Illusion, United Nations Peace Operations in Changing Global Order, ISBN978-3-319-99105-4.*

хүчирхэгжиж байгаа улс гүрнүүд шийдвэр гаргах үйл явцад нөлөөлөх, зэргээр НҮБ-ын ЭДА-нд өөрийн байр суурийг бэхжүүлж байна.[162] Энэ нь цаашлаад дэлхийн улс төрийн дэг журам, аюулгүй байдлын төлөөх засаглалд тодорхой өөрчлөлтийг авчирахаар байна. Мөн түүнчлэн ЭДА-нд Өмнөд болон Хойд туйлын хүчнүүдийн тэнцвэртэй байдлыг хангах, энхийн ажиллагаанд бүс нутгийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлж байна. Үүнээс үзэхэд олон улсын энх тайваны төлөөх үйл хэрэгт зарим их гүрнүүдийн байр суурь, ашиг сонирхол давамгайлах эсхүл бүс нутгийн байгууллага гэсэн нэрийн дор өөр өөрийн ашиг сонирхлыг гүйцэлдүүлэх хандлагатай үйл ажиллагаа явуулж болохыг үгүйсгэхгүй юм.

Санхүүжилт. Дэлхийн энх тайван аюулгүй байдлын төлөөх ЭДА-ны үүрэг оролцоо нэмэгдэхийн хирээр түүнийг үйл ажиллаганд шууд нөлөөлөх санхүүжилтын асуудал анхаарал татаж байдаг. НҮБ-ын НБД Антони Гүтэррс ЭДА-нууд хангалттай санхүүжилт хийгдэхгүй байгаа нь ажиллагааны газар оронд энхийн сахиулагчдын үүрэг гүйцэтгэлтэд сөргөөр нөлөөлж байгаа төдийгүй цаашид ч нөхөн төлбөрийг гүйцэт төлж чадахгүй байдалд хүрээд байгаа талаар мэдээлэл хийсэн.[163] Энэ асуудлыг шийдвэрлэхийг тулд тэрээр хэд хэдэн шинэчлэлийг эхлүүлээд байна. Тухайлбал 2019 оны 7 дугаар сард төсвийн удирдлага, санхүүжилтийн талаарх ЕА-гаар 73/307 дугаар тушаалыг батлуулсан.[164] Энэ тушаалд ЭДА-ны төсвийг батлахдаа санхүүгийн 3 үечилэл буюу төсвийг урьдчилан төлөвлөх, санхүүгийн гүйцэтгэлд хяналт явуулах, нэгдсэн удирдлагаар хангах зэрэг асуудлыг тусгаж өгсөн. Өнөөгийн байдлаар энхийг дэмжих нийт 14 ажиллагаанд 120 орноос 131000 гаруй цэрэг, цагдаагийн 24000 энгийн ажилчид 270 ажиллагааны цэгт, 30 гаруй улс оронд үүрэг гүйцэтгэж байна. Төсвийн хамгийн их зарцуулалттай ажиллагаануудад БНӨСУ-д явагдаж байгаа ЭДА 1.18 тэрбум доллар, Малид явагдаж байгаа ЭДА 1.13 тэрбум доллар, БНАҚУ-д явагдаж байгаа ЭДА 1.01 тэрбум долларын жилийн төсөвтэй байна.[165] ЭДА-г мандатын дагуу явуулахад жил бүр 7 тэрбум долларыг төсөвлөн санхүүжүүлдэг. НҮБ-ын ЕА 3 жил тутамд гишүүн улс орнуудын эдийн засаг төсвийн байдалд үнэлгээ хийж хандивын хэмжээг шинэчлэн баталдаг байна.

---

[162] *Cedric de Coning UN Peace Operations and Changes in the Global Order: Evolution, Adaptation and Resilience, United Nations Peace Operations in Changing Global Order, ISBN978-3-319-99105-4.*

[163] *Joachim A. Koops, Norre Macqueen, Thierry Tardy, Paul D. Williams. The Oxford Handbook of United Nations Peacekeeping Operations, Oxford University Press.2015-7, ISBN978-0-19-968604-9;*

[164] *Joachim A. Koops, Norre Macqueen, Thierry Tardy, Paul D. Williams. The Oxford Handbook of United Nations Peacekeeping Operations, Oxford University Press.2015-7, ISBN978-0-19-968604-9;*

[165] *Congressional Research Service, United Nations Issues: U.S Funding of U.N. Peacekeeping, August 14, 2019. https://fas.org/sgp/crs/row/IF10597.pdf*

1 дүгээр хүснэгт.

НҮБ-ын ЭДА-г санхүүжүүлдэг эхний 10 улс

№	Улс	Хувь
1	АНУ	27,89
2	БНХАУ	15,22
3	Япон	8,56
4	Герман	6,09
5	Их Британ	5,79
6	Франц	5,61
7	Итали	3,31
8	ОХУ	3,05
9	Канад	2,73
10	Өмнөд Солонгос	2,27
Бусад гишүүн орнууд нийлээд 19,4%		

Жич: Хүснэгтийн эх сурвалж U.N.document, A/73/350/Add.I.December 24.2018.

Хүснэгтээс харахад төсвийн ихэнх хувийг АЗ-ийн байнгийн гишүүн орнууд хандивлаж байна. 1990-ээд оны эхээр АНУ 30 хүртлэх хувийг бүрдүүлж байсан төдийгүй зарим тохиолдолд НҮБ-ын санхүүжилтийн хомсдолыг ч АНУ санхүүжилдэг байсан байна. Харин 2016 онд АНУ-ын ерөнхийлөгч Доналд Трамп засаглалын эрхийг аваад НҮБ-д өгөх татвар, хандиваа багасгана гэж мэдэгдэн НҮБ-ыг зарим хөтөлбөрүүдийг зогсоох, НҮБ-ын ЭДА-нд дахин үнэлгээ хийх улс төрийн дарамтыг тавьсан.[166] Мөн АНУ-ын НҮБ-д өгөх хандив, тусламж бусад гишүүн улс орнуудтай харьцуулахад шударга биш байгааг онцлоод 25 хувиас хэтрүүлэхгүй байх бодлого барих болсон.[167] Түүнээс болж НҮБ зарим хөтөлбөрүүдээ зогсоосоныг 2019 оны 3 дугаар сарын 26-нд ЕА-д ЕНБД-ын тавьсан илтгэлд ЭДА-нууд 2 тэрбум долларын өрөөс 1,25 тэрбум доллар нь Трампын гаргасан санхүүжилтийг 3 хувиар бууруулсан шийдвэрээс болсон гэж илтгэсэн.[168] ЭДА-ны санхүүжилтийг улс орнуудын хандив татааснаас шууд бүрдүүлдэг бөгөөд энэ хөрөнгөнөөс төвлөрүүлсэн эрсдлийн сан гэж байдаггүй нь цаашид НҮБ-ыг энэ талаар бодлогын түвшинд стратеги боловсруулах шаардлага байгааг харуулж байна.

АНУ-аас гадна бусад гишүүн орнууд хандив болон татаас цаг хугацаанд нь өгч чадахгүй байгаагаас болоод НҮБ 2018 онд цэрэг болон цагдаа хандивлагч улс орнуудад 255 сая америк долларын нөхөн төлбөр

[166] *Cedric de Coning, Mateja Peter, United Nations Peace Operations in Changing Global Order, Springer Nature Switzerland AG, 2019. 45, ISBN 978-3-319-99105-4*

[167] *Trump's Strong-Arm Cuts Put UN Peacekeepers Out in the Cold April 29, 2019 by La Rainne Pasion, https://www.passblue.com/2019/04/29/trumps-strong-arm-cuts-put-un-peacekeepers-out-in-the-cold/*

[168] *Trump's Strong-Arm Cuts Put UN Peacekeepers Out in the Cold April 29, 2019 by La Rainne Pasion, https://www.passblue.com/2019/04/29/trumps-strong-arm-cuts-put-un-peacekeepers-out-in-the-cold/*

шилжүүлэх өртэй байна.[169] Энэхүү нөхөн төлбөрийн олголтын асуудлаас болоод ажиллагааны газар оронд үүрэг гүйцэтгэж байгаа цэрэг цагдаагийн анги салбаруудын зэвсэглэл техникийн завсар үйлчилгээ, шинэчлэл орхигдож, цэргийн багуудын ээлжийг хугацаанд нь солиход хүндрэл учруулж байгаа нь ажиллагааны үр дүнд сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал 2018 онд MINUSCA-д үүрэг гүйцэтгэж байсан Урвандагийн цэргийн багийн зэвсэглэлийн нөхөн төлбөрийг авч чадаагүйн улмаас цэргийн нэг салбарыг бүрэн бус техниктэй үүрэг гүйцэтгүүлэх боломжгүй гэж үзэн татах хүртэл арга хэмжээ авсан байна.[170] НБД Антони Гүтэррэс 2019 онд НҮБ санхүүгийн хямралд орж байгаад санаа зовниж байгаагаа илэрхийлж гишүүн улс орнуудыг хууль эрх зүйгээр хүлээсэн хандив татаасыг цаг хугацаанд нь бүрэн өгөхийг уриалсан байна.

Оперативын түвшинд асуудлыг тодорхойлохдоо зэвсэгт мөргөлдөөний шинж чанар, ажиллагааны арга барил болон байнгын бэлэн байдал гэсэн чиглэлээр тусгаж байна.

Зэвсэгт мөргөлдөөний шинж чанар. Сүүлийн үеийн зэвсэгт мөргөлдөөнүүд богино хугацаанд их хэмжээний хохирол учруулах чадвартай, дайсагналын хэлбэр нь ямар нэг хэв загварт баригддагүй, хөнгөн зэвсэглэсэн жижиг бүлгийн ажиллагаа болж байна. Мөн түүнчлэн террорист ажиллагаа болон улс дамнасан гэмт хэргийн чанартай аюул ихээр нүүрлэх болсон байна. Энэ нь ЭДА-нд энгийн иргэдийг хамгаалах, хорлон сүйтгэгчид, алан хядагчид болон гэмт хэргийн бүлэглэлүүдийг аюулгүй болгоход тухайн улс орны оролцоог илүүтэйгээр бий болгох, тухайн орны засгийн газрын цэрэг бие даан тэмцэх чадавхитай болгоход дэмжлэг үзүүлэх хэрэгцээг бий болгоод байна. Тухайлбал Нигерын хойд хэсэгт хэт үзэлтэн болох Боко Харамын хууль бус ажиллагаа, Мавритан, Мали, Чад Букина Фасо, Сахелийн бүс нутаг дах олон улсын алан хядах ажиллагаа олон улс дамжсан зохион байгуулалттай гэмт хэрэгүүд ЭДА-нд сөргөөр нөлөөлж энхийн үйл явцад ахиц дэвшил гаргахгүй байна. 2013 онд Малид НҮБ-ын ЭДА дэлгэгдсэний дараа цэнхэр дуулгатнууд янз бүрийн зэвсэгт бүлэглэлүүдийн мөргөлдөөний бай болж 94 хүн алагдаж нилээд олон хүн шархадсан[171]. Энэ мэтчилэн сүүлийн 5 жилд Африкт болж байгаа байлдаан, зэвсэгт мөргөлдөөн болон иргэний хөдөлгөөнүүдийн шинж чанарыг тодорхойлоход хүндрэлтэй болсоор байна.

Ажиллагааны арга барил. Дайн тулаан, зэвсэгт мөргөлдөөн ихэвчлэн гадагшаа чиглэсэн буюу улс хоорондын асуудал байсан бол өнөөдөр улс болон улс бус тоглогчдын хууль бус эмх замбараагүй үйлдэлүүд нь ихэвчлэн дотогшоо чиглэсэн буюу улс доторх үймээн самуун, хямрал, зэвсэгт мөргөлдөөний шинжтэй болсон. Энэ нь уламжлалт энхийг дэмжих ажиллагааны үндсэн хэлбэр болох гал зогсоох хэлэлцээрт хяналт тавих,

[169] *International Peace Institue. Financing UN Peacekeeping: Avoiding another Crisis, April 2019.*

[170] *International Peace Institue. Financing UN Peacekeeping: Avoiding another Crisis, April 2019.*

[171] *Cedric de Coning, Mateja Peter, United Nations Peace Operations in Changing Global Order, Springer Nature Switzerland AG, 2019. 45, ISBN 978-3-319-99105-4*

ажиглагчийн байр сууриас хандах, энгийн иргэдийг хамгаалах зэрэг нь тийм ч үр дүнтэй арга барил биш болсныг харуулж байна. ЭДА нь тухайн улс орны хууль ёсны байгууллагуудтай хамтран нийгмийн болон цэргийн олон талт ажиллагаа явуулах, тухайн улс орны төр, нийгмийн байгууллыг сэргээн босгоход зарим салбарт дэмжлэг үзүүлэх, цаашид бие даан үйл ажиллагаа явуулахад хамтран ажиллах зэрэг өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулах шаардлагыг бий болгож байна.

Байнгын бэлэн байдал. НҮБ өөрийн гэсэн байнгын цэрэг, цагдаагийн хүчингүй учир олон үндэстэнээс бүрдсэн гишүүн орнуудын цэрэг, цагдаагийн хүчийг дайчилж бүтэц зохион байгуулалтын хувьд ажиллагааны газар оронд нэгдсэн зохион байгуулалтад оруулж олон талт үйл ажиллагааг явуулах нэгжийг богино хугацаанд бэлтгэн ажиллагааны газар оронд илгээх боломжгүй байдаг. Энэ нь цэргийн байгууллагуудын хамтын ажиллагаанаас гадна НҮБ-ын энгийн албан хаагчдын хувьд ч гэсэн тулгамдсан асуудал юм. Ялангуяа орчин үеийн эрлийз болон хүч тэнцвэргүй байлдааны ажиллагаанд энхийг сахиулагчид бэлтгэгдэх сургалт, судалгааны асуудал чухлаар тавигдаж байна.

Тактикийн түвшинд асуудлыг тодорхойлохдоо ажиллагааны нэгдсэн ойлголт, хамтын ажиллагаа болон сахилга бат, ёс зүй гэсэн чиглэлээр тусгаж байна.

Ажиллагааны нэгдсэн ойлголт. НҮБ-ын гишүүн орнуудын идэвхигүй, сул дорой улс төр, санхүү болон материаллаг болон материаллаг бус туслалцаа дэмжлэг, зарим асуудалд санаачиллаггүй хандах байдал, мөн улс орнуудын харилцан адилгүй чадавхи, нөөц бололцоо, болон шийдвэр гаргах болон үүрэг гүйцэтгэхэд харилцан хамтын ажиллагааны нэгдсэн ойлголтод хүрч чаддаггүй зэргээс шалтгаалан зарим ажиллагаа бүтэлгүй, амжилтгүй болж байсныг Босниа, Руванда, Соманлид болсон ажиллагааны туршлага сургамжаас харж болно. Сүүлийн үед ажиллагааны газар орон дээр үүрэг гүйцэтгэж байгаа цэрэг, цагдаагийн албан хаагчид аюул заналыг урьдчилан таньж, түүнд хариу шаардлагатай арга хэмжээг авахад туйлын хүндрэлтэй болсон. Учир нь хэт үзэлтнүүдийн ажиллагаа эрчимжиж, хил дамнасан хууль бус наймаа хийх, террорист бүлэглэлүүд цаг хугацаа, орон зайд хязгаарлагдахгүйгээр хорлон сүйтгэх ажиллагаа явуулж байна. Үүнтэй холбоотойгоор ажиллагааны нэгдсэн ойлголтыг боловсронгуй болгож болзошгүй эрсдэлээс хамгаалах асуудал чухлаар тавигдаж байна.

Олон талт хамтын ажиллагаа. НҮБ-ын болон НҮБ-ын бус байгууллагуудтай нэгдсэн зохион байгуулалтад орж ажиллагааны газар оронд хамтран ажиллах үр дүнтэй удирдлагын тогтолцоог цогц байдлаар шийдэх асуудал бэрхшээлтэй хэвээр л байна. Тухайлбал БНАКУ, Судан, Афганистан зэрэг улс орнуудад явагдаж байгаа ЭДА-ны бүтцүүдийн харилцан хамтын ажиллагаа нэгдэн зангидаж чадахгүй байгаагаас болоод энх тайван аюулгүй байдлыг тогтвортой байдлыг хангаж чадахгүйгээр барахгүй өөрсдөө олон талын бэрхшээлтэй нүүр тулсаар байна.[172]Тухайлбал Конгод явагдаж байсан ЭДА-нд хүмүүнлэгийн

172 Emily J.Munro. Geneva Papers; Multidimensional and integrated Peace Operations:

туслалцаа үзүүлэх байгууллагын зохицуулагч Хүчний командлагчтайгаа илүү ойр ажиллаж харилцан ажиллагааны үе дэх талуудын үүрэг, ажлын хүрээ, боломж, дэмжлэгийн талаарх дэлгэрэнгүй чиглэл удирдамжийг өгч чадсан бол, мөн цэргийн хөдөлгөөнт бүлгүүдтэй хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу ажилласан бол 8 сарын хугацаанд ажиллагаа хохиролгүй явагдах боломж байсан төдийгүй Катанга дах орон гэргүй болсон 230000 иргэнийг 24000 хүртлэх хэмжээнд буурууллж чадах байсан.[173] гэж шинжээчид үздэг.

Сахилга бат, ёс зүй. ЭДА-нд үүрэг гүйцэтгэж байгаа цэрэг, цагдаа, энгийн ажилтан албан хаагчид энгийн иргэдэд бэлгийн дарамт учруулах, харилцааны зөрчил гаргах, зан заншилтай холбоотой үл ойлголцолд хүрч асуудал үүсгэх, НҮБ-ын эд хөрөнгөд ариг гамгүй хандах, нас, арьс өнгө болон хүйсны ялгаварлал гаргах зэрэг ёс зүйгүй хууль бус үйлдэл гаргасаар байна. Тухайлбал Гайти дахь ЭДА-нд үүрэг гүйцэтгэж байсан энхийг сахиулагчид бэлгийн дарамт хүчирхийлэл үзүүлсэн хэрэгт холбогдож түүний уршгаар Шри-Ланкийн 117 энхийг сахиулагчийг нутаг буцаасан байдаг.[174] Мөн Гайтид үүрэг гүйцэтгэж байсан Непалын цэргийн алба хаагч, энхийг сахиулагч "Нутгийн иргэдийг маш залхуу хүмүүс юм. Тэд тариалан эрхэлдэггүй. Тэд юу ч хийдэггүй. " Гаитын хүн амын дунд өвчлөл, ядуурал өндөр байгаа нь тэд эрүүл мэнддээ анхаардаггүйгээс болдог.[175] гэх мэтчилэн эзэн орны ард түмнийг доромжилсон нь нутгийн иргэдийг энхийг сахиулагчдын эсрэг хандах хандлагыг бий болгосон байдаг. Энэ мэт үйлдлүүд НҮБ-ын нэр хүндийг унагах, ажиллагааны амжилтыг үгүйсгэх зэргээр цаашлаад цэнхэр дуулгатны амь насанд хүртэл нөлөөлөх шалтгаан болохыг үгүйсгэхгүй байна.

Дүгнэлт

НҮБ нь олон улсын тавцан дах энх тайван аюулгүй байдлын төлөө хараат бусаар бие даан үйл ажиллагаа явуулах хамгийн чухал байгууллага юм. Олон үндэстэн, хүчнүүдээс бүрдсэн энэ байгууллагын явуулсан ЭДА-ны амжилт, давуу талыг үнэлж баршгүй ч цаашид бодлогын бүхий л түвшинд шат дараалсан хяналт, шинжилгээ, үнэлгээний багуудыг томилон тэдгээрийн гаргасан үнэлгээнд ач холбогдол өгч зохих хэмжээний

Trends and Challenges.Norwegian Ministery of Foreign Affairs.

[173] *Emily J.Munro. Geneva Papers; Multidimensional and integrated Peace Operations: Trends and Challenges.Norwegian Ministery of Foreign Affairs.*

[174] *Catherine Lutz, Matthew Gutmann, and Keith Brown, Conduct and Discipline in UN Peacekeeping Operations: Culture, Political Economy and Gender Report submitted to the Conduct and Discipline Unit, Department of Peacekeeping Operations United Nations October 19, 2009, https://www.researchgate.net/publication/272243585_Conduct_and_discipline.*

[175] *Catherine Lutz, Matthew Gutmann, and Keith Brown, Conduct and Discipline in UN Peacekeeping Operations: Culture, Political Economy and Gender Report submitted to the Conduct and Discipline Unit, Department of Peacekeeping Operations United Nations October 19, 2009, https://www.researchgate.net/publication/272243585_Conduct_and_discipline.*

эрх зүй, зохион байгуулалтын өөрчлөлтийг хийх гишүүн орнуудын олон талт оролцоог идэвхижүүлэх нь чухал байна. Тухайлбал сүүлийн 5 жилд Африкт болж байгаа байлдаан, зэвсэгт мөргөлдөөн болон иргэний хөдөлгөөнүүдийн шинж чанараас харахад асуудалд богино хугацаанд түргэн шуурхай хариу арга хэмжээ авахын тулд НҮБ-ын уламжлалт цэрэг, цагдаагийн ажиллагааг боловсронгуй болгох, шинэчлэх шаардлага хэрэгцээ байгааг харуулж байна. Ялангуяа ЭДА-нд хууль сахиулах, хууль тогтоох байгууллага, цагдаагийн хүчний оролцоог нэмэгдүүлэх, засаглалыг чадавхжуулахад энгийн мэргэшсэн алба хаагчдын оролцоог нэмэгдүүлэх нь энхийн ажиллагааг илүү үр дүнтэй болгож болох юм. Мөн түүнчлэн ажиллагааны мандатыг улам боловсронгуй болгох, мандатад эзэн улс, НҮБ, сөргөлдөгч талуудын хариуцлага, эрх үүргийг илүү тодорхой болгох, хүч хэрэглэх дүрмийн талаар тусгай судалгаа, шинжилгээний ажлыг явуулах зайлшгүй шаардлага байна.

НҮБ-ын ЭДА-ны цаашдын хандлага, хөгжил зөвхөн НҮБ-ын олон талт бодлого төдийгүй гишүүн орнуудын оруулах хувь нэмэрээс ихээхэн шалтгаалах юм.Тухайлбал, ЭДА-нд үүрэг гүйцэтгэж байгаа улс орнуудын цэргийн зэвсэглэл, техник хоцрогдсон, ажиллагааны, газар орон цаг агаарын онцлогт бие бүрэлдэхүүний сэтгэл зүй бие бялдар хангалттай бэлтгэгдсэн эсэхэд цэргийн багуудын туршлага сургамжийг ашиглан ажиллагааны өмнөх сургалт дадлагыг шинэчлэн сайжруулах хэрэгцээ байна.

Мөн түүнчлэн бүс нутгийн болон дэд бүсийн байгууллагуудын энхийн ажиллагааны оролцоо, эрх, үүрэг, хариуцлагын талаарх эрх зүйн баримт бичгүүдийг боловсронгуй болгох, стратегийн болон оперативын түвшинд гишүүн орнуудтай илүү ахисан түвшинд хамтарч ажиллах нь нэн чухал байна.

Эшлэл авсан, ашигласан материалын жагсаалт:

1. http://www.un.org/en/sections/history/history-united-nations/index.html
2. Монгол Улс энхийг дэмжих үйлсэд: Туршлага, сургамж". УБ., 2012. т.16.
3. https://peacekeeping.un.org/en/troop-and-police-contributors
4. https://peacekeeping.un.org/en/data
5. Joachim A. Koops, Norre Macqueen, Thierry Tardy, Paul D. Williams. The Oxford Handbook of United Nations Peacekeeping Operations, Oxford University Press.2015-7, ISBN978-0-19-968604-9;
6. Joachim A. Koops, Norre Macqueen, Thierry Tardy, Paul D. Williams. The Oxford Handbook of United Nations Peacekeeping Operations, Oxford University Press.2015-7, ISBN978-0-19-968604-9;
7. Joachim A. Koops, Norre Macqueen, Thierry Tardy, Paul D. Williams. The Oxford Handbook of United Nations Peacekeeping Operations, Oxford University Press.2015-7, ISBN978-0-19-968604-9;

8. The Devastating Impacts of Cuts to United Nations Funding,
9. https://globalhealth.org/wp-content/uploads/Devastating-Impacts
10. Report of the Advisory Group of Experts for the 2015 Review of the United Nations Peace building Architecture 29June 2015.
11. Joachim A. Koops, Norre Macqueen, Thierry Tardy, Paul D. Williams. The Oxford Handbook of United Nations Peacekeeping Operations, Oxford University Press.2015-7, ISBN978-0-19-968604-9;
12. Hilde Frafjord Johnson. Protection of Civilian in the United Nations: A Peacekeeping Illusion, United Nations Peace Operations in Changing Global Order, ISBN978-3-319-99105-4.
13. Cedric de Coning UN Peace Operations and Changes in the Global Order: Evolution, Adaptation and Resilience, United Nations Peace Operations in Changing Global Order, ISBN978-3-319-99105-4.
14. Joachim A. Koops, Norre Macqueen, Thierry Tardy, Paul D. Williams. The Oxford Handbook of United Nations Peacekeeping Operations, Oxford University Press.2015-7, ISBN978-0-19-968604-9;
15. Joachim A. Koops, Norre Macqueen, Thierry Tardy, Paul D. Williams. The Oxford Handbook of United Nations Peacekeeping Operations, Oxford University Press.2015-7, ISBN978-0-19-968604-9;
16. Congressional Research Service, United Nations Issues: U.S Funding of U.N. Peacekeeping, August 14, 2019. https://fas.org/sgp/crs/row/IF10597.pdf
17. Cedric de Coning, Mateja Peter, United Nations Peace Operations in Changing Global Order, Springer Nature Switzerland AG, 2019. 45, ISBN 978-3-319-99105-4
18. Trump's Strong-Arm Cuts Put UN Peacekeepers Out in the Cold April 29, 2019 by La Rainne Pasion, https://www.passblue.com/2019/04/29/trumps-strong-arm-cuts-put-un-peacekeepers-out-in-the-cold/
19. International Peace Institue. Financing UN Peacekeeping: Avoiding another Crisis, April 2019.
20. Emily J.Munro. Geneva Papers; Multidimensional and integrated Peace Operations: Trends and Challenges.Norwegian Ministery of Foreign Affairs.

ТЕРРОРИСТ ХҮНИЙ СЭТГЭЛ ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛД

С.Пүрэвдорж
БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан,
доктор(Ph.D), дэд профессор

Key Words: *Terrorism psychology, frighten, blackmail, ideology, ethics, suicide bomber's psychology, psychological impact of terrorism, mental terrorism.*

Abstract: *Terrorism has become an important factor to affect social psychology on international level. For Mongolia, preventing terrorist attack is very important. Strengthening country's internal order, law enforcement sector and people's psychology are preconditions to prevent terrorism. People's psychology is very influential for prevention of terrorism. Especially, terrorists are mentally not normal. Terrorism's psychological issues has become one of the most dangerous and complicated threating pheno menon to modern human society. Thus, psychological research about terrorism is relatively new and researchers have started to emphasize on these issues.*

Үндсэн асуудал:

Терроризмын сэтгэл зүй гэдэг нь нийгэм, улс орныг тэдний шаардлагыг биелүүлэхэд өдөөх зорилгоор хувь хүн эсвэл жижиг бүлгүүд явуулдаг сэтгэл зүйн (айлган сүрдүүлэх) болон бие махбодийн (хүчирхийллийн) бүрэлдэхүүн хэсгүүдийг нэгтгэсэн улс төрийн зорилготой үйл ажиллагааны хэлбэр юм.

Энэхүү зорилгын хүрээнд терроризмын сэтгэл зүйг дараах байдлаар ангилан үзэж байна. Үүнд:

1. Үндсэрхэг үзэлтэн - салан тусгаарлах эсвэл үндэсний эрх чөлөөний зорилгоо биелүүлж хэрэгжүүлэх;

2. Шашинлаг - шашин шүтлэгийг өөр хоорондоо (Энэтхэг ба Лалын шашинтан, Лалын шашинтан ба Христэд итгэгч нар) ижил итгэлийн хүрээнд (Протестант Католик шашинтан) тэмцэж байгаатай холбоотой байж болох ба дэлхийн эрх мэдлийн тэнцвэрийг алдагдуулж унагаах, шашны хүчийг бий болгох зорилготой;

3. Үзэл суртлын, нийгмийн - аливаа хурц, хүндрэлтэй асуудалд олон нийтийн анхаарлыг татаж, улс орны эдийн засаг, улс төрийн тогтолцоог эрс, эсвэл хэсэгчлэн өөрчлөх зорилгыг баримтлах гэх мэт.

Сэтгэл зүйн хувьд орчин үеийн терроризм хэд хэдэн шинж чанарыг агуулж, өөрийн өвөрмөц онцлогтой байна. Тухайлбал:

1. Терроризм – сэтгэл зүйн төлөөлөгч: өвөрмөц онцлог нь айдас, түгшүүртэй орчныг санаатайгаар бий болгож, сэтгэлийн хямралд оруулах. Түүнчлэн энэ нөхцөл байдал нь хувь хүн эсвэл жижиг бүлгийн түвшинд биш, нийгмийн түвшинд зохицуулагддаг. Үндсэн обьект нь террорист халдлага байх бөгөөд хохирогчид биш харин амьд үлдсэн хүмүүс байна. Үүний зорилго нь харин амьдралыг айлган сүрдүүлэх, сүйтгэх явдал болж, материаллаг, эдийн засаг, улс төрийн хохирол учруулдаггүй, харин нийгэмд ёс суртахууны гэмтэл, доголдлыг үүсгэдэг.

2. Террорист үйлдэл нь маш хэрцгий: хайрлах, энэрэнгүй байдал гаргадаггүй, террорист ажиллагаа анх зохион байгуулагчид нь төлөвлөж хэрэгжүүлдэг.

3. Терроризм соёлын үндэс болсон - нигилизм[176]- нийтлэг ёс зүйгээс татгалздаг. Хүний ерөнхий үнэлэмжийг үгүйсгэж, “юу ч үгүй” болгож бууруулдаг - орчин үеийн терроризмын дүр төрхийг агуулдаггүй.

4. Бодит терроризмоос ялгаатай, түүний гүйцэтгэлийн олон нийтийн шинж чанар нь өргөн нээлттэй, шаардлагагүйгээр нээлттэй террорист ажиллагаа явуулдаггүй. Террористууд тэдний үйлдлээс үүдсэн олон нийтийн эсэргүүцлийг харгалзан үздэг. Гэвч ард, иргэдийг хамгаалах чадваргүй хэмээн хууль сахиулах байгууллага болон эрх баригчид үздэг байна.

Террористын хувийн шинж чанар нь сөрөг хандлагаар тодорхойлогддог бөгөөд дэлхийн хамгийн тохиромжтой загвар дүр төрх ба өөрийн бодит байдал, өөрийгөө танин мэдэх боломжуудын хоорондын зөрүү. Хувь хүний хүчин зүйлээс гадна террорист үйл ажиллагааны оролцоог хангадаг хэд хэдэн нийгэм-сэтгэл зүйн хүчин зүйлийг тодорхойлсон байдаг. Эдгээрийн дотор дараах зүйлс багтдаг. Тухайлбал:

1. “тархи угаах” зорилготой янз бүрийн төрлийн сэтгэцийн технологийг ашиглах (урам зориг өгөх, зөн совин, тархийг угаах нөлөө гэх мэт);

2. “бүлгийн таних механизм” - өөрийгөө үнэлэх чадваргүй хүмүүст өөрийгөө бүрэн эрхт хүн шиг мэдрэх боломжийг олгодог бөгөөд энэ нь “дэлхийг засахаар сонгогдсон” хүмүүсийн тоонд багтдаг;

[176] *Нигили□зм - философия, ставящая под сомнение (в крайней своей форме абсолютно отрицающая) общепринятые ценности, идеалы, нормы нравственности, культуры. Нигилизм в общем смысле подразумевает под собой отрицание, негативное отношение к определённым или даже ко всем сторонам общественной жизни. В словарях определяется также как “отрицание”, “абсолютное отрицание”, “социально-нравственное явление”, “умонастроение”, то есть определение нигилизма и его проявление в разное время зависели от культурно-исторической эпохи, субъективно и контекстуально зависимы.*

3. сэтгэцийн өвөрмөц байдлыг алдагдуулах - “бүлгийн бодол” үүсгэдэг бөгөөд түүний агуулгыг бүлгийн гишүүд шүүмжлэлгүй, бие даасан байдлаар оролдохгүйгээр хуваалцдаг. Энэхүү зөрчилдөөн нь дээрх бодлын үндсэн агуулгыг тодорхойлдог. Бүх дэлхий “биднийх” ба “биднийх биш” гэж хуваагддаг. “Бидний” талаарх бүх зүйл, тэдний аливаа мэдэгдэл, үйлдлүүд бүрэн батлагдсан байдаг. “Биднийх биш”-ээс үүдэлтэй бүх зүйлийг буруушааж, харгис гэж тунхагладаг. Ийм хаалттай зааврын эсрэг зөрчилтэй аливаа мэдээллийг блоклож, түрэмгий байдлаар авч үздэг.

Террористуудын ерөнхий сэтгэл зүйн дүр зургийг гаргах нь нэлээд хэцүү боловч энэ асуудалд зориулагдсан сэтгэл зүйн янз бүрийн судалгааны дүн шинжилгээ нь террористуудын дараах хамгийн онцлог шинж чанарыг гаргах боломжийг олгож байна.

- өөртөө итгэх итгэл бага;
- өөрийгөө зөвтгөх;
- хувийн болон сэтгэл санааны хувьд төлөвшөөгүй байдал;
- түрэмгий параной[177] ;
- террорист байгууллагад сохроор үнэнч байх, түүний даалгавар, зорилгыг хэрэгжүүлэх;
- боловсролын түвшин доогуур, танин мэдэхүйн сонирхол сул, оюун ухаан нь хангалтгүй хөгжсөн;
- хэрцгий түрэмгий байдал, уур хилэн, хэн нэгний “би” -ийг хамгаалах байнгын бэлэн байдал, өөрийгөө батлах хүсэл, хэт өөрийгөө шингээх чадвар;
- хэт их тэвчих, эсэргүүцэх гэх мэт.

Терроризм нь түүний бүх хэлбэр, илрэл, цар хүрээ, хэмжээгээр хүнлэг бус байдал, хэрцгий байдал нь одоо дэлхийн хэмжээнд тулгамдсан хурц асуудал болоод байна. Гэхдээ терроризмын аюул занал бүрэн арилдаг гэдгийг онцолж үзэх нь зүй хэрэг. Терроризмтой тэмцэх аргууд нь “панаций” биш, харин цоо шинэ шийтгэл, түрэмгийллийг өдөөж, улмаар терроризмыг устгахын оронд харгис тойрог бий болгож байгааг дэлхийн олон нийт ойлгох нь зүйн хэрэг. Иргэдэд хүчирхийллээс татгалзах мэдрэмжийг улс төрийн тэмцлийн арга хэрэгсэл болгох,

[177] *Параной бол хуурмаг зүйл юм. Паранойд хүмүүс бусдын эсрэг цйлдэгддэг итгэл үнэмшилгүй, буруу ойлголттой байдаг. Параной нь олон янзын хэлбэртэй байдаг боловч хамгийн түгээмэл нь: бусад ард түмний зорилго, цйлдлүүдийг сэжиглэх, таныг танихгүй хүмүүс, танил хүмүүс, хайртай хүмүүст ул итгэсэн эсвэл сурдүүлэгүй итгэл, телевиз, сонин, шуудан, олон нийтийн цахим шуудан, интернет (зарлалын сан гэх мэт) -аар дамжуулан тусгай далд мессежүүд танд дамжуулагдана гэдэгт итгэдэг, таныг танихгүй, танигдаагүй, эсвэл бусдад танигдахуйц онцгой цүрэг, ач холбогдолтой гэдэгт итгэдэг. Паранойны мэдрэмж нь хүний амьдралын хэвийн цйл явцын нэг хэсэг бөгөөд эмзэг булгийнхний дунд түгээмэл байдаг. Параной нь сэтгэлийн хямрал, хоёр туйлын эмгэг зэрэг сэтгэцийн эрүүл мэндийн олон асуудлын нэг байж болох ч шизофрения гэх мэт сэтгэл зүйн эмгэгтэй холбоотой юм.*

түүнчлэн хүчирхийлэлтэй тэмцэхэд бүхэл бүтэн нийгэм хүчин чармайлт гаргах шаардлагатай байгааг ойлгуулах нь чухал юм. Терроризмыг ялах нь нийгэм хүссэн тохиолдолд л боломжтой. Энэхүү тэмцлийг боловсрол, олон нийтийн соёлыг түгээх, хэвлэл мэдээллийн ажлын чин шударга байдал, олон нийтийн санаа бодлыг бий болгох гэх мэт чиглэлээр явуулах нь ойлгомжтой. Асуудлыг хурдан бодитой шийдвэрлэх нь нийгэм дэх хуваагдлыг арилгаж, террорист хөдөлгөөнийг нийгмийн шаардлагатай баазаас чөлөөлдөг. Нийгмийн аль нэг хэсгийн дэмжлэггүйгээр террорист хөдөлгөөнүүд бүрмөсөн алга болдоггүй.

Терроризм нь хүн төрөлхтөнд асар их аюул учруулж байна. Энэ үзэгдэл нь үндэстэн дамждаг. Терроризмыг улам хурцатгаж байгаа нь төрийн байгууллын сул тал, гадаад, дотоод бодлогын чиглэлээр гарсан томоохон алдааг тооцох, этнопсихолог[178]- ийн хууль тогтоомж, түүхийг үл тоомсорлохтой үргэлж холбоотой байдаг. Тусгай албаны мэргэжлийн ур чадварын чиглэлээр терроризмтой тэмцэхэд сэтгэл зүйн зөвлөмжийг ашиглах нь маш чухал байна. Терроризмыг хөгжүүлэхэд шууд бусаар нөлөөлдөг хүчин зүйлийг блоклох нь нийгмийн янз бүрийн бүлгүүдэд энэ үзэгдэлд хандах хандлага, хэвлэл мэдээллийн байр суурь юм.

Терроризмын дүр төрх нь гүн гүнзгий нуугдсан хамгийн эртний давхаргууд соёл иргэншлийн бүрхүүл дор, нийтийн амьдрал дахь дэвшил гарсан үеэс эхэлсэн гэдгийг судлаачид тэмдэглэсэн байдаг. Орчин үеийн терроризмын гол онцлог нь хүчирхийллийг өдөөх хүсэл эрмэлзлийн үндсэн шинж юм. Хэдийгээр үндэслэлтэй байж болох ч үндэслэл нь хоёрдогч зүйл болж хувирдаг. Энэ үзэгдлийг 1970-1980-аад онд Герман, Францын террористуудтой хамтран ажиллаж байсан сэтгэл судлаачид нарийвчлан судалж гаргасан байна. Алан хядах ажиллагаанд оролцсон хүмүүсийн сэдэл нь бүрэн дур зоргоороо бус болох нь тогтоогдсон бөгөөд хэн нэгний хувийн дургүйцлийг хүргэхээс эхлээд хамгийн төвөгтэй улс төрийн онолууд ордог. Эдгээр онолуудын ноцтой байдал нь хуурамч болж хувирахад тухайн хүн хэдэн сарын турш бодол санаагаа боловсруулж, улмаар гэнэт тэднийг орхих болно.

Орчин үеийн терроризмын механизм нь маш гүн гүнзгий, үг хэллэгийн үндэслэлээр далдлагдсан байдаг. Ихэнх тохиолдолд террорист үйлдлүүд нь цөөнх үндэстэн өөрийгөө олж мэдсэн нөхцөл байдлаас найдваргүй байдал, сэтгэл зүйн таагүй байдал зэргээр өдөөгддөг. Эсвэл үзэл суртлын итгэл үнэмшил эсвэл шашны шалтгаанаар цөөнх үндэстэн болдог. Ямар ч тохиолдолд сэдэл нь ижил төстэй байдаг бөгөөд манай хүмүүс, бидний соёл, хэл, бидний итгэл үнэмшил устах гэж байна, хэн ч бидний аргументыг тоохгүй тул зөвхөн хүчирхийллийн ойлголт л үлддэг. Гэхдээ энд бодит байдлыг түүний ойлголтоос ялгах шаардлагатай хэмээн үздэг байна.

Террорист хүний хувийн шинж чанар нь сөрөг хүчин зүйлээр тодорхойлогддог бөгөөд энэ нь хэд хэдэн хүчин зүйлийн нөлөөн дор үүсдэг байна.

[178] Дробижева Л.М “Методологические проблемы этносоциологических исследований”. 2015. № 3., -89 стр;

Нэгдүгээрт, эдгээр нь дэлхийн хамгийн тохиромжтой загварын дүр төрх ба бодит байдал дахь өөрийгөө илэрхийлэх боломжуудын хоорондын зөрүүг багтаадаг. Энэ нь туйлын хүсэлтэй зөрчилдөж хувь хүний болон нийгмийн хангалтгүй байдлын субьектив мэдрэмж болж хувирдаг; Үүний үр дүнд террористын хувийн шинж чанар нь "Би бол сайн, дэлхий муу" гэсэн байр суурьтай байдаг бөгөөд энэ нь аливаа хор хөнөөлтэй үйлдлүүдийг зөвтгөх боломжийг бий болгодог ёс суртахууны өөрийгөө хамгаалах хэрэгсэл болж өгдөг. Ийнхүү террористуудын үйл ажиллагаа өөрийгөө сүйтгэх шинж чанарыг олж авдаг. Үүний зэрэгцээ, татгалзах замаар өөрийгөө зөвтгөх "ашиг хонжоо харах" үзэл баримтлал гарч ирдэг бөгөөд энэ нь террорист бүлэглэл ба хувь хүний террористуудад эерэг нөлөө үзүүлэх боломжийг багасгадаг. Дүрмээр бол террорист дайчдаас үүдэлтэй сэтгэл хөдлөл нь түрэмгий, сэтгэлийн хямралд өртөх аюулын (стеник) шинжтэй байдаг.

Хоёрдугаарт, аливаа илрэл дэх терроризм нь тухайн хүний эсрэг чиглэсэн хамгийн аюултай, сүйтгэх, хүчирхийлсэн үйлдлүүдийн нэг болж байна.

Тухайн улсад терроризм илэрч байгаа тохиолдлууд олон нийтийн дунд хүчтэй эсэргүүцлийг бий болгосноор хүмүүс өөрсдийн аюулгүй байдал, гэр бүл, найз нөхдийнхөө аюулгүй байдалд онцгой санаа тавьж анхаарал хандуулдаг болсон.

Террорист үйлдлийг тодорхой харгислалтайгаар хийдэг бөгөөд үүнийг анх зохион байгуулагчид нь төлөвлөсөн байдаг. Террорист үйлдэл нь хохирогчдод шууд хохирол учруулахаас гадна тодорхой сэтгэл зүйн нөлөө үзүүлэх зорилгоор айдас төрүүлэх, олон хүмүүст аюул заналхийлэх явдал юм. Терроризмын аливаа үйлдэл нь террористуудтой санал нийлэхгүй байгаа бүхнийг айлгах зорилготой байдаг. Тиймээс энэ нь улс оронд зөвхөн материаллаг, эдийн засаг, улс төрийн хохирол төдийгүй нийгэмд ёс суртахууны хохирол учруулж байна.

Терроризм бол хүний нийтлэг бэрхшээлийн нэг юм. Өнөөдөр терроризм нь улс, нийгэм, хувь хүнд ноцтой аюул занал учруулж байгаа бөгөөд энэ талаар зохих хариу арга хэмжээ авахыг шаардаж байна.

Терроризмын хүн төрөлхтөнд аюул учруулах байдлаар заналхийлэх нь өдөр бүр нэмэгдэж байна. Үүнтэй холбогдуулан терроризм ба түүний сэтгэл судлалын чиглэлээр мэргэшсэн судлаачид Ю.М.Антонян[179], В.В.Витюк[180], Д.В.Ольшанский[181], В.Ф.Пирожков[182], С.А.Ефиров нарын явуулсан судалгааны туршлагыг авч үзэхэд:

[179] *Антонян Ю. М. "Особо опасный преступник: тоталитарные преступники, серийные убийцы, террористы, бытовые убийцы, сексуальные маньяки, наемные убийцы". М.: Проспект, 2011 г.- 310 стр.-*ISBN 978-5-392-01941-0*;*

[180] *Витюк В.В. "Терроризм в современном мире: истоки, сущность, направления и угрозы". -М.: Институт социологии. РАН., 2003 г. - 358 стр. ISBN 5-89697-070-6;*

[181] *Ольшанский Д.В. "Основы политической психологии". Екатеринбург: -2001 г.- 496 стр., -ISBN 5-88687-098-9;*

[182] *Пирожков В.Ф." Криминальная психология". - М.: 2001 г. - 704 стр., - ISBN 5-86894-492-5;*

- амиа золиослогчийн сэтгэл зүйн сэдэл;

- террористуудын сэтгэл зүй гэсэн хоёр талтай байна.

Терроризмын асуудал олон талтай. Үүнд, сэтгэл зүйн шинжлэх ухааны доктор, судлаач В.Ф.Пирожковын хэлснээр "нийгэм, хууль эрх зүй, эдийн засгийн зэрэгцээ сэтгэл зүйн талыг нарийвчлан авч үзэх, гүнзгий судлах шаардлагатай"[183] гэжээ.

Түүнчлэн, алан хядах ажиллагаа үйлдсэн хүмүүс сэтгэл зүйн үүднээс юу хийдэг, үйлдлийн сэтгэл зүйн шалтгаан юу болохыг тодорхойлсон байна.

Террорист ажиллагаа явуулах чадвартай хүмүүсийн, эсвэл террорист бүлэглэлийн удирдагчдын үйл ажиллагаанд ашиглаж болох хүмүүсийн сэтгэл зүйн байдлыг тодорхойлохдоо: эдгээр нь улс төрийн хүрээнд өөрсдийгөө ухамсарлаж чадаагүй, гэхдээ эрх мэдлийг эрэлхийлсэн тодорхойгүй төлөвтэй хүмүүс юм. Тэдгээр нь аль хэдийн цус урссан, террорист байгууллагуудын аливаа тушаалыг мөнгөний төлөө биелүүлэх чадвартай дээрэмчдийн бүлэгт элссэн байдаг.

Гуравдугаарт, террористууд бол хүмүүсийн тусгай ангийн нэгдэл юм. Тэдний мэдэгдэхүйц хэсэгт тэд сөрөг шинж тэмдэг бүхий сонгодог хэлбэрүүд бөгөөд амьдралын талаар хоёрдмол хандлагатай байдаг: нэг талаас үүнийг шударга, зөв болгохыг хүсдэг бол нөгөө талаас тэд үүнийг устгаж, өөрсдийн зорилгодоо хүрэхийн тулд олон хүний амь насанд хүрдэг байна. Үүний зэрэгцээ тэд өдөр тутмын оршихуйн цар хүрээг хамарч, түүнийг тод өнгө, ер бусын үйл явдал, эрсдэл, айшигт туршлагаар дүүргэж, эцэст нь, ялангуяа үхэлтэй холбоотой байх, тэр ч байтугай түүний дотор орох хүсэл эрмэлзэлээр илэрхийлдэг.

Терроризмын сэтгэл зүйн нөлөө нь хоёр аргаар илэрдэг: хэт даврагч нь түүний амь насыг эрсдэлд оруулж, түүнийг юу ч үгүй болгохын оронд амь насыг нь үгүй хийдэг.

В.В.Витюк, С.А.Ефиров зэрэг судлаачийн үзэж байгаагаар террористууд максималист идеалист утопианизм, одоо байгаа тогтолцоог үзэн ядах, эсвэл өөрөөсөө холдох мэдрэмжээс үүдэлтэй үзэл бодол, фанатизмыг хэт тэвчих шинжтэй байдаг. Тэдгээр нь үнэмлэхүй, өвөрмөц, эцсийн үнэнийг эзэмших, итгэл үнэмшилтэй, хувь хүний хувь тавилан, аврал эсвэл аз жаргалын төлөө илүү их өвөрмөц байдлаар итгэх итгэлээр тодорхойлогддог. Тайлбарлахад: хувийн шинж чанар нь "хаалттай" төрөл юм, яагаад гэвэл энэ нь ертөнцийг зөвхөн урьдчилан тодорхойлсон "ганц үнэн" -ийн гэрлээр хардаг ч гэсэн бодит байдалтай эсвэл удаан хугацааны туршид холбоогүй байсан ч аливаа шүүмжлэлтэй бодол, сонголт хийх эрх чөлөөг алдсан байна.

Дөрөвдүгээрт, терроризм бол нийгэмд болон хүн төрөлхтөнд хор хөнөөлтэй хүчнүүдийн гаралтай бүтээгдэхүүн бөгөөд хүчирхийллийн шүтлэгийг тусгаж, түүний бэхжилт, тархалтад хувь нэмэр оруулж, хүнийг доройтуулдаг. Терроризм нь хууль тогтоомжийн ач холбогдол,

[183] *Пирожков В.Ф." Криминальная психология". - М.: 2001 г. - 704 стр., - ISBN 5-86894-492-5;*

буулт хийх боломжийг эрс бууруулж, харгис хэрцгий хүчийг амьдралын бараг бүх гол зохицуулагч болгон нэмэгдүүлдэг.

Террористууд ихэнхдээ өөрсдийн үйлдэл болон өөр бусад сэтгэл зүйн шалтгаанаар олон нийтэд сурталчлах шаардлагатай байдаг. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, улс төрийн болон төрийн удирдагчид болон бусад хүмүүсийн хувьд тэд толин тусгал шиг онцгой байдлаа хүлээн зөвшөөрч, баталж байгааг харуулдаг.

Бүх террористууд хүний амьдралыг үл хүндэтгэдэг гэдгээрээ онцлог бөгөөд тэд бүгд өөрсдийн үзэл бодлоосоо хамааран гэм зэмгүй хүмүүсийн амийг золиослох зорилготой өндөрт хүрэх боломжтой гэж үздэг. Террористууд нийгмийн боловсролгүй, амжилтанд хүрээгүй хүмүүсийг татан оролцуулдаг. Тэд сургууль, их сургуульд амжилтгүй суралцсан, тэд карьераа гаргаж чадахгүй, үе тэнгийнхэнтэйгээ ижил түвшинд хүрч чадаагүй ажээ. Тэд үргэлж ганцаардмал байдлаас болж зовж байсан, тэд эсрэг хүйсийн төлөөлөгчидтэй харилцаа холбоогоо хөгжүүлээгүй. Нэг үгээр хэлбэл, хаа сайгүй, үргэлж хоцорч байсан, тэд өөрсдийгөө жинхэнэ утгаар нь мэдрээгүй хүмүүсийн төлөөлөл болсон байдаг.

Ихэнх тохиолдолд террористууд бол 20-25 настай, эх оронч, шашны өндөр соёлд өссөн залуучууд юм. Тэдний оюун ухаан нь ихэвчлэн үндэстнийхээ түүхэн замналын талаар хүчтэй итгэл үнэмшилтэй байдаг ба хүчтэй сэтгэл хөдлөлийн холбоотой байдаг. Нийгмийн ердийн мэдрэмж нь уй гашуу, үндэсний бахархалдаа хавсарсан мэдрэмжтэй юм. Террористууд нь "түүхэн гэмт хэрэгтэн" ба түүний шийтгэлийг хүлээх хэрэгцээний талаарх онцгой санаануудаар тодорхойлогддог. Эдгээр санаанууд нь хамаатан садан, найз нөхөд, зүгээр л хамаатан садныхаа үхлийн бодит бариmттай, сэтгэцийн гэмтэлтэй холбоотой байдаг.

Судлаачдын үзэж байгаагаар тэд хийж байгаа үйлдэлээ төгс төгөлдөрт айж эмээх зүйл байхгүй, бараг л төгс мэддэг.

Зэвсэгт мөргөлдөөн явагдаж байгаа янз бүрийн бүс нутгуудаар аялж, нэг талд буюу нөгөө талд тулалдаж байсан хөлсний ажилтнууд террористуудыг элсүүлэх чухал эх үүсвэр юм. Тэдний сэтгэл зүйн хувьд нэг зүйл чухал байдаг: хэн илүү их мөнгө өгөх вэ, тэд ихэвчлэн "сонирхлыг татах", "хүмүүст эрх мэдлийг мэдрэх", "бусдаас давуу байдлаа харуулах" гэх мэтээр өдөөгддөг.

Террористуудын дунд хүүхэд, залуу насандаа доромжлогдсон, өөрсдийгөө баталж чадахгүй олон хүн байдаг. Эдгээр нь хүсэл зорилго, санаагаа хэрэгжүүлж чадаагүй хүмүүс юм. Олон террористууд тухайн цаг үедээ зарим эрх, эрх чөлөөг хамгаалан төрийг буруушааж, хуулиас гадуур гаргаж, тэдний хувьд терроризм нь энэ улсын нийгмийн өшөө авалт болсон хүмүүс юм.

Террорист үйлдэл хийхдээ гэмт этгээд тодорхой хууль зөрчдөг, үүнд сэтгэл зүйн хамгаалалт, өөрийгөө зөвтгөх зохих механизм шаардагдана. Эдгээр механизмын талаарх мэдлэг нь террористуудын сэдлийг ойлгох боломжийг олгодог. Ихэнх тохиолдолд тэд өөрсдийн үйлдлийг албадлага гэж үздэг, учир нь бусад хэрэгслүүд зорилгодоо хүрэхийг зөвшөөрдөггүй

байна. Террорист нь түүний энэ үйлдлийг нийгэмд шударга ёсыг зөрчсөн, эсвэл зарим эрхээ хэрэгжүүлж чадаагүйгээс үүдсэн гэж үзэж байгаа юм.

Террористуудын эгнээнд элссэн хүмүүс нийгмийн янз бүрийн давхаргын, янз бүрийн амьдралтай хүмүүс байдаг. Террорист байгууллагын гишүүн болоход юу өдөөдөг, тэр үүнийхээ үр дүнд юунд хүрсэн гэх мэт террористууд эзэмших ёстой хувийн шинж чанаруудын цогц байдаг нь ойлгомжтой.

Терроризм судлаачид, террорист хүний хувийн шинж чанарын дараах онцлогыг гаргаж тавьсан байна. Тухайлбал:

1. Дутуу байдлын цогцолбор. Энэ нь нөхөн олговрын механизм болж ажилладаг түрэмгийлэл, хүчирхийллийн шалтгаан болдог. Дутуу чанарын цогцолбор нь "Би" -ийг байнгын түрэмгий, хамгаалалттай бэлэн байдалд байлгахад хэт төвлөрөхөд хүргэдэг.

2. Өөрийгөө таних чадвар багатай. Террорист бүлэглэл нь тухайн хүнийг сэтгэл зүйн тогтворгүйжүүлэх хүчин зүйл болох үүрэг гүйцэтгэж, сэтгэцийн таних чадвар дутагдахаас салахад тусалдаг.

3. Өөрийгөө зөвтгөх. Ихэнх тохиолдолд улс төрийн болон үзэл суртлын сэдэл нь терроризмын замналд гарах гол хөшүүргийг заадаг боловч дүрмээр бол эдгээр нь нууцлагдмал хувийн хэрэгцээг оновчтой болгох хэлбэр юм.

4. Хувь хүний болон сэтгэлийн хөдөлгөөнгүй байдал. Ихэнх террористууд максимализм (хэт их эрэлт хэрэгцээ, үзэл бодол), абсолютизмаар тодорхойлогддог бөгөөд энэ нь бодит байдал, улс төр, онолын сонирхогчдын өнгөц ойлголтоос үүдэлтэй байдаг.

Террорист байгууллагууд ихэвчлэн түрэмгий сэтгэлгээний дасан зохицох чадвар өндөр хувийг эзэлдэг. Тэдний гишүүд гаднах хандлага, бүтэлгүйтсэн нөхцөл байдлыг буруутгах, өөрсдийн хангалтгүй байдлаа тайлбарлах, гадны хүчин зүйлийг эрэлхийлэх хандлагатай байдаг. Түүнээс гадна, гаднах байдал нь бараг бүх төрлийн шинжүүд террористуудад хамааралтай болох нь тодорхой юм. Энэ шинж чанар нь алан хядагчдыг өдөөн турхирах сэтгэл зүйн болон үзэл суртлын үндэс суурь болох нь гарцаагүй. Энэхүү хувийн хандлага нь бусад үндэстэн, шашин шүтлэг эсвэл нийгмийн бүлгийн хүмүүсийн үзэн ядалтыг идэвхтэй өдөөж, тэдэнд хамгийн их тааламжгүй шинж чанарыг агуулж, өөрсдийн дутагдал, бүтэлгүйтлийг, дайснуудын заль мэх, харгислалаар тайлбарладаг. Террорист үйлдэл үйлдэхэд тэр тусмаа харгислал, тэдний хохирогчдод өрөвдөх сэтгэл байхгүй байдаг. Терроризмд буруутгагдаж байгаа тодорхой хүмүүс өөрсдийгөө өөрсдийн бүтэлгүйтлийн эх үүсвэр гэдгийг хүлээн зөвшөөрөх нь тэвчихийн аргагүй байдаг гэдгийг олон судалгаа харуулж байна.

Террористуудын сэтгэл зүйн бусад шинж чанар нь байнгын хамгаалалтын бэлэн байдал, хэт өөрийгөө өөртөө шингээх чадвар, бусдын мэдрэмжинд бага анхаарал хандуулах, заримдаа бүр үл тоомсорлох явдал юм. Эдгээр шинж чанарууд нь "бусад" -аас байнга аюул заналхийлж, түрэмгийлэлд хариу үйлдэл үзүүлэх хандлагатай байдаг террористуудын сэтгэлгээний дасан зохицох чадвартай холбоотой.

Террористуудын сэтгэлгээний дасан зохицох чадвар нь хатуу байдал, хөдөлгөөний дутагдал, шилжих чадвар, сэтгэл хөдлөл, туршлага зэргийг хослуулан удаан хугацааны туршид үүссэн шалтгаан нь алга болсон ч гэсэн үргэлжилдэг. Хатуу үзэгдэл, үйл явц нь хувь хүний хараат бус байдлыг мэдрэхэд хүргэдэг. Олон террористууд сэтгэлийн зовиурыг мэдэрдэг бөгөөд сэтгэл дундуур байгаа нь өөрийгөө үнэлэх чадваргүй болох, хувь хүний зохисгүй үйлдэлд хүргэдэг.

Террорист бүлгүүдийн хоорондын ялгааг харахад, бүгдээрээ байгууллагын гишүүдийг үүрэг даалгавар, зорилгодоо сохроор чиглүүлдэг. Эдгээр зорилго, зорилт нь хүмүүсийг энэ байгууллагад элсэхэд түлхэц өгдөг гэж бодож болохгүй юм. Зорилго, үзэл суртал нь террорист харьяаллын үндэс суурь болдог. Бодит шалтгаан нь элсэх, бүлэгт харьяалагдах, өөрийгөө танин мэдэх мэдрэмжийн өндөр шаардлага юм. Ихэвчлэн террорист байгууллагуудын гишүүд нь эцэг эхийн гэр бүлээс гардаг бөгөөд одоо байгаа нийгмийн бүтцийн хүрээнд ямар нэгэн шалтгаанаар өөр бэрхшээлтэй тулгарсан, эсвэл огт ажилгүй байсан хүмүүс байдаг. Ийм нөхцөл байдалд үүсдэг харь гарагийн мэдрэмж нь хүнийг өөрийнх нь хувьд нийгэмшсэн мэт харагддаг бүлэгт элсэхэд хүргэдэг.

Террористуудын нийтлэг шинж чанар бол өөрийгөө танихтай холбоотой асуудалд багтдаг ийм хүмүүсийн бүлэгт хамрагдах шаардлагатай байдаг. Тиймээс терроризмд мэргэжлийн түвшинд оролцсон олон хүмүүс өөрсдийн бүлэгт тусгаарлагдсан, түүний үнэт зүйл, үйл ажиллагааны зорилгоо тодорхойлдог. Эхлээд харахад ийм төвлөрөл нь хувь хүний шударга байдлыг гэрчилдэг боловч үнэн хэрэгтээ энэ нь соёлын тусгаарлалт руу хөтөлж, тухайн хүний хувь хүн, сонголт хийх эрх чөлөөнд ноцтой хязгаарлалт тавьдаг. Ийм нөхцөлд хүн бүр өөр ертөнцөөс өөрийн болон бусдын эрх мэдэлд хуваагдаж, бусад соёлоос заналхийлж буй аюулыг хэтрүүлж эхэлдэг.

Бүлгийнхэнтэй салж тусгаарлах нь террористын хувьд бараг боломжгүй зүйл бөгөөд энэ нь сэтгэл зүйн хувьд амиа хорлохтой адил юм. Террористын хувьд байгууллагаас гарна гэдэг нь таних тэмдэгээ алдах гэсэн үг юм. Террорист маш өөртөө итгэлгүй байдалтай тул түүнийг шинэ төрхөөрөө орхих нь бараг боломжгүй. Эдгээр нэр төрийн төлөө хөөцөлдөгч хүмүүс хатуу дэглэмтэй бүлгүүдийн гишүүн болж байна. Ийм бүлэгт элссэнээр тэд авторитаризмаас айдаг. Түүгээр ч барахгүй аливаа бүлэглэлийн дайралтыг тэд өөрсдөө дайрч байна гэж ойлгодог. Иймээс гаднаас ямар нэгэн үйлдэл хийх нь бүлгийн эв нэгдлийг эрс нэмэгдүүлдэг. Террорист нь байгууллагынхаа үзэл суртлыг дуурайж эхлэхэд тэрээр үнэмлэхүй үг хэллэгийг өөртөө шингээдэг. Түүний хувьд дэлхий өөрийн хар, цагаан, зөв ба буруу гэсэн хуваагдал бүхий өөрийн болон дайснуудад хуваагдаж, ямар ч сүүдэр, хоёрдмол байдал, эргэлзээ төрүүлдэг. Энэ сэтгэлгээ нь террористуудыг хэнийг ч тооцдоггүй олон нийт, дайсан руу дайрахыг уриалдаг. Дайсныг байгууллагын удирдлагууд тодорхойлдог. Тэд террор ажиллагааны зорилтууд болон террорист үйлдлийн дайралт явуулах арга, тактикийг нарийвчлан гаргадаг байна.

Терроризмд өртөмтгий хүмүүс энэ төрлийн зан чанарт хамаарагддаг бөгөөд энэ нь сэтгэлийн хөдлөлийн үндэслэлээр тодорхойлогддог, ойлголтынхоо хэрээр бодит байдалд шууд хариу үйлдэл үзүүлдэг; үнэлгээнд туйлшрах хандлага, хүлцэл бага байх, өөрийгөө хянах чадвар хангалтгүй болдог. Ийм хүмүүс хүчирхийллийн үзэл санаанд амархан дасдаг.

Терроризм судлаач Ольшанский Д.В. террористуудын сэдлийг дараах байдлаар тодорхойлсон[184]:

- өөрийгөө батлах;

- өөрийгөө таних;

- залуусын дэврүүн сэтгэл ба баатарлаг байдал, тэдний үйл ажиллагаанд онцгой ач холбогдол өгөх;

- тусгаарлалт, сөргөлдөх үзлийг даван туулах (оппортунизм, ерөнхий үзэл бодлыг чанд баримтлахгүй байх), хувьчлал, стандартчилал, ахиу байдал;

- амин хувиа хичээх гэх мэтчилэн авч үзжээ.

Түүнчлэн Ольшанский Д.В. үзэж байгаагаар "үзэл суртлын абсолютизм", цорын ганц, хамгийн өндөр, эцсийн үнэнийг эзэмших "төмөр" итгэл үнэмшил, ард түмнийхээ, бүлгийн эсвэл бүр хүн төрөлхтний өвөрмөц "авралын жор" нь террорист дайчдын үндсэн сэдэлд тооцож байна.

Юуны өмнө бусдыг давамгайлах, дарах, хянах хүсэл эрмэлзэлтэй байнга холбоотой байдаг өөртөө итгэх итгэл нь чухал хэрэгцээ шаардлагыг хангадаг байна. Ийм хэрэгцээ нь заримдаа сэтгэлийн түгшүүртэй холбоотой байдаг бөгөөд энэ нь нийгмийн орчинд давамгайлах тохиолдолд илэрдэг бөгөөд харгис хэрцгий хүч, хүсээгүй зүйлийг устгах замаар ноёрхлыг бий болгодог. Энэ сэдэл нь аливаа террорист зан үйлд байдаг, ялангуяа бусдыг дарах нь ихэнхдээ хувийн аюулгүй байдлыг хангадаг гэж үздэг.

Хүний золиослол, хувь хүмүүсийг үхэлд хүргэх, устгахад хүргэх сэдэл нь амьд явахад хүргэх хүчин зүйлтэй адил хүчтэй байдаг. Террорист хүний сэтгэл зүйн болон сэтгэцийн шинж чанарууд нь түүний үхэлтэй шууд холбоотой байдаг нь нэг талаас түүний сэтгэл зүй, түүнд багтсан үйлдэл, үйл явдалд нөлөөлдөг, нөгөө талаас түүний хувийн үхэхийн тулд гаргаж байгаа шинж чанар.

Террорист ажиллагаа өдөөж болох өөр нэг шалтгаан бол амиа хорлохыг хүсэх явдал юм, яагаад гэвэл амиа золиослогч этгээдэд ердийн зүйл биш юм. Энэхүү сэдэл нь дараах хувилбараар хэрэгжиж болно. Үүнд:

1. тухайн субьект нь ямар нэгэн гэмт хэрэг үйлдэх үедээ үхлийн төлөө хичээдэг бөгөөд үүний төлөө бүх зүйлийг хийж, урьд өмнө нь хаягдсан байсан өөрөө өөртөө анхаарлыг татахын тулд үхлийг хүсч магадгүй юм;

2. хүн заавал үхэх болно гэдгээ бүрэн ойлгодог боловч "өндөр" санаа бодлын төлөө өөрийгөө санаатайгаар золиосолдог. Хувь хүн түүний хувьд маш эрсдэлтэй террорист гэмт хэрэгт ордог боловч түүний ухамсар нь амиа хорлох гэсэн одоо байгаа сэдлийг хамардаггүй.

[184] *Ольшанский Д.В. Терроризмын сэтгэл зүй. Нийтлэгч: Петр, 2002 он., - 215 х;*

Террористуудын дунд мөрийтэй тоглоомын сэдлээр хөтлөгдсөн хүмүүс цөөнгүй байдаг. Тэдний хувьд террорист халдлагад оролцох нь тоглоом, болзошгүй нөхцөл байдал, дайсан, хувь тавилан, үхэл хэмээн үздэг. Энэ нь ялангуяа залуу хүмүүст, түүний дотор өсвөр насныханд хамаатай. Тэд энэ нөхцөл байдлыг тэдний амьдралд хөндлөнгөөс оролцож болох сонирхолтой тоглоом гэж ойлгодог. Гэхдээ энэ нь олон хүнийг айлгахгүй, тэдний хувьд амьдрал бол зүгээр л "сэтгэл хөдөлгөм" тоглоомонд оролцсны төлбөр хэмээх ойлголт өгдөг байна.

Террористуудын сэтгэл зүйн онцлог, террорист үйл ажиллагаанд хүргэдэг шалтгааныг судласан шинжээчдийн үзсэнээр орчин үеийн террористуудын удирдан чиглүүлдэг хэд хэдэн тэргүүлэх сэдлийг ялгаж тогтоосон байна. Тухайлбал:

1. өөртөө болон тухайн нийгмийн харьяалагдах бүлэгт гомдох;

2. террорист ажиллагаа явуулах замаар өөрийгөө батлан даалтад гаргах, бусдыг дарах;

3. түүний зөв гэдэгт зуун хувь итгэх; "миний" санаа, үзэл суртал, зорилго бол цорын ганц жинхэнэ зүйл бөгөөд "Би" гэдэгт ямар ч аргаар хүрэх ёстой гэсэн хийсвэр ухамсар;

4. "өөрийгөө өрөвдөх хэрэггүй", бусдыг золиослох хүсэл, эрмэлзлэл зэрэг болно.

Ихэнх терроризм судлаачид дээрх сэдэлтэй нэг буюу өөр чиглэлээр санал нийлж байна.

Гэсэн хэдий ч бүх сэдэл нь дундаж хүнийг терроризмын зам руу түлхэж чадахгүй. Эхний болон гуравдах сэдлийг "болзолгүй" шалтгаантай холбож үзэж болохоор байна. Эдгээр шалтгааны улмаас террорист болсон хүмүүс хамгийн аюултай, хэт шүтэн бишрэгчид болдог байна. Харин хоёр, дөрөв дэх сэдэл нь хүмүүсийг террорист бүлэглэл руу нэгдэхэд түлхэц өгөх урьдчилсан нөхцөл болохооргүй байгаа юм. Эдгээр сэдэл нь хүрээлэн буй хүмүүс, нийгэмд зохих сөрөг нөхцөлийг бий болговол зөвхөн сөрөг үүрэг гүйцэтгэдэг. Эндээс харахад, хүн террорист болж болно, үгүй ч байж болно.

Ганц террорист харьцангуй ховор байдаг, ихэвчлэн террорист удирдагчийн үүрэг маш чухал бүлэгт нэгдсэн байдаг. Террорист бүлэглэл нь найдваргүй, дорд үзэлтэй хүмүүсээс гадна ухаалаг, хүчтэй бодолтой, өөртөө итгэлтэй хүмүүсээс бүрдэж болно. Урьд нь бүлэгт танигдаж, сэтгэл зүйн хоргодохыг эрэлхийлж, сүүлийнх нь тэд удирдагч болох юм бол бусдыг давамгайлах, хянах хандлагатай байдаг.

Бүлэг нь дөнгөж шинээр байгуулагдаж байх үед дайсны дүр төрхийг бий болгож, дайсан байх ёстой түүнийг хэн нэгэн хүн илэрүүлэн бут цохиж улмаар хуримтлагдсан бүх хор хөнөөлийг гаргаж өгдөг. Хэрэв дайсан байхгүй байсан бол түрэмгийллийг бусад өөр төрлийн гэмт бүлэглэлд чиглүүлэх болно.

Дотоод бүлгийн эв нэгдэл, хүн бүрийн нийтлэг эрх ашигт захирагдах явдлыг хангах чухал арга бол нийгэм, төрийн эрх мэдэл, нийгмийн

бүлэглэл, өөр шашин, өөр үндэстэн гэх мэт хүнд харгис хэрцгий, зальхай, бэлэн дайсны дүр төрхийг бий болгох явдал юм. Эдгээр санаанууд нь ялангуяа хариу үйлдэл нь буруу, ёс суртахуунгүй үйлдлээс бус харин амьдралын алдаа, бүтэлгүй байдлаа үргэлж мэдэрдэг хүмүүс байсан бөгөөд харин хүн бүр тэдэнд шударга бус байсан тул ямар ч шалтгаангүйгээр хавчигдан гадуурахадсан байдаг. Нийгмийн үзэн ядалт (эрх мэдэл, дэг журам, нийгмийн бүлэг гэх мэт) нь тэднийг хамт байлгах болно.

Террорист байгууллагууд террорист халдлагын хамгийн аймшигтай хэлбэр болох амиа золиослогчдыг ашиглахыг ихэвчлэн зорилгоо болгодог.

Террорист бүлгүүдийн гишүүд маш их мэдрэмтхий шинжтэй, маш их зантай өндөр түвшиний түрэмгийлэгчид. Тэд сэтгэлийн хөөрлөөр эрэлхийлэх хандлагатай байдаг бөгөөд өдөр тутмын амьдрал тэдэнд утгагүй, уйтгартай, хамгийн чухал нь утгагүй санагдаж, эрсдэл, аюулыг хүсэмжлэдэг. Террорист бүлэглэлүүд нь таних, харьяалагдах мэдрэмжийг хангахад тусалдаг. Эдгээр бүлгүүдэд хүмүүс бусад хүмүүсийн хүлээн зөвшөөрлийг өндөр түвшинд мэдэрдэг. Эдгээр бүлэглэлүүд хаалттай бөгөөд тэдгээрт орох нь бусад хүмүүсийн амьдрал, түүний дотор хувийн хяналтыг бүрэн хянах эрхийг хүлээн зөвшөөрнө гэсэн үг юм.

Сүүлийн жилүүдэд дэлхий даяар болон ОХУ-д үйлдсэн террорист үйлдэлд дүн шинжилгээ, үнэлгээ хийж үзэхэд, хамгийн түгээмэл дараах төрлийн террорист болох “амиа золиослогч” -ыг тодорхойлж болохоор байна.

Нэгд, Террорист “Зомби”. Zombification (сэтгэцийн програмчлал) гэдэг нь тухайн хүнийг сэтгэцийн боловсруулалт болох гипноз, сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэх замаар террорист үйлдэл хийхээр програмчлах гэсэн үг юм. Тиймээс алан хядах ажиллагаа нь юу хийж байгаагаа мэдэхгүй байгаа этгээдээр үйлдэгддэг, өөр хүн түүний зан байдлыг хянадаг. Энэ тохиолдолд сэтгэцийн эрүүл хүмүүс болон янз бүрийн түвшинд сэтгэцийн эмгэгтэй хүмүүс хоёулаа “зомби” болох;

Хоёрт, Террорист “өшөө авагч”. Эдгээр террористуудын дунд нөхөр, хүүхэд, ойр дотны хүмүүсээ “алдсан” олон эмэгтэйчүүд байдаг. Гэр бүлийнхэн нийгмийн хүрээллээс гарч, үзэл суртлын болон сэтгэцэд нөлөөт хүчтэй эмчилгээнд хамрагдсан “шахидууд” (“бэлэвсэн хар эмэгтэй”, “аллахын сүйт бүсгүй”) суурийг бүрдүүлдэг. Итгэлийн төлөө өөрийгөө золиосолж өшөө авах ажлыг төрийн эрх мэдлийн обьект руу эсвэл тодорхой хүн рүү чиглүүлэх;

Гуравт, Террорист «эх оронч» («дайчин», «итгэлийн төлөө»). Энэ бол террорист дайчдын хамгийн түгээмэл төрөл юм. Туршлагатай багш нарын удирдлага, нөлөөн дор өөр өөр үндэстний, өөр өөр үндэстний төлөөлөгчийн дүрээр түүний итгэл үнэмшил, үзэл бодол, дайсны дүр төрхөөрөө хэт бишрэн шүтэх итгэл үнэмшил бий болдог. Тэрээр алан хядах ажиллагаа үйлдсэнийг «үл итгэгчид»-ийн эсрэг «жихад»(хичээнгүй байдал, бурханы хүслийг биелүүлэх), ард түмнийхээ итгэл үнэмшил эсвэл чөлөөлөлтийн шинж тэмдэг гэж үздэг. Тэрбээр алан хядах ажиллагаа

үйлдэж, хүмүүсийг алж, эд хөрөнгийг сүйтгэж байгаагаа ухаарч, ийм үр дагаврыг хүсч, тэрбээр гэмт хэрэгт шууд чиглэж, түүний зөв гэдэгт итгэл үнэмшилтэйгээр явах;

Дөрөвт, Террорист «мөнгөний төлөө». Тэрбээр хувиа хичээсэн шалтгаанаар террорист халдлага хийхээр санхүүгийн бүрэн хамааралтай байгаа хүмүүсийн даалгаврыг биелүүлэх, эсвэл маш хүнд байдалд байгаа гэр бүлээ санхүүгийн хувьд туслахыг хичээж, террорист нь үзэл суртлын хомсдол, бусдад хайхрамжгүй ханддаг шинж чанартай байх;

Тавд, Террорист «албадлага». Хүн террорист ажиллагаа явуулахдаа гэр бүлийнхээ гишүүдийг барьцаалж, хүнийг гутаан доромжилсон аливаа мэдээлэл дэлгэнэ гэж сүрдүүлэх эсвэл гэмт хэрэг үйлдсэнийхээ төлөө Шариатын шүүхийн шийдвэрээр хүн албадлагын аргаар Бурханы өмнө гэм буруугаа цагаатгах;

Зургаа. Террорист «маньяк»(хуурамч санаатай). Ихэнх тохиолдолд энэ нь янз бүрийн сэтгэцийн эмгэгээс болж зовж шаналдаг ганцаараа террорист юм. Түүний психопатологийн шинж чанар, хийсвэр үзэл бодлын үүднээс тэрээр ямар ч хамаагүй нэр алдар («мегаломания»), түүнийг дагаж буй «дайснуудыг» устгах эсвэл улс орон, дэлхий, ертөнцийг дахин бүтээхийг хүсдэг. Ийм террористын үзэл санаа, ухамсарыг террорист байгууллага удирдаж байгаа тохиолдолд онцгой аюултай болно.

«Амиа золиослогч» террористууд олон төрлийн байдаг ч тэдгээр нь амиа хорлох бодол, сэтгэлийн хөдлөлөөс үүдэлтэй байнгын сэтгэл зүйн сэтгэлийн дарамтанд байх, «тусгай алба»-ын гарт амьд үлдэх айдас нь сэтгэлийн түгшүүрийг үүсгэдэг (сэтгэлийн түгшүүр, сэжиглэл, эргэн тойрныхоо хүмүүст үл итгэх байдал улам бүр нэмэгддэг) нийтлэг зүйлтэй байна.

Сэтгэл зүйн терроризм бол шинэ үзэгдэл биш, харин түүнээс өөрийгөө хэрхэн хамгаалах асуудал чухал.

Нэгд, одоо эрсдэлд өртөж байгаа эсэхийг тодорхойлох явдал бөгөөд төгсгөлд нь сэтгэцийн террористууд хүн бүрийг сонгодоггүй, тэд дүрмээр бол хүний сэтгэл судлалын сайн мэргэжилтнүүд. Тэд өөрсдийнхөө залруулгыг тодорхой зорилтод бүлэгт чиглүүлж, сэтгэл зүйн терроризмын төгс хохирогч болоход чиглүүлдэг байна.

Хоёрт, хэрэв та эрсдэлтэй байгаа бол залилангаас хэрхэн яаж зайлсхийхэд анхаарч «Хандивлагчид»-тай харьцахаас зайлсхий.

Гуравт, хэрэв тантай ямар нэгэн байдлаар холбоо барьж, тусламж санал болгосон бол өөртөө шийдвэр гаргах цаг гаргаж, ийм айдсын нөлөөнд өртөөгүй чухал хүмүүстэй зөвлөлдөх боломжийг олох шаардлагатай болно.

Эшлэл авсан, ашигласан материалын жагсаалт:

1. *Антонян Ю. М.* “Особо опасный преступник: тоталитарные преступники, серийные убийцы, террористы, бытовые убийцы, сексуальные маньяки, наемные убийцы”. М: Проспект, 2011 г.- 310 стр.-ISBN 978-5-392-01941-0;

2. 2. Витюк В.В. “Терроризм в современном мире: истоки, сущность, направления и угрозы”. -М: Институт социологии. РАН, 2003 г. - 358 стр. ISBN 5-89697-070-6;
3. 3.Ольшанский Д.В.“Основы политической психологии”.Екатеринбург: -2001 г.- 496 стр., -ISBN 5-88687-098-9;
4. 4. Пирожков В.Ф.” Криминальная психология”. - М: 2001 г. - 704 стр., - ISBN 5-86894-492-5;
5. 5. Ольшанский Д.В. Терроризмын сэтгэл зүй. Нийтлэгч: Петр, 2002 он, - 215 х;
6. 6. *Жаринов К.В.*Терроризм ба террористууд. Минск: 1999 он, -606 х;
7. 7. Асямов С.В. Орчин үеийн терроризмын сэтгэл зүй. http: // yurpsy. fatal. ru/files/stat /8. htm;
8. 8. Кудрявцев В.Н. Олон улсын терроризмтой тэмцэх асуудал. М: 2004 он;
9. 9. Ефиров С.А. Терроризм: сэтгэл зүйн үндэс ба хууль эрх зүйн үнэлгээ. (Төр ба хууль эмхэтгэл). 1995 он, № 9. -78 х;

ИХ СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ШИНЭЧЛЭЛ БА СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТИЙН АСУУДАЛД

Д. Болод
ҮБХИС-ийн Гадаад хэлний сургалтын төвийн багш

Key words: *University, University of the research work, Reform, Learning, Research, Student, Professor and Science, Lesson programme, Leraning environment, Financing*

Summary: Education on the modern University based on the results of the investigation. Results of the investigation can be accelerated to development of Mongolia. The investigation of the University will be fully suited to the development aim of Mongolia.

ИХ СУРГУУЛЬ - Их сургууль нь *шинжлэх ухааны хэд хэдэн чиглэлээр суурь ба хавсарга судалгаа явуулдаг, бакалавр, магистр, докторын сургалт эрхэлдэг, цйлдвэр,цйлчилгээний бааз лаборатори бцхий эрдэм шинжилгээ-сургалт-цйлдвэрлэлийн буюу эрдэм шинжилгээ-сургалтын байгууллага байна.*[185]

Дэлхийн их сургуулиудын чансаагаар 2015 оны байдлаар МУИС 16000-д жагсжээ. Ази Номхон далайн орнуудын төрийн өмчийн 34 их сургууль МУИС-ийн дипломыг хүлээн зөвшөөрдөг. Их Британийн "Time Higher Education" сэтгүүлийн газраас 2015 онд дэлхийн шилдэг 200 их сургуулийн жагсаахад Калифорнийн Технологийн Их Сургууль дөрөвдөх удаагаа тэргүүлж, шилдгээр тодорсон бол хоёрт Харвардын Их Сургууль оржээ. Дэлхийн шилдэг Их сургуулийн жагсаалтад Азийн 5 их сургууль орсноос 3 нь Японых аж. Энэ жагсаалтад Америкийн 74 Их Сургууль орсноос 7 нь эхний 10–т бичигдсэн байна. Энэхүү шалгаруулалтад шинжлэх ухааны салбарынх нь нэр хүнд, судалгааны чанар, их сургуулийн гаргадаг шинжлэх ухааны сэтгүүлээс нь эш татсан байдал, санхүүжилт зэргийг гол үзүүлэлт болгодог.

Энд сонирхуулахад 2007 онд Их Британи Кембрижийн Их Сургуулийн дэргэдэх судалгааны хүрээлэнгээс зохион байгуулсан Дэлхийн шилдэг 100-н их сургуулиудын захирлуудын чансаагаар манай ҮБХИС-ийн захирал доктор профессор, хошууч генерал Н.Жалбажав шалгарч байсан сайхан амжилт бидэнд байна. Өөрөөр хэлбэл манай сургуулийн сургалт, удирдлагын үйл ажиллагааг дэлхий харж байдгийн бодит жишээ гэж үзэж болох юм.

[185] *Дээд боловсролын хуулийн 4.2*

2017-2018 оны Global Competitiveness Report (*Даяаршлын өрсөлдөөний тайлан*) -д Монгол улс дээд боловсролын чанараар дэлхийн 137 орноос 110-д, авьяас чадварыг тогтоон барих багтаамжаар 127-д, шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн чанараар 107-д жагсжээ.[186]

Нэг сая хүнд ноогдох шинжлэх ухааны бүтээлийн тоогоор нь тухайн улс орны хөгжлийг хэмждэг. Их сургуулийн багшийн чанарыг докторын зэрэгтэй багшийн тоогоор биш, бичсэн бүтээл (өгүүлэл)-ийн чанараар нь үнэлдэг нь дээрх байдлаас тодорхой харагдаж байна.

Шинжлэх ухаанд туршлага гэдэг олон жил ажилласан гэдэг үг огт биш. Хамгийн гол нь а."судалгааны сайн өгүүлэл" бичсэн, б. "чансаатай бүтээл"-тэй байх нь маш чухал. Их сургуулийн багш бүтээлийнхээ чансаагаар л бусдад хүлээн зөвшөөрөгдөнө. Бүтээлийн чансаа нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нээлт, патент, олон улсын хөндлөнгийн үнэлгээ, IF бүхий судалгааны сэтгүүлд өгүүлэл хэвлүүлж, шинжлэх ухааны эргэлтэд оруулсан, эшлэл авсан байдлаар л хэмжигдэнэ.

Олон улсын нэр хүндтэй мэргэжлийн сэтгүүлд хэвлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүлэл нь тухайн улсынхаа нэр хүндийн асуудал бөгөөд энэ нь дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын оюуны өрсөлдөөний жинхэнэ талбар болдог ажээ. Дэлхийн шинжлэх ухааны охь болсон мэдээллийн санд өөрийн мэдээллээ оруулах нь тухайн орны нэр төрийн асуудал. Учир нь уг бүтээл нь тухайн улсынхаа оюуны чадамжийг илэрхийлэгч хүчин зүйл болохоос гадна маш олон тооны мэргэжлийн хүмүүст хүрдэг тул тухайн орныхоо нэр хүндийн асуудал болдог аж.

Харин манай сургуулийн хувьд энэ боломж их байгаа боловч манай багш нар энэ боломжийг ашиглаж чадахгүй байна уу даа гэсэн сэтгэгдэл төрж байна.

БХЯ-ны ШУТЗ, БХЭШХ-ээс эрхлэн гаргадаг "Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал" сэтгүүл нь улсын хэмжээний төрөлжсөн, шинжлэх ухааны бүтээл нийтэлдэг, Монгол Улсын төрийн захиргааны болон Шинжлэх ухааны академиар хүлээн зөвшөөрөгдсөн тогтмол хэвлэл юм. Харин бид "Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал" сэтгүүлийг олон улсад хүлээн зөвшөөрүүлэх, DOI дугаартай, Scopus-т бүртгэлтэй болгож чадвал гадна мөнгө төлж хэвлүүлэх биш өөрсдөө мөнгө олгох боломж байна. Их сургуулийн хувьд багш судалгааны ажилд оролцох гол хэлбэр нь эрдэм шинжилгээний өгүүлэл бичих, тиймээс их сургуулийн багшийн үндсэн ачааллын хэдэн хувийг судалгааны ажилд зориулснаар нь үнэлэх нь хамгийн шударга алхам. Бидний гол зорилго бол шинжлэх ухааны хувьд тэдэнтэй өрсөлдөх биш эхний ээлжинд зэрэгцэж очиход хэр хугацаа хэрэгтэй вэ гэдэгт анхаарч ажиллах нь чухал. Бид хаашаа явж байна түүндээ зориулж боловсон хүчнээ бэлтгэнэ.

Бид дээд боловсролын салбарт олон улсын стандарт, жишгийг баримталж байж л их сургуулийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж чадна. Олон улсын стандартыг монголын нөхцөлд тохируулж байна гэдэг нэрийн

[186] *Өдрийн сонин 2019.12.12 №252 Ц. Дэмбэрэл Судалгааны их сургууль ба дөрвөн шинэчлэл*

дор өөрчлөх юм бол нэр төдий ажил болно.[187]

Үгийн төөрөгдөл үзлийн төөрөгдөлд л хүргэдэг. Бүх юм нэрнээсээ шалтгаалаад байхгүй ч нэрнээсээ эхэлдэг нь үнэн. Эх хэлний зөв нэршил шинжлэх ухаанд суралцахуйн суурь болно. Аливаа шинжлэх ухааны мэдлэг үнэ цэнтэй байх ёстой. Жинхэнэ үнэ цэнтэй мэдлэг л үнэн зөв, огтхон ч алдаа мадаггүй бичигдсэн байдаг. Тиймээс үнэн зөв байснаараа шинжлэх ухааны үнэ цэнийг харуулдаг.

Шинжлэх ухаанд нэр томьёо нь хэлж таних, хэлний тэмдгээр зуучлан агуулгад нэвтрэх сэтгэхүйн цйл ажиллагааны илэрхийлэл болдог. Энэ тухайд:

НЭГ. ҮНДЭСНИЙ Батлан Хамгаалахын Их Сургуулийнхаа нэрийг найруулгын хувьд "Үндэстний Батлан Хамгаалахын Их Сургууль" гэх нь зүйд нийцнэ. Энэ нь Монгол Улсын Батлан Хамгаалахын Их Сургууль л гэсэн үг.

А. ҮНДЭС гэдэг үг нь: гарал, угсаа, суурь, язгуур гэсэн л ойлголт. /Яс үндэс, модны үндэс, үгийн үндэс гэх үгэнд л хэрэглэнэ Англи хэлэнд/ base, basis,backbone, essential, foundation, fundamental...гэж ялгаатай орчуулдаг.

Б. ҮНДЭСТЭН: Нэг хэл, соёл, газар нутагтай, олон ястны нэгдэл. Энэ үгийг англиар "nation, nationality... " гэж ялгадаг.

ТАЙЛБАР: УБХИС (*Засгийн газрын 2016 оны 156 дугаар тогтоолоор монгол үндэстэнтэй огт хамааралгүй, ямар нэгэн зүйлийн үндэс, угсаа, гарал үүсэл, язгуурын ИХ сургууль мэт болж таарав.* Жишээлбэл: Мал сүрэг бол үндэс (үндэстэн)-ний баялаг, Үндсэн хуулийн 5-ийн 5, үндэс (ҮНДЭСТЭН)-ний аюулгүй байдал, 11-ийн 1) гэх мэтийн алдаа манай улсын үндсэн хуульд байх нь ерийн үзэгдэл. *ҮНДЭСТЭН- ийг баталдаг гурван шалгуур бий. Нэгд нь бусдаас ялгарах а. хэл, бичиг үсэг, б. зан заншил, в. ертөнцийг үзэх үзэл.*

ХОЁР: *Дээрх санааг тур орхин өгүүллийнхээ үндсэн агуулгатайгаа холбон УБХИС-ийнхаа* Цэргийн нэгдсэн ДЭЭД сургуулийн эрхэм зорилгыг үзвэл: "*... судалгааны их сургууль болоход оршино*" гэжээ. Миний хувьд ЦНДС-ийг УБХИС-ийн үндсэн сургууль гэж ойлгодог. Энэхүү нэр цаашид судалгааны их сургууль болох боломжийг нэгмөсөн үгүйсгэсэн нэршил мэт санагдана. (*Их сургууль шинэ мэдлэг бүтээж, дээд сургууль мэдлэгийг түгээдэг. Их дээд сургуулийн гол ялгаа нь ердөө энэ. Шинэ мэдлэг бүтээхгүйгээр судалгааны их сургууль болно гэвэл ёстой цлгэр. Тиймээс мэдлэг түгээх үндсэн цүрэгтэй дээд сургуулийн багшид "шинэ мэдлэг бүтээ" гэж шаардах нь орчин цагийн шаардлага, эрх зүй, статус, их сургуулийн зорилтод хэр нийцэх бол...*). Хэрвээ ШУТИС-ийн Холбоо мэдээллийн сургуулийг бүтцийн шинэ өөрчлөлтөөр Холбоо мэдээллийн ДЭЭД сургууль болгон өөрчилсөн гэж үзвэл асуудал цаашид яаж өрнөх бол...

[187] *Докторын зэргийн боловсролын тухайд Б. Чулуундорж ХУИС Өдрийн сонин 2017.11.23 №251*

ГУРАВ: ҮБХИС-ийн Аюулгүй байдлын ДЭЭД сургууль нэрийг монгол хэлний тайлбар тольд тайлбарласнаар үг бүрийн утгаар нь ухаж үзвэл, үндэстний язгуур эрх ашиг, сонирхол, гадаад, дотоод таатай нөхцөл, аюулгүй байдал дээд зэргээр баталгаатай хангагдсан, айх аюул, айдас түгшүүр, сэтгэл зовох юмгүй, амар амгалан бурхны шажны номлолоор бол шамбалын орон маягтай ч юм уу гэж мөхөс би мунхаглаад байх юм) Ингэж *буруу цг хэрэглэсээр байгаа нь бид бүтэн сэтгэж чадахгүй л байна гэсэн цг. Бид буруу ярьж зөв ойлгодог гэж бүдүүлгээ цагаатгадаг байсан бол одоо бүр анхнаасаа буруу биччихээд зөв ойлгуулна гэж муйхарлаж байгаагийн тодорхой жишээ энэ биш гэж цү...*)

СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛИЙН ТАЛААР ӨГҮҮЛЬЕ – Аливаа их сургуулийн өөрийнх нь үндсэн үүрэг бол судалгаа шинжилгээний ажил. Манай ихэнх их сургуульд судалгаа шинжилгээний ажил нь орхигдсон, ахисан түвшний бакалаврын сургалт зонхилсон хэвээр байна. Судалгааны их сургуулийн олон улсын жишгээс үзвэл а. *дэлхий нийтийн шинжлэх ухааны чиг хандлага*, б. *судалгааны тэргүүлэх чиглэл, в. тухайн улсын өрсөлдөх чадварт үндэслэгдсэн төгсөлтийн сургалтын хөтөлбөр* зэрэг болно. Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлж судалгаа хийдэг а. шилдэг эрдэмтдээс бүрдсэн баг, б. судалгааны орчин в. судалгаа хийх хөрөнгө мөнгө гурвыг зөв шийдэх хэрэгтэй. Ингэж чадвал судалгаанд суурилсан их сургууль болж хөгжих боломж бүрдэнэ. Бас судалгаа шинжилгээний ажил хийх сонирхолтой, оюуны өндөр чадамжтай, шилдэг залуусыг сонгон суралцуулах нь чухал. Өөрөөр хэлбэл элсэлтийн босго өндөр байх ёстой. Зөвхөн мэдлэгээс гадна ур чадвар, сэтгэл чухал. Ж. Цолмон "АШУУИС судалгааны их сургууль болно"[188]

Швед улс Нобелийн шагналыг санаачилж, дэлхийн сор болсон эрдэмтдийн бүтээлүүдийг ямар ч зардалгүй авч чадаж байна. Манай ШУА, Шведийн ШУА-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, боловсрол шинжлэх ухаандаа шинэчлэл хийх хэрэгтэй. Их сургуулийг судалгааны их сургууль болгох материал тэнд л байгаа. Тиймээс судалгааны их сургууль бол эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэж, элитийн сургалт явуулдаг байгууллага. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тэргүүлэх эрдэмтэд ажиллаж, хамгийн чадварлаг оюутнууд элсэн суралцдаг.

Профессор багш нар нь олон улсын түвшний онолын судалгаа хийхийн зэрэгцээ нийгмийн хөгжлийг тодорхойлох технологийн болон хавсарга судалгаа хийдэг бол оюунтан нь бүтээлчээр сэтгэж, шүүмжлэл өрнүүлж, өөрийгөө хөгжүүлэх арга барил, хөрвөх, өрсөлдөх чадварын аль алиныг эзэмшсэн байдаг. Энэ бол судалгааны их сургуулийн гол ялгаа.

СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛИЙН ПРОФЕССОР- Профессор нь улс орныхоо хөгжлийн хурдасгуур, ард түмнээ соён гэгээрүүлэгч, эрдэм мэдлэгийн оньсыг тайлагч, оюун ухааныг тэлэгч, амьд ном, үндэстний "ХЭЛ СЭТГЭЛГЭЭ"-ний сор...Профессор нь олон жилийн эрдмийн ажлын үнэлгээ... Энэ нь бусдаас илүү өөрийгөө хөгжүүлж, бусдаас илүү бодож СЭТГЭН, шинжлэн судална гэсэн үг. Профессор гэж насаараа СУРЧ, СЭТГЭЖ, ЗОХИОЖ, ХЭВЛЭН НИЙТЭЛЖ, ТҮГЭЭН

[188] *Өдрийн сонин 2019.04.22 № 083*

ДЭЛГЭРҮҮЛЭХИЙН НЭР. *Өмнөд монголд докторын жолоодогч хэмээн нэрлээд хэвшчихсэн.* (*Газраас сансарт хүртэл бодож, галактикаасаа гартал сэтгэдэггүй юм гэхэд цндэстнийхээ хэмжээнээс давж, дэлхийн цараатай, дэлхийн энтэй сэтгэхийн нэр*) Өөрөөр хэлбэл номын эрдэм, хүний эрдэм хоёрыг хамтад нь өв тэгш (*нэвтэрхий*) эзэмшсэн багштан. Мэдлэг бүтээж, түгээхийн тулд мөнхийн эрэл хайгуул, хөдөлгөөнд байдаг төгсгөлгүй үргэлжлэх үйл явц. Зүйрлэвэл яг л төгсгөлгүй үргэлжлэх түмэн насан хээ шиг... Мэргэжлийн мэдлэгээрээ шилдэг нь учир профессорын бүтээл улс үндэстнийхээ хэмжээнээс давж, эрдэм шинжилгээ, лавлагааны ач холбогдлоороо олон улсад ч, судалгааны түвшинд ч бүрэн хүлээн зөвшөөрөгдсөн байдаг. Тиймээс профессор бол судалгааны их сургуулийн оюуны цөм нь буюу "сэтгэдэг тархи" нь "мозг орган мышление" юм.

СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧ НЬ ОЮУНТАН НЬ... Оюу бол зэс дагаж явдаг хагас эрдэнийн чулуу... Эмийн номд "цус цэвэрлэж, цусны эргэлтийг сайжруулдаг" гэх нь бий. Чухам тийм л увдистай болохоор есөн эрдэнэд орсон биз. Хүзүү хоолой, гар хуруундаа баахан ногоон цэнхэр өнгөтэй хагас эрдэнийн чулуу зүүсэн хүнийг л ОЮУТАН (багштан, ламтан, эрдэмтэн хөрөнгөтөн гээд бодоод үз) гэмээр. Түүнээс биш судалгааны их сургуульд сурч, оюун билгээ хурцлах гэж эрдэм ухаанд шамдаж яваа хүнийг оюу цуглуулж панз үсэргэн, ашиг харж яваа хүнтэй яаж зүйрлэж болох вэ? ...

Орчин үеийн их сургуулиудад хоёр томоохон өөрчлөлт гарч байна. Нэгдүгээрт: Дээд боловсролын хүртээмж нэмэгдэж нийгэмд үйлчлэх хүрээ нь тэлсэн. Хуучин цагт ЕБС төгсөгчдийн 10 (элитийн боловсрол) хүрэхгүй хувь нь их дээд сургуульд элсдэг байсан бол эдүгээ бараг 90 (массын боловсрол) хувь нь хувь, хувьсгалын аль нэгэн сургуульд элсэж байна. Хоёрдугаарт: Нийгмийн янз бүрийн хэрэгцээг хангах өөр өөр зорилго бүхий их сургуулийн олон хэлбэр бий болов. Эдгээр өөрчлөлтийн нөлөөгөөр орчин үеийн их сургуулиуд судалгааны ба сургалтын гэсэн хоёр чиглэлээр хөгжиж байна.

Дэлхийн түвшний судалгааны их сургуулийг буй болгоход *оюуны өндөр чадамжтай багш судлаач ба оюунтан, санхүүгийн хангалттай нөөц, академик эрх чөлөө бүхий улс төрөөс цл хамаарах зохистой засаглал* зэрэг суурь хүчин зүйл хамгаас чухал.

Судалгааны их сургууль байгуулж буй орнуудын туршлагаас үзвэл шинжлэх ухаан, дээд боловсролын удирдлагын орчныг эрүүлжүүлэх дөрвөн шинэчлэлийг хэрэгжүүлж байна.

1. Судалгааны хууль зүйн үндсийг шинэчлэх (*Судалгааны их сургууль болох статусыг УИХ-ын 2020 оны намрын чуулганаар хэлэлцэнэ*)
2. Санхүүжилтийн зарчмуудыг шинэчлэх (*Их сургуулийнхаа сургалтын зардлын дийлэнх хэсгийг судалгааны ажлын цр дүнгээсээ олдог*)
3. Байгууллагын бүтцийг шинэчлэх
4. Шинжлэх ухааны судалгаа ба их сургуулиудыг нэгтгэх

Орчин үед эксперт (шинжээч)-гүй судалгаа бол судалгаа биш, дэмий л хөрөнгө, цаас, цаг үрсэн ажил. Экспертгүй газар эрдэмтэд нь тухайн байгууллагынхаа явцуу эрх ашигт захирагдсан хөлсний ажилтан мэт болж, зар сурталчилгааны хэрэгсэл төдий л болж хувирдаг. Төр өгсөн захиалгынхаа дагуу өөртөө тохирсон дүгнэлтийг тэднээр хүчээр гаргуулдаг. Өөр дүгнэлт гаргавал хохирдог. Ийм нөхцөлд шинжлэх ухаан нь шинжлэх ухаан биш эрдэмтэд нь эрдэмтэн биш болдог. Ингэж аргаар академич, залиар захирал болох нөхцөл бүрддэг.

Гэтэл өндөр хөгжилтэй оронд сэтгэлгээ, хандлагыг л чухалчилдаг. Тэд бүтээлчээр ургуулан, цэгцтэй сэтгэх, тунгаан бодох, багаар ажиллах зэрэг оюун сэтгэлгээний дээд эрэмбийг эрхэмлэдэг. Судалгааны их сургууль 13 сая хүн амтай улсад 1 гэсэн жишиг бий. (Хятадад 100, Орост 10 байхыг судлаачид зөвлөдөг) Эстони ерөнхий (Public comprehensive) 3, мэргэжлийн (Public specialized) 10 их сургууль, хувийн 8 дээд сургуультай.

АНУ-д 200 гаруй их сургууль, БНХАУ-д 9 их сургууль, ОХУ-д Москвагийн Их Сургууль зэрэг их сургуулиуд судалгааны цр дүнгээ цйлдвэрлэлд нэвтрцулэх замаар судалгааны их сургуулийн загварыг хөгжцулж байна.

Сцулийн жилцүдэд их сургуулийн нийгмийн хариуцлагыг дээшлцулэхэд их чухалд цзэх болов. Энэ бол дээд боловсролын удирдлагад гарч буй дэлхий нийтийн хандлага.1. Нийгмийн дэвшилд бодит хувь нэмэр оруулах нь их сургуулийн нийгмийн цүрэг болж байна. 2. Эдийн засгийн хөгжцулэх, технологийн дэвшлийг хангах нэг гол хөдөлгцүр болж байна. (Удирдлагын шинэчлэлтэй холбоотой) Их сургуулийн судалгааны чиг баримжааг хөгжцулэхэд эн тэргцүнд сургалтын цйл ажиллагаанд чанарын өөрчлөлт хийх (а.Төлөвлөлт, зохион байгуулалт, хөтөлбөрт өөрчлөлт хийх замаар судалгаанд суурилсан сургалт зохион байгуулах, б. Хөтөлбөрийг сонгох тогтолцоо нь зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг дэмждэг, в.Дэлхийн шилдэг их сургуулиудаас санаа авч дээд боловсролын шинэ цнэлэмж шингэсэн шинжлэх ухааны багтаамж ихтэй хөтөлбөр боловсруулан хэрэглээнд оруулах гэж тодорхойлсон байна.)[189]

ХӨТӨЛБӨР- Энэ нь сайтар боловсруулсан агуулга, зааврыг багтаасан төлөвлөгөө. Их сургуулийн хөтөлбөр нь олон улсад зөвшөөрөгдөхүйц хэмжээний хангалттай мэдлэг олгож байна уу? гэдэг асуудал маш чухал. *(Их сургууль нь мэдлэг бүтээдэг бол дээд сургууль нь мэдлэгийг тцгээдэг*) Хөтөлбөрийн чанар дээр их сургууль оршин тогтнодог. Тиймээс хөтөлбөрийн хөгжлийн асуудал маш чухал. Хөтөлбөр эрэлт хэрэгцээнд бүрэн нийцсэн байх шаардлагатай. *Ажил олгогч өндөр ур чадвар шаардаж, ажлын байрны шаардлага жил бүр шинэчлэгдэж байгаа өнөө цед УБХИС-ийн цндсэн цүрэг бол ЗХЖШ-ын захиалга, ажлын байрны шаардлагыг бүрэн хангасан чадварлаг офицер бэлтгэх явдал.*

[189] *Б.Чулуундорж Хүмүүнлэгийн ухааны их сургууль "Дээд боловсролын шинэчлэлийн хандлагын талаар" ("Шинэчлэл"- үндсээр нь өөрчлөх, "шинэтгэл" - шинэчлэн найруулах, сайжруулах гэсэн утга)Өдрийн сонин 2018.01.26 № 020*

2018 оны байдлаар МУИС-ийн 36, ШУТИС-ийн 57 хөтөлбөр магадлан итгэмжлэгдсэн. (1.*Эзэмшсэн байх ёстой суурь чадваруудаа эзэмшээгүй оюутан элсүүлж байгаа бол бакалаврын хөтөлбөрийг хэчнээн сайжруулаад ч нэмэргүй. 2. Их сургуулийн багшийг өөрчлөхгүйгээр хөтөлбөр солиод ямар ч ур дүнгүй. Хүн бүгд л нийгмийн өөрчлөлтийн тухай ярьдаг хэрнээ нэг нь ч өөрийнхөө өөрчлөлтийг ярьдаггүй. Цаг их өөр болсон ч хүмүүс нь ер өөрчлөгдөөгүй. Өөрөөр хэлбэл эдийн засгийн хөгжлийн хурдаас хүмүүсийн сэтгэлгээний хөгжил үлэмж хоцорч байна.Энэ бол боловсролын шинэчлэлд маш чухал Хүн өөрөө өөрчлөгдөж байж л нийгэм хөгжинө. Бид хүний хөгжлийн тухай маш их ярьдаг ч өнөөдрийн шинжлэх ухааны судалгааг 100% гэж үзвэл 95% нь амьд бус зүйлийг судалсан байна. Амьд зүйлийг судалсан нь ердөө 5-хан хувь. Тэрхүү 5 хувийн зөвхөн 1 хувь нь л хүний судалгаа. Судлагдаагүй хүнээ судалгаагүйгээр хөгжүүлэх гээд байгаа нь ихээхэн сонирхол татна.)*

-Дэлхийн нэр хүндтэй их сургуулиуд сургуулиа олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн QS (Quacquarelli Symonds, QS World University Ranking) байгууллагаар эрэмблүүлэхийн тулд их сургууль дотроо "профессоруудаа эрэмбэлж, чансааг нь тогтоодог" гэсэн. (*АШУУИС профессоруудаа жилд дор хаяж нэг эрдэм шинжилгээний өгүүллийг "Скопус" платформд бүртгэлтэй сэтгүүлд нийтлүүлсэн байхыг шаарддаг."Скопус" платформд бүртгэлтэй олон улсын болон дотоодын сэтгүүлд хариуцлагатай зохиогч, нэгдүгээр зохиогч, хамтран зохиогчоор өгүүлэл хэвлүүлэх, олон улсын болон дотоодын санхүүжилттай төсөл хөтөлбөр удирдах зэрэг үзүүлэлтээр дүгнэвэл судалгааны ажлын чанар өсөхийн зэрэгцээ өрсөлдөөнд суурилсан зарчим цйлчилж, эрэмблэгдэнэ. Профессор цолыг олгох шалгуурт тухайн эрдэм шинжилгээ, судалгааны мэргэжлийн ИМПАКТ ФАКТОР өндөр сэтгүүлд өгүүллээ хэвлүүлсэн тохиолдолд шууд профессор цолыг олгох боломжтой. Ингэж докторын зэрэг хамгаалуулах тооны хойноос хөөцөлдсөн хэлбэрийг халж байгаа юм*)

Дүгнэлт

- Их сургуулийн төлөвлөлт, нэршил, нэр томьёо нь судалгааны их сургууль болох үндсэн зорилттойгоо бүрэн нийцсэн байна.
- 100 жилийн буурал түүхтэй, монгол улсын дээд боловсролын ууган байгууллага УБХИС мэргэшсэн судлаач (*судлагч*) бэлтгэж байгаа цагт л их сургуулийнхаа сургалтыг судалгаанд суурилсан хэв шинжтэй болгоно.
- Салбартаа мэргэшсэн судлаач (судлагч) их сургуульдаа багшилж, салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн, гал тогоонд нь сайтар чанагдсан судлаач (судлагч) их сургуулийнхаа судалгааг удирдана. *(Судалгаа шинжилгээний ажилд авьяастай нэгэн нь эрдэм шинжилгээний байгууллагад 10 гаруй жил тасралтгүй бас уйгагүй хөдөлмөрлөж байж жаахан дөртэй болдог бол авьяасгүй мань мэт нь энэхүү нүсэр ажлыг хийх гэж нэгэн насаараа оролдсон ч дөрийг нь олдож*

дийлэхээргүй нарийн чимхүүр ажил бололтой)

- Өнөөдрийн бидний ЦАРАЙ, бидний л ЦАРАА (Цараа бол бидний хэмжээ бас бидний чадал тэнхээ, бидний багтаамж. Жижиг саванд бага ус, том саванд их ус багтдагтай адил. ҮБХИС хэзээ судалгааны их сургууль болох эсэх нь бидний л цараа...)
- Монгол улсынхаа тэргүүлэх их сургуулиудтай нягт хамтран ажиллаж, багш судлаачдаа сэлгүүлэн ажиллуулвал а. багшийн хөгжилд б. тэдэнтэй зэрэгцэхэд в. их сургуулийн хөгжил судалгаанд суурилахад үлэмж тустай.
- Биднийг маргааш хоёр л зам тосч байна. 1. ҮБХИС маань хэзээ судалгааны их сургууль болж өөрчлөгдөхийг тэвчээртэй хүлээх 2. Эсвэл бид цаг үеийнхээ шаардлагад бүрэн нийцэн өөрсдөө өөрчлөгдөх

АРДЫН ЦЭРГИЙН ДАРГЫН СУРГУУЛИЙН АНХНЫ ЗАХИРАЛ ПАВЕЛ МИХАЙЛОВИЧ ТОЛПЫГИН (1881-1937)

Т.Сүхбаатар
БХЭШХ-ийн Цэргийн түүх судлалын
төвийн дарга, доктор (Ph.D), хошууч

Keywords: *Даргын сургуульь, Даргын сургуулийн анхны захирал, Павел Михайлович Толпыгин, Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит Үндэсний батлан хамгаалаын их сургуулийн үндэс суурь.*

Abstract: *Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн үндсийг тавихад үнэтэй хувь нэмэр оруулсан хүмүүсийн нэг бол Оросын офицер Павел Михайлович Толпыгин юм. Тэрээр Богд Хаант Монгол Улсын цэрэгт сургагчаар, Ардын хувьсгалын анхны он жилд байгуулагдсан Ардын Журамт цэргийн анхны "Даргын сургуульь"-ийн захирлаар ажилласан ажээ. Жанжин Сүхбаатарын нэрэмжил УБХИС түүний санаачилгаар үүсгэн байгуулагдсан болохын нэг бодит баримт бол түүнтэй Богд хаант Монгол Улсын цэрэгт болон хэвлэлийн газарт хамтран ажиллаж байсан, цэргийн хэргийн зохих боловсролтой оросын офицер Толпыгиныг анх байгуулсан цэргийн "Даргын сургуульь"-ийн захирлаар томилон ажиллуулсан явдал юм. УБХИС-ийн анхны үндэс суурь бологч "Даргын сургуульь"-ийн захирлын амьдралын ээдрээ түвэгтэй замналыг бүрэн судлаагүй ч, түүнийг тухайн цейин Оросын засгийн газар хэлс хэрэгт холбогдуулан хэлмэгдүүлж амь насыг нь бүрэлгэсэн болох нь л түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн байна.*

Монгол Улсын боловсролын ууган байгууллага болох Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургуулийн түүхт 100 жилийн ой ирэх 2021 онд болох бөгөөд уг ойг угтан тус сургуулийн үе үеийн захирлуудын намтар үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах ажлын хүрээнд олон судалгааг цэргийн түүх судлалын төвөөс хийн гүйцэтгэж цувралаар олны хүртээл болгож байгаагийн нэг нь анхны захирал Павел Михайлович Толпыгиний намтар юм.

П.М.Толпыгины талаарх намтар туйлын бүрхэг бөгөөд Монгол болон ОХУ-ын архивт тун цөөн мөр баримт хадгалагдаж байгаа ажээ.

Мөн УБХИС-н үе үеийн ойн бүтээлд уг хүний намтрыг өнгөц дурдах төдийхнээр хязгаарласан байдаг.

Павел Михайлович Толпыгин 1881 онд Орос Улсын Чита мужийн Оловяннинск районы "Чиндант" сууринд тариачины гэр бүлд төрсөн байна. УБХИС-ийн 80 жилийн ойн түүхийн номд[190] түүнийг Халимаг үндэстэн гэж бичсэн байдаг ч ОХУ-ын улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн хүмүүсийн намтарт Орос үндэстэн гэж бичжээ. Тэрээр бага насандаа нутгийн баячуудад зарагдан ядуу зүдүү амьдарч байгаад 1901 онд хаант Оросын армид дайчлагдан цэрэгт татагджээ. ЗСБНХУ-д хэлмэгдсэн хэлмэгдэгсдийн мэдээллийн нэгдсэнд түүний талаар: *"нударган бус (баян биш) хаант Орос улсын армийн офицер. Тэрбээр Цагаан армид алба хааж байсан. Цагаантны талтай холбоотой учир БНМАУ-аас хоёр удаа хөөгдсөн"*[191] гэсэн мэдээлэл үлджээ.

П.М.Толпыгин хаант оросын армид ажиллаж байх үедээ 1912 онд олноо өргөгдсөн Богд хаант Монгол Улсад цэргийн сургагчаар уригдан ирээд 1918 он хүртэл Хужирбулангийн цэргийн сургуульд ажиллажээ. Түүнийг чухам ямар шалгууруар Богд хаант Монгол Улс руу явуулсан нь тодорхой бус юм.

Тэрээр Богд хаант Монгол Улсад ахлах сургагчаар ажиллах хугацаа (1913.03-1919.10[192])-ндаа нийтдээ 4700 монгол цэргийг сурган хүмүүжүүлж төгсгөжээ. Монгол Улсын автономт эрхийг 1919 оны 11-р сард хятадын цэргийн эрхтнүүдээс устгахад Хужирбулангийн цэргийн сургууль хаагдсан бөгөөд Оросын сургагч нар нутаг буцжээ. Харин П.М.Толпыгин яагаад ч юм явалгүй үлдэж Нийслэл Хүрээний орос хэвлэлийн газар ажиллах болсон байна. Тэрээр Хужирбуланд цэргийн сургагчаар ажиллаж байхдаа болон хэвлэлийн газар ажиллаж байхдаа жанжин Д.Сүхбаатартай дотно танилцаж, түүний хүү Венимиан Павлович нь Сүхбаатартай үерхэн бие биедээ орос, монгол хэл сурахад тусалдаг байв[193].

Монгол оронд 1921 онд ардын хувьсгал эхэлж хувьсгалчид 1921 оны 7-р сарын 10-нд Нийслэл хүрээг чөлөөлсний дараагаар шинэ засгийн цэргийн зөвлөл зургаан сарын сургалт бүхий "Даргын сургууль" байгуулахаар шийдвэрлэсний дагуу Бүх цэргийн жанжин Д.Сүхбаатар 7-р сарын сүүлчээр Олноо өргөгдсөн Монгол Улсын цэргийн албан хаагч, хамтран зүтгэгч нараа урьсаны нэг нь хуучны танил П.М.Толпыгин байжээ.

1921 оны зун, намар Нийслэлээс элссэн 28 залуу, Халхын голоос партизан А.Мягмарын авч ирсэн 30 хүнтэй баг цэрэг, 1 дүгээр морьт бригадын 2 дугаар морьт хорооноос 18 цэрэг авч дамжааг бүрдүүлжээ. Энэ дамжааг Ардын цэргийн даргын сургууль хэмээн нэрлэсэн нь УБХИС-н үүсэл хөгжлийн эх хэмээн судлаачид үзсээр ирсэн байна.

---

[190] *"Монгол Улсын Батлан Хамгаалахын Их Сургуулийн түүхийн хураангуй" УБ.2001 он. 14-р тал*

[191] *https://bessmertnybarak.ru/books/person/363436/*

[192] *Д.Гомбосүрэн. "Зэвсэг хүчний байгуулалтын түүх" УБ.2009 он*

[193] *"Монгол Улсын Батлан Хамгаалахын Их Сургуулийн түүхийн хураангуй" УБ.2001 он. 14-р тал*

П.М.Толпыгин захирлын анхны тушаал 1921 оны 8-р сарын15-нд гарсан гэж түүхэнд тэмдэглэжээ. Тэрбээр захирлаар томилогдох үед захирлын туслахаар Н.Юмзав, комиссараар Н.Насанбат, жагсаалын даргаар Найдансүрэн, штабын даргаар Цэгмэд, ажил ангийн даргаар Н.Лувсанбат, түүний сургагчаар Абросимов, штаб, ажил ангийн туслах ажилтнаар Лхасүрэн, Очиржав, Гомбо нар тус тус ажиллаж байжээ.

Мөн морьт салааны даргаар Осор, Будбаатар, тэдний сургагчаар Урусов, Е.И.Лопатин, артиллерийн тасгийн даргаар Б.Саарав, сургагчаар Буньков, морьт пулемётын тасгийн даргаар А.Мягмар, сургагчаар Бинали нарыг томилж ажиллуулсан байна[194].

Сургуулийн бие бүрэлдэхүүн 1921 оны 8-р сарын сүүлээр жанжин Д.Сүхбаатарын удирдсан цэргийн хамт Нийслэл Хүрээнээс зүүн тийш Хэрлэн гол, Батсүмбэр уулын орчмоор цагаантныг нэхэн байлдсан ажиллагаанд идэвхтэй оролцжээ. Энэ талаар партизан Н.Лувсанбат: *“1921 онд Даргын сургууль нээхэд орж суралцаж байтал мөн оны намар Нийслэл Хүрээний орчим гарч ирсэн цагаантны цлдэгдлийг бут ниргэн устгахаар захирал, комиссар Юмзав нарын отрядад явж байлаа. Нийслэлээс зүүн зүг Галттайн “Зуун мод” гэдэг газар цагааны хэсэг дээрэмчидтэй байлдахад манай сургууль оролцсон юм”*[195] хэмээн дурсан бичжээ.

Ардын цэргийн даргын сургуулийн анхны захирал П.М.Толпыгин анхны гэсэн бүх зүйлийн эхлэлийг тавих хувь тохиолтой байжээ. Тэрээр сурагчдаа удирдан анхны байлдаанаа хийсэн бол 1922 оны 1-р сард сургуулийн түүхэн дэх анхын төгсөлтөө хийжээ. Төгсөлтөөр цэргийн дүрэм, дотор сургуулийн ном, хуарангийн (гарнизоны) сургууль, сургууль боловсруулах, явган жагсаал, буудлага, гимнастик, шагайвар, командлах сургууль зэрэг 12 төрлийн хичээлээр шалгаж, 4 баллаар үнэлжээ.

Захирлын 1922 оны тушаалаар сургуулийн сургалтын хугацааг нэг жил болгон өөрчилсөн байна. Энэ нь Зөвлөлт Орос Улсын цэргийн бага дарга нарыг бэлтгэдэг хичээлийн программаар сургалтын төлөвлөгөөг төлөвлөсөн нь энэ байлаа.

П.М.Толпыгин 1923 оны 3-р сар хүртэл сургуулийн захирлаар ажиллаж байгаад тодорхойгүй шалтгааны улмаас Улаанбаатар хот дахь морьт бригадын 1 дүгээр морьт хороонд шилжээд тэндээ 1925 он хүртэл ажиллаж байгаад эх орондоо буцсан байна. Оросын баримтаар тэрээр буцсан (Монголоос хөөгдсөн) боловч 1926 онд дахин монголд ирж, Цэргийн бэлтгэлийн дарга, Налайхын уурхайд аж ахуйн дарга зэрэг ажил хийж байгаад 1932 онд дахин буцаж (хоёрдах удаагаа хөөгдсөн) Красноярск хотод суурьшин аж төржээ. Түүнийг Монголоос хөөх болсон

[194] *Үндэсний түүхийн архив (ҮТА). ф.1.т.6. хн. 28.*
[195] *Ардын журамт цэргийн дурдатгалууд. Дэд дэвтэр. УБ., 1985 он. 458-р тал*

учир шалтгаан нь Унгернист[196], тагнуул-босогчдын[197] ажиллагаанд оролцсон гэх хилс хэрэг юм.

Красноярск хотод амьдарч байхдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн артелд нягтлан бодогчоор баригдах хүртлээ ажиллаж байжээ[198].

Орос болон Монгол орныг нэгэн зэрэг нөмөрсөн улс төрийн хэлмэгдүүлэлтийн хар шуурга түүнийг ийнхүү дайрсан байна. Түүнийг 1937 оны 9-р сарын 14-нд улс төрийн хилс хэргээр баривчлан олон шоронд тамлан зовоож байгаад эрүүгийн хуулийн 58-р зүйлийн 10 буюу эх орноосоо урвасан, цагаантны тал, Зөвлөлт засгийн дайсан хэмээх хилс хэрэгт хүчээр тулган 1937 оны 9-р сарын 25-нд буудан хороосон байна. Ийнхүү Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургуулийн анхны захирал эмгэнэлтэйгээр амь насаа алджээ.

ЗХУ-ын удирдагч Сталиныг 1953 онд нас барсны дараагаар түүний хавтас хэрэгтэй Сибирийн тойргийн цэргийн шүүх танилцаад ямар ч буруугүй болох нь тогтоогдож 1960 оны 4-р сарын 29-ны өдөр цагаатгасан байна[199].

Ардын цэргийн даргын сургуулийн анхны захирлаар П.М.Толпыган ажиллах хугацаандаа тус сургуулийн зуун жилийн түүхийн эхлэлийг тавилцсан төдийгүй Монгол Улсад 1912 онд анх ирэхдээ ч тэр цэргийн боловсон хүчнийг хөгжүүлэх талаар өөрийн оюун билэг, эрдэм ухаан ухамсарт амьдрлынхаа нэгээхэн хэсгийг зориулжээ. Өдгөө түүний үүсгэн байгуулан тулгын чулууг нь тавилцсан цэргийн сургууль нь Монгол Улсын үндэсний хэмжээний их сургууль болтлоо хөгжин дэвшиж Монгол Улсын Батлан хамгаалах салбарын боловсон хүчнийг бэлтгэх гол цөм нь болж түүхт 100 жилийнхээ ойн босгон дээр ирээд байна. Ардын цэргийн даргын сургуулийн анхны захирал П.М.Толпыгины намтрыг товчхон ч атугай дурдахад ийм буюу.

Эшлэл авсан, ашигласан материалын жагсаалт

1. “Монгол Улсын Батлан Хамгаалахын Их Сургуулийн түүхийн хураангуй” УБ.2001 он. 14-р тал
2. https://bessmertnybarak.ru/books/person/363436/

[196] *Толпыгин өвөө хуучин хаант Оросын цэрэг байсан бөгөөд мөн адил цэрэг байсан Барон Унгерныг талархан дэмжигч гэж хардсан бололтой. Тухайн цед цагаантны цэрэгтэй холбоотой хэн бүхэн харддагддаг байсан це юм;*

[197] *Тухайн цед 1921 онд Саж лам Жамъянданзангийн хэрэг, 1922 онд Д.Бодоо, Д.Чагдаржав, Д.Пунцагдорж да лам нарын хэрэг, гүн Цэрэнпил, хувилгаан лам Довчин, Буриад Очиров, Туванов нарын хэрэг, 1924 онд С.Данзан, Бавaасан, Дорнод аймгийн бээл Сайнбаярын хэрэг, 1925 онд Урианхайн гүн Чултэм, Бадрах нарын хэрэг, Улаангомын хүрээний лам нарын хөдөлгөөн гэх мэтийн хэргүүд тус тус болсон бөгөөд эдгээрийн аль нэгээр нь М.П.Толпыгинийг буруутгасан нь тодорхой юм.*

[198] *Красноярскийн хязгаараас улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртсөн хүмүүсийн дурсгалын ном Боть 8 Красноярск 2009 он. ISBN 978-5-901533-25-3*

[199] *“ЗСБНХУ-ын улс төрийн террорист хохирогчид”; Эрхүү мужийн дурсамжийн ном; Красноярск нийгэмлэгийн ДБ “Дурсамж” 2009 он*

3. Красноярскийн хязгаараас улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртсөн хүмүүсийн дурсгалын ном Боть 8 Красноярск 2009 он. ISBN 978-5-901533-25-3
4. “ЗСБНХУ-ын улс төрийн террорист хохирогчид”; Эрхүү мужийн дурсамжийн ном; Красноярск нийгэмлэгийн ДБ “Дурсамж” 2009 он
5. Ардын журамт цэргийн дурдатгалууд. Дэд дэвтэр. УБ., 1985 он. 458-р тал
6. Д.Гомбосүрэн. “Зэвсэг хүчний байгуулалтын түүх” УБ.2009 он
7. “Монгол Улсын Батлан Хамгаалахын Их Сургуулийн түүхийн хураангуй” УБ.2001 он. 14-р тал
8. Үндэсний түүхийн архив (ҮТА). ф.1.т.6. хн. 28.

ЭРТ, ДУНДАД ҮЕИЙН МОНГОЛЧУУДЫН ТӨМӨРЛӨГ БОЛОВСРУУЛЖ АСАН АРГА ТЕХНОЛОГИЙН ТУХАЙД

Ж.Базарсүрэн
БХЭШХ-ийн Зэвсэглэл техник инновац
судлалын төвийн ЭШТА доктор(Ph.D), профессор

Key words: *Mongolian, metallurgy, metallurgical processing methods, cast iron*

Abstract: *Since the Neolithic times Mongolians have discovered and used the method of smelting copper. As the production capacity developed, the way metallurgy was processed also improved. In the 13th century, a relatively large furnace began to be used for smelting metal and thus weapons were produced. Received several types of metal mixture, special alloy and used in everyday life. Also, tungsten was discovered almost 500 years ago than the Europeans. So produced weapons from tungsten and cast iron.*

Therefore, the level of development of metallurgical processing, the production of weapons of the Mongolians of middle antiquity not only did not lag behind the countries of the West and the East of that time, but also in some way they led and it's confirmed by the evidence.

Дайн, байлдаан хэмээх үзэгдэл бусад улс түмний нэгэн адил монголчуудын амьдрал, түүхэнд ч онцгой үүрэг гүйцэтгэсээр ирсэн бөгөөд эртнээс инагш гадны түрэмгийлэлд цөөн бус өртөж, байнгын заналхийлэлд оршсоор ирсэн авч хүн амын тоогоор бус, гагцхүү цэрэг, зэвсгийн чадавхаар дутуугүй байсны хүчинд гал голомтоо сахин хамгаалж, туурга тусгаар оршин тогтносоор өдий хүрсэн билээ.

Тэгээд ч XIII-XIV зуунд ертөнцөд урьд хожид байгаагүй их гүрнийг байгуулж, цэргийн хүчээр цагтаа ааглаж байсны учир Чингис хааны Монголын цэрэг, зэр зэвсэг гадаадын түүхч, судлаачдын сонирхлыг онцгой их татсаар иржээ. Тэр тусмаа үйлдвэрлэлийн томоохон суурин баазгүй, дөрвөн цагийн эргэлтэд нэгэн газраа тогтож суудаггүй «бүдүүлэг, нүүдэлчин, малчин улс» тул материалын болон оюуны багтаамж ихтэй нарийн хийцэт зэвсэг олон тоогоор үйлдвэрлэж, их цэргийг хангах бололцоогүй атал юуны учир тийн хүчирхэгжив хэмээн одоо хэр гайхширсаар буй.

Гэтэл эртний монголчууд өөрсдийнхөө амьдралын хэв шинжид тохирсон үйлдвэрлэл, түүний дотор төмөрлөг олзворлох, боловсруулах үйлдвэрийн технологийг нэн эртнээс эзэмшсэн, зэр зэвсэг дархлах өвөрмөц технологитой байсан нь эртний судлалын баримтаар нотлогдсоор байна.

Дорнод аймгийн Халх гол, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Дарьганга, Дорноговь аймгийн Эрдэнэ, Мандах, Даланжаргалан, Өмнөговь аймгийн Манлай, Номгон, Булган/Баянзагийн/, Гурван-Тэс, Өвөрхангай аймгийн Гучин-Ус, Говь-Алтай аймгийн Бигэр, Говь-Сүмбэр, Баянхонгор аймгийн Баянлиг сумдын нутгаас илрүүлсэн неолитын үед холбогдох дурсгалт суурин газруудаас зэсийн хүдэр малтаж байсан орд, уурхайн ором, зэс, хүрэл хайлж байсан бууц, зэс хайлуулах зуухнууд олдсоныг эртний судлаачид шинжлэн судалж «Монгол оронд аргын тооллын өмнөх (чанагш "АТӨ" гэнэ) III мянган жилд анхны төмөрлөг болох зэс хайлах ажил неолитын аймгуудын дунд бие даан үүсчээ»[200] гэсэн дүгнэлт хийжээ.

Монголчууд эхний үед төмрийн хүдрийг задгай галд ил хайлж байсан бол сүүлдээ салхины хүчийг ашиглан, битүүмжилсэн аргаар галын дөлийг төвлөрүүлэн халаалтыг их болгож, богино хугацаанд харьцангуй их хэмжээний хүдэр хайлуулж авдаг болжээ. Ийм аргын нэг нь монголчуудын дунд «Бух дарах» хэмээн нэрлэгдэж асан өвөрмөц технологи юм. Бух дарахдаа «үргэлж салхитай байдаг уулын онь, хөтөл дээр галлах амыг салхи өөд харуулсан зуух барьж, түүнд илч ихтэй түлш хийж, тэр түлшин дээрээ төмрийн хүдэр овоолоод, гал оруулж орхидог. Зуухан доторхи гал нь аяндаа үлээгдэн хөгжиж, түлш шатан хүдрийг хайлуулахад төмөр нь ялгаран зуухны ёроолд тунадаг байв»[201].

"Баянхонгор аймгийн Баянлиг сумын нутаг дахь Зуух-Зоогийн суурингййн зэс хайлуулах нэгэн зуухыг жижиг довцгийн орой̆д барьсан нь байгалийн салхины хүчийг ашиглан ихээхэн хэмжээний төмрийг хайлуулдаг «Бух дарах» гэдэг эртний дэвшилтэт арга зарим талаараа бүр энеолитын үеэс эх үүсвэртэй̆ болохыг гэрчлэхийн зэрэгцээ монголчуудын төмөрлөг боловсруулах ажлын эртний уламжлал, залгамжлалыг харуулж байна" хэмээн доктор, профессор Д.Цэвээндорж «Бух дарах» аргыг хэрэглэж эхэлсэн цаг үеийг тодорхойлон тодотгожээ.

Үйлдвэрлэхүй хүчин хөгжихийн хэрээр монголчуудын төмөрлөг боловсруулах арга ч улам сайжирч төмөр хайлах, улайтгахдаа байгалийн салхийг ашиглахаа больж, хиймэл үлээгүүр, ямааны арьсыг туламлан хуулж хийсэн «Тулман хөөрөг», үхрийн ширээр хийсэн «Бух хөөрөг», гонзгой дөрвөлжин хэлбэртэй̆ модон шахуурга ашиглан хөөрөгдөх «Авдар хөөрөг» болон «Тарваган хөөрөг», «Шувуун хөөрөг», «Савслага хөөрөг» зэрэг төрөл бүрийн хийцийн хөөрөг ухаалан зохиож, төмөр дархлах голомт хясыг хэрэглэх болж, улмаар хэд хэдэн төрлийн төмөрлөгийн

[200] *Цэвээндорж Д. Монгол оронд төмөрлөг боловсруулж эхэлсэн тухай асуудалд. "Дорно дахины судлалын асуудалд" сэтгүүл. УБ. 1989. №1. (20). 23 дахь тал.*

[201] *Пэрлээ Х. Чингисийн чулууны бичиг. "Гурван өгүүлэл". УБ. 1962. 43 дахь тал.*

хольц, тусгай зориулалтын хайлш гарган авч амьдрал ахуйдаа хэрэглэх болжээ.

Монголын нэгдсэн улс байгуулагдсан нь нийгмийн дэвшил хөгжилд саад тотгор болж байсан овог, аймгийн хоорондын удаан хугацааны тасралтгүй дайн дажин намжиж, салангид тасархай байдал эцэс болж, улмаар нэгэн угсаантан бүрэлдэх нөхцлийг бий болгосон төдийгүй үйлдвэрлэх хүчний өсөлт, соёлын хөгжилтөд хүчтэй түлхэц болжээ. Үүний зэрэгцээ цэрэг-захиргааны нэгдмэл тогтолцоо бий болж, нийтээр цэрэгжсэн улс байгуулагдсанаар их цэргийг унаа морь, хоол хүнс, хувцас хэрэгсэл, зэр зэвсэг, бүхий л хэрэгцээт зүйлээр эн түрүүнд хангах шаардлага амьдралаар дэвшигдэн гарсан нь улс орны эдийн засгийг бүхэлд нь цэрэг дайны зорилгод нийцүүлэн үйлдвэрлэхүй хүчин, түүний дотор зэр зэвсгийн үйлдвэрлэлийг улс орны хэмжээгээр өргөн цар хүрээтэй, эрчимтэй хөгжүүлэх чиг хандлагыг тодорхойлсон чухал хүчин зүйл байв.

Эрт, дундад эртний үеийн аль ч улсын цэрэг, зэр зэвсгийн хүчин чадлын түвшин тухайн улсын үйлдвэрлэхүй хүчин, түүний дотор төмөрлөг олзворлох, боловсруулах үйлдвэрлэлийн хөгжлөөс ихээхэн шалтгаалдаг байв. Төмөрлөг нь ийнхүү стратегийн чухал бүтээгдэхүүн байсан учир хөрш зэргэлдээх улсууд, түүний дотор ойрын хөрш Зүрчин, Сүн (Хятад) улс ч төмөрлөгийг гадаадад гаргахыг хатуу хориглосон хуультай байлаа.

Ийм нөхцөлд төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудал монголчуудын хувьд нэн чухал бөгөөд зөвхөн өөрийн хүчинд тулгуурлан хийх ёстой зүйл байв. Учир нь үргэлжийн халдлага, түрэмгийлэл заналхийлж байсан тэр цагт хүчирхэг цэрэгтэй байх, түүнийгээ шаардлагатай зэр зэвсгээр хангах асуудал хамгийн тулгамдсан зүйлийн нэг болж байлаа. Зөвхөн XIII зуунд холбогдох нэгэн тооцоог авч үзье. Эрдэмтэн Х.Пэрлээ нэг ширхэг сумны төмөр зэвний хүндийг 12-13 гр гэж тооцон «арван цэргийг зэвээр зэвсэглэхэд 11250-11700 гр төмөр боловсруулах хэрэгтэй болно»[202] гэж багцаалан тооцоолсныг эш болговол: Их Монгол Улсын 10,5 түмэн цэргийг зөвхөн нэг ээлжийн зэвээр хангахад 118125-122850 кг сайтар боловсруулсан төмөр шаардагдаж байжээ. Гэтэл саадагт бэлэн байдаг 60 сумнаас гадна хүн бүр дор хаяад 100-гаад зэв сум, түүний дээр хуяг дуулга, халх бамбай, илд, жад, хуягласан төмөр гутал зэрэг төмөрлөгөөр үйлдсэн олон зүйлтэй байх шаардлагатайг бодохул төмөрлөгийн хэрэгцээ үлэмж байсан нь тодорхой. Эл хэрэгцээг хангахын тулд сайтар хөгжсөн үйлдвэрлэлийн бааз, уламжлалтай байх шаардлагатай болно.

«Монгол нутагт төмөрлөгийн үйлдвэрлэл ихэд хөгжсөн хоёр үеийн нэг нь Түрэгийн үе, нөгөө нь Монголын их гүрний үе гэж үздэг»[203].

Хархорумд удаа дараа явуулсан малтлагаар XIII-XIY зуунд холбогдох төмөр эдлэл, зэр зэвсгийн олдвор их гарсан нь тэнд төмөрлөг

[202] *Пэрлээ Х. Монголын нүүдэлчдийн металлурги, металл боловсруулалтын түүхийн асуудалд. "Археологийн судлал". УБ., 1982. 60 дахь тал.*

[203] *Пэрлээ Х. Дээр дурдсан зохиол. 43 дахь тал.*

боловсруулах, зэвсэг дархлах томоохон хэмжээний үйлдвэр, дархны газрууд ажиллаж байсныг нотолж байна.

Тэр цагийн хууль ёсоор цэрэг-захиргааны нэгж бүр өөрийн цэргийн бүхий л хангалт, зэр зэвсгийг хариуцдаг байсан болохоор түмтүүд төдийгүй, овог аймаг, цэргийн мянгат бүр өөрсөддөө тохирсон дархны газартай, төмөрлөг болон үйлдвэрлэлийн бусад хэрэгцээт зүйлсээ олборлодог газартай байсан гэж үзэх үндэстэй байна. Ялангуяа эрхтэн дархтан том ноёд орд хийдийнхээ дэргэд өөрийн харьяаны дархны газартай байж, гол хэрэгцээт зүйлс, зэр зэвсгээ дархалдаг байжээ. Үүний баримт Их Монгол Улсын өнцөг булан бүрт оршиж асан овог аймгийн тэргүүн, мянгат, түмтийн ноёдын орд гэрийн тууринд буй бөгөөд Чингис хааны хүү Зүчи, дүү Хасарын гол ордны нэг байсан «Хархираагийн хот» хэмээн судлаачдын нэрлэсэн хотхоны тууринаас л гэхэд тийм дархны газрын ором, үлдэц гарсан нь үүний нэгээхэн жишээ. Хэрлэн голын зүүн цутгалын Аваргын голын Рашаан дэрсний Аураг балгас, Дундговийн Тахилын ус, Өмнөговийн Бяруухай, Өвөрхангайн Онгийн Харганы голын Шаазан хот, Хүнхэрээгийн Шаазан толгой, Мазар /булаг/, Архангайн Орхон Бургалтайн Сарлаг толгой, Хэнтийн Хэрлэнгийн Мөнх дов, Дорнодын Хулстай нуур, Дорноговийн Хатанбулагийн «Хатны» таван хэрэм бэхлэлт зэрэг газарт төмөр боловсруулалтын баримт болох төмрийн баас, шаар, хайлш, төмөр, ширмэн эдлэлийн хэсэг бусаг зүйлс их хэмжээгээр олдсон нь дээрхийн нотолгоо.

1189-1206 онд Хамаг Монголын нийслэл хот шинжтэй оршин тогтнож байсан Рашаан Дэрсний «Аураг» хотын балгасыг 1961, 1966, 1967, 1976 онд эрдэмтэн Х.Пэрлээ тэргүүтэй эртний судлаачид малтан шинжилж, төмрийн дархны газрууд байсан ул мөр, олдоц, мөн ширмэн цутгуур хийж байсан зуухны үлдэцийг илрүүлжээ. Уг зуухыг "байшингийн зүүн хэсгийн төв дунд баруунаас зүүн тийш уртааш нь хандуулан барьсан. Зуухны урт 3.6 м, өргөн 2 м байна»[204]. Энэ нь тэр үед монголжин овог аймгийн хан, ноёдын аураг орд, хийд сууринд байдаг байсан, хэмжээний хувьд том бус дархны газруудын нэгэнд ашиглаж байсан зуухны нэгэн бололтой гэж судлаачид үзжээ.

Энэ хотын туурь одоогийн Аварга Тосонгийн рашаан сувиллаас урагш Аваргын голын хойд хөвөөнд байрлах ба зүүнээс баруун тийш 1200 метр, хойноос өмнө зүгт 500 метр, нийт 60 орчим га талбайг эзлэн оршиж байгаа. Х.Пэрлээ академичаас хойш 1992 онд Монгол-Японы хамтарсан "Гурван гол" төслийн хүрээнд тус хотын дэвсгэр зургийг үйлдэн хэд хэдэн цэгт геофизикийн судалгаа явуулсан ба 2001 оноос Монгол-Японы хамтарсан "Шинэ зуун" төслийн хээрийн шинжилгээний анги нарийвчилсан малтлага судалгааны ажлыг байгалийн шинжлэх ухааны олон талын судалгааны үр дүнтэй нэгтгэн гүйцэтгэж энэ хот нь орд өргөө, газар тариалан, төмрийн дархан, агуулах болон бусад жижиг үйлдвэрлэлийн газруудтай байсныг тогтоожээ.

---

[204] Пэрлээ Х. Монголын нүүдэлчдийн металлурги, металл боловсруулалтын түүхийн асуудалд. "Археологийн судлал". УБ., 1982. 57 дахь тал;

Их Монгол Улс байгуулагдсанаар Монгол оронд цэрэг, аж ахуйн холбогдолтой, хот, суурин газар нэмэгдэн олширч, төмөр дархлах хуучин газруудыг өргөтгөж, шинээр нэмэн байгуулж байсан бөгөөд төмөрлөг, төмрийн ажлыг голлон эрхлэх гар үйлдвэр нь Монгол нутгийн дундад хэсэгт төвлөрч, аж ахуйн нэгэн чухал салбар болон хөгжсөн байна[205]. Тийм учраас Хархорум мэт төвлөрсөн суурин газарт байгуулж байсан үйлдвэр, дархны газрууд, түүнд ашиглаж байсан төмрийн зуухны буюу дундад эртний монгол-араб хэлний «Мукаддимат ал-Адаб толь»-ийн нэр томъёоллоор бол «temur uiledukci golumtan» (төмөр үйлдэгч голомт)[206]–ын хэмжээ дээрхээс том агаад хийц, бүтцийн хувьд ч нарийлаг байсан нь ойлгомжтой. Тэдгээр дархны газар их төлөв зүйл бүрийн зэвсэг үйлдвэрлэж байжээ.

Хархорумаас олдсон зарим нэг эд зүйлийг задлан шинжилсэн дүнгээс тэнд байсан төмөрлөгийн үйлдвэрлэлийн хөгжлийн түвшинг таамаглан мэдэж болно. Жишээ нь: Цагаан ширмийг 1350 хэмийн дулаанд хайлуулж байсныг задлан шинжилгээний дүн харуулжээ. Тийм өндөр дулааныг гаргахад гар хөөрөг хүчрэхгүй байсан нь илэрхий бөгөөд харин Орхон голоос Хархорум руу татаж оруулсан усны хүчээр ажиллаж байсан хөдөлгүүрийг хэрэглэж байсан бололтой гэж мэргэжилтнүүд үзжээ[207]. Тувагийн Дён-Терек суурингийн малтлагын үед олдсон кокс, ширмийн хэлтэрхийнүүдийг судалсныхаа үндсэн дээр шинжээчид тэр цагийн төмөрчид "зөвхөн түүхий шавар хяс хөөргөөр төмөр гарган авч байсан төдийгүй, харин лавтайяа том бус ч гэлээ, хайлуулах зууханд /домница/ кокс ашиглан ширэм хайлуулах болсон байжээ"[208] гэсэн дүгнэлт хийжээ .

Ер нь ширмийг монголчууд амьдрал ахуйн хэрэгцээндээ харьцангуй их ашигладаг байв. Алсын аян, дайн байлдаанд явахдаа аравт, зуут цэргийн хэрэглэдэг байсан гурван тулгат «Баур» болон ганзагын «Хайс», «Бухаш» зэрэг төрөл бүрийн тогооноос эхлээд байлдааны хуягийн тушим /ялтас/, хависыг хүртэл ширмээр хийдэг байжээ. «Монголын нууц товчоо (МНТ)»- нд:

«Хөвчин бие нь

Ширмээр ширэгдсэн

Шөвөг хатгахуйяа

Чөлөө үгүй» (МНТ. §195) гэж гардаг нь үүний баримт юм.

Хэрлэн голын Рашаан дэрснээс олдсон цагаан ширэм нь Улаанбаатар хотын Авто засварын заводад XX зууны дундаас хойш үед хэрэглэж байсан ширэмнээс хатуулгаараа 10 гаруй хувь, бат бөхөөрөө 20 орчим хувь илүү байсан нь тэр үед механик шинжийн хувьд элэгдэлд тэсвэртэй,

---

[205] *Пэрлээ Х. Монголын нүүдэлчдийн металлурги, металл боловсруулалтын түүхийн асуудалд. "Археологийн судлал". УБ., 1982. 56 дахь тал;*

[206] *Поппе Н.Н. Монгольский словарь "Мукаддимат ал-Адаб". Часть I-III. Труды Инстия тута Востоковедения. XIV. Москва-Ленинград. 1938. 346 дахь тал;*

[207] *БНМАУ-ын түүх. УБ., 1984. 181-182 дахь тал.*

[208] *Кызласов Л.Р. Городище Дён-Терек. В кн.:"Древнемонгольские города. Москва. 1965. 118 дахь тал*

бат бөх, чанар сайтай ширэм, ган болд гарган авч ашиглаж байсныг харуулж байна.

Тувад хийсэн судалгаанаас харахад Кызылын ойролцоох Ондум голын хөвөө, Тагна уулын өврөөс соронзон гүр /мимонит/, Карасукийн ордоос хүрэн гүр /лимонит/ олзворлож, Увс нуурын ойролцоох Дус-Даге хэмээх давст уулнаас давс авч, урчууд нь нутгийнхаа төмрийн хольц бүхий сайн чанарын шавраас гадна болгомол гөлтгөнө /алебастр/, гөлтгөнө /гипс/, элдэв чулуу, эрдэс ашиглаж Елегест голын хавийн уулнаас чулуун нүүрс малтаж хэрэглэж байсан нь нотлогдож байгаа юм.

Бид Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Археологийн болон Физик-технологийн хүрээлэн, МУИС-ийн цөмийн судалгааны төв, ШУТИС-ийн Механик, тээврийн сургуульстай хамтран эрт, дундад эртний үеийн 20 гаруй ширхэг төмөрлөг зэвсэг, эд өлгийн зүйлийн химийн бүтцийг тодорхойлон, зарим дээжид бүрэн ойлтын рентгенфлуоресценцийн аргаар шинжилгээ, металлографийн үнэлгээ хийсэн бөгөөд тэрхүү шинжилгээний үр дүнгээс үзвэл сумны зэвний материалын мөхлөгийн хэмжээ нь давталт, дулааны боловсруулалтын үр дүнд өөрчлөгдсөн байх бөгөөд ирний хэсэгт төмөрлөг бус хольцтой байгаа нь тусгай хат түрхэж, хатаалга хийж хатуулгыг нь дээшлүүлж, механик шинж чанарыг нь сайжруулж байсныг харуулж байна гэж дүгнэх боломжийг олгож байгаа юм.

Тувад хийсэн судалгааны материалаас харахад дундад эртний үед "сумны зэвийг 950-1100^0-С хэмд халуун давталтын аргаар хийдэг байсан нь тогтоогдсон бөгөөд тийм учраас төмөр дээр ямар нэг хэв гажилтын (деформацийн) ул мөр ч үлддэггүй байжээ. Зэв, сумны хошуун талын хатуулаг нь сурвалжийнхаасаа (угийн хэсгийг ийнхүү нэрлэдэг) үлэмж илүү байдгийг үзэхэд тэр цагийн зэвчин дархчуул тусгай боловсруулалт хийж материалын хатуулгыг тодорхой хэсэгт нэмэгдүүлэх аргыг мэддэг байсан нь нотлогдож байна. Энэ мэт байдал гагц Тува төдийгүй Их Монгол Улсын оршиж байсан нутаг дэвсгэрт газар бүр ажиглагдаж байна.

Түүгээр ч үл барам Баянмодны уурхай зэрэг газарт XIII зууны үед хар гянт олборлож байсан агаад тэр гянтаа төмрийн хүдэрт нэмж болдыг хатан болгох арга олсон байжээ[209]. Гэтэл гянтыг Европ дахинд 1781 онд нээсэн бөгөөд энэ нь монголчууд тэднээс бараг 500 гаруй жилээр түрүүлэн гянтыг мэддэг байсан төдийгүй, олборлон ашигладаг байжээ гэсэн үг. Ийнхүү тэр үеийн монгол дархчууд зэвэрдэггүй гянт болд болон бусад хангамал төмрөөр зэр зэвсгээ дархалж байв. Ташрамд өгүүлэхүй: Сайтар боловсруулсан ганг монголчууд «Хангамал төмөр» гэж нэрлэдэг байсан ба харин өнөө бидний «Ган», «Болд» хэмээн нэрийдэж буй сайтар боловсруулсан төмрийг монголчууд «Хангамал төмөр» гэж нэрлэдэг байжээ. Харин «Ган» гэдэг нь тийм төмрийг хятадаар, «Болд» гэдэг нь араб, персээр өгүүлсэн нэр томьёо юм.

Эртний уламжлалт монгол аргаар болгосон хангамал төмрөөр Сайн ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошууны дархчуулын хийсэн «Арван хангал» бурхны илдийг ОХУ-д шинжилсэн мэдээнээс үзэхэд

[209] *Ринчен Б. Өмнө этгээдэд зорчсон тэмдэглэл. УБ., 1955. 64 дэх тал*

орчин үеийн цахилгаан аргаар гаргаж авсан болдоос илүү сайн чанартай байжээ. Гэтэл ийм болд хийдэг нууцыг Европын эрдэмтэд найман зуун жилийн өмнө мартагдсан гэж үзэж байв[210].

Төмрийг боловсруулж илд, хутга тэргүүтэн зэр зэвсэг давтахдаа гянт, анзаан, албин зэрэг хатуу төмөрлөгийг ир дагуулан давхарлаж ширээн хатааж, давхар иртэй үйлддэг байсан[211] нь өвөрмөц сонин технологи байжээ. Тийм ч учраас түүх судар, үлгэр домогт төд, өдөн хатат, төдөн давхар иртэй илд хэмээн гардаг нь эл өвөрмөц аргаар үйлдсэн илдний нэг ёсны «Техникийн тодорхойлолт» юм.

Монголчууд төмөрлөгийг ийнхүү болгож хатаахдаа тусгай жороор бэлтгэсэн зуурмаг буюу «Хат»-ыг төмөрлөгтөө түрхэж хэрэглэдэг байв. Тэрхүү хат нь дотроо хэд хэдэн төрөл хэлбэртэй байжээ. Үүнд:

1. Хярвас 50 хувь, давс 30 хувь авч дээр нь шүдтэр нэмж нэгэн төрлийн хат бэлтгэдэг байжээ. Хярвас бэлтгэхдээ адууны туурай юмуу ямааны эврийг бага зэрэг шатааж гадна талын түлэнхий хэсгийг нь хусан авдаг байна;

2. Адууны туурайн хярвас 1 лан, дарь 3 цэн, давс 1 цэн, хужир 1 цэнг хольж зуураад хуурайдуу хат бэлтгэдэг;

3. Зунгагтай ноосыг давстай хольж зөөлөн шатааж шар өнгийн хусам гарган авч бас нэг төрлийн хат болгодог байсан байна.[212]

Чухам ямар хат хэрэглэхийг сонгохдоо дархчуул «Төмрийн хат тохируулах хутга» хэмээх тусгай «Эталон» /эх хэмжүүр, шалгах хэмжүүр/ хутга хэрэглэдэг. Тийм хутгыг дээд зэргийн боловсруулалт хийсэн хангамал төмрөөр үйлддэг байсан бөгөөд ямар нэг эдлэлийг хатаах аргаа уул хутганы даацаар жишин сонгодог байна. Өөрөөр хэлбэл хатааж болгох төмрийнхөө механик шинж чанар, бүтэцтэй нь уялдуулан хатаа сонгож, хат суулгах хэсэгтээ зурваслан түрхдэг байж. Хатаа сайн шингээхийн тулд бас хат бэхжүүлэгчийг хэрэглэдэг. Үүнд, шар эсгий юмуу зунгагтай ноосыг бэхжүүлэгч болгон ороож ашигладаг байна.

Ийнхүү хатаах эдлэлдээ хат түрхэж, бэхжүүлэгчээр орооснихоо дараа модны нүүрсний цог дээр тавьж хөөрөгдөн улайсгана, Улайсалтын байдлаас хат оруулах хэмжээ шалтгаалах учир хэр зэрэг улайсгахаа хатаах материалынхаа бүтэц, байдалд зохицуулан тохируулна. Төмөрлөг улайсч, хат таран гүн улаан юмуу шаргал, эсвэл хүрэндүү өнгөтэй болмогц галаас гаргаж сонгосон аргаараа хатаадаг байна. Үүнд: «Салхин хатаалга», «Тосон хатаалга», «Усан хатаалга», «Цусан хатаалга» гэж бий.

1. Улайсгасан төмрийг салхинд цохиулж хатаахыг «Салхин хатаалга» гэнэ. Салхийг зөөлөн, сэр сэр, дунд, хүчтэй гэхчилэн ангилж, түүнд хэр удаан байлгахыг тохируулна.

---

[210] *Гонгоржав Г. Монголчуудын эрдэм ухааны уламжлал. Тэргүүн дэвтэр. УБ., 1992. 38 дахъ тал*

[211] *Бор Ж. Монгол баатар, матигар сэлэм. "Ил товчоо", 1994. №18 /121/. 7 дахъ тал;*

[212] *Нацагдорж Н. Монголын үндэсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх уламжлалт технологи. Докторын зэрэг горилсон нэгэн сэдэвт зохиол. УБ., 1997. УТНС. 139-141 дэх тал;*

2. Төмөрлөгийг тосонд дүрж хатаахыг «Тосон хатаалга»гэнэ. Эд зүйлийг зөөлөн, дунд зэрэг хатаахад тохиромжтой гэж үздэг. Жишээ нь: хутганы төмрийг адууны туурайн хярвас, дарьтай хольж түрхэн улайсгаад тосонд дүрж хатаадаг.

3. Ган төмрийг усанд дүрж хатаахыг «Усан хатаалга» гэнэ. Хатаах зүйлийнхээ хэрэглэгдэх байдал, шинж чанараас хамааран халуун, бүлээн, хүйтэн, зайрмагтай, эсвэл давстай усанд дүрнэ. Ноомой хатаахдаа цэвэр, бүлээн усанд, догшин хатаах бол хүйтэн усанд дүрнэ

4. Цусанд дүрж хатаахыг «Цусан хатаалга» гэнэ. Тулалдаанд ялагдсан баатрын цусаар зэвсгээ хатааж сүр хүчээ үзүүлж байсан гэх домогтой бөгөөд

ямар ч атугай цусны физик, химийн шинж чанарын онцлогийг ашиглан ийнхүү хатаалга хийдэг байжээ[213].

Ийнхүү хат оруулж хатаасан төмрийн хатыг танихдаа гал дээр барин хуурайгаар үрж гарсан үртэсний шаталтаар нь мэддэг байна. Хат сайтай төмрийг үрэхэд шүр шүр гэсэн дуу гарч, үртэс нь цайвар шар өнгөтэй байх ба галд хийхэд цацарсан болон салаа цайвар оч /од/ гарна. Хатгүй төмрийн үртэс бужигнасан улаан гал үүсгэдэг байна.

Энэ мэт ирт зэвсэг төдийгүй монгол аргаар үйлдсэн зүү, шөвөг, хуурай, зүлгүүр хүртэл чанар сайтай, өвөрмөц аргаар бэлтгэгдсэн зүйл байлаа.

Плано Карпини «Тэд нар саадгандаа сум ирлэх хуурай ямагт авч явмуй»[214] хэмээсэн байдаг. «Монгол дархчуул хуурай хийхдээ тусгайлан болгосон төмрийг улайсгаж хатыг нь хариулж зөөлрүүлээд цавчуур алхаар цавчиж ир гаргадаг. Түүнийгээ улайтган хатаана. Монгол хуурай шинэ дээрээ урж дааж байгаад сэв нь дарагдсаны дараа ир нь тэгширч, элэгдэх тутам даалт нь сайн болдог байжээ. Мөн хуурай хийх төмрийг улайтгаад иртэй багажаар цохиж хийх ч ёс байсан»[215] байна.

Энэ мэтчилэн дундад эртний үеийн монголчуудын эдийн боловсрол, технологийн холбогдолтой баримт материалаас үзэхэд төмөрлөг боловсруулалт, зэр зэвсгийн үйлдвэрлэлийн хөгжлийн түвшингээр тэр цагийн өрнө, дорнын улс орнуудаас дутуугүй төдийгүй зарим талаар, тухайлбал харвуул зэвсгийн хөгжлөөр тэргүүлж байсан нь нотлогдож байна.

Эшлэл авсан, ашигласан материалын жагсаалт

1. БНМАУ-ын түүх. УБ., 1984
2. Бор Ж. Монгол баатар, матигар сэлэм. “Ил товчоо”, 1994. №18 /121/

[213] *Нацагдорж Н. Өмнө дурдсан нэгэн сэдэвт зохиол. 138 дахъ тал;*

[214] *Жиовани дел Плано Карпини.” Монголчуудын тууж”, Гильем де Рубрук. “Дорно этгээдэд зорчсон минь”. УБ., 1988. 40 дэх тал;*

[215] *Сономцэрэн Л. Монголын эдийн соёл, ардын урлагийн зүйлчилсэн тайлбар толь. Тэргүүн дэвтэр. УБ., 1992. 31 дэх тал;*

3. Гонгоржав Г. Монголчуудын эрдэм ухааны уламжлал. Тэргүүн дэвтэр. УБ., 1992
4. Жиовани дел Плано Карпини.” Монголчуудын түүх”, Гильем де Рубрук. “Дорно этгээдэд зорчсон минь”. УБ., 1988
5. Кызласов Л.Р. Городище Дён-Терек. В кн.:”Древнемонгольские города. Москва. 1965
6. Монголын нууц товчоо. Ц.Дамдинсүрэн. УБ. 1990. §195
7. Нацагдорж Н. Монголын үндэсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх уламжлалт технологи. Докторын зэрэг горилсон нэгэн сэдэвт зохиол. УБ., 1997. УТНС.
8. Поппе Н.Н. Монгольский словарь “Мукаддимат ал-Адаб”. Часть I-III. Труды Института Востоковедения. XIV. Москва-Ленинград. 1938
9. Пэрлээ Х. Чингисийн чулууны бичиг. “Гурван өгүүлэл”. УБ. 1962
10. ПэрлээХ. Монголын нүүдэлчдийн металлурги, металл боловсруулалтын түүхийн асуудалд. “Археологийн судлал”. УБ., 1982
11. Ринчен Б. Өмнө этгээдэд зорчсон тэмдэглэл. УБ., 1955
12. Сономцэрэн Л. Монголын эдийн соёл, ардын урлагийн зүйлчилсэн тайлбар толь. Тэргүүн дэвтэр. УБ., 1992.
13. Цэвээндорж Д. Монгол оронд төмөрлөг боловсруулж эхэлсэн тухай асуудалд. “Дорно дахины судлалын асуудалд” сэтгүүл. УБ. 1989. №1. (20)

МА И-ИЙН ОТОЛТ

Т.Эрдэнэхишиг
БХЭШХ-ийн Цэргийн түүх судлалын төвийн ЭШАА,
доктор(Ph.D), профессор

Abstract: *During peacful time Han dynasty kings were preparing to move against the nomads, and by the time of Wu-Di's ascendance to throne, the preparation was basically complete.*

In order to start a war against the northern nomads, king U-Di decided to trick the Xiongnu army to penetrate into his land, and crash. King Wu-Di's big army ambush was planned in a place called Ma Yi, Han Dynasty, however Xiongnu Shanyu returned his army to the north after discovering Wu-Di's secret plan on the way.

Regardless of this occasion, Xiongnu army move towards Ma Yi city became the excuse to start a war between the two countries. However Xiongnu army was attacking Han dynasty borders from time to time by minor forces, the trade between the two countries continued normally.

Хятдын Баруун Хан улс (НТӨ 206-НТ 25 он)-ын эхэн үед Цин улсын сүүл, Баруун Хан улсын эхэн үеийн дайн байлдаан, овог ондоо вангууд болон овог нэгт жөхоу вангуудын үймээн самуун зэргээс болж сүйдсэн аж ахуйг сэргээн босгох шаардлагатай болсон байна.

Тиймээс Хан улсын эрх баригчид Хүннүтэй урьд байгуулсан "Энх ургийн гэрээ"-г сахин, эвтэй найртай байх бодлого баримталж байв. Энэхүү найрамдалт бодлого Хан улсын Гаоди хаан (НТӨ 206-НТӨ 194)-ы үеэс У-Ди хаан (НТӨ 140-НТӨ 87)-ы эхэн үе хүртэл үргэлжилжээ.

Харилцаа тайван байх цагт Хан улсын хаад гар хумхин суулгүй цаг нь болохоор нүүдэлчдийн эсрэг хөдлөхөөр бэлтгэлээ базаасаар байсан ба У-диг хаан ширээнд суух үед энэ бэлтгэл үндсэндээ хангагдсан байлаа. У-дигаас өмнөх Хан улсын эзэн хаад Хүннүтэй тэмцэхэд хүч хүрэхгүй учир хориглон хамгаалах бодлого баримталж байжээ. Харин У-дигийн үед байдал өөр болов.

Тэрбээр хаан ширээнд суусныхаа дараа орон нутгийн вангуудын толгой даах эрмэлзлийг бут цохиж, Цин улсын үеийн засаг захиргааны системийг эргэн сэргээж, төвлөрсөн хүчирхэг төвтэй засаг захиргааны том аппарат, мөн хяналт шалгалтын байгууллагыг дахин байгуулсан ба давс төмөрлөгийн үйлдвэрлэл, мөнгө хайлуулалт болон дарсанд улсын онц эрх[216] тогтоов.

[216] *История Китая с древнейших времен до наших дней. М., 1974. с. 80*

У-ди улсын сан хөмрөгийг нэмэгдүүлэхийн тулд сан хөмрөгийн байгууллага байгуулж тэрэг, завь зэргийг албан татварт авдаг болсон ба энэ татварын хэмжээг суань нэгжээр хэмжиж байв. Тухайн үед байсан яамдын санаачилснаар нэг суань нь 120 зэс мөнгөтэй тэнцэж байсан ба тосгоны засаглалын "Гурван ахлагч" ба түшмэлийн онцгой эрхгүй болон хойд хилийн морин цэргээс бусад хүн бүрт хөнгөн тэрэгний татвар оноож[217] байв. Ийнхүү энгийн иргэд, худалдаачдын хөрөнгөнд татвар тогтоосноор улсын сан хөмрөг ихээхэн арвижиж цэргийн хүчийг нэмэгдүүлэх болоцоотой болжээ.

Хойд зүгийн нүүдэлчидтэй байлдах хурдан шалмаг хөдөлгөөнтэй хөнгөн морьт цэрэг байгуулах нь хятадуудын хувьд шинэ зүйл учраас их хүч хөрөнгө шаардагдаж байсан ч хил хязгаар нутагт 30 түмэн толгой адуу өсгөжээ.

Хүннүгийн тухайд гэвэл Гюньчэнь шаньюйн дараа хаан ор суусан Лаошань шаньюйн үед Хүннүгийн хүчин чадал улам бүр сайжирч, хил хязгаарын цэргийг өргөтгөжээ. Тэр үед ху же (өнөөгийн Шинжаны хойд хэсэг, жай сан бо, монголын баруун хэсгийн зарим газар нутаг), жянь кун (өнөөгийн Енисэй гол болон Обь мөрний дээд урсгалын сав газар) зэрэг нь аль Хүннүгийн эзэмшилд байсан ба давань (Ферганий хөндийн си ар голын дээд хэсэг), кангюй (си ар голын доод урсгал болон түүнээс хойших газар) зэрэг орон ч мөн Хүннүгийн харъяанд орсон байв. Хүннүчүүд Янь чи, Вэй шү, Вэйли зэрэг газар тунпу дувэй байгуулж баруун хязгаарын орнуудын захирч байв. Өнөөгийн хятадын Гансу, Шанси, Хөбэй зэрэг мужийн баруун хойд болон хойд хэсэг, Дунбэйгийн баруун хэсэг ч мөн хүннүгийн харьяа нутагт хамаарч байв[2182]. Тухайн үедээ хүннүгийн эзэнт улс нь дэлхийн хамгийн шилдэг морьт цэрэгтэй байсан ба Баруун Хан улсын хувьд ялан дийлэхийн аргагүй дайсан нь байсан ажээ.

НТӨ 135 он Хүннүгийн Гюньчэнь шаньюй хан улсад элч илгээж энх ургийн гэрээг бататгахыг хүсчээ. Хан улсын У ди том тушаалын түшмэдээ цуглуулан "Энх ургийн" гэрээний талаар зөвлөлдөв.

Тухайн үед Хан улсын ордонд дайны талыг баримталдаг нөлөө бүхий хэсэг бүлэг хүмүүс байсан ба тэд хойд зүгийн "Бүдүүлгүүд"-ийн статус нь Хан улстай эн тэнцүү байгааг яагаад ч хүлээн зөвшөөрч чадахгүй байжээ. Дайны талыг баримтлагчид Хүннүгийн эсрэг дайн хийх өдөөн хатгалгын шинжтэй ухуулгыг эзнийхээ сонорт байнга хүргэдэг байв. Тэд "Хүннүг зөвхөн хүчээр захирч болно, тэдэнтэй хүнлэг харьцаж болохгүй. Одоо Хан улс цэцэглэн хөгжиж, урьдхаас арав дахин баян хүчирхэг болсон. Тийм учраас бид баялгийнхаа мянганы зуухан хувийг зарцуулж Хүннү улсад довтлон дайтах нь тэдний эмзэг газар руу харвасан мэт болно"[219] гэх мэтээр хэлж байжээ.

Янь улсын хүн болох Дасин цолт түшмэл Ван Хуй олон жил хилийн албанд зүтгэсэн учир Хүннүгийн байдлыг илүү сайн мэддэг байв.

[217] *Хуань Куань. Спор о соли и железе. Пер. Кроля.Ю.Л. Т. II. М., 2001. с. 481*
[218] 中国战争史. 第一卷. *2016* 年. 第*629*页;
[219] *Крадин Н.Н. Империя Хунну. М., 2002. с. 119*

Тэр хэлэхдээ: Хүннү, Хан хоёр улс "Энх ургийн гэрээ" байгуулаад хэдхэн жил ч өнгөрөөгүй байхад хүннү тохирсноо умартаж, Хан улсад довтолсоор байсан гэсэн бол Да синун тушаалтай Хан Аньгуо Хүннү, Хан улсын харилцааны талаар "Хан улс 1000 ли газар цэрэг гарган Хүннүг довтлоход хүн ядарч, морь зүдэрнэ, хохирол ихтэй. Тэд хүчирхэг нумтай" гэх зэргээр өгүүлсэнд олонх түшмэд төдийгүй хаан ч түр зуур найрамдалт харилцааг хадгалах нь зүйтэй гэж үзжээ.

НТӨ 134 онд Янмэнь Ма И (өнөөгийн Шаньси мужийн шосень) –ийн нутгийн эрхтэн Не Вэни гэгч Ван Хуйд "У ди хаанд айлтгал өргөж, Хүннү, Хан улстай дахин энх ургийн гэрээ байгуулан, хил амар амгалан байгаа үеийг далимдуулан Хүннүд довтлох санал гарга" хэмээн хэлсэнд ёсоор болгов. Хан улсын У Ди хаан дахин том түшмэдээ цуглуулан саналыг нь сонсоход Ван Хуй Хүннүд довтлох нь зүйтэй гэх саналыг дахин гаргажээ. Гэвч Хан Аньго "Хүннүтэй дайтах нь өнөөдөртөө ашиггүй" хэмээн үзсэн хэвээр байв.

Ван Хуй "Хан улс шиг ийм хүчирхэг том улс хүчин чадлынхаа 100-ны нэгхэн хувийг зарцуулан Хүннүд довтолоход ялж чадах төдийгүй бид дайсныг өдөөн хатгаж, бүгсэн цэргээр гэнэт довтолбол ялах нь гарцаагүй" хэмээн өгүүлжээ.

У Ди хаан анх Хүннүд шууд довтлох бодолтой байсан боловч Ван Хуйгийн саналыг сонсоод өдөөн хатгаж отон байлдахаар болжээ. Энэ үйл явдлыг хятадын түүхэнд Ма И-ийн отолт хэмээн нэрлэдэг.

Хүннү, Хан улсын хоёр улсын Ма И-ийн отолтод оролцсон цэргийн жанжны нэр болон цэргийн тоо:

Хүннү улс:

Бүх цэргийн захирагч	Гюньчэнь шаньюй	
Цэргийн тоо	10 түм гаруй морьт цэрэг	
Хан улс:		
И ши дайфу	шадар цэргийн жанжин	
Хан Аньгуо		
Вэйвэй	эрэлхэг морьт цэргийн жанжин	Ли Гуан
Тайфу	хөнгөн тэрэгт цэргийн жанжин	Гун Сунхао
Дасин	тариалан эрхлэх цэргийн жанжин	Ван Хуй
Тайжун дайфу	чадварлаг жанжин	Ли си

Цэргийн тоо тэрэгт явган цэрэг 30 түм

Хан улсын цэргийн ерөнхий командлагчаар И ши дайфу Хан Аньгуо, туслах жанжнаар эрэлхэг морьт цэргийн жанжин Ли Гуан, хөнгөн тэрэгт цэргийн жанжин Гун Сунхао, тариалан эрхлэх цэргийн жанжин Ван Хуй, чадварлаг жанжин Ли Си нар тус бүртээ өөрийн цэргийг удирдан Ма И-гийн ойролцоох Шангуд отолт хийн Хүннүгийн цэрэг ирэхийг хүлээхээр төлөвлөжээ[220].

[220] 中国战争史. 第一卷. 2016 年. 第630页;

Ван Хуй, Ли Си, Ли Гуаны цэргүүд байрлан отох зуур Не Вэн И Хүннүг хууран хөдөлгөж отсон цэргүүд дээрээ авчрахаар болов.

Хан улсын цэргүүд төлөвлөсөн ёсоор Ма И-ийн ойролцоох газруудад салан ашигтай байрлал эзлээд Не ВэнИ-ийг Хүннү рүү илгээв. Не Ван И Хүннүгийн шаньюйтай уулзаад хэлсэн нь: "Би МаИ-ийн толгойлогч Чэньши-гийн толгойг цавчин, хотыг буулган аваад эд агуурсыг олж чадна"[2212] гэв. Тэрээр Ма И хотыг эзлэхэд нь шаньюйд тусална хэмээн итгүүлж түүнийг дагуулан ирнэ гэсэн амандаа хүрч Шаньюйг ятган итгүүлж чадав. Не Ван И Ма И-д буцаж ирсний дараа хангийн цэргүүд цаазаар авхуулах ялтай этгээдийн толгойг цавчин хотын хэрмийн дээр өлгөж, Ма И-ийн захирагч Чэнь ши-гийн толгой хэмээн зарлаж, Хүннүгийн элчид зориудаар харуулсанд Хүннүгийн элч даруй шаньюйдаа мэдээлсэн нь: "Ма И-ийн захирагч хэдийн үхсэн тул даруй ирнэ үү" гэжээ. Шаньюй элчийн мэдээг сонсоод 10 түмэн морьт цэрэг толгойлон урагш довтолгон У жоу бэхэлэлт (өнөөгийн Шаньсигийн Зуоюнь сень) дээр ирэв[222].

Хангийн цэргүүд Хүннү нарыг итгүүлэхийн тулд Ма И-ийн иргэдийн үхэр, адуу, хонь ямааг хээр талд тараан бэлчээв. Хүннүгийн их цэрэг явсаар Ма И-ээс 100 гаруй ли зайд байх газарт ирээд дээрэмдэх үед таран бэлчсэн малын дэргэд мал хариулж буй хүн харагдахуй тул Гюньчэнь шаньюй ихэд гайхаж ойролцоох ажиглалтын цамхагийг эзлэн авав. Цамхагийг эзлэх үеэр хил эргэж явсан Яньминий вэйши цамхагт нуугдсан байсныг барьж авахад Хүннү нарт алагдахаас айсан түшмэл Ма И-ийн эргэн тойронд отолт хийж байгаа талаар шаньюйд хэлжээ. Шаньюй сонссон даруйдаа ихэд түгшиж, даруй цэргээ хойш татав. Бэхлэлтийн цаана гармагц шаньюй ийнхүү хэлжээ: Вэй ши-г олзолсон нь тэнгэрийн ивээл" гэж хэлээд вэй шид тэнгэрийн ван цол хайрлав[2231].

Хангийн цэргүүд Хүннүчүүдийг ухран одохыг хараад хэрмийн зүг яаран довтлон ирэхэд тэд холдсон тул гүйцэхгүй нь хэмээн орхив. Энэ үед Дай тойргоос хөдлөн Хүннүгийн ачаа хөсгийг олзлох ёстой байсан Ван Хуй жанжин 3 түм гаруй морьт цэрэгтэй хэдий ч Хүннүгийн шилдэг морьт цэрэгтэй өөрийн биеэр тулахаас айн буцжээ. Хан улсын 30 түмэн цэргээр Хүннүг отон бутцохих төлөвлөгөө ийнхүү нурав.

Хан улсын У ди байлдахаар яваад үхэхээс айсан Ван хуйд ихэд хилэгнэж, түүний толгойг авах зарлиг гаргав. Ван Хуй мянган алтан зоос Тэнь Фэнь чэньсяньд өгч У Ди хаанаас өршөөл гуйж өгөхийг хүсчээ. Тэнь Фэнь хаанд шууд хандан Ван Хуйгийн амийг гуйж зүрхлээгүй тул хатанд хандав. Хатан хаанд хандан Ван Хуйд өршөөл үзүүлээч хэмээн гуйхад У Ди хатандаа: Ван Хуй Ма И-д Хүннүгийн цэргийг отох санал гаргасан, би Ван Хуйгийн саналыг хүлээн авч тэнгэрийн доорх 30 түмэн цэргээ хөдөлгөсөн. Гэвч шаньюй цэргээ толгойлон буцан явах үед Ван Хуй анх төлөвлөсөн ёсоор Хүннүгийн цэргийн хөсөг рүү довтолсон бол мэдэгдэхүйц амжилтад хүрээд зогсохгүй цэргүүдийг зоригжуулах байлаа.

[221] 史记卷一百八 • 韩长孺列传第四十八. 第2861页
[222]中国战争史. 第一卷. 2016 年. 第630页
[223]史记卷一百八 • 韩长孺列传第四十八. 第2861页

Хэрвээ Ван Хуйгийн толгойг авахгүй бол тэнгэрийн доорход талархаж мэддэгүй хэрэг болно"[2242] гэжээ.

Ван Хуй эзэн хаан өршөөл үзүүлэхгүйг нь мэдээд өөрийгөө хороожээ. Хан улсын У Ди хаан суугаад 8 жил болсны дараа Ма И-ийн хэрэг явдал болжээ.

Ийнхүү У Ди хаан умардын нүүдэлчидтэй хийх дайныг Хүннү нараар эхлүүлэхийн тулд тэднийг өөрийн нутагт хууран авчирч бутцохих шийдвэр гаргасан ч бүтэлгүйтжээ.

Гэсэн ч Хүннүгийн цэрэг Ма И хотын зүг хөдөлсөн явдал нь хоёр улсын хооронд дайн эхлэх шалтаг болсон юм. Энэ явдлаас хойш хэсэг хугацаанд Хүннү нар Хан улсын хилд багахан хүчээр довтолсоор байсан боловч хоёр улсын хоорондын худалдаа харин хэвийн явагдсаар байв.

Эшлэл авсан, ашигласан материалын жагсаалт

1. История Китая с древнейших времен до наших дней. М., 1974;
2. Крадин Н.Н. Империя Хунну.М., 2002;
3. Хуань Куань. Спор о соли и железе. Пер. Кроля.Ю.Л. Т. II. М., 2001;
4. 司马迁. 史记. 中华书局. , 1962;

БХТА. СХ.17. Д.5. ХН.60

* *Д.Цэдэв хувьсгалын музейг байгуулах ажлаар архивын баримт судлах явцдаа цэргийн туцхийн судалгаанд нэн чухал бариmтыг олж илрүүлсэн нь 1945 оны Чөлөөлөх дайнд амь үрэгдсэн монгол дайчдын дурсгалд зориулж Жанчхүүгийн дабаанд босгосон анхны хөшөөн дээр бичсэн бичээс байдаг юм.*

Түүнд "Японы эзэрхэг түрэмгийн гарт нухлагдан дарлагдсан дотоод Монголын ард түмнийг чөлөөлөх байлдаанд баатарлагаар байлдаж амь үрэгдсэн Монгол Ардын Хувьсгалт Цэргийн байлдагч Ханайн Лхамрагчаа, Тувааны Самданжамц, Янживын Дагва, Пэлжээгийн Нямаа, Маналжавын Зундуй, Лувсанцэрэнгийн Аюуш, Магсарын Жанчив, Цэрэннадмидын Маамуу, Галсаны Чүлтэмсамбуу нарын хүүрийг хүндэтгэн оршуулав. 1945.8.25".

Хөшөөнд өргөсөн цэцгийн туузан дээр "Японы түрэмгийлэгчдийн эсрэг байлдаанд амь үрэгдсэн баатруудын нэр алдар үүрд мандтугай. Монгол Ардын Хувьсгалт Цэргийн дээд командлалын өмнөөс дэслэгч генерал Ю.Цэдэнбал" гэж бичсэн байжээ.

Энэхүү баримтыг Д.Цэдэв тухайн байлдаанд хамт явж байсан гэрэл зурагчин Дагвадоржийн хувийн архиваас олж илрүүлээд хөшөөний зураг, бичсэн үгийн хамт Хувьсгалын музейд шилжүүлсэн байна.

1. 中国战争史. 第一卷. 2016 年;

[224] 史记卷一百八 • 韩长孺列传第四十八. 第2863页;

ЖАНЧХҮҮГИЙН ДАВААНД БОЛСОН БАЙЛДААН

С.Ганболд
Доктор (Ph.D), профессор, бэлтгэл хурандаа
Ц.Бямба-Эрдэнэ
БХЭШХ-ийн Цэргийн түүх судлалын
төвийн ЭША, магистр, дэслэгч

Түлхүүр үг: Жанчхүүгийн даваа, Жанчхүүгийн даваанд болсон байлдаан, байлдааны ололт, сургамж, дутагдал

Summary: In the military history of Mongolia, the largest battle fought by the Mongolian People's Revolutionary Army in the 1945 war is considered to be the Battle of Janchkhuu. A total of 75 Soviet and Mongolian troops were killed and 116 wounded in the battle on August 19 and 20, 1945. This time, we aim to look at the process, the lessons, the achievements, and the shortcomings of the battle that took place on the Janckhuu Pass.

Манай улсын болон цэргийн түүхэнд 1945 оны дайнд оролцсон МАХЦ-ийн нэгтгэл, ангиудаас явуулсан томоохон байлдаан нь Жанчхүүгийн даваанд болсон байлдаан гэж үздэг. Уг байлдааны ажиллагаа нь 1945 оны 8 дугаар сарын 19-21-ний өдөр болж түүнд оролцсон хурандаа Д.Нянтайсүрэн даргатай 7 дугаар механикжуулсан хуягт бригадаас Монгол улсын баатар цолтон Л.Аюуш, С.Дампил, Д.Данзанваанчиг, М.Жанчив, Т.Дүүдэй нар төрөн гарсаныг бид бүхэн сайн мэднэ.

Тиймээс Жанчхүүгийн гэж нэрлэгдсэн энэ байлдаан чухам ямар байдалтай болсон, түүнд 7 дугаар хуягт бригад ямар үүрэг гүйцэтгэв гэдэг талаар зарим нэг зүйлийг тодруулах нь зүйн хэрэг юм.

Зөвлөлт, Монголын морьт механикжуулсан бүлгийн гол хүчийг баруун жигүүрээс нь хамгаалж Чуулалт Хаалганы чиглэлд туслах цохилт өгөх үүрэгтэйгээр Зөвлөлтийн улаан армийн хурандаа И.С.Дорожинский даргатай 27 дугаар мотобуудлагын бригад, дэд хурандаа Попов даргатай 30 дугаар мотоциклийн хороо, хурандаа Д.Нянтайсүрэн даргатай 7 дугаар хуягт бригад, хошууч Ё.Төрхүү даргатай 3 дугаар их бууны хороо зэрэг анги, Замын-Үүд (Эрдэнэ сумын)-ийн районоос Хаалганы чиглэлд давшсан байна.

7 дугаар хуягт бригад 8 дугаар сарын 9-ний үүрээр улсын хил даван замд тохиолдсон дайсны хэсэг бүлэг цэргийн эсэргүүцлийг няцааж 15-ны өдөр Баруун Сөнөд вангийн хүрээнд иржээ. Энэ үед бүлгийн штабаас тус бригадыг 16-ны орой гэхэд Жамбэй хотын районд хүч хуралдуулсан байх тушаал өгсөн байна. Гэтэл хуягт бригадын ар тал хэт хол хоцорсны улмаас

шатахуунгүй болж цааш явах бололцоогүй болсон байна. Иймд бүлгийн штабаас өгсөн тушаалыг биелүүлж дараагийн үүрэг биелүүлэхийн тулд бригадын удирдлага бүх шатахуунаа шавхан тэргүүний анги гарган явуулахаар шийдвэрлэжээ.

Ингээд тус бригадаас хошууч Л.Сосор даргатай буудлагын I дүгээр батальон, Чойдог даргатай 76 мм-ийн их бууны батарей, Дамдин даргатай дунд хуягтын суманг (10 хуягт машинтай) тэргүүний ангид томилон гаргаж 16-ны өдрийн 15 цагт явуулав. Тус отрядад нийтдээ 385 хүн орсон байна.

Тэргүүний анги 18-ны орой заагдсан районд очсон бөгөөд бүлгийн штабаас тус бригадыг цааш хөдлөн Хаалган хот орох замаар дайсныг тагнаж илрүүлэн уг хотыг 19-ний өдрийн 15 цаг гэхэд эзлэн авах тушаал өгчээ. Тэргүүний анги бригадын үндсэн хүчийг хүлээвэл цаг алдах учир уг тушаалыг биелүүлэхээр цааш хөдөлжээ. Ингээд 19-ний өглөөний 6 цагт толгойн сэргийлэх болон 3 хуягтыг 24 цэрэгтэй (салаа орчим хүч), дараа нь 8 цагийн үед толгойн хаалтанд буудлагын рот, танк эсэргүүцэх 2 бууны хамтаар Хаалганы замаар илгээсэн байна.

Толгойн хаалтын салбар 15 км орчим яваад Жанчхүүгийн даваанд дөхөж иртэл толгойн сэргийлэхийн хуягтууд буцаж ирэн дайсны бэхлэлтээс гал нээж танк эсэргүүцэх шуудуун дээгүүр тавьсан гүүрийг дэлбэлсэн байна гэж мэдэгдэв. Тэгтэл дайсан гал нээж эхлэн манай салбарууд явгалан бэхлэлт рүү давшиж эхэлсэн байна. Удалгүй толгойн хаалтын араас хөдөлсөн тэргүүний ангийн үндсэн хүч ирж байлдаанд оров. Жанчхүүгийн даваан дахь Хаалганы бэхлэлтийн районд дайсан бий гэдгийг Зөвлөлт, Монголын цэрэг мэдэж байсан ч чухамдаа хэдий хэрийн хүч хэрэгсэл байгааг тодорхойлж чадаагүй байсан юм.

Жанчхүүгийн дабааны энэ бэхлэлтийг Японучууд 5 жилийн хугацаанд 40 мянган гаруй хятад хүмүүсээр бариулсан ажээ. Энэ бэхлэлт нь Хаалган хотоос баруун хойш 20 орчим км зайтай, тус хот руу орох замыг халхалсан газар орны ашигтай байдлыг сонгон байгуулсан хориглолтын том байгууламж байсан ажээ.

Энэхүү бэхлэлт нь гурван хэсэг батальоны эсэргүүцлийн зангилаанаас бүрдсэн бөгөөд хоёр үзүүрийн зангилаа нь баригдаж дуусаагүй байв. Дундах гол зангилаа нь 6 км өргөн, 3 км гүнтэй, ротын тулгуурт байруудаас бүрдсэн, эргэн тойрон танк, явган цэрэг эсэргүүцэх саад мина-ийн талбай, төмөр утсан тор, шон, шуудуугаар хүрээлэгдсэн ажээ. Танк эсэргүүцэх шуудуу нь 4 м гүнтэй, 7-8 м өргөнтэй, мод чулуу, тоосго, төмөр бетоноор хийсэн 2 м хүртэл зузаантай удаан хугацааны 74 галын цэг, командын байрууд болон агуулах зэргээс бүрдсэн байв. Галын бүх цэгүүд нь хоорондоо харилцах шуудуугаар холбогдсон, бүх л талаар удаан хугацаагаар хориглоход тохиромжтой том байгууламж байлаа. /зураг 1/

Энэ бэхлэлтэд Японы хүч нэмэгдүүлсэн явган хороо орчим цэрэг байрлаж байсан байна. Хуягт бригадын тэргүүний анги бэхлэлтийн районд тулгарах байлдаанд оров. Байлдаан маш ширүүн болж манай салбарууд

ил задгай газар орон дээр дайсны бэхлэлт рүү давшиж эхэлсэн байна. Дайсан хэсэг хүчээр буудлагын I дүгээр батальоны зүүн жигүүрээр тойрч бүслэхийг хоёр ч удаа оролцсон боловч нөөц хүчинд байсан автоматчдын салаа, 3 хөнгөн хуягтын хүчээр уг санаархлыг няцаасан байна.

Дайсан далдлалтаас бүх төрлийн галаар эсэргүүцэн байлдаж байгаа явдал манай цэргийн хувьд хүндрэлтэй байсан бөгөөд улмаар давшилт зогсоход хүрэв. Байлдаан ширүүсч байдал хүнд болсон тул тус бригадад Улс Төрийн газрын төлөөлөгчөөр ажиллаж байсан Д.Цэдэндамба Жамбэй хотод буй 27 дугаар мотобуудлагын бригадын штаб руу очиж цагийн байдлыг танилцуулсан байна. Бригадын дарга хурандаа Дорожинский ангиасаа их бууны дивизион, 3 мбх-ны хоёр хоёр батальон, 30 дугаар мотоциклийн хорооны нэг рот томилон гаргаж Жанчхүүгийн даваа руу яаралтай хөдөлгөв.

Дээрх салбарууд болон хошууч Сосорын батальон 17 цагийн үед давшилтаа сэргээн 22 цаг хүртэл байлджээ. Шөнө болсон тул манай тал байлдаанаа түр зогсоов. Буудлагын I дүгээр батальон болон бусад салбарууд галын шугамаас гэдрэг 1 км орчим газар хориглосон бөгөөд Япончууд шөнийн цагаар довтлох оролдлого хийгээгүй байна.

Энэ өдрийн байлдаанд Г.Чулуунбат, М.Жанчив, Л.Аюуш, П.Ням нарын 9 хүн амь үрэгдэж Л.Нямжав, Ч.Цэрэндорж, Д.Дэлгэр, Г.Дашдондог, Д.Данзанваанчиг нарын 20 хүн шархджээ.

Маргааш өглөө Монгол, Зөвлөлтийн салбарууд галын шугаманд буцан очиж байлдахаар бэлтгэж байтал Япончууд цагаан дарцаг барьж ирэн бууж өгөх тухай хэлэлцээр хийх санал тавьсан байна. Тэд үг дуугүй бууж өгөн, зэвсгээ хураалгах тухай манай талын саналыг сунжруулан цаг хожиж буй нь тодорхой байсан тул үдээс хойш 17 цагийн үед Монгол Зөвлөлтийн салбарууд давшин байлдаж эхлэв. Байлдаан шөнө болтол үргэлжилж завсарласан байна. Энэ өдрийн байлдаанд буудлагын I дүгээр батальоноос их бууны наводчик Д.Боролдой, Д.Цэрэндолгор нар шархдаснаас өөр хохирол үзээгүй ажээ[225].

Харин 27 дугаар мотобуудлагын бригадаас 60 орчим хүн алагдаж, шархдсан бөгөөд тус бригадын салбарууд дайсны удаан хугацааны галын цэг наймыг сөнөөж 120 гаруй цэрэг, офицер устгасан байна[226].

Маргааш өглөө нь буюу 21-ний өглөө 27 дугаар мотобуудлагын бригадын батальонууд мотоциклийн ротын хамтаар бэхлэлтийн 2 жигүүрээр давшилтаа сэргээж байлдав. Харин 7 дугаар хуягт бригадын тэргүүний анги болох I дүгээр батальон байлдаанд оролцоогүй байна. Байлдаан орой болтол үргэлжилж Зөвлөлтийн цэргийн салбарууд бэхлэлтийн район руу 2 жигүүрээр нь нэлээн гүнд орсон байв. Энэ үед бүлгийн командлалаас байлдааныг зогсоож галын шугамнаас гэдрэг гарах тухай тушаал ирүүлсэн байна[227]. Энэ тушаалын дагуу манай анги, салбарууд байлдаанаас гарч Жамбэй хотоос урагш 3 км газарт хүч хуралдуулав.

[225] *БХТА. СХ.1. ХН.486*
[226] *БХТА. СХ.17. Д.5. ХН.75*
[227] *БХТА. СХ.3. Д.1. ХН.290*

Тэр шөнөдөө Японы тал бэхлэлтэд буй анги салбаруудаа цагаан хэрмийн зүг яаралтай татаж авчээ.

7 дугаар хуягт бригадын үндсэн хүч болон их бууны 3 дугаар хороо зэрэг хойно хоцорсон ангиуд 21-ний өдрийн 20 цагийн үед хүрч ирсэн бөгөөд байлдаанд ороогүй ажээ.

Ийнхүү Жанчхүүгийн даваанд болсон байлдаан дууссан бөгөөд байлдааныг гэнэт зогсоох болсныг дараах нөхцөл байдлаар тайлбарлаж болох юм.

Үүнд: Японы эзэн хаан, Засгийн газрын бууж өгөх тухай шийдвэр нэлээн хэдэн өдрийн өмнө гарсан боловч тэр нь цэрэгтээ тэр бүр хүрч чадаагүйгээс Японы цэрэг эсэргүүцэл үзүүлж байсан юм. Тухайн үед энэ шийдвэрийг Хаалганы районд буй цэрэг хүлээн авсан бөгөөд нөгөө талаар ЗХУ болон Хятадын хооронд байгуулсан хэлэлцээр, түүний дагуу хийсэн тохиролцоогоор Зөвлөлт, Монголын цэрэг давшилтаа зогсоож, Хятадын цагаан хэрмийг давахгүй байх шийдвэр гарсан байв. Энэ тохиролцооны дагуу Хятадын цагаан хэрмээс урагш буй Японы цэрэг Хятадын ардын чөлөөлөх армид хэрмийн наад талд буй цэрэг нь Зөвлөлт, Монголын цэрэгт зэвсгээ хураалгах ёстой байжээ.

Жанчхүүгийн даваанд болсон энэ байлдаанд Зөвлөлт, Монголын анги, салбаруудаас нийтдээ 75 хүн амь үрэгдэж 116 хүн шархдсан байна[*228]. (Зураг 2, 3) 7 дугаар хуягт бригадаас 10 хүн амь үрэгдэж 21 хүн хүнд, хөнгөн шархджээ.

Хаалганы чиглэлд ажилласан дээрх нэгтгэл, ангиуд Жамбэй хотын орчимд байрлаж байгаад 9 дүгээр сарын дундуур буцсан байна. Жанчхүүгийн даваанд болсон байлдааны ажиллагааг товч дурдвал ийм бөгөөд хамгийн гол нь энэ байлдаанд оролцсон 7 дугаар хуягт бригадын хувьд ямар үр дүнд хүрэв гэдэг нь чухал зүйл юм.

Энэ байлдаан нь тус бригадын хувьд ч бус МАХЦ-ийн хэмжээнд олон талын ололт, сургамжийг үлдээв.

Бригадын ар тал нь улсын хил давснаас эхлэн үндсэн хүчнээсээ хол хоцорсны улмаас ар талын бүх хангалт тасалдахад хүрчээ. Юуны түрүүнд шатахуунаар дутагдсан явдал байлдааны үүрэг биелүүлэх боломжийг нь хязгаарлагдсан байна. Үүнд бензиний машинууд орон тооноос дутуу, тэдгээр нь үүрэг гүйцэтгэх боломжоор тааруухан байсан нь нөлөөлсөн байна.

Ар тал хоцорсноос шалтгаалан Баруун Сөнөдөөс эхлэн олзолсон зүйлсээр болон орон нутгаас хангалт хийхэд хүрч байв. Хээрийн халуун тогоогүйгээс цэргүүдийг халуун хоолоор хангах ажил тасалдаж өдөрт нэг удаа л хооллож байжээ. Ингэхдээ цэргүүд нь өөрсдийн хувинд буюу нутгийн хүмүүсээс тогоо авч хоолоо бэлтгэж байв.

---

[228] Эл бариmтыг дурддагийн учир нь тэрхүү анхны хөшөө нь 2 м кв дөрвөлжин суурин дээр, 3 м орчим өндөр пирамид хэлбэрийн, дөрвөн талтай байсан бөгөөд цагийн урmад элэгдэж, эвдэрснээр Хятадын тал хожим тууnийг шинэчлэн засахдаа Монгол, Зөвлөлтийн амь үрэгдсэн дайчдын дурсгалд зориулсан хөшөө хэмээн нэрлэж, хэлбэрийг нь өөрчилж, бичээсийг нь хятад үсгээр бичсэн байдаг юм.

Бригадад халуун усны газар, талхны завод байхгүй байсан нь зохих бэрхшээл учруулж байсан юм. Улсын хил давж байлдааны үүрэг гүйцэтгээд бүтэн сар шахам болоход ганц ч удаа шуудан ирээгүй байна. Түүнчлэн бригадын хувцасны хангалтыг тун тааруу хийснээс бие бүрэлдэхүүний 40 орчим хувь нь хугацаа дууссан гуталтай, нэлээд нь муудаж өмсөх аргагүй болсон байв[229].

Тус бригад 1945 оны 8-р сарын 2-нд байлдааны цагийн шинэ орон тоо хүлээн авч түүний дагуу зохион байгуулалт хийсэн байна. Дайнд орох хүртэлх богинохон хугацааны дотор шинэ орон тоогоор хангагдаж чадаагүй бөгөөд орон тооноос 72 офицер, 214 цэрэг түрүүч дутуу байв[230].

Байлдаанд голлон оролцсон буудлагын I дүгээр батальоны 37 офицерын 1/3 нь салаа, сумангийн дарга зэрэг албан тушаалтныг орлон ажиллаж байсан доод албан тушаалтнууд байсан бөгөөд түүний дотор нэлээд хэдэн бага дарга түрүүч, ахлагч нар салааны даргын албан тушаалыг орлон ажиллаж байжээ[231].

Тэрчлэн орон тооноос 61 машин, 59 жолооч дутуу байсан бөгөөд 30 гаруй машин засварт орсон, ихэнх машин, хуягт нь дунд, их засварт орох болсон байв. Нийт жолооч нарын 70 хувь нь 1944 онд, 30 хувь нь 1945 онд жолоочийн сургууль төгссөн, дадлага туршлагаар бага байжээ.

Бригад сэлбэг хэрэгслийн хомсхон нөөцтэй, зэвсэг, галт хэрэглэлийн хангалт ч ихээхэн дутуу байв. Шинэ орон тоог тулгаж авснаас ар талын гол албан тушаалтнаар бүрэн хангагдаж чадаагүй байна. Тухайлбал, бригадын ачаа, хувцасны бэлтгэлийн дарга, шатахууны дарга, батальоны ажил ангийн дарга зэрэг орон тоо дутуу байжээ. Иймээс ар талын ажлыг бригадын улс төрийн хэлтсийн дарга нь хариуцан удирдахад хүрсэн байна.

Байлдааны тус бригадын 76 мм-ийн болон танк эсэргүүцэх буунууд нь дайсны удаан хугацааны галын цэгийг 400-500 м зайнаас чиг шагайлтаар буудаж байсан хэдий ч үр дүн багатай байв. Дээрх буунууд удаан хугацааны нэг галын цэгийг устгахын тулд 200-250 сум зарцуулж байжээ. Бригадын зэвсэглэлд буй 50 мм-ийн миномёт нь тусгал ойр, галын хүч багатай нь харагдсан байна.

Тэрчлэн байлдааны үед амь үрэгдэгсэд болон шархдагсдыг татан авах талаар бэлтгэл, туршлага дутмаг байв. Зарим үед байлдааны талбараас шархтанг авчруулахаар хүн явуулж тэр нь бас шархдахад хүрч байжээ. Үүнээс сургамж аван шөнийн цагаар шархтанг татан авах үе ч байжээ.

Тус бригад байлдаанд орохоор анх гарахдаа, мөн явцын дунд ч холбоо болон ар талыг хэрхэн зохион байгуулах, хангах талаар ямар нэгэн тушаал, захирамж аваагүй байна. Бригадад байсан 5 АК, 71 ТК радио станцууд нь тэжээлгүйгээс мөн автомашинууд нь шатахуунгүйгээс марш болон байлдааны үед дээд штабтай ямар ч холбоо байхгүй байжээ.

[229] *БХТА. СХ.17. Д.5. ХН.108*
[230] *БХТА. СХ.1. ХН.486*
[231] *БХТА. СХ.17. Д.5. ХН.74*

Энэ байлдаан нь хуягт бригадын бүтэц, зохион байгуулалтыг дахин эргэн харах шаардлагатай байгааг харуулав. Бригадын бүрэлдэхүүнд байдаг 76 мм- ийн их бууны батарей нь галын боломжоор бага учир түүнийг дивизион болгон өргөтгөх, 50 мм-ийн миномётыг 82 мм-ийн миномётоор солих, тэрчлэн 120 мм- ийн миномётын батарейг шинээр нэмж байгуулах хэрэгтэй гэдгийг харуулсан байна.

Бригадын орон тоонд биеэ даасан инженерийн салбар бий болгох нь зайлшгүй чухал байжээ. Тухайн үед бригадын шифрийн салаа нь инженерийн ажлыг давхар хариуцдаг байсан бөгөөд түүний үүрэг гүйцэтгэх боломж хязгаарлагдмал, зориулалтын техник хэрэглэл дутмаг байжээ.

Удаан хугацааны марш болон байлдаан нь бригадын бүрэлдэхүүнд говь цөлд худаг ус гаргах болон минэ хайгч багаж, энэ талаар сургагдсан хүн байх хэрэгтэйг харуулсан байна. Байлдааны үед төмөр утсан саадыг хайчлах хайч, удаан хугацааны галын цэгүүдийг дэлбээлэх тэсэлгээний хүчтэй материал, хэрэглэл үнэхээр үгүйлэгдэж байсан байна.

Байлдаанд штаб болон дарга нараас их бууны салбаруудыг удирдах ажлыг давхар хийж байснаас байлдааныг ерөнхийд нь удирдахад саад болж байв. Иймээс бригадын удирдлагад их бууны даргын албан тушаалыг бий болгох нь чухал гэдгийг харуулсан байна.

Дээр дурдсан зүйлс нь тус бригадын байлдааны ажиллагаанд ямар нэг хэмжээгээр нөлөөлсөн ч гэсэн хамгийн гол нь Жанчхүүгийн даваанд болсон байлдааныг бид бүхэн нарийн сайн судалж задлан шинжлэх ёстой юм.

Дээрх байлдаан нь манай цэргийн түүхэнд болон 1945 оны дайны ажиллагаанд томоохон байр суурь эзлэх нь дамжиггүй бөгөөд цэргийн оператив, тактикийн хөгжил, цэргийн байгуулалтад дорвитой нөлөө үзүүлсэн гэж хэлж болмоор байна.

Эл байлдаан нь тус бригад ч бус ерөөс МАХЦ байлдаанд зохих ёсоор бэлтгэж чадаагүй, сургалт, бэлэн байдал, хангалтын хувьд сулхан байсныг харуулж байна.


7 дугаар хуягт бригадын хувьд энэ байлдаан нь бэлэн байдал, байлдах чадварыг шалгасан томоохон сорилт болсон юм. Хэдийгээр бүрэн бүрэлдэхүүнээрээ байлдаанд оролцоогүй ч тавигдсан үүргийг зохих ёсоор биелүүлсэн байна.

Жанчхүүгийн гэж нэрлэгдсэн энэ байлдааны гол үр дүн сургамж гэвэл:

1. МАХЦ-т шинэ тутам үүсч байгуулагдсан механикжуулсан нэгтгэл анх удаа газар орон, байгаль цаг уурын хүнд нөхцөлд 800 шахам км-ийн марш үйлдэж багагүй дадлага, туршлага хуримтлуулсан байна.
2. МАХЦ-ийн байлдааны түүхэнд анх удаа хүчтэй бэхэлсэн бэхлэлтийг эзлэн авахын төлөө байлдаж байлдах арга тактикаа баяжуулсан.
3. Хуягт бригад улаан армийн анги, салбаруудын хамт байлдаанд оролцсон нь тэдний туршлагаас суралцах том сургууль болсон.

Эцэст нь тэмдэглэхэд энэхүү байлдаан нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хамгаалахын төлөө Монгол Улс, түүний Зэвсэгт хүчнээс явуулсан тэмцлийн нэг салшгүй хэсэг нь бөгөөд хамгийн гол нь тэнд халуун цусаа урсгаж, алтан амиа алдсан ахмад дайчид, цэрэг эрсийнхээ гавъяаг бид мартах учиргүй юм.





Зураг 1. Жанчхүүгийн даваан дахь Японы бэхлэлтийн районы будуувч

Зураг 2. Жанчхүүгийн дабаанд орших Монгол, Зөвлөлтийн дайчдын дурсгалд зориулсан дурсгалын цогцолбор



Зураг 3. Жанчхүүгийн дабаанд орших Монгол, Зөвлөлтийн дайчдын дурсгалд зориулсан цогцолборын нүүрэн талын хэсэг

Эшлэл авсан, ашигласан материалын жагсаалт

1. БХТА. СХ.17. Д.5. ХН.75;
2. БХТА. СХ.1. ХН.486;
3. БХТА. СХ.З. Д.1. ХН.290;
4. БХТА. СХ.17. Д.5. ХН.60;
5. БХТА. СХ.17. Д.5. ХН.108;
6. БХТА. СХ.17. Д.5. ХН.74;

ТҮҮХ БИЧЛЭГТ БНМАУ-ЫН ЦЯЯ-НЫ САЙД БӨГӨӨД БҮХ ЦЭРГИЙН ЖАНЖИН, УЛСЫН МАРШАЛ Г.ДЭМИДИЙН ТАЛААР СУДАЛСАН НЬ

Н.Наранхүү
БХЭШХ-ийн Батлан хамгаалах дүн шинжилгээний төвийн ЭША, ахмад

Key words: *Demid, Marshal, Ministry of Military Affairs, the Mongolian of Revolution army, the Mongolian Revolution Party*

Adstract*: Marshall G. Demid, is one of the most famous Mongolian statesmen, social and military figures of the 1930s.*

This article describes how he was studied in the historical record. In other words, his biography and history have been mentioned in books and works since the 1930s and have been forgotten due to repression, and have been studied to a lesser extent from 1965 to the late 1980s.

Since 1990 s domestic and international scholars have written extensively on his policies and measures to develop and strengthen the army and on his death and repression.

XX зууны Монголын төр, нийгмийн түүхэнд өөрийн ул мөрийг тод үлдээсэн нэгэн сод хүмүүн бол төр, цэргийн нэрт зүтгэлтэн, анхны маршал Гэлэгдоржийн Дэмид[232] билээ. Түүний Монголын төр, нийгэмд,

[232] *"Монгол ардын хувьсгалт цэргийн тууҳэнд холбогдох баримт бичгүүд" /1921-1945/, УБ. 1974. т.343-347 /1936 оны 2 дугаар сарын 21-нд хуралдсан БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчид ба Ардын Сайд нарын зөвлөлийн гишүүдийн хамтарсан XIV хурлаас: "БНМАУ-ын өрлөг жанжин" Маршал гэх цэргийн алдар цолыг баталж, тогтоол ёсоор "...11 дүгээр /1921/ онд ардын партизан цэргийг байгуулсан цагаас эхлэн удаа дараа байлдан тэмцэж туйлын их цусан гавьяаг байгуулсанаар ул барам он удтал цэргийн удирдах тушаалыг хүлээж Ардын цэргийн зохион байгуулалтыг бэхжүүлэн өргөтгөж байлдааны ба техникийн хийгээд улс төрийн сүр хүчийг удирдан зузаатгаж энэ 15 жилийн дотор ба одоо хүртэл тус улсыг гадаад, дотоодын дайсан самуунаас батлан хамгаалах цэргийн хэрэгт олон гавьяатайгаар зүтгэж буй нөхдөд зохих алдар цолыг сайшаан шагнаж олгох нь чухал" хэмээгээд Ерөнхий сайдын 2 дугаар орлогч, Цэргийн яамны сайд, Бүх цэргийн жанжин Г.Дэмид, Ерөнхий сайдын*

батлан хамгаалах салбарт оруулсан хувь нэмэр, гүйцэтгэсэн үүргийг сүүлийн жилүүдэд эргэн харж бодитойгоор дүгнэн цэгнэх оролдлого гарах болсон байна.

Улс төрийн хэрэгт холбогдуулан шалгагдаж байсан түүнийг нас барсны дарааханаас "Гэндэн, Дэмидийн удирдсан хувьсгалын эсэргүү байгууллага" гэх зохиомол хэргийг бий болгон олон арван мянган хүнийг хоморголон хэлмэгдүүлсэн явдалтай холбоотойгоор Г.Дэмидийн талаар төдийлөн судлагдалгүй орхигдсон нь өмнөх үеийн хэлмэгдүүлэлтийн шуурганд өртсөн түүний амьдрал, үйл хэргээс улбаалан судлаачид судлахаас зайлсхийдэг байсан, болгоомжилдог байсан бололтой.

1990 оноос хойш Г.Дэмидийн талаар түүний амьдрал, үйл хэргийн жинхэнэ үнэн байдлыг тодруулан гаргахыг оролдсон, цэргийн салбарт оруулсан хувь нэмрийг үнэлэн цэгнэсэн судалгааны илтгэл, өгүүлэл, зохиол бичигдэх болсон сайшаалтай. Үүнээс үзвэл түүний амьдрал, үйл ажиллагааны талаарх судалгаа харьцангуй хожуу эхэлсэн гэж хэлж болох талтай. Гэхдээ "Г.Дэмид судлал"-д 1980-90-ээд оны зааг үеэс эхлэн Г.Дэмидийн намтар, үйл ажиллагааг нь гүнзгийрүүлэн судлах эхлэл тавигджээ.

Монголын түүх бичлэгт доктор (Ph.D), профессор, хурандаа С.Ганболд "Г.Дэмид судлал"-ыг он цагийн хувьд 1930-1937 он, 1965-1985 он, түүнээс хойш хэмээн гурван үед хуваан үзсэн байдаг.

Үүнд: *1 дүгээр үе буюу 1930-1937 он.* Энэ үеийн онцлог нь Г.Дэмидийг амьд сэрүүн ахуйд түүний дэлгэрэнгүй намтар сэдвийг хэд хэдэн удаа сонин хэвлэлд нийтэлсэн. Анх 1930 онд Г.Дэмидийг Хувьсгалт цэргийн зөвлөл (ХЦЗ)-ийн тэргүүлэгчээр томилогдсоны дараахан түүний албан ёсны дэлгэрэнгүй намтрыг хэвлэн гаргав[233].

Мөн ардын хувьсгалын 10 жилийн ойг 1931 онд тэмдэглэхэд уг ойд зориулж тусгай альбом хэвлүүлсэн байна. Тэрхүү цомогт төр засаг, нам, цэргийн удирдах зүтгэлтэнүүд, түүний дотор Г.Дэмидийн товч намтар, үйл ажилллагааг өгүүлсэн байна[234]. Улмаар 1934 онд ардын хувьсгалын 13 жил, Үндсэн хууль баталж, Бүгд найрамдах засаг тогтоон явуулсны 10 жилийн ойг орон даяар өргөн дэлгэр тэмдэглэхэд түүнд зориулан ойн баярын төв комиссоос эрхлэн гэрэл зургийн цомгийг хэвлүүлсэн байна. Түүнд Г.Дэмид нарын 90 орчим удирдах хүмүүсийн гэрэл зураг бүхий товч намтрыг бичжээ[235]. Энэ үйл явдлыг тохиолдуулан Г.Дэмидийн дэлгэрэнгүй намтар сэдвийг хэвлэлд дахин нийтэлсэн[236].

Өгүүлэн буй үед хил хязгаарыг төвшитгөж, ард олны амгалан тайван байдлыг хамгаалахад онц хүчин зүтгэсэн тул Г.Дэмидийг Цэргийн

1 дүгээр орлогч Х.Чойбалсан нарт анх удаагаа мөн оны 2 дугаар сарын 25-нд БНМАУ-ын маршал, өрлөг жанжин цол олгож байжээ/

[233] *"Хувьсгалт улаан цэргийн бодлого" сэтгүүл. 1930., №5,*

[234] *"Ардын хувьсгалын 10 жилийн ой" альбом. УБ., 1931*

[235] *Үндэсний хувьсгалын 13 жилийн ой ба Бүгд найрамдах засгийн 10 жилийн ойн тулхт зургууд (Ойн баярын төв комиссын хэвлэл) УБ., 1934*

[236] *"Хүндэт удирдагч Дэмидийн тулх (хөрөгтэй) "Улаан од" сонин. 1934.07.11, №37,*

гавьяаны дөрөв дэх одонгоор шагнасан бөгөөд түүнд зориулж “Улаан од” сонинд томоохон өгүүлэл нийтлэгдэв[237].

1920-иод оны сүүлч үеэс МАХЦ-ийн түүхийг нэгтгэн бичих шийдвэр гарч энэ чиглэлээр хэд хэдэн бүтээл гарсаны дотор Х.Чойбалсан өөрийн бичсэн номондоо Г.Дэмидийн намтар түүхийг дэлгэрэнгүй өгүүлж түүний үйл ажиллагааг өндрөөр үнэлсэн байдаг[238].

Монгол Улсад цэргийн нисэх хүчин үүсэн байгуулагдсаны 10 жилийн ойг 1935 оны 5 дугаар сард тэмдэглэсэн юм. Уг ойд зориулсан Улсын батлан хамгаалах эвлэлийн төв зөвлөл ба нисэх онгоцны бригадаас эрхлэн тусгай сэтгүүл ном хэвлүүлсэн бөгөөд түүнд нисэх хүчнийг хөгжүүлэн бэхжүүлэхэд Г.Дэмидийн гүйцэтгэсэн үүргийг өндөр үнэлэхийн хамт түүний нэр орсон дуу, гэрэл зураг зэргийг оруулжээ[239].

Улсын Бага Хурлын Тэргүүлэгчид, Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор 1936 оны 2 дугаар сард Г.Дэмидэд МАХЦ-ийг хөгжүүлж, бэхжүүлэхэд оруулсан хувь нэмрийг өндөр үнэлж БНМАУ-ын өрлөг жанжин (маршал) хэмээх анхны цэргийн дээд алдар цолыг олгосон түүхтэй. Тэрхүү тогтоолыг бүрэн эхээр нь болон Г.Дэмидийг цэргийн өндөр дээд цол хүртсэнд нь баяр хүргэсэн материалууд тухайн үеийн хэвлэлд нийтлэгдэж байв[240].

Гэвч жилийн дараа Монголын түүхэнд эмгэнэлтэй явдал гарсан нь Г.Дэмид 1937 оны 8 дугаар сард ЗХУ руу явж байгаад учир битүүлгээр амь насаа алдсан билээ. Энэхүү цаг бусын үхэлд нь гашуудсан эмгэнэл болон түүний намтар түүх сонинуудад хэвлэгдсэн. Тухайлбал: “Ардын үндэсний эрх”, “Улаан од” сонинд түүний намтар түүхийг нийтэлж, хийж гүйцэтгэсэн ажлыг өндөр үнэлэн “...гавьяат нөхөр Дэмидийн 16 жилийн турш байлдан тэмцэж явсан түүхт туршлага бүхий зам мөрөөр замнан явж...тус улсын тусгаар тогтносон хувьсгалт засаг төрийг үүрд бат нотоор хамгаалан мандуулж явахаа”[241] илэрхийлжээ.

Үүний хамт Г.Дэмидийг нас нөгцсөн тухай мэдээг хүлээж аваад МАХН-ын Төв хороо болон Улсын Бага Хурлын Тэргүүлэгчид, Сайд нарын Зөвлөлийн хамтарсан хурлаас гаргасан тогтоол, албан байгууллага, хувь хүмүүсээс бичсэн гашуудлын мэдээнүүд, Улаанбаатарт болсон гашуудлын цуглаан дээр хүмүүсийн хэлсэн үг, ЗХУ-ын сонин хэвлэлд гарсан албан мэдээний орчуулга зэрэг олон тооны материал “Ардын үндэсний эрх” зэрэг сонинд нийтлэгдсэн[242]. Эдгээр нь өрлөг жанжиныг цаг бусаар нас нөхцсөнд эмгэнэн гашуудаж, түүний ард түмнийхээ өмнө

---

[237] *Манай үндэсний удирдагч бөгөөд баатарлаг байлдагч, хүндэт нөхөр Дэмидийн бие саяхан Улсын Бага Хурал ба Засгийн газраас цусан гавьяаны улаан одон тэмдэгээр шагнагдав. “Улаан од” сонин. 1934.11.23, №67,*

[238] *Чойбалсан., Х., “Үндэсний хувьсгалт цэргийн агуу хөгжилтийн товч зам” УБ., 1935., т.121-127,*

[239] *“МАХЦ-ийн агаарын нисэх хүчний 10 жилийн ой” УБ., 1935,*

[240] *Лосол.Д, “Өрлөг жанжин нарт өвгөн партизанаас баярыг хүргэе” “Үнэн” сонин. 1936, №35,*

[241] *“Хайрт удирдагч нөхөр Дэмидийн товч түүх” “Улаан од” сонин. 1937.08.25, №41, “Ардын үндэсний эрх” сонин. 1937.08.25, №77*

[242] *“Ардын үндэсний эрх” сонин. 1937., №77-83, “Үнэн” сонин. 1937., №95-98, 103, “Улаан од” сонин. 1937., №41, 57, 58,*

байгуулсан гавьяаг онцлон дурдсан, өөрөөр хэлбэл Г.Дэмидийн амьд ахуйдаа хийж гүйцэтгэсэн ажил, үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгсөн зүйл байлаа.

Түүнчлэн Г.Дэмидийн Улсын их, бага, намын их, бүгд болон Тэргүүлэгчдийн хуралд тавьсан илтгэл, хэлсэн үг нь түүний үйл ажиллагаа бичгийн өвийг судлахад чухал хэрэглэгдэхүүн болдог[243].

Харамсалтай нь Г.Дэмидийг 1937 онд улс төрийн хилс хэрэгт холбогдуулснаас хойш түүний талаар дурсаж ярих байтугай нэрийг нь хүртэл дурдахаас зайлсхийж түүнийг эзэнгүйдүүлж ирсэн.

Хоёрдугаар үе буюу 1965-1985 он. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдүүлэгсдийг цагаатгаж нэр төрийг нь сэргээх үйл явц 1962 оноос хойш эрчимжиж энэ ажлын хүрээнд Г.Дэмидийг хилс хэрэгт холбогдуулсан болохыг нь шалган тогтоож цагаатгасан байдаг[244]. Энэ үеэс түүний намтар, үйл ажиллагааг нь судалж нийтийн хүртээл болгох боломж нээгдсэн.

Эрдэмтэн А.Маамуу анх 1965 оны 6 дугаар сард "Ардын хувьсгалт цэргийн нэрт жанжин Г.Дэмидийн мэндэлсний 65 жилийн ойд" өгүүллийг "Үнэн" сонинд нийтэлснээр түүний нийгэм улс төр, цэргийн үйл ажиллагааг судлах эхлэлийг тавьсан[245]. 1971 онд Ардын хувьсгалын партизан, төр засаг, намын ахмад зүтгэлтэн болон ахмад дайчдын дуртгалын эмхтгэлүүдийг хэвлэн гаргав[246]. Монголын ардын армийн 50 жилийн ойд зориулсан хамтын бүтээл[247] нь цэргийн дээд удирдлагад ажиллаж байсан үеийг нэгтгэн дүгнэсэн бол Ц.Чойндонгийн эмхтгэсэн

---

[243] "БНМАУ-ын 17 дугаар онц Бага хурлын илтгэл, тогтоол"УБ., 1932; Хувьсгалт намын 3 дугаар онц бүгд хурал дээр нөхөр Дэмидийн шүүмжилсэн шүүмжлэл. "Үнэн" сонин, 1932.07.09,№157; Үндэсний хувьсгалын 13 жилийн ой ба Бүгд найрамдах засгийн 10 жилийн ойн түүхт зургууд (Ойн баярын төв комиссын хэвлэл) УБ., Цэргийн яамны сайд, Бүх цэргийн жанжин нөхөр Дэмидээс Улсын 18 дугаар Бага хуралд эдүгээгийн гадаад дотоодын онц чухал байдлаас авч шүүмжлэн хэлсэн үг. "Улаан од" сонин. 1934.04.07, №19; МАХН-ын IX их хурал. Дэлгэрэнгүй тайлан. УБ., 1984; "Намын 9 дүгээр их хурал дээр хүндэт нөхөр Дэмидээс шүүмжилсэн шүүмжлэл" 1934, Өлзийбат.Д., "Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Улаан цэргийн улс төрийн сургуульд суралцах дэвтэр" УБ., 23 дугаар он (1933) т.39, "Хүндэт удирдагч Дэмидийн түүх" (хөрвөгтэй) "Улаан од" сонин. 1934.07.1, №56, Улсын 7 дугаар их хурлын илтгэл ба тогтоол. УБ., 1935, "Хүндэт удирдагч Дэмидийн түүх"(хөрвөгтэй) "Ардын үндэсний эрх" сонин. 1937.07.№56,

[244] Ганболд.Г., "Монгол Улсын өрлөг жанжин (маршал) Гэлэгдоржийн Дэмид" УБ., 2000., т.9-10

[245] Наадгай.Ж., "Хувьсгалт цэргийн нэрт жанжин Г.Дэмид" өгүүлэл // "Ардын арми" сэтгүүл, №4, 1970, Пүрэв., "Монгол ардын хувьсгалын түүхэнд холбогдох нутаг, газар усны нэрийн товч тайлбар толь". УБ., 1983., т. 97, Пүрэв.О., Гомбосүрэн.Д.,"Маршал Дэмид" өгүүлэл // "Улаан-Од" сонин, №52, 1985, Литвинов.Н.Н, "1930-аад оны үеийн Монгол Улсад. Интернационалч цүрэгтээ үнэнч. (Дуртгал, өгүүллийн эмхтгэл) УБ., 1987., т.105-106,

"Комиссаруудын дуртгал" УБ., 1971, "МАХН-ын ахмад ажилтан, гишүүдийн дуртгал. Iдэвтэр. УБ., 1978, "МАЖЦ-ийн дуртгалууд" I, II, III дэвтэр. УБ., 1982, 1985, 1986,

[246] "Комиссаруудын дуртгал" УБ., 1971, "МАХН-ын ахмад ажилтан, гишүүдийн дуртгал. Iдэвтэр. УБ., 1978, "МАЖЦ-ийн дуртгалууд" I, II, III дэвтэр. УБ., 1982, 1985, 1986,

[247] Монголын ардын арми 50 жил" УБ., 1971,

баримтын эмхтгэл нь тэрхүү он жилүүдийн үйл ажиллагааг нь судлан тодруулахад чухал хувь нэмэр болох сонирхолтой мэдээ юм[248]. Харин Г.Дэмидийн бусад нөхөдтэй хамтран бичсэн "Монгол ардын үндэсний хувьсгалын анх үүсэж байгуулагдсан товч түүх" хэмээх хоёр боть номыг 1979 онд крилл үсгээр дахин хэвлүүлжээ.

1983 онд доктор О.Пүрэв Ардын хувьсгалын түүхийн талаарх судалгааны явцдаа Г.Дэмидийг орон нутагтаа сайн дурын баг цэрэг зохион байгуулж, цагаантаны үлдэгдэлтэй тэмцэж байсан улмаар Ардын журамт цэрэг[249]-т нэгдсэн тухай өгүүлсэн нь түүний намтар түүхийн нэгэн бүдэгхэн хэсэг болох Ардын хувьсгалд оролцож явсан үеийг тодруулахад чухал хувь нэмэр болох сонирхолтой мэдээ юм[250].

Энэ хугацаанд хэвлэгдсэн гадаадын иргэдийн дуртгалуудаас Н.С.Сорокины дуртгал номыг онцлон тэмдэглүүштэй. Тэрээр 1920-оод оны дунд үеэр Монголд уригдан ирж Их даргын сургуульд сургагчаар ажиллаж байсан бөгөөд тэр үед нь Г.Дэмид сумангийн даргаар ажиллаж байв. Н.С.Сорокин дуртгал номондоо: "Дэмид" гэсэн гарчигийн дор түүний талаар халуун дотноор дурсахын хамт Г.Дэмидийн ажил хэрэгч чанар, мэдлэг чадвар, үзэл бодол, зан байдлынх нь талаар тодорхой өгүүлсэн байдаг[251].

Өгүүлэн буй үеийн Г.Дэмид судлалын онцлог нь түүний намтар, үйл ажиллагааг судлан тодруулж, шинэ үеийн монголын түүхэнд зохих байр суурийг нь эзлүүлэх эхлэл тавигдсанаараа чухал ач холбогдолтой.

Гуравдугаар цеийг 1988 оноос өнөөг хүртэл гэж үзэж болно. Улмаар Монгол оронд өөрчлөлт шинэчлэлтийн эхэлсэн 1990-ээд оноос Г.Дэмидийн амьдрал үйл ажиллагааг олон талаас нь судлах өргөн бололцоо нээгдэж судалгаа, эрдэм шинжилгээний өгүүлэл, дуртгал ярилцлага, ном гарч түүний зохиол бүтээлийг хэвлэх ажлыг эхэлсэн болно[252].

[248] "МАХЦ-ийн тухэнд холбогдох баримт бичгүд" (1921-1945) эмхтгэсэн Ц.Чойндон., УБ., 1974 // Ганболд.Г., "Монгол Улсын өрлөг жанжин (маршал) Гэлэгдоржийн Дэмид" УБ., 2000., т.11-ээс дам эшлэв.

[249] "Монгол ардын журамт цэргийн дуртгалууд" дэд дэвтэр, УБ., 1985., т.126-127

[250] Пүрэв.О., "Монгол ардын хувьсгалын тухэнд холбогдох нутаг, газар усны нэрийн товч тайлбар толь" УБ., 1983., т.97 // Ганболд.С., "Монгол Улсын өрлөг жанжин (маршал) Гэлэгдоржийн Дэмид" УБ., т.11-ээс дам эшлэв.

[251] Сорокин Г., Дэмидийг тэр цеийн монгол цэргийн дарга нарт тэр болгон цэгддэггүй маш өндөр шаардлагатай, аливаа зүйлийг сурч мэдэхийн төлөө эрмэлздэг, цэргийн хэрэгт дуртай, тухнийгээ сайн ч мэддэг гавшгай морин цэрэг байсан, тухнийг хүмүүс их ч хүндэтгэж үздэг байсан гээд "...ард түмэндээ хязгааргүй үнэнч, малчин ардын аж байдлыг сайн мэддэг, зохион байгуулах авьяас чадвар, улс төрийн их идэвх, эрэлхэг зориг, оюун ухаан, барагдашгүй их эрч хүч, тухайн байдлыг чадвартайгаар мэдэж чаддаг шинж чанар нь Дэмидийг нам засгийн удирдагчдын эгнээнд дэвшүүлсэн юм" хэмээн тодорхойлжээ. Сорокин.Н.С., "Анхны эхлэл" УБ., 1972., т.110

[252] Даваасурэн.Б., Дашдаваа.Ч., "МАХН-аас цэргийн боловсон хүчин бэлтгэх талаар явуулсан бодлого, цйл ажиллагаа" (1921-1940) УБ., 1990, Агваан.Ш., "Х.Чойбалсан ба Дотоод явдлын яам" УБ., 1991, "Маршал Дэмид" УБ., 1994, Сүрэнжав.Ч..,"Өрлөг жанжны тухай өгүүлэх минь" /"Тусгаар тогтнол". №30, 1992/, маршал жанжин Дэмид (ярилцлага) /"Үнэн". №3, 1994/, Агваан.Ш.,"Маршал Г.Дэмид" УБ., 1994,"Монголын нисэх хүчин" УБ., 1995, Амарсайхан.У., "Дэмид жанжны "нуудгай хүү" (Н.Авирмэдтэй хийсэн ярилцлага)Засгийн газрын мэдээ" сонин. 1995.07.11,

Урьд нь Г.Дэмидийн цэрэг, улс төрийн үйл ажиллагааг үнэлж дүгнэхээр хязгаарлаж байсан судалгааны чиг хандлага энэ үеэс улам гүнзгийрч эхэлсэн бөгөөд ялангуяа түүний "сэжиглэлтэй" үхлийн талаар хөндөн бичих болжээ. 1988 онд Г.Дэмидийн тухай томоохон өгүүллийг "Улаан од" сонины сэтгүүлч Л.Зоригт бичиж олны хүртээл болгосон байна[253].

Энэ үеэс эхлэн Г.Дэмидийн үйл ажиллагаа түүхэнд гүйцэтгэсэн үүргийг шинэ нөхцөл байдлын үүднээс үнэлэн дүгнэхэд чиглэсэн хэд хэдэн өгүүлэл гарч эхэлсэн. Тухайлбал, хуульч С.Баттогтох[254] маршал Г.Дэмид, хууль ёс завхруулах явдалд хэрхэн хандаж байсан болон нам, төр, цэргийн үйл ажиллагааг нь БНМАУ, ЗХУ-ын хоорондын харилцааны өргөн хүрээнд авч үзэн түүний үхлийн шалтгааныг эндээс эрэлхийлсэн бол түүхч, дэд доктор Ч.Дашдаваа[255] Г.Дэмидийн амь насаа алдах үеийн үйл явдлыг судлан тодруулж, түүний үхлийн шалтгааныг ЗХУ-ын бодлого, үйл ажиллагаатай холбон авч үзжээ. Мөн дэд доктор, хурандаа С.Баатар[256], хошууч генерал С.Гангааням[257] нар Монгол Улсын батлан хамгаалах хүч чадал, түүний дотор МАХЦ-ийг бэхжүүлэхэд Г.Дэмидийн гүйцэтгэсэн үүрэг, оруулсан хувь нэмрийг нь тодруулахыг эрмэлзсэн өгүүлэл бичжээ. Өгүүлэн буй үед Г.Дэмидийн цэргийн үйл ажиллагааны зарим хэсгийг тусгайлан судалсан өгүүллийг доктор (Ph.D), профессор Э.Лувсанбалдан[258], доктор, профессор С.Ганболд[259] нар бичиж нийтлүүлсэн. Эдгээр өгүүллүүдэд өрлөг жанжины удирдлагаар 1934 онд тус улсын баруун хил хязгаарыг түйвээн сүйтгэж байсан хасагийн дээрэмчдийг бут цохиж устгасан байлдааны ажиллагаа, үр дүнг судлан шинжилсэн.

Өрлөг жанжин Г.Дэмидийн үхлийн шалтгаан өнөөг хүртэл бүрэн ил

№79, "Монгол цэргийн туцхийн товчоон", (1911-1990-ээд он), дэд дэвтэр, УБ, 1996, "Монгол цэргийн туцхийн товчоон", (1911-1990-ээд он), дэд дэвтэр, УБ, 1996, "Монгол Улсын төр, цэргийн зүтгэлтэн, маршал Г.Дэмид" УБ, 1996, Баточир.Л.,"Чойбалсан. Намтрын балархайг тодоруулахуй" УБ., 1996, Батсайхан.О., "К.Ворошилов. Дэмидийн цхэл тун сэжиглэл бцхий явдал", "Ардын эрх сонин" 1996. 09. 10, №180, Монгол Улсын төр цэргийн зүтгэлтэн маршал Г.Дэмид (Монгол Улсын маршал Г.Дэмидийн мэндэлсний 95 жилийн ойд зориулсан ЭШБХ-ийн материал) УБ., 1996, Гомбосүрэн.Д.," И.Сталин: Бид хоёр мотобригад өгнө. Дэмид: Авахгүй" "Ням гариг" сонин. 1997.11.16, №46, Иэдцйн өмнө цлдээсэн өчил. "Дал" сонин. 1997, Хаврын дунд сарын шинийн найман. №09, "Монгол Улсын Зэвсэгт хүчний байгуулалтын туцх". УБ., 1998, Батбаяр.Ц., "Монгол ба Япон XX зууны эхний хагаст" УБ., 1998,

[253] *Өрлөг жанжин (маршал) Г.Дэмидийг нас барсаны дараа Монголд хумуусийг цй олноор нь хоморголон баривчлах ажиллагаа эхэлсэн, туунийг удалгүй "эсэргүү" гэж зарласан зэрэг учир битүүлэг олон зүйл байгааг дурдан "ил тод байдал өргөжин гүнзгийрч байхад хэлэхэд хэцүү ч гэсэн туцхийн цнэнийг дарагдуулж байх учиргүй" хэмээн Г.Дэмидийн намтар туцхэн дэх бурхэг, нуугдмал асуудлыг анх удаа хөндөн тавьсан нь сайшаалтай. Зоригт .Л.,"Өрлөг жанжин Дэмид" /"Улаан Од", №23, 1988*

[254] *Баттогтох.С., "Төр тумнийхээ төлөө" мөн сонин. №55, 1989,*

[255] *Дашдаваа.Ч., "Өрлөг жанжныг Сталинизм егцүтгэсэн" мөн сонин. №21, 1990,*

[256] *Баатар. С., "Үнэн гавьяат өрлөг жанжин" мөн сонин. №22, 1990*

[257] *Гангаанам.С., "МАХЦ-ийн дээд удирдлага. цаг це, хумуус" (1921-1940) УБ., 1991., т.92-95,*

[258] *Лувсанбалдан.Э., "Дэмид жанжин баруун хилд" "Ардын эрх". №149, 1993*

[259] *Ганболд.С., "Хасгийн дээрэмчдийг устгасан нь" "Тусгаар тогтнол" сонин, 1994.1.01-10, №28,*

тод болж чадаагүй боловч судалгааны эргэлтэд орсон Монгол Улс, ОХУ-ын архивын баримтуудад түшиглэн тэрхүү нуугдмал үйл явдлын талаар хэд хэдэн өгүүллийг доктор, дэд профессор Д.Гомбосүрэн бичсэн[260].

2000-аад оны эхэн үе болон сүүлийн үед маршал Г.Дэмидийн тухай бүтээлүүд цөөнгүй хэвлэгджээ[261]. Мөн сүүлийн үе[262]-д хэвлэгдсэн зохиол бүтээлүүдэд Г.Дэмидийн намтар, төрөл садан хүмүүсийн дурсамж, удирдан хэрэгжүүлсэн цэргийн шинэчлэл, гадаад харилцаа, хилс хэрэгт хэлмэгдсэн талаар голчлон авч үзсэн байна. Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Түүх, археологийн хүрээлэнгээс эрхлэн гаргасан Халхын голын байлдааны ялалтын 80 жилийн ойд зориулан "Халхын голын дайн-1939" бүтээлд урьд өмнө судалгааны эргэлтэд ороогүй олон арван шинэ баримт, гэрэл зураг, захидал, эд хэрэглэгдэхүүнийг оруулсан. Үүнээс зөвхөн маршал Г.Дэмидтэй холбогдох баримтыг авч үзэхэд "Халхын голын дайны өмнөх бүс нутгийн геополитикийн нөхцөл ба БНМАУ-ын стратегийн ач холбогдол" дэд сэдэв бүхий 1 дүгээр хэсэгт, МАХН-ын ТХ-ны тэргүүлэгч гишүүн П.Гэндэн, Г.Дэмид, Д.Намсрай нар ЗХУ-ын удирдагч И.В.Сталинтай 1936 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр уулзаж ярилцсан тухай НТХ-ны нууц тогтоол[263]-ийн тухай эх хувийг гэрэл зурагт буулган хавсаргасан, Батлан хамгаалах хүч чадлын бэхжилт" дэд сэдэв бүхий 2 дугаар хэсэгт, БНМАУ-ын СнЗ-ийн 1933 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн хурлаар "Улсын батлан хамгаалах зөвлөл"-ийг шинэчилж, СнЗ-ийн дэргэд "Улсын батлан хамгаалах комисс"-ыг байгуулан Ерөнхий сайд П.Гэндэн удирдаж, түүний орлогчоор ЦЯЯ-ны сайд, Бүх цэргийн жанжин, маршал Г.Дэмид...томилогдсон байна. Мөн тус комиссын хэрэгжүүлж байсан улс орныг батлан хамгаалах бодлого[264], ...Адаг дулааны харуулаар довтлон ирсэн Япон-Манжийн цэргийг бут цохин устгасан байлдааны ажиллагааны амжилт, түүнд оролцсон МАХЦ-ийн дайчид, хилчид, нисгэгчдийн байгуулсан баатарлаг гавьяаг тэмдэглэж гаргасан БНМАУ-ын ЦЯЯ-ны сайд бөгөөд Бүх цэргийн жанжин, Улсын маршал Г.Дэмидийн гаргасан 9 тоот тушаал, байлдаанд оролцсон нисэх отрядын бүрэлдэхүүнийг шагнуулахаар Ардын сайд

---

[260] *Гомбосүрэн.Д., "Дэмид консеровт хордож цхсэн нь худлаа" "Ардчилал" сонин. 1997.12 дугаар сар, №18, "Маршалын цхлийн талаар эргэцүүлэл" "Соёмбо" сонин. 1998, №15, "Маршал Г.Дэмидийн цхлийн талаар өгүүлэх нь" "Өнөөдөр" сонин. 1998.08.13, №155*

[261] *Батжаргал.Б., "Жанжин Дэмидийнхэн" (Д.Оюунтай хийсэн ярилцлага)"Өнөөдөр" сонин. 1999.12.18, №294, Думбурай.А.,"Ямарч нөхцөлд нам, төрдөө тэрсэлж болдоггүй юм шүү" (Н.Элбэгийн дурсамж) Залхаан цээрлүүлэлт. УБ., 1997., т.43-47,Жанжин Дэмидийнхний удам тасраагүй (Я.Чимидбумаатай хийсэн ярилцлага) "Зууны мэдээ" сонины хавсралт. "24 цаг" сонин.2000.02 дугаар сар, №34,*

[262] *Лхагваа.Т., "Халхын голын дайны өмнөх цейн И.В.Сталин, Монголын Удирдагчдын харилцаа, байр суурь" // "Халхын голын дайн: Түүх, орчин үе" УБ., 2009., т.32, Орхончимэг.Х., "Монгол Улсын маршал Г.Дэмидийн цэргийн боловсрол сургалтыг хөгжүүлэхэд гүйцэтгэсэн үүрэг" // "Цац" сэтгүүл., 2018., №13, УБ., т.89-98, Сухбаатар.Т., "Цэргийн зүтгэлтэн маршал Гэлэгдоржийн Дэмид", "Соёмбо" сонин, 2020.4.23., №16, Толгойлогч. мн., "маршал Г.Дэмидийн цхлийн нууц", 2020, Батжаргал.Д., "Дэндүү харгислалд өртсөн Дэмид жанжныхан" Толгойлогч. мн., 2020*

[263] *"Халхын голын дайн-1939" УБ., 2019., х.46-47*

[264] *Мөн тэнд. х.52-53*

нарын зөвлөл, Улсын Бага хуралд явуулсан бичгийн эх хувийг гэрэл зурагт буулган тус тус хавсаргажээ[265].

Мөн маршал Г.Дэмид ЗХУ-ын маршал М.Н.Тухачевскийн орчин үеийн армийн тухай үзэл баримтлал, цэргийн номлолыг тууштай баримтлагч байсан талаар цухас дурдсан тал бий.

Хойд хөршид XX зууны сүүлч үеэс эхлэн эрчимтэй өрнөж эхэлсэн өөрчлөлт шинэчлэлтийн үр дүнд хүний эрх, эрх чөлөө, ил тод байдал, шударга ёсыг эрхэмлэсэн нийгмийн ардчилсан тогтолцоо буй болох хөрс суурь тавигдав. Үүнтэй холбоотойгоор хоёр системийн улс орнуудыг зааглаж байсан "төмөр хөшиг" нээгдэж, "хаалттай" байсан капиталист системийн улс орнуудтай харилцаж эхэлсэнээр түүхэнд хандах хандлага өөрчлөгдөж, урьд өмнө хаалттай байсан түүхийн тодорхой асуудлууд хөндөгдөж, судалгааны эргэлтэд орох болжээ. Үүний нэг жишээ нь ЗХУ-ын Батлан хамгаалахын ардын комиссар К.Е.Ворошиловын урилгаар Зөвлөлтийн Ажилчин Тариачны Улаан арми /АТУА/-ийн морьт болон механикжуулсан нэгтгэлүүд, нисэх хүчин оролцсон хээрийн сургуулийг үзэхээр явж байгаад 1937 оны 8 дугаар сарын 27-нд тухайн үеийн ЗХУ-ын Сибирийн төмөр замын Тайга өртөөнд учир битүүлгээр нас барсан маршал Г.Дэмидийн тухай асуудал юм.

Өрлөг жанжны учир битүүлэг үхэл, хилс хэрэгт холбогдсон болон тухайн үеийн ЗХУ, БНМАУ, Япон, Манжийн хоорондын ээдрээт харилцаа, Японы арми Хятадыг эзлэн түрэмгийлэх дайн явуулж байсан тухай орос, англи[266]...хэл дээр хэвлэгдсэн зохиол бүтээлүүдийн талаар товч авч үзвэл судлаач А.Флимоновийн "Кармино-буранныйн өртөө"[267] хэмээх өгүүлэл болон А.Е.Павлюковын "Ежовын намтар" бүтээл /"Алан хядах ажиллагааг экспортолсон нь"[268] хэмээх 29 дүгээр бүлэг/ зэрэг юм.

Г.Дэмидийн цэрэг улс төрийн үйл ажиллагаанд холбогдох үндсэн эх сурвалж бичгүүдэд Үндэсний төв архивын 1 дүгээр сан хөмрөг, Батлан хамгаалахын төв архивын 1 дүгээр сан хөмрөг, Намын төв архивын 4 дүгээр сан хөмрөгийн материалуудыг онцлон дурдаж болно.

1930-аад оны үеийн цэргийн түүхийн судалгааны эх сурвалжуудыг судалгааны эргэлтэд оруулах үүднээс хэд хэдэн баримтын эмхтгэлийг хэвлүүлжээ. Эдгээрээс Цэргийн түүхийн хүрээлэнгээс эрхлэн гаргасан "Г.Дэмидийн илтгэл, өгүүлэл, хэлсэн үг" (1930-1937), УБ, 1991, "Бүх цэргийн зөвлөл" /1921-1934/, УБ., 2010 зэрэг баримтын эмхтгэлийг авч үзэх нь зүйтэй.

Эмхтгэлүүдэд Г.Дэмидийн удирдлагаар боловсруулсан МАХЦ-ийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт, шинэчлэлт,боловсон хүчин, улс төр, байлдааны бэлтгэл, сургалт, зэвсэглэл техник, цэргийн эрх зүй, сахилга, эрүүл мэнд, ар тал, ахуй хангалтын талаар гаргасан цөөнгүй

[265] *Мөн тэнд. х.120-122*

[266] https://www.bbc.co.uk/history/ww2peopleswar/user/10/u3050510.shtmГ1935-1936, *https://mongolianstore.com/the-soviet-army-in-mongolia/*

[267] *"Textonly" №25 // "Город назывался Томск" №25, 2008., стр.1-5*


[268] *Павлюков., А.Е., "Ежов.Биография" М.,2007., стр.82-362*

тооны дүрэм заавар, тушаал[269], удирдамж өөрийнх нь бичсэн нийтлэлүүд нь тухайн цаг үеийн сонин сэтгүүлд цөөнгүй хэвлэгдсэн. Эдгээр сонин, сэтгүүлд бичигдсэн нийтлэлүүдэд улс төр, цэргийн шинэчлэлийн үйл ажиллагаа, цаашдын хөгжлийн зорилтыг тайлбарлахын зэрэгцээ түүхэн үйл явдлын талаар тэмдэглэн үлдээж зарим асуудлаар үнэлгээ, дүгнэлт, гаргалгаа хийсэн байдгаараа судалгаанд нэн чухал ач холбогдолтой болсон байдаг.

Дээр өгүүлсэн Г.Дэмидийн амьдрал үйл ажиллагааны олон талыг хөндсөн судалгааны өгүүлэл, ном, эмхтгэлээс гадна Монголын түүх болон салбарын түүхийг судалсан зохиол бүтээлд эл асуудлыг судалгааны дашрамд авч үзсэн нь цөөнгүй байдаг нь түүний үзэл санаа, үйл ажиллагааг гүнзгийрүүлэн судлах судалгаа өргөжсөний илрэл юм.

Мөн Г.Дэмидийн талаар гаргасан судалгаа шинжилгээний бүтээлүүдийг тоймлон үзвэл түүний үйл ажиллагаанд холбогдох сүүлийн үед гаргасан судлаачдын бүтээлүүд нь доктор Д.Гомбосүрэн, С.Ганболд нарын эрдэмтдийн тэмдэглэсэнчилэн, түүхэн үнэнийг сэргээж түүхийг эзэнгүйдүүлэхээс зайлсхийсэн нь онцлог болсон бөгөөд одоо үед түүхийн намтар судлалын салбарт “Дэмид судлал” өөрийн байр суурийг баттай эзлэх болсон гэж үзэж болно.

Гэхдээ судалгааны зохиол бүтээлүүдэд Г.Дэмидийг бүх талаас нь бүрнээ нээн харуулж чадаагүй, ашиглаж чадаагүй орхигдуулсан түүнд холбогдох баримт сэлт цөөнгүй байх нь мэдээж бөгөөд ерөөс түүний намтар, түүхийг бүхий л талаас нь задлан шинжилж бүрэн гүйцэд судлах нь бидний цаашдын зорилт билээ.



Зураг 1. БНМАУ-ын ЦЯЯ-ны сайд бөгөөд Бүх цэргийн жанжин, Улсын маршал Г.Дэмид



Зураг 2. Зүүн гар талаас: Г.Дэмид, эхнэр Б.Навчаа, Д.Лувсаншарав нар

[269] *Батлан хамгаалахын төв архив., сх.1, д.1, хн.332,*



Зураг 3. *Зүүн гараас: Өвөр эгнээнд Бүх цэргийн жанжны 1 дүгээр орлогч, Улс төрийн газрийн дарга, Цэргийн ерөнхий комиссар О.Дашчарав, БНМАУ-ын ЦЯ-ны сайд, БЦ-ийн жанжин, өрлөг жанжин Г.Дэмид, БЦ-ийн жанжны 2 дугаар орлогч, корпус командлан захирагч Т.Самбуу,*
Арын эгнээнд Цэргийн ерөнхий сургуулийн захирал, Бригад командлан захирагч Гончигшарав, Жанжин штабын дарга, корпус командлан захирагч Б.Малж, 2 дугаар корпусын дарга, Корпус командлан захирагч Дамба, Улс төрийн газрийн орлогч дарга, Корпусын комиссар Галдан нар. 1936 он.

Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээлийн жагсаалт:

1. Наадгай.Ж., “Хувьсгалт цэргийн нэрт жанжин Г.Дэмид” // “Ардын арми” сэтгүүл, №4, 1970,
2. Пүрэв.О., “Монгол ардын хувьсгалын түүхэнд холбогдох нутаг, газар усны нэрийн товч тайлбар толь”. УБ., 1983,
3. Пүрэв.О,Гомбосүрэн.Д.,“Маршал Дэмид” өгүүлэл // “Улаан-Од” сонин, №52, 1985,
4. Литвинов.Н.Н., “1930-аад оны үеийн Монгол Улсад. Интернационалч үүрэгтээ үнэнч. (Дуртгал, өгүүллийн эмхтгэл) УБ., 1987,
5. “Комиссаруудын дуртгал” УБ., 1971, “МАХН-ын ахмад ажилтан, гишүүдийн дуртгал. Iдэвтэр. УБ., 1978,
6. “МАЖЦ-ийн дуртгалууд” I, II, III дэвтэр. УБ., 1982, 1985, 1986,
7. Батбаяр.Ц., “Монгол ба Япон XX зууны эхний хагаст” УБ., 1998,
8. Ганболд.С., “Хасгийн дээрэмчдийг устгасан нь” “Тусгаар тогтнол” сонин, 1994.01.10, №28,
9. Ганболд.Г., “Монгол Улсын өрлөг жанжин (маршал) Гэлэгдоржийн Дэмид” УБ., 2000

10. Орхончимэг.Х., “Монгол Улсын маршал Г.Дэмидийн цэргийн боловсрол сургалтыг хөгжүүлэхэд гүйцэтгэсэн үүрэг” // “Цац” сэтгүүл., 2018., №13 /36/, УБ., т.89-98,
11. Сүхбаатар.Т., “Цэргийн зүтгэлтэн маршал Гэлэгдоржийн Дэмид”, “Соёмбо” сонин, 2020.4.23., №16,
12. 12.Сүхбаатар.Т.,Толгойлогч. мн., “маршал Г.Дэмидийн үхлийн нууц”, 2020,
13. Батлан хамгаалахын төв архив., сх.1, д.1, хн.332
14. https://www.bbc.co.uk/history/ww2peopleswar/user/10/u3050510.shtmГ1935-1936, 15.https://mongolianstore.com/the-soviet-army-in-mongolia/
16. “Textonly” №25 // “Город назывался Томск” №25, 2008., стр.1-5
17. Павлюков., А.Е., “Ежов.Биография” М.,2007., стр.82-362
18. Сүхбаатар.Т., “Цэргийн зүтгэлтэн маршал Гэлэгдоржийн Дэмид”, “Соёмбо” сонин, 2020.4.23., №16,

Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлдэг эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл бичих журам

Манай хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлдэг "АЮУЛГҮЙ БАЙДАЛ, БАТЛАН ХАМГААЛАХ СУДЛАЛ" сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл хүлээн авч байна.

Сэтгүүлд хэвлүүлэх өгүүллийн судалгааны чиглэл:

- Аюулгүй байдал
- Батлан хамгаалах бодлого
- Зэвсэгт хүчний хөгжил, шинэчлэл
- Цэргийн сургалт, боловсрол
- Түүх, уламжлал

Сэтгүүлд ирүүлэх өгүүлэл дараах ерөнхий шаардлагыг хангасан байна:

1. Сэтгүүлд ирүүлэх өгүүлэл өөр газар хэвлэгдээгүй байх.
2. Бичлэгийн хэлбэр, формат

Цаасны хэмжээ B5 байна. Бичиглэл дээд талаасаа 0.845 inch (2.15см), доод талаасаа 0.845 inch (2.15см), зүүн талаасаа 0.845 inch (2.15 см), баруун талаасаа 0.845 inch (2.15 см) байна.

3. Хэл

Өгүүллийг англи, монгол, орос хэлээр Latex, MS Word, Word perfect программ-аар зөвхөн Times New Roman фонтоор бичсэн байна.

Mon-той фонт огт хэрэглэж болохгүйг анхаарна уу.

4. Өгүүллийн бүтэц

Сэтгүүлд өгөх эрдэм шинжилгээний өгүүллийг дараах бүтцийг баримтлан бичнэ.

- Гарчиг
- Зохиогчдын нэр, байгууллага, хаяг
- Товч утга /50 үгээс хэтрэхгүй/
- Түлхүүр үг (Заавал биш)
- Удиртгал
- Үндсэн хэсэг
- Онолын үндэс
- Үр дүн, дүгнэлт
- Ишлэл буюу ном зүй
- Товчлол зөвхөн англи, монгол хоёр хэлийн аль нэгээр байна. Өгүүллийг англи хэлээр бичсэн бол товчлол монгол хэлээр, бусад хэлээр бичсэн бол зөвхөн англи хэлээр байна.

5. Бичлэг хийхэд баримтлах зарчмууд

- Ишлэлийн footnote, end note-ийн аль нэгээр хийж болно.
- Ишлэлийг дөрвөлжин хаалтанд [1], [7, 10-12.14] гэх мэт тэмдэглэнэ.
- Ишлэл хийхдээ зохиогчийн нэр, он, өгүүллийн нэр, эх сурвалж нэр, дугаар, хуудас гэсэн дарааллаар хийнэ.

6. Бичиглэл хийх үсгийн хэв маягууд

6.1 Header (хуудасны толгой) - 9 pt., Italic, тэгш талын зүүн үзүүрт нь хуудасны дугаар, 0.5 inch зай аваад зохиогчийн нэр, цэг тавиад гарчиг бичнэ. (хоёроос дээш зохиогчтой бол ...нар гэж товчилно, гарчиг нь нэг мөрөнд багтахгүй бол гол утгыг нь гарган хураангуйлж багтаана).

6.2 Гарчиг - 14 pt, Bold, Том үсгээр эхэлж жижиг үсгээр бичнэ.

6.3 Зохиогч - 11pt, Bold, Томоор эхэлж жижгээр бичнэ.

6.4. Хаяг - 9pt, italic.

6.5 Abstract (Товч утга) - 9 pt, Үндсэн хэсгийн баруун, зүүн талаас 1 inch (2.54 см) зайтай бичнэ.

6.6 Үндсэн хэсэг - 11 pt, Зөвхөн хоёр баганаар (хоорондын зай нь 0.25 inch=6.35mm).

6.7 Бүлгийн (section) гарчиг - 11 pt, ALL CAPITAL, Bold, дугаарлавал Ром тоо хэрэглэнэ.

6.8 Дэд бүлгийн subsection гарчиг - 11 pt, Томоор эхэлж жижгээр бичнэ, Bold, дугаарлавал A,B,C.... гэнэ.

6.9 Ишлэл буюу ном зүй - 11 pt.

7. Өгүүллийг хүлээн авах:

7.1 Өгүүллийн тод хэвлэсэн хоёр хувийг файлын хамт авна. Зургийн файлыг тусад нь авна.

7.2 Хэвлэсэн хувь дээр зохиогчид гарын үсэг зурсан байна.

7.3 Өгүүлэл хэвлүүлэхийг зөвшөөрсөн сэтгүүлийн зөвлөлийн эрхлэгч болон эрдэм шинжилгээний судлаачийн гарын үсэг бүхий зөвшөөрөлтэй байна.

Сэтгүүлийн зөвлөл

Хаяг: Баянзүрх дүүрэг, Улаанхуаран, УБХИС-ийн төв байр,

Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн - 305 тоот

E-mail: mids@mndu.gov.mn

Утас: 453942